



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 15 он 04  
сарын 01 өдөр

Дугаар ЗГ-1/57

Улаанбаатар  
хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
З.ЭНХБОЛД ТАНАА

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг  
өргөн мэдүүлэх тухай

“Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг  
Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



Ч.САЙХАНБИЛЭГ



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2015 он 03 дугаар  
сарын 31-ны өдөр

Дугаар ... хэрг/624

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.БОЛДБААТАР ТАНАА

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг үндэслэн “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



С.БАЯРЦОГТ


1235

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

“ХҮЙ.3.ХЭЛЭЛЦСЭН нь: Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## ТАНИЛЦУУЛГА

*Засгийн газрын үйл ажиллагааны  
хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай*

Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг өргөн мэдүүлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг яамд, агентлагаас авч нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2014 оны эцсийн байдлаар 56.9 хувьтай гарлаа. Энэ нь 2013 оноос 10.7 хувийн өсөлттэй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүлгээр нь харуулбал:

**Нэг.** Ажилтай орлоготой Монгол хүн - 53.9 хувь

1. Үйлдвэржүүлэх чиглэлээр – 43.4 хувь
2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого – 46.6 хувь
3. Уламжлалт мал аж ахуй, мах, сүүний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого – 60.0 хувь
4. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого – 39.0 хувь
5. Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого – 55.0 хувь
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого 60.8 хувь
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого– 47.4 хувь
8. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого – 74.0 хувь
9. Нийгмийн хамгааллын бодлого – 69.3 хувь

**Хоёр.** Эрүүл чийрэг Монгол хүн – 49.0 хувь

**Гурав.** Эрдэм боловсролтой Монгол хүн – 59.6 хувь

**Дөрөв.** Аюулгүй орчинтой Монгол хүн – 65.0 хувь

1. Батлан хамгаалах бодлого – 62.1
2. Гадаад харилцаа – 65.0 хувь
3. Нийгмийн аюулгүй байдал – 61.0 хувь

**Тав.** Эрх чөлөөтэй Монгол хүн – 57.0 хувь

Хөтөлбөрийн 319 зорилтоос: 100 хувийн хэрэгжилттэй 18; 90 хувийн хэрэгжилттэй 20; 80 хувийн хэрэгжилттэй 3; 70 хувийн хэрэгжилттэй 57; 60 хувийн хэрэгжилттэй 33; 50 хувийн хэрэгжилттэй 96; 40 хувийн хэрэгжилттэй 34; 30 хувийн хэрэгжилттэй 48; 10 хувийн хэрэгжилттэй 6; 0 хувийн хэрэгжилттэй 1 зорилт байна.

Засгийн газар эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, салбаруудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтээн байгуулалтын ажлуудын зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, салбаруудын норм, стандартыг шинэчлэх, авто зам барих, иргэдийг орон сууцжуулах, орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх, түлш, шатахуун, цахилгаан эрчим хүч зэрэг бусад бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг суурь бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулдаг болгох

бодлого явуулах, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж хөгжлийг нь дэмжих, ажлын байрыг олноор бий болгож иргэдийг ажилтай, орлоготой болгох, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, нийгмийн эмзэг бүлгийг дэмжих чиглэлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

Манай улсын эдийн засагт бий болсон хүндрэлээс шалтгаалан инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах, санхүү, хөрөнгө оруулалт ихээр шаардсан томоохон зорилтууд болох банк санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах ажлыг эхлүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлэх, транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам барьж ашиглалтад оруулах, бүх аймгийн төвд кинотеатр, усан бассейн бүхий үйлчилгээний цогцолбор байгуулах, Сайншанд хотод аж үйлдвэрийн парк байгуулах, “Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг барьж байгуулах, Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн 60-100 МВт-ын дунд чадлын цахилгаан станц барих, их сургуулиудын хотхон байгуулах, хаягжилтын шинэчлэлийг хийх, аймгуудын төвийг дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаатай хот болгон хөгжүүлэх зэрэг зорилтуудын хэрэгжилт удаашралтай байна.

Засгийн газар бүрэн эрхийн үлдсэн хугацаанд эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг бодитой хэрэгжүүлэх, төсөв, мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийхэд чиглэн ажиллах болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ  
/2014 оны байдлаар/**

**НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН**

1. Бизнесийг дэмжсэн татварын хоёр дахь үе шатны шинэчлэлийг хийх

**Биелэлт:** Татварын 2 дахь үе шатны шинэчлэлийн хүрээнд дараах хуулийн төслүүдийг боловсруулав. Үүнд:

1. Татварын ерөнхий хуулийн төсөл
2. Өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын тухай
3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
4. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай
5. Хувь хүний орлогын албан татварын тухай
6. Бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоог бүртгэж, иргэдийг урамшуулах тухай
7. Хөрөнгийн албан татварын тухай
8. Байгаль орчин бохирдуулсны төлбөрийн тухай
9. Ашигт малтмал, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн тухай
10. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
11. Хотын албан татварын тухай
12. Эд мөнгөний хонжворт сугалааны тухай
13. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
14. Газрын хэвлийн төлбөрийн тухай
15. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
16. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жижиг хэмжээний ажил, үйлчилгээ эрхлэгч этгээдийн орлогын албан татварын тухай зэрэг хуулиудийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлэхээр тогтов.

Түүнчлэн шинэчлэлийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэл, томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Гаалийн татвар, Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудийг УИХ-аар батлуулав. **/50 хувь/**

2. Зээлийн хүүг бууруулж нэг оронтой тоонд оруулах

**Биелэлт:** Монголбанкнаас 2013 онд мөнгөний тэлэх бодлого баримталж, оны эцсийн байдлаар мөнгөний нийлүүлэлтийг 24.1 хувиар нэмэгдүүлж, бодлогын хүүгийн түвшинг 2 удаа бууруулж 10.5 хувь болгосон нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн түвшинг бууруулж, бодит эдийн засгийг дэмжихэд түлхэц үзүүлсэн.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын 2011 оны 677/229/188/142 дугаар хамтарсан тушаалаар “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Үүний нөлөөгөөр арилжааны банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2013 оны 3 дугаар сард 19.5 хувь байсан бол 2013 оны 12 дугаар сард 14.9 хувь болж 4.6 нэгж хувиар буурсан байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2014 оны 12 дугаар сарын байдлаар Монголбанкнаас эдийн засгийг тогтворжуулах зорилгоор 2013-2014 онд

хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн зээлийг оруулж тооцвол 16.9%, оруулахгүй тооцвол 19.5% байв. Энэ нь 2013 оны эцсийн гүйцэтгэлтэй харьцуулбал харгалзан 2.00, 2.14 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 12.9% болж өмнөх оны мөн үеэс 0.24 нэгж хувиар нэмэгджээ.

Зээлийн хүү ийнхүү өндөр хэвээр байгаагийн суурь шалтгаан нь макро эдийн засгийн гадаад тэнцвэр 2013-2014 онуудад тогтвортой бус, төлбөрийн нийт тэнцэл 2013 онд 1.9 тэрбум ам.долларын, 2014 онд 0.5 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, төлбөрийн тэнцлийн хүндрэл бий болсон, үүнээс шалтгаалж эдийн засгийн өсөлт саарч бодит секторын идэвхжил муудсан, санхүүгийн эх үүсвэрийн дутагдал бий болсноор эх үүсвэрийн өртөг нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна. **/50 хувь/**

### 3. Орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх

**Биелэлт:** Засгийн газар 2013 оны 4 дүгээр сард Монголбанкттай "Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын Санамж бичиг"-ийг байгуулсан. Үүнтэй холбогдуулан "Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам"-ыг Монголбанкттай хамтран баталж, жилийн  $8\pm 1$  хувийн хүүтэй, 20 хүртэл жилийн хугацаатай ипотекийн зээлийг 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн банкуудаар дамжуулан олгож эхлээд байна. "Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам"-д амины орон сууц барих болон худалдаж авах аймаг, сумдын иргэдэд жилийн 7 ( $\pm 1$ ) хувийн хүүтэй ипотекийн зээлийг олгох талаарх өөрчлөлтийг Засгийн газрын 2014 оны 151 дүгээр тогтоолоор батлав.

Улаанбаатар хот, 21 аймгийн хэмжээнд орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг нэгтгэн дүгнэлээ. Одоогоор орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн нэгдсэн мэдээллийн сан байгуулаагүй байна.

Орон сууцны зээлийн баталгааны сангийн асуудлыг Орон сууцны тухай хуулийн үзэл баримтлалын төсөлд тусган боловсруулаад байна.

Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолоор "Орон сууцны зээлийн хөнгөлөлтөд хамрагдах зорилтот бүлэгт үзүүлэх хөнгөлөлт"-ийг тодорхойлох, хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулаад байна.

"Эрчим хүчний үр ашигтай, байгаль орчинд ээлтэй барилгыг төлөвлөн барьсан болон хуучин барилгын дулааны алдагдлыг бууруулсан тохиолдолд эдийн засгийн урамшуулал олгох журам"-ын төслийг боловсруулав.

"Төрийн албан хаагчдын орон сууц" дэд хөтөлбөрийн хүрээнд 2008 онд 963, 2009 онд 668, 2010 онд 2730, 2011 онд 4140, 2012 онд 5185, 2013 онд 5095, нийт 18781 төрийн албан хаагч орон сууцтай болсон байна.

"Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

Түрээсийн орон сууц барих ажлыг үргэлжлүүлэн 23.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэн, барих эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн. Баянгол дүүргийн 20 дугаар хороонд эхний ээлжийн барилгын ажлыг эхлүүлээд байна.

Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт түрээсийн 300 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулав. **/70 хувь/**

### 4. Ажлын байр шинээр бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх

**Биелэлт:** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр", "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр", "Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр" болон "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөр"-ийг шинэчлэн, "40-өөс дээш болон ахмад настай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Эзэнтэй Монгол хөтөлбөр"-ийг шинээр тус тус батлуулж хэрэгжилтийг зохион байгуулснаар 2013 онд нийт 7370

шинэ ажлын байр, 34186 түр ажлын байр бий болсон бол 2014 онд нийт 60818 ажлын байр бий болсны 18839 шинэ ажлын байр, 41979 түр ажлын байр байна.

Цахим мэдээллийн нэгдсэн санд байгаа ажлын байрны мэдээллийг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор 21 аймаг, 9 дүүрэг, интернетийн сүлжээнд холбогдсон 142 сум, нийслэлийн 134 хороо, төрийн зарим байгууллагын нийт 355 байршилд Е-Биржийг суурилуулан ажиллуулж байна. **170 хувь!**

## 5. Инфляцид хөтлөгдөх бус зохицуулдаг тогтолцоонд шилжих

**Биелэлт:** Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сард байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудад жижиглэнгийн худалдааны шатахууны үнийг тогтвортой байлгах, газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэхэд зориулан 192.0 тэрбум төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай олголоо.

Газрын тосны бүтээгдэхүүний үнийн түвшинг ОХУ-аас бусад улс орнуудад нийлүүлж байгаа үнийн дундажтай харьцуулан судлахад Монгол Улс тонн тутамд 300-400 ам.доллараар илүү үнэтэй авч байгаа нь тогтоогдсон тул ОХУ-ын талд асуудал тавьж “Роснефть” компаниас газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлж буй одоогийн гэрээнд өөрчлөлт оруулах, улмаар бүтээгдэхүүний үнийг томъёогоор тооцож хүлээн авахаар болсон. Энэхүү үнийн томъёоллоор тооцоход 2013 оны 6 дугаар сарын үнийг 2013 оны 1 дүгээр сарын үнийн дундажтай харьцуулахад тонн тутмын үнийг даруй 300 ам.доллараар буулгаад байна.

Газрын тосны бүтээгдэхүүний үнийг газрын тосны биржийн үнэд суурилан тогтоодог тогтолцоонд шилжсэн. Ингэснээр Роснефть компаниас авдаг газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнийг тонн тутамд дунджаар 300 ам.доллараар хямдрууллаа.

2013 онд газрын тосны бүтээгдэхүүний нийт импортын хэмжээнд “Роснефть” компанийн эзлэх хэмжээ 25 хувь хүртэл буурсан.

Дотоодод олборлосон газрын тосоо БНХАУ-д экспортолж оронд нь газрын тосны бүтээгдэхүүн авч байгаа бөгөөд энэ хэмжээг сарын нийт хэрэглээний 40 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанаар газрын тосны бүтээгдэхүүний импортыг урт хугацаанд тогтвортой байх талаар хэлэлцэж тохирсон.

Засгийн газрын 2013 оны 352 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээнд гарсан өөрчлөлттэй уялдуулан 2014 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжийн бүрдүүлэх нөөцийн хэмжээг Засгийн газрын 2012 оны 126 дугаар тогтоолоор заагдсан 30 хоногийн буюу 70200 тонноос нэмэгдүүлэн 80480 тонн байхаар тогтоолоо.

Дархан-Уул аймагт жилд 2.0 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах тухай Засгийн газрын 2013 оны 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэр байгуулахад зээлийн баталгаа гаргах болон бусад асуудлаар Японы талтай хэлэлцээ хийж байна.

2013 оны улсын төсвийн 1.45 тэрбум төгрөгийн хөрөнгөөр тус үйлдвэрийн ТЭЗҮ-г Япон Улсын “Тоёо инженеринг” компаниар хийлгүүлсэн бөгөөд нарийвчилсан зураг төслийг боловсрууллаа.

2014 оны 3-р сарын 17-нд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс “*Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах*” зөвлөмжийг гаргасан учир газрын тос боловсруулах үйлдвэрийг аж үйлдвэрийн шинэ төвүүд болон газрын тосны ирээдүй бүхий ордуудтай аль болох ойр байршуулах боломжийг судалж шийдвэрлэхээр болсон.

Засгийн газраас “Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрийн төсөл”-ийг шалгаруулахаар зарлаж, иргэн, аж ахуйн нэгжийн нийт 1151 төслийг хүлээн авч төслүүдийн урьдчилсан үнэлгээг хийж байна.



Чингис бондын 24.0 тэрбум төгрөгөөр “Байшин үйлдвэрлэх комбинатын төсөл”-ийг санхүүжүүлэхээр баталж, тоног төхөөрөмжийн 30 хувийн урьдчилгаа төлбөр болох 7.0 сая ам.долларыг шилжүүлснээр үйлдвэрийн барилгын засвар, дэд бүтцийн шинэчлэлийн ажил хийгдэж байна.

Монголбанктай хамтран хэрэгжүүлж байгаа “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 оны 11 дүгээр сарын байдлаар барилгын материал үйлдвэрлэгч, худалдаалагч аж ахуйн нэгжүүдэд 266.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна. Үүний үр дүнд монгол цементийн үнэ 6.3, орос цементийн үнэ 23.5 хувиар тус тус буурсан байна.

Монголбанкнаас 2013 онд мөнгөний тэлэх бодлого баримталж, оны эцсийн байдлаар мөнгөний нийлүүлэлтийг 24.1 хувиар нэмэгдүүлж, бодлогын хүүгийн түвшинг 2 удаа бууруулж 10.5 хувь болгосон нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн түвшинг бууруулж, бодит эдийн засгийг дэмжихэд түлхэц үзүүлсэн.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн 2013 оны 11 сарын байдлаар нийт 645.8 тэрбум төгрөгийг арилжааны банкуудаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд бага хүүтэйгээр зээл хэлбэрээр олгож эхэлсэн.

Мөн “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрөөр бага хүүтэй орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 470.6 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлж, орон сууцны зээлийн хүүг 8 хувь руу шилжүүлж, 645.6 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгосон байна.

Замын-Үүд хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхээр “Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өртгийг бууруулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхээр өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тогтсон хуваарийн дагуу тусгайлсан 2 галт тэргээр гүйцэтгэж, ачаа эргэлтийг хурдасгасан бөгөөд ингэснээр өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг 1 хоногт багтаан тээвэрлэдэг болж, тээвэрлэлтийн зардал буурч, дотоодын зах зээл дэх үнэ харьцангуй тогтвортой байх нөхцөл бүрдэж байна.

Монголбанк, Засгийн газраас хамтран хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн нөлөөгөөр мах, гурил, шатахууны үнийн өсөлт нь өмнөх онуудаас эрс буурч, нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах, улмаар нам түвшинд нь тогтвортой байлгах нөлөөг үзүүлж байна. Харин өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 12.6 хувь байжээ. Энэ нь төлбөрийн тэнцлийн хямралаас үүдэлтэй төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулралт (өмнөх оноос 13.8%), импортын барааны үнийн өсөлтөөс голчлон шалтгаалав. **/50 хувь/**

## 6. Барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэдэг болох

**Биелэлт:** Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн барилгын материалын үйлдвэрүүдэд Монгол банкны хөнгөлөлттэй зээл олгосон бөгөөд Архангай аймгийн “Гүнжийн даваа” ХХК 500 сая, Баян-Өлгий аймагт “Мадинэ” ХХК 400 сая төгрөг, Ховд аймагт “Ховдын тулга” ХХК 200 сая төгрөг, Дорнод аймагт “ТОУУ” ХХК 700 сая төгрөг, “Ногоон газар” ХХК-ийн полистрол бетон хавтан, блокны үйлдвэр, “Арга барил” ХХК-ийн хөнгөн дүүргэгчтэй блокны үйлдвэрт 730 сая төгрөгийн зээл авч үйлдвэрээ байгуулж байна.

Хөтөлийн цемент шохой, Дархан–Уул аймгийн төмөрлөгийн үйлдвэрүүдийн өргөтгөл хийгдсэн. Дорноговийн шохойн чулууны ордод түшиглэн цементийн үйлдвэр байгуулахаар ажиллаж буй “МАК” ХХК, “Монполимет” ХХК, “Гермес гахиур” ХХК-иудын төсөл, Орхон аймагт Арматур боловсруулах үйлдвэр байгуулахаар “Бэрэн групп” ХХК-ийн төсөл зэргийг Чингис бондын зээлээр санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.

Барилгын материалын үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрөөр 2013 онд цемент, арматурын бизнес эрхлэгч 55 компанид

125,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг дэмжин олгуулж 161,6 тонн арматур, 490000 тонн цемент импортлосон мөн дотоодын барилгын материалын үйлдвэрийг дэмжиж 71 компанид 174,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгуулж үр дүнд нь 21 үйлдвэр тоног төхөөрөмжөө шинэчлэж үйлдвэрээ өргөжүүлсэн, 11 үйлдвэр шинээр байгуулагдсан байна.

Барилгын материалын бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, төрөл шаардлага хэрэгцээг нь тодорхойлох зорилгоор Барилгын үндэсний ассоциацтай хамтран барилгын материалын үйлдвэрүүд, орон нутгаар судалгаа хийж байна.

Барилгын материалын үйлдвэрлэлд ашигладаг түгээмэл тархацтай ашигт малтмалын нэр томъёог тодорхой болгох, геологи хайгуулын болон олборлолт, ашиглалтад тавих шаардлага, нөхцөл, төлбөрийг хялбаршуулах зорилгоор "Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль"-ийг боловсруулж УИХ-аар батлуулав.

### **/70 хувь/**

## **7. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлэх**

**Биелэлт:** Уул уурхайн сайдын 2014 оны 177 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн шийдвэрийн дагуу эрдэс баялгийн бирж байгуулахад тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаа зохицуулах журам батлах, гэрээ байгуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, түлхүүр гардуулах нөхцлөөр эрдэс баялгийн бирж байгуулах олон улсад нээлттэй сонгон шалгаруулалт зарлах ажлыг Сангийн яам тус тус хариуцан ажиллаж байна.

2013 оны 3 дугаар сард "Монгол брэнд" сэдвийн дор зохион байгуулагдсан "Монголын эдийн засгийн форум"-ын үеэр гарсан саналыг үндэслэн эхний ээлжинд хүнс, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлал, мэдээллийн технологийн салбарт брэнд бүтээгдэхүүн бий болгох чиглэлийг тодорхойлсон. Брэнд бий болох асуудал нь салбар дундын шинжтэй тул холбогдох байгууллагын ажлын уялдааг хангах зорилгоор Брэндийн зөвлөлийн дүрмийн төслийг боловсруулаад байна.

Ноолуур, ноос, арьс ширний салбарыг дэмжих бодлогын хүрээнд "Чингис" бондоос ноос, ноосон бүтээгдэхүүний салбарт 45.0 сая, ноолуур, ноолууран бүтээгдэхүүний салбарт 68.8 сая ам.долларыг тус тус зарцуулахаар шийдвэрлэсэн.

Зохион бүтээгчдийн 31 бүтээл, патент, 16 барааны тэмдгээр гадаад орнуудад хамгаалагдсан бөгөөд бүгд үйлдвэрлэлд нэвтэрсэн байна.

Өндөр болон тэргүүний технологийг нутагшуулах зорилгоор АНУ-ын патент эзэмшигч, Монгол иргэний зохион бүтээсэн шинэ бүтээл болох элэгний вирусын эсрэг эмийн технологийг нутагшуулах чиглэлээр патент эзэмшигчтэй хамтран ажиллаж байна.

Газар зүйн заалт бүхий "брэнд", оюуны шингэц бүхий бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Архангай аймгийн сарлагийн хөөвөр ашиглан газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох чиглэлээр ажиллаж байгаа нөхөрлөлтэй газар зүйн заалтаар бүртгүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлж байна. 2015 онд Монгол улсын нэг газар зүйн заалтыг Европын Холбоонд бүртгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна.

### **/30 хувь/**

## **8. Хилийн боомтын шинэчлэлийг хийх**

**Биелэлт:** Хилийн боомтын тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулан, хуулийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна.

Алтанбулаг, Замын-Үүдийн хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын санхүүжилт 2013 оны улсын төсвийн тодотголоор хасагдсан тул зөвлөхийн тендер шалгаруулалт хүчингүй болсон. "Хилийн боомтын тухай" хуулийн дагуу Монгол Улсын Хилийн боомтын Үндэсний зөвлөлийн 2014 оны 01 дугаар тогтоолоор Бургастай, Бичигт, Булган, Ханги, Ханх, Зэлтэр боомтуудын хөгжлийн

ерөнхий төлөвлөгөөг батлав. Гашуунсухайт, Шивээхүрэн, Боршоо хилийн боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулж дуусгав.

Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолоор “Боомтын хөгжлийн загвар”, “Боомтын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга, байгууламжийн давтан хэрэглэх зургийн жагсаалт”-ыг батлав. Засгийн газрын 2014 оны 46 дугаар тогтоолоор Монгол, Хятадын улсын хилийн хоёр талын зорчигч, ачаа тээврийн, түр ажиллагаатай Хавирга, Баянхошуу, Ханги, Бургастай авто замын боомтуудыг байнгын ажиллагаанд, Монгол-Оросын улсын хилийн Алтанбулаг-Хиагт боомтоор зорчигч нэвтрүүлэх ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлэв.

Замын-Үүд боомтоор нэвтрэх гадаад худалдааны баримт бичгийг ижилсүүлэх, шат дамжлагыг багасгах болон техник, программ хангамжийн судалгаа хийж, нэгдсэн камерын системд холбох төсөл боловсруулсан. Түүнчлэн гааль болон Хилийн мэргэжлийн хяналтын албыг хооронд нь онлайн сүлжээнд холбохоор схем гаргаад байна.

Гадаад худалдааг хөнгөвчлөх “Үндэсний цахим нэг цонхны систем”-ийг бий болгох ажлыг удирдан зохион байгуулах Удирдах хороог Засгийн газрын 2013 оны 69 дүгээр тогтоолоор шинэчлэн байгуулж, Азийн хөгжлийн банкнаас 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл авахаар ажиллаж байна.

Замын-Үүдийн “Нэг цэгийн үйлчилгээ”-г “Цахим нэг цонхны систем”-д шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Хилийн боомтын үйл ажиллагааг цахим нэг цонхны системд шилжүүлж гадаад худалдааг хөнгөвчлөх, баримт бичгийн бүрдүүлэлт, зардал, хугацааг багасгах чиглэлээр импортын гэрчилгээ, хяналтад хамрагдсан мэдэгдэл, импортын мэдэгдэл, саатуулах тухай мэдэгдэл, хураах тухай мэдэгдэл, буцаах тухай мэдэгдэл, саатуулсан шийдвэрийг цуцлах тухай мэдэгдэл, хяналтыг шилжүүлсэн тухай мэдэгдэх хуудас зэрэг баримт бичгийн шинэчилсэн төслүүдийг боловсруулсан. Мөн экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, хил дамжуулан тээвэрлэх мэдэгдэл хүссэн өргөдлүүдийн маягтуудыг боловсруулж байна. /60 хувь/

## 9. Хөрөнгийн биржийг шинэчлэх

**Биелэлт:** Хөрөнгийн биржийг шинэчлэх ажлын хүрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулав. Мөн Монголын хөрөнгийн биржийн захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилов.

Монгол Улсын Засгийн газар 2011 онд Монголын үнэт цаасны зах зээлийн олон улсын жишигт нийцүүлэх зохилгоор Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратеги хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-г байгуулан ажиллаж байна. Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран төсөл хэрэгжүүлж эхний ээлжинд 120 гаруй мэргэжилтнийг сургалтад хамруулав.

Хөрөнгийн бирж болон брокер, дилер компаниудын чадавхийг сайжруулах талаар Монголын хөрөнгийн биржээс үе шаттай сургалтуудыг зохион байгуулж байна.

“МХБ” ХК болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны чадавхийг дээшлүүлэх зорилгоор Японы Жайка байгууллагаас 2014 оны 12 дугаар сараас 5 чиглэлээр техникийн туслалцаа авахаар ажиллаж байгаа ба 2 ажилтанг хөтөлбөрийн дагуу дадлагажигч ажилтнаар 3 сарын хугацаагаар Япон улсад ажиллуулав. Хөтөлбөр 2017 оны 7 дугаар сар хүртэл хэрэгжинэ. /40 хувь/

**10.** Банк санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах ажлыг эхлүүлэх

**Биелэлт:** Хөрөнгө оруулалтын тухай шинэ хуулиар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ижил нөхцөл олгон, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн.

Евро-Азийг дамнасан санхүүгийн чөлөөт бүс байгуулах төслийн танилцуулгыг боловсруулаад байна.

Зангилаа төвийн үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан хууль батлагдсаны дараа концессоор хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. /10 хувь/

11. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагыг өсгөхгүй, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг хуульчлах

**Биелэлт:** Монгол Улсын 2013, 2014 оны төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулж УИХ-аар батлууллаа.

Үзүүлэлт	2014 оны Төсвийн тухай хууль		Урьдчилсан гүйцэтгэл
	Тод 1 (2014.0 5)	Тод 2 (2014.1 2)	
Орлого	6,903.8	6,945.1	6,223.4
ДНБ-д эзлэх хувь	31.9%	32.1%	28.5%
Зарлага	7,312.4	7,352.7	7,031.3
ДНБ-д эзлэх хувь	33.8%	33.9%	32.2%
Алдагдал	408.5	407.6	807.9
ДНБ-д эзлэх хувь	-1.99%	-2.0%	-3.7%

УИХ-ын чуулганы 2014 оны 12-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэж нэгдсэн төсвийн 2014 оны нийт тэнцвэржүүлсэн орлого 6,945.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ны 32.1%, нэгдсэн төсвийн нийт зарлага 7,352.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ны 33.9%, нэгдсэн төсвийн нийт алдагдал 407.6 тэрбум төгрөг буюу ДНБ-д -2.0 хувийг эзлэхээр батлагдсан.

2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-д нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь 28.5 хувь, зарлагын эзлэх хувь 32.2 хувь, нийт алдагдал -3.7 хувийг эзэлж байна. /30 хувь/

12. Инфляцийг нэг оронтой тоонд барьж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах

**Биелэлт:** Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээг авч ажиллав. Улсын төсвийн инфляцид үзүүлэх дарамт бага байсан, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрүүдийн үр дүнгээр нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл багасахаар хүлээгдэж байсан тул Монголбанк 2013 оны 1, 4, 6 дугаар саруудад мөнгөний бодлогын хүүг 0.75, 1.0, 1.0 хувиар тус тус бууруулж 10.5 хувьд хүргэв. 2014 оны 7 дугаар сарын 30-ны ээлжит хуралдаанаар бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн, 12.0 хувь болгох шийдвэрийг тус тус гаргав. Энэхүү арга хэмжээ нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой байв.

Жилийн инфляци **2014 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 11.0 хувь**, Улаанбаатар хотын хэмжээнд 10.7 хувь гарсан нь инфляцийн зорилтот түвшнээс **3.7 нэгж хувиар өндөр** байна. 2014 оны 12 дугаар сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (10.7%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн - 0.06, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 2.20, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.58, шатахуун 0.07, бусад бараа, үйлчилгээ 6.90 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2013 онд нийт 677.0 тэрбум төгрөгийн зээлийг банкуудад олгосон бөгөөд хөтөлбөрийн зээлүүд хуваарийн дагуу эргэн төлөгдөж байна. Ийнхүү нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн энэхүү хөтөлбөрийн үр дүнд хэрэглээний үнийн сагсаар хэмжигдэх инфляци дахь нийлүүлэлтийн гаралтай сөрөг нөлөөллүүд эрс буурсан үр дүнтэй байна.

Түүнчлэн, төсөв, мөнгөний бодлого хоорондын уялдааг сайжруулах зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 217/А161 дугаар хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг баталсан.

“Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрөөр бага хүүтэй орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн бөгөөд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 470.6 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлж, орон сууцны зээлийн хүүг 8 хувь руу шилжүүлж, 645.6 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгосон байна. **/40 хувь/**

**13.** Улсын төсвийн зардлыг хязгаарлаж, дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн эзлэх хувийг 40-өөс илүүгүй байлгах

**Биелэлт:** УИХ-ын 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд 2014 оны нэгдсэн төсвийн орлого 7,514.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 36.2, 2015 онд 32.8, 2016 онд 31.0 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 2014 онд 7,686.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.2, 2015 онд 34.1, 2016 онд 32.4 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 416.3 тэрбум төгрөг буюу 2014 онд ДНБ-ий 2.0, 2015 онд 2, 2016 онд 2 хувь байхаар тус тус тусган батлуулсан.

Үзүүлэлт	2014 оны Төсвийн тухай хууль		Урьдчилсан гүйцэтгэл
	Тод 1 (2014.05)	Тод 2 (2014.12)	
Орлого	6,903.8	6,945.1	6,223.4
ДНБ-д эзлэх хувь	31.9%	32.1%	28.5%
Зарлага	7,312.4	7,352.7	7,031.3
ДНБ-д эзлэх хувь	33.8%	33.9%	32.2%
Алдагдал	408.5	407.6	807.9
ДНБ-д эзлэх хувь	-1.99%	-2.0%	-3.7%

**/70 хувь/**

**14.** Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлыг хоёр хувиас илүүгүй байлгах

**Биелэлт:** УИХ-аас 2013 оны төсвийн тодотголыг мөн оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан бөгөөд нэгдсэн төсвийн нийт орлого 6,289.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.0, нэгдсэн төсвийн нийт зарлага 6,629.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 39, нэгдсэн төсвийн нийт алдагдал 340.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2 хувьтай тэнцэж байна.

УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг баталсан бөгөөд 2014 оны төсвийн нийт орлого 6,883.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.6, төсвийн нийт

зарлага 7,239.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 байхаар, алдагдал 355.9 тэрбум төгрөг буюу ДНБ-нд -2 хувьтай байхаар батлагдлаа.

Үзүүлэлт	2014 оны Төсвийн тухай хууль		Урьдчилсан гүйцэтгэл
	Тод 1 (2014.0 5)	Тод 2 (2014.1 2)	
Орлого	6,903.8	6,945.1	6,223.4
ДНБ-д эзлэх хувь	31.9%	32.1%	28.5%
Зарлага	7,312.4	7,352.7	7,031.3
ДНБ-д эзлэх хувь	33.8%	33.9%	32.2%
Алдагдал	408.5	407.6	807.9
ДНБ-д эзлэх хувь	-1.99%	-2.0%	-3.7%

УИХ-ын чуулганы 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар батлагдсан 2014 оны төсвийн тодотголын нэгдсэн төсвийн алдагдлын хэмжээг 407.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2% байхаар батласан байна. **/30 хувь/**

#### 15. Хөрөнгө оруулалтыг тав хүртэл жилээр төлөвлөх зарчимд шилжих

**Биелэлт:** УИХ-ын 2012 оны 60 дугаар тогтоолоор “Монгол Улсын дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” боловсруулах үүргийг Засгийн газарт өгсний дагуу уг хөтөлбөрийг боловсруулан УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

УИХ-ын 2012 оны 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор нийт 222 төрийн албан хаагчдаас бүрдсэн 37 ажлын хэсгийг нэг сарын хугацаанд нийт орон даяар ажиллуулж, Улаанбаатар хот, 21 аймаг, 330 сум, 17 боомт, 21 баг, тосгоныг хамруулан “2014-2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэлээ. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар нийт төсвийн ерөнхийлөн захирагчид, УИХ-ын гишүүд, аймаг, нийслэлээс давхардсан тоогоор 95 гаруй их наядын 20.0 мянган төслийн саналыг ард иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлсэн.

Хөрөнгө оруулалтын төслийн норм, стандартыг боловсронгуй болгох талаар Ерөнхий сайдын захирамжын дагуу ЭЗХСайд /хуучнаар/, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдуудын хамтарсан тушаалаар БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2013 оны “Сумдын хөгжлийн загвар болон түүнд хамаарах нэг маягийн загвар зургийн жагсаалт батлах тухай” 226 дугаар тогтоолд заасны дагуу нийгмийн үйлчилгээ, үйлдвэрлэл, бизнесийн 130 барилга, байгууламжийн нэг маягийн загвар зураг төслийг боловсруулж улсын экспертизэд хянуулахаар өгөөд байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдсэн систем /mdi.med.gov.mn/-ийг боловсруулсан бөгөөд уг програм хангамжийг нэмж сайжруулах нийт хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналтын цогц систем болгохоор гүйцэтгэгчийг шалгаруулан, эхний ээлжийн программ хангамжийг хүлээн аваад байна. **/50 хувь/**

#### 16. Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчийн компанийн удирдлагад хариуцлага тооцож, ашигтай ажиллахаар өөрчлөн зохион байгуулах

**Биелэлт:** 2012 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 98 аж ахуйн нэгжийн 37 нь алдагдалтай ажиллаж байсан бол 2013 онд 24 болж буурсан байна.

2012 оны жилийн эцэст нийт 63 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан компаниудыг 2013 онд нийтэд ил тод зарлаж, шинэ менежмент хэрэгжүүлсний үр дүнд 6 тэрбум төгрөг (91 хувиар) болгож бууруулж чадсан. Тухайлбал, алдагдлыг эрчим хүчний салбарт 12 тэрбум төгрөгөөр, банк, санхүүгийн салбарт 38 тэрбум төгрөгөөр, зам тээврийн салбарт 7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулав.

2013 оны жилийн эцэст нийт 51,6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан компаниудад 2014 онд үе шаттай арга хэмжээ авч ажилласны үр дүнд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 28,8 тэрбум төгрөг (54 хувиар) болгож бууруулсан байна. Тухайлбал, алдагдлыг уул уурхайн салбарт 10 тэрбум төгрөгөөр, эрчим хүчний салбарт 1,1 тэрбум төгрөгөөр, зам тээврийн салбарт 1 тэрбум, бусад салбар 10,7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулав.

2013 оны жилийн эцсээр 5893,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан “ДЦС-3” ТӨХК, “Өмнөд бүсийн ЦТС” ТӨХК, “Дорноговь АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Биокомбинат” ТӨҮГ, “Эрчим корпораци зэрэг 7 аж ахуйн нэгж 2014 оны 3 дугаар улирлын тайлан тэнцлийн дүнгээр 2689,6 сая төгрөгийн ашигтай гарсан.  
**/60 хувь/**

**17.** Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулж, захиалагч нь шийдвэрлэдэг өнөөгийн тендерийн тогтолцоог өөрчилж гүйцэтгэгч нь шийдвэрлэдэг болгох

**Биелэлт:** Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг хангах, одоогийн мөрдөгдөж буй тогтолцоонд өөрчлөлт оруулах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулав.

2013 онд зарласан тендер оролцсон 695 компанийн дадлага, туршлага, ажиллах хүчний чадавхи, тендер шалгарч, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гэрээний үүргийн биелэлтээр чансаа тогтоон жагсаалт гаргаж, мэдээллийн сантай болсон.

2012 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Монгол Улсад цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх төсөл”-ийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан бөгөөд Худалдан авах ажиллагааны газар уг системийг хариуцан ажиллаж байна.

Цахим худалдан авах ажиллагааны системээр дамжуулан 2013 онд нийт 167 цахим тендерийг зохион байгуулсан байна.

2013 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээнээс 43 төсөл, арга хэмжээний 98 багц ажлын худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь нийт төсөл, арга хэмжээний 22.2 хувийг эзэлж байсан бол 2014 онд 100 хувь буюу 1143 тендер шалгаруулалтыг “Цахим худалдан авах ажиллагааны систем”-ээр зохион байгуулав.

Цахим худалдан авах ажиллагааны “MEPS” системд 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 487 аж ахуйн нэгжүүдийг бүртгэн цахим системийн хувийн нууцлалын кодыг олгосон нь нийт тендер оролцсон 695 аж ахуйн нэгжийн 70.1 хувийг эзэлж байна. “Цахим худалдан авах ажиллагааны систем”-д 2014 оны 12 дугаар сарын байдлаар нийт 2610 аж ахуйн нэгж бүртгүүлээд байна.

Түүнчлэн олон нийтэд цахим худалдан авах ажиллагааг сурталчлах, таниулах үүднээс 4 анги бүхий хөдөлгөөнт дүрст бичлэгийг бэлтгэж фэйсбүүк, youtube цахим хуудсаар дамжуулан 5950 иргэнд, цахим хэлбэрээр буюу компакт дискээр 2100 иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлж ажилласан байна.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн систем [/www.e-procurement.mn/](http://www.e-procurement.mn/), байгууллагын [www.e-tender.mn/](http://www.e-tender.mn/),

**18.** Гадаадын зах зээлээс хямд эх үүсвэрийг боломжит хэмжээгээр татаж зөвхөн бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх

**Биелэлт:** Дунд хугацааны үнэт цаасны хөтөлбөрийн дагуу 2012 онд гаргасан 1.5 тэрбум ам.долларын өрийн бичиг дээр нэмж, олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалах үнэт цаасны хэмжээг ДНБ-ий төсөөллийн хүрээнд гаргасан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баримтлан ажиллаж байгаа болно. Монгол Улсын өр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хэмжээнд хүрсэн учраас Сангийн яам болон ЭЗХЯ-с хамтран боловсруулсан Өрийн удирдлагын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан бөгөөд энэ хууль батлагдсаны дараа “Чингис” болон өөр үнэт цаасуудыг олон улсын санхүүгийн зах зээл дээр борлуулах болно. /60 хувь/

**19.** Цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлэх

**Биелэлт:** “Цалин хөлсний талаар Үндэсний хэмжээнд баримтлах бодлого”-ыг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулан хэрэгжүүлж байна. “Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн бүтээмж тооцох аргачлал”-ыг 2014 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн Хөдөлмөрийн сайдын А/240 тоот тушаалаар батлав.

Монгол Улсын 2013 оны нийгэм, эдийн засгийн байдал, хэрэглээний үнийн индекс, инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах 90.0 тэрбум орчим төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2014 оны Төсвийн тухай хуульд тусган УИХ-аар батлуулав.

Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн албан хаагчийн 200,0 мянга хүртэлх төгрөгийн тэтгэврийн хэмжээг 27,0 мянган төгрөгөөр, 600,0 мянга хүртэлх төгрөгийн тэтгэврийн хэмжээг 22,0 мянган төгрөгөөр, түүнээс дээш тэтгэврийн хэмжээг 20,0 мянга төгрөгөөр тус тус нэмэв. /50 хувь/

**20.** Цалин, тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмэх

**Биелэлт:** Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд цалин хөлсийг индексжүүлэх талаар тусгаад байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох ажлын хүрээнд хуульд заасан эдийн засгийн дөрвөн үзүүлэлтийг харгалзан тооцоо, судалгаа хийж, хувилбаруудыг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2013 оны 7 дугаар тогтоолоор батлууллаа.

Хувийн хэвшлийн салбарын цалин хөлсний тарифын хэлэлцээр байгуулах зөвлөмжийг боловсруулж Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороогоор хэлэлцүүлэхэд бэлтгээд байна.

Үндэсний статистикийн хорооноос зарласан 2013 оны жилийн эцсийн инфляцийн үзүүлэлтээр төрийн албан хаагчдын цалинг 2014 онд боловсрол, эрүүл мэндийн салбараас эхлэн нийтэд зарлахгүйгээр ээлж дараатай нэмэгдүүлэхэд 2014 оны улсын төсөвт суулгасан хөрөнгө дээр 35,0 тэрбум төгрөгийг төсвийн тодотголоор нэмж шийдвэрлүүлэн цалинг нэмэгдүүлэх арга хэмжээг 3 удаа ээлж дараатай авч хэрэгжүүллээ. Төрийн албан хаагчийн цалинг нийтэд зарлахгүйгээр, салбар бүрээр ээлж дараатай нэмэгдүүлэх арга хэмжээнд нийтдээ 180,150 хүн хамрагдаж, сарын үндсэн цалин нь дунджаар 83,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд жилд тооцсоноор 129,6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулав.



Одоогоор автотээвэр, геологи, уул уурхай, эрчим хүч, авто зам, барилга, эрүүл мэнд зэрэг 10 салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоогоод байна.

**/70 хувь/**

## **21. Мөнгөний бодлогыг бодит эдийн засгийг дэмжихэд чиглүүлэх**

**Биелэлт:** Гадаад валютын орох урсгал тасралтгүй буурч, төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй нөхцөл байдал удаан үргэлжлэн, Монгол Улсын гадаад цэвэр актив сүүлийн 3 жилийн турш буурсны нөлөөгөөр нийт эрэлт буурч, 2014 онд өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар саарч 7.8% болоод байна. 2014 оны 12-р сарын байдлаар Монгол Улсын гадаад цэвэр актив (Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын нийт гадаад активаас нийт гадаад пассивыг хассан дүн)-ын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2636 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээгээр буураад байна. Гадаад цэвэр активын хэмжээ ийнхүү сүүлийн 2 жилийн туршид огцом буурсан нь эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, төлбөрийн нийт тэнцэл оны эхнээс сайжрахгүй байгаатай шууд холбоотой.

Ийнхүү гадаад валютын орох урсгал сайжрахгүй, төлбөрийн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр 2014 онд 471.1 сая ам.долларын алдагдалтай гарсан нь эдийн засгийн бодит секторыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжих боломжийг хязгаарлаж, мөнгөний бодлогын хүүг бууруулах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, улмаар бодит секторын идэвхжилийг дэмжих нөхцөлийг бүрдүүлсэнгүй. Төлбөрийн тэнцлийн 2013 оны “хямрал”-ын нөхцөл байдал сайжрахгүй, төлбөрийн тэнцэл дэх дарамт арилахгүй хэвээр байгаа нь 2014 оны сүүлийн хагаст макро эдийн засгийн бодлогыг хумих, тэр дундаа төсвийн зардал болон төсөвтэй адилтгах зарцуулалтыг эрс бууруулах шаардлагыг бий болгосон.

Гэвч улсын төсвийн зардал болон төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд нь макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангахад нөлөөлөхүйц хэмжээнд буураагүй тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдөр мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан юм.

Монголбанк эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөх зарим арга хэмжээг Засгийн газартай хамтран боловсруулж, хэрэгжүүлэв. Үүнд:

-ҮХААЯ, СЯ-тай хамтран ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх (НҮДЭН) арга хэмжээний схем, НҮДЭН арга хэмжээг хэрэгжүүлэх журам, Засгийн газрын батлан даалтын гэрээ, Монголбанкнаас банкттай байгуулах зээлийн гэрээ, зээлийн эх үүсвэрийг олгох, буцаан төлүүлэх, хяналт тавих механизм, аргачлалыг тус тус боловсруулан баталж, Засгийн газар холбогдох шийдвэрийг гаргасан.

-Монголбанк барилгын салбарыг дэмжих, орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны барилгын зээлд ашиглагдах 534.5 тэрбум төгрөгийн зээлийг 7 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай олгосон. Үүнээс 2014 оны эцсийн байдлаар 359.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр эргэн төлөгдөж, 175.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

-2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар банкууд 18,649 зээлдэгчийн нийт 546.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, 8 хувийн хүүтэй ипотекийн зээл рүү шилжүүлсэн байна. Энэ хугацаанд банкууд 27,707 иргэнд 1,563.8 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгожээ.

-Алтны салбарын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, алтны үнийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бууруулах замаар 2014 онд алт олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Монголбанк,

УУЯ, ЭЗХЯ хамтран “Алтны салбарын санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох арга хэмжээ”-г 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хамтарсан тушаалаар батлав.

-Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг үргэлжлүүлэн бууруулах, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих зорилгоор “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (FPS) дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 400.7 тэрбум төгрөгийн зээл олгосноос 204.2 тэрбум төгрөг (51%)-ийн эргэн төлөлттэй байна.

-Монголбанк гадаад валютын орох урсгалыг дэмжих, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих зорилгоор “Урт хугацаат своп хэлцэл”-ийг нэвтрүүлж Хятадын Ардын банктай 2014 оны эхнээс өссөн дүнгээр нийт 9 тэрбум юанийн своп хэлцлийг хийсэн. /50 хувь/

**22.** Түлш, шатахуун, цахилгаан эрчим хүч зэрэг бусад бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлдөг суурь бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулдаг болгох бодлого явуулах

**Биелэлт:** 2012 оны 10 сард Засгийн газар, Монголбанкны хооронд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулан, энэ хүрээнд 5 дэд хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнд:

1. “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах”,
2. “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах”,
3. “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах”,
4. “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах”,
5. “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах”.

Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн сайдын хамтарсан 2012 оны А-171, 46-1 дүгээр тушаалаар “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийг батлан гадаад валютын ханшийн хэлбэлзлээс хамгаалах зорилгоор жижиглэнгийн борлуулалт хийж байгаа аж ахуйн нэгжүүдэд 192.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгов.

Он	Шатахууны үнийн өсөлтийн хувь		
	АИ-80	АИ-92	Дизел
2012	16.8%	1.89%	6.06%
2013	0	0	0
2014	1.3%	2.5%	2.3%

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулан 11,4 мян.тн махны нөөц бэлтгэж, 87.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, хуваарийн дагуу 100% буцаан төвлөрүүлсэн бол 2015 онд нийт 14 мянган тн махны нөөц бүрдүүлэхээр болж санхүүжилтийн 40 хувийг тухайн аж ахуйн нэгж өөрийн эх үүсвэрээр, 60 хувийг Монголбанк гаргахаар гэрээнд тусгасан байна.

“Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд бага хүүтэй (жилийн 8 хувийн) орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Дэд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2014 оны 12 дугаар сарын байдлаар 546.9 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлж, орон сууцны зээлийн

хүүг 8 хувь руу шилжүүлсэн бөгөөд 1563.8 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийг 27707 иргэнд шинээр олгосон байна.

**“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах хөтөлбөр”**-ийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас үл хамааран хэрэглэгчдэд худалдах эрчим хүчний үнэ тариф, үйлдвэрлэгчийн үнэ, дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөрийг эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах зардлын үндсэн хүчин зүйлсийн бодит өөрчлөлтөөс хамааруулан тооцож зохицуулах тогтоол гаргаж 2014 оны 11-р сарын 7-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахаар болсон.

ШӨХТГ-ын 2013 оны 10 дугаар тогтоолоор тарифыг дараах байдлаар нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн. Үүнд:

- Цахилгаан болон дулааны эрчим хүчинд дунджаар 20 хувиас ихгүй,
- Ахуйн хэрэглээний тарифыг шатлалтай болгон өрх бүрийн эхний 150 кВтц хүртэлх цахилгааны хэрэглээг 78 төгрөг/кВт.ц-аар, 151 кВтц-аас дээшхи хэрэглээг 15 хувиар,
- Бага орлоготой, эмзэг бүлгийн хэрэглэгчдийн тарифыг нэмэгдүүлэхгүй. **/70 хувь/**

**23.** Дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Хөгжлийн банкнаас олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2012 оны 118 дугаар тогтоолоор “Үйлдвэржилтийн шинэ эрин үе”-ийг зарлав.

Засгийн газрын 2013 оны 126 дугаар тогтоолоор Чингис бондын санхүүжилтээс ноолуур боловсруулах салбарт 68.0 сая ам.доллар, 141 дүгээр тогтоолоор сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 27.7 сая, хүлэмжийн аж ахуй байгуулахад 17.4 сая, ноосны салбарт 45.0 сая, оёдлын салбарт 13.5 сая ам.долларын зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор тус тус шийдвэрлэн, нийт 108 төслийг санхүүжүүлэхээр Голомт банкинд хүргүүлснээс ноолуур боловсруулах 37 үйлдвэрт 65.8 тэрбум, ноос боловсруулах 12 үйлдвэрт 48.5 тэрбум, оёмол бүтээгдэхүүний 11 аж ахуйн нэгжид 2.2 тэрбум, сүүний 8 төсөлд 11.6 тэрбум, хүлэмжийн аж ахуйд 24.2 тэрбум, нийт 152.3 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Засгийн газрын 2013 оны 76 дугаар тогтоолоор төрийн өмчит “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор”-ын байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээнд 2013 онд шаардагдах 14.2 тэрбум төгрөгийг зохих журмын дагуу Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулав. “Легал Полиси” ХХК, “Тейлор Вессинг” түншлэлийн гүйцэтгэж буй хуулийн зөвлөх үйлчилгээний ажил 95%, “Флоур” компанийн гүйцэтгэж буй ерөнхий зөвлөх үйлчилгээний ажил 70%, “Натур Фрейндли” ХХК-ийн гүйцэтгэж буй байгаль орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажил 40%, “Говь трейвэл” ХХК-ийн гүйцэтгэж буй суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөөний ажил 40 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. **/70 хувь/**

**24.** Төсөв, санхүү, боловсон хүчний томилгоотой холбоотой орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах

**Биелэлт:** Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”, “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг тус тус батлан мөрдүүлж байна.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд орон нутгийн суурь төсвийг дээрх аргачлалын дагуу тооцоход орон нутгийн суурь төсвийн орлого 596.1 тэрбум, суурь зарлага 508.7 тэрбум төгрөгөөр тооцогдож, нийт 17 аймагт 152.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн

хэрэгжүүлэхэд улсын төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт 792.7 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд 247.6 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлгийг тус тус олгохоор батлагдсан. Эдгээр шилжүүлгүүдийн дүнд орон нутгийн төсвийн орлого 1,828.9 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 1,873.7 тэрбум төгрөгт хүрч, 2012 оны орон нутгийн төсөвтэй харьцуулахад 2.5 дахин тэлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, орлогын шилжүүлэг, орон нутгийн суурь төсвийг тооцох, санхүүгийн дэмжлэгийг олгох замаар орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж байна.

ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, тайлагнах, сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах болон ОНХС-аар хэрэгжүүлэх чиг үүргүүдийг нарийвчилж заасан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлан мөрдөж байна.

2015 онд батлагдсан төсвийн Орон нутгийн суурь орлого 757.6 тэрбум төгрөг, суурь зарлага 642.3 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан 201.9 тэрбум, орлогын шилжүүлэг буюу санхүүгийн дэмжлэг 160.3 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлэг 939.7 тэрбум төгрөг байхаар батлагдсан.

УИХ-ын чуулганы 2014 оны 12-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар батлагдсан 2014 оны төсвийн тодотголд орон нутгийн суурь орлого 710.1 тэрбум, суурь зарлага 563.8 тэрбум, санхүүгийн дэмжлэг 161.0 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлэг 900.2 тэрбум төгрөг байхаар тусгагдсан байна. **/70 хувь/**

**25.** Бусад улстай хийсэн давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох

**Биелэлт:** 2012 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр УИХ-аас Нидерландын Вант Улс, Люксембургийн Вант Улс, Кувейт Улс болон Арабын Нэгдсэн Эмират Улстай тус тус байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийг хүчингүй болгож, хууль гаргасан.

Монголын нөхцөл байдал болон олон улсын жишиг дээр үндэслэн сул ба давуу талуудыг үнэлж, Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан хэлэлцээрүүдийг сайжруулах зөвлөмж боловсруулсан. Үнэлгээ, шинжилгээ, зөвлөмжид тулгуурлан Монгол улсын давхар татварын загварыг холбогдох дүрэм журмын (харилцан тохиролцох журам, мэдээлэл солилцох, татвараас зугатах, зайлсхийх, орлогын суурь багасах, ашиг шилжүүлэх г.м.) хамт хянан боловсруулсан. Мөн давхар татварын гэрээтэй холбоотой бусад дүрэм, журмуудыг судалж, Сангийн сайдын 2014 оны 260 тоот Хэлэлцэн тохиролцох тухай журмыг батлав. **/90 хувь/**

**26.** Уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт, газрын тосны экспорт, үүрэн холбооны операторын үйлчилгээ, архи, спирт, тамхи зэргээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй аж ахуйн нэгжид төсөвт төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох

**Биелэлт:** Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн татварыг хялбаршуулж, хувь хэмжээг бууруулах зорилгоор жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум хүртэлх ААН-үүдийн төлсөн татварын 90 хувийг буцаан олгохоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д 2014 оны 1 сарын 24-нд өргөн барьсан.

Мөн жижиг дунд бизнес эрхлэгч ААН-үүдийн татварын харилцааг хөнгөвчлөх, тайлан тушаах ажлаас чөлөөлөх зорилгоор НӨАТ-ын босгыг 50 сая болгож нийт НӨАТ төлөгчийн 45 хувийг уг хариуцлагаас чөлөөлөхөөр НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барив.

Түүнчлэн УИХ-аар жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор импортоор оруулж ирж буй тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийг хэлэлцүүлж 2014 оны 6 сарын 6-ны өдөр батлуулав. **/60 хувь/**

**27.** Төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх аж ахуйн нэгжид нийт борлуулалтын гучаас доошгүй хувийг өөрийн үйл ажиллагааны орлогоос олдог байх шаардлага тавих

**Биелэлт:** Төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх аж ахуйн нэгжид нийт борлуулалтын 30-аас доошгүй хувийг өөрийн үйл ажиллагааны орлогоос олдог байх шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын үнэлгээнд харгалзан үзэж үнэлдэг болгохын тулд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулга буюу “Монгол Улсын Засгийн газраас Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болгон шинэчлэн найруулан Улсын Их Хуралд 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөр өргөн барьсан боловч Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн шинэчилсэн найруулгын төслийг буцаан татахаар шийдвэрлэсэн ба хуулийн төслийг дахин хянан үзээд 2015 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газарт дахин хэлэлцүүлэхээр тогтсон.

Хуулийн төсөлтэй уялдуулан холбогдох журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийг шинэчлэн батлах шаардлагатай тул хуулийн төслийг эцэслэн баталсны дараа дээрх ажлыг зохион байгуулахаар хүлээгдэж байна. **/50 хувь/**

**28.** Гадаадын төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтыг хянан зохицуулсан бодлого хэрэгжүүлэх

**Биелэлт:** Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаар Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль хүчингүй болсон.

Шинэ хуулиар уул уурхай, банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авахаар зохицууллаа. **/90 хувь/**

**29.** Хувийн хэвшилтэй хамтран бизнес форум тогтмол зохион байгуулж, тодорхой асуудлуудыг шийдвэрлэх

**Биелэлт:** 2013 оны 3 дугаар сард “Монголын эдийн засгийн форум”-ыг “Монгол брэнд” сэдвийн дор зохион байгуулав. Форумын үеэр “Эдийн засгийн орчин ба Монгол брэнд”, “Хөгжлийн санхүүжилт”, “Хөдөлмөрийн зах зээл ба ажиллах хүчний чадавхи”, “Хууль эрх зүйн орчин” зэрэг нэгдсэн хуралдаануудаас гадна “Монголын хүнсний бүтээгдэхүүн, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн, аялал жуулчлал Монгол брэнд болох нь” салбар хуралдаан боллоо.

“Хот байгуулалтын форум”-ыг “Төлөвлөлт ба хөгжил” сэдвийн дор, Монголын архитекторуудын эвлэл, НҮБ-ын Хүн амын нутагшилт, суурьшлын төсөл, БНСУ-ын “Самсунг Си энд Ти” компанитай хамтран 2013 оны 9 дүгээр сард амжилттай зохион байгууллаа.

Монголын Эдийн засгийн чуулган-2014”-ийг 3 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Засгийн газрын ордонд “Монголын Эдийн засгийн форум” ТББ-тай хамтран зохион байгууллаа. Нийт 35 салбар хуралдааныг тухайн салбарын мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулав. **/70 хувь/**

**30. Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх**

**Биелэлт:** Хөнгөн үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулав.

2013 онд оёдол, нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрүүдэд техник, технологийн шинэчлэл хийхэд зориулж Чингис бондын санхүүжилтээс ноолуур боловсруулах салбарт 68.0 сая, ноосны салбарт 45.0 сая, оёдлын салбарт 13.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор тус тус шийдвэрлэв.

Уг зээлд хамруулахаар ноосны 39, ноолуурын 68, оёдлын 32, нийт 139 төслийг санхүүжүүлэхээр Голомт банкинд хүргүүлснээс 2014 оны 11 сарын байдлаар ноолуур боловсруулах 40 үйлдвэрт 74.4 тэрбум, ноос боловсруулах 16 үйлдвэрт 44.2 тэрбум, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 14 аж ахуйн нэгжид 3.03 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Зээлийн үр дүнд ноос ноолуурын салбарын хүчин чадал самнах үйлдвэрлэл 2,4 хувь, ээрэх үйлдвэрлэл 20 хувь, сүлжих үйлдвэрлэл 22 хувиар тус тус өссөн байна.

2014 онд үйлдвэр компаниудын худалдаж авсан ноолуур нийтдээ 2600тн түүхий ноолуур бэлтгэснээс дээрх зээл авсан компаниуд нь 1350 тонн буюу 50%-ийг эзэлж байгаа болно. Эргэлтийн хөрөнгийн зээл авсанаар үйлдвэрлэлт, борлуулалт 35-40%-иар өссөн байна.

2014 онд улсад бэлтгэсэн ноосны 95%-ийг буюу 18400 тонныг үндэсний үйлдвэрүүд худалдан авч, 594,9 мянган м<sup>2</sup> хивс, 124,3 мянм эсгий, 16,3 мян.м тэмээний ноосон хөнжил, 8,0 мянган хос эсгий гутал үйлдвэрлэснээс гадна барилгын дулаалгын материал үйлдвэрлэлийн 3 аж ахуйн нэгж зээлд хамрагдаж 520 мян.м<sup>2</sup> хонины ноосон дулаалгын материал үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

“Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолоор оёдол, сүлжмэл, ноосны нийт 18 аж ахуйн нэгжид 23.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор нийт 108 аж ахуйн нэгжид 2632 ажилчин ажиллаж, оёмол хувцас 183.2 мянга, сүлжмэл майк, цамц 74.1 мянган ширхэгийг үйлдвэрлэн, 130.0 мянган ширхэг бүтээгдэхүүнийг борлуулаад байна. Сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэх үндэсний оёдол, сүлжмэлийн 19 тэргүүлэх үйлдвэр болон туслан гүйцэтгэгч 125 жижиг, дунд оёдлын үйлдвэрт, нийт 2171 хүн ажиллаж, ажлын байрыг 70 хувиар нэмэгдүүллээ. 2013-2014 онд нийт сурагчдын 90 гаруй хувийг дүрэмт хувцасаар хангалаа.

Эдгээр зээлийн үр дүнд 2012 онд 2005 оны зэрэгцүүлэх үнээр 82332.5 сая төгрөгийн нэхмэл, 7473.9 сая төгрөгийн оёмол, 12538.5 сая төгрөгийн арьс ширэн, 6942.3 сая төгрөгийн мод, цаасан бүтээгдэхүүнийг тус тус үйлдвэрлэн, 247.9 мянган м<sup>2</sup> хивс, 7282 м ноолууран нэхмэл, 3026.8 м тэмээний ноосон нэхмэл бүтээгдэхүүн экспортолсон.

2013 онд нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.0, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл 37.6 хувиар нэмэгдэж хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл боловсруулах аж үйлдвэрийн салбарт 17.6 хувийг эзэлж, нэхмэл бүтээгдэхүүний борлуулалт 30.6, оёмол бүтээгдэхүүний борлуулалт 63.1 хувиар нэмэгдэж, өмнөх оноос 24.0 хувиар өссөн нь хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалтад 15.4 хувийг эзлэх боллоо.

2014 оны 12 сарын байдлаар самнасан ноолуур 633.2 т, сүлжмэл эдлэл 954.4 мянган ширхэг, тэмээний ноосон хөнжил 18.5 мянган м, хивс 743.6 мянган м<sup>2</sup> тус тус үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос хивснээс бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.3-25.9 хувиар өссөн байна.

Борлуулсан бүтээгдэхүүний 42.6 хувийг экспорт эзэлж байна. Ажлын байрны тоо өмнөх оноос 11.4 хувиар өсч 10763-т хүрсэн байна.

Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2012 онд 14,083.8 сая төгрөгт хүрч өмнөх оноос 33.2 хувиар өссөн бөгөөд целлюлоз, цаас, картон, тэдгээрээр хийсэн зүйлийн импорт 6,257.9 мянган ам.доллар буюу 9.7 хувиар буурчээ.

Ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн модон түүхий эдийг ашиглан шахмал хавтан, шахмал түлш үйлдвэрлэх зорилгоор 4 аж ахуйн нэгжид 2,7 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймагт тус бүр 2 шахмал түлшний жижиг үйлдвэр байгуулагдав.

Монголын барилгачдын холбооны дэргэдэх хөдөлмөрийн хувийн бирж ажилд зуучлах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ эрхлэхээр эрхэлж байна. **/70 хувь/**

**31.** Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх

**Биелэлт:** “Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжүүлэх хугацаа 2015 онд дуусгавар болж буйтай холбогдуулан “Үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийг эцэслэн боловсруулсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр 2012 онд 12, 2013 онд 7, 2014 онд 8 төсөл хэрэгжүүлж байна.

Салбараар	Төслийн тоо			Санхүүжилт /сая төгрөг/		
	2012	2013	2014	2012	2013	2014
Мал аж ахуй	2	2	1	256.9	449.1	20.0
Мал эмнэлэг	2	2	3	487.7	326.3	400.0
Хүнс	3	-	1	357.3	-	200.0
Газар тариалан	2	3	3	251.7	1071.07	1.405.3
Хөнгөн үйлдвэр	3	-	-	341.2	-	-
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>1694.8</b>	<b>2346.4</b>	<b>2025.3</b>

Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр 2013 онд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр адууны цус, мах боловсруулах, хүнсний ногооны хангамжийн чиглэлээр Европ Холбоо болон Канад, БНХАУ, БНСУ зэрэг орнуудын өвлийн хүлэмжийн аж ахуйг судалж өөрийн орны онцлогт тохируулах, хүнсний ногооны гол нэр төрлийн үр үйлдвэрлэлийн судалгаа, туршилтыг хийж, үр үйлдвэрлэлийг дотооддоо шийдвэрлэх, газар тариалангийн салбарт таримлын сэлгээ, бордооны зохистой хэрэглээ зэрэг технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр ажиллаж байна. **/40 хувь/**

**32.** Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэмжиж иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах

**Биелэлт:** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав. Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан “Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх” журмыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор баталсан. **/50 хувь/**

**33.** Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан жижиг бизнесийг дэмжих

**Биелэлт:** Төрийн, хувийн хэвшил болон Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа II төсөл”, Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай “Зээлийн батлан даалтын сан байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг”-

ийг байгууллаа. Зээлийн батлан даалтын сан нь 2012 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдаж сангийн дүрмээ баталсан.

Зээлийн батлан даалтын сангаас 2012 онд тус санд 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс төвлөрүүлсэн ба нийт 61 төсөлд 4.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

2013 онд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 42 аж ахуйн нэгж, иргэний 9.1 тэрбум төгрөгийн зээлд 3.1 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргаад байна.

2014 онд нийт 137 төсөлд 9.0 тэрбум төгрөгний батлан даалт гаргасан. Үүний үр дүнд шинээр 387 ажлын байр, 1183 ажлын байр хадгалагдаж байна.

Нийт батлан даалтын 75 хувь буюу 42 нь Улаанбаатар хотод, 18.6 хувь буюу 14 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, иргэд байна. Батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан харилцагчдын 70 хувийг үйлдвэрлэл, 22.5 хувийг хөдөө аж ахуй, 7.84 хувийг худалдаа үйлчилгээ эрхлэгчид тус тус эзэлж байна. /70 хувь/

**34.** Хөдөө, аж ахуйн биржийн тухай хууль, Улсын Их Хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, Засгийн газраас баталсан “Хүнсний аюулгүй байдал”, “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоолоор хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулах үүрэг бүхий “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулж, 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр биржийн туршилтын арилжааг зохион байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/35 тоот тушаалаар биржээр арилжих “Бараа, түүхий эдийн жагсаалт, ангилалын код”, “Бараа түүхий эдийг коджуулах журам”, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 9 дүгээр тогтоолоор Биржийн бараа. Ямааны ноолуур MNS6375:2013, Биржийн бараа. Хонины ноос MNS 6375: 2013 стандартыг тус тус батлан мөрдүүлсэн. Стандартад ноолуурыг өнгө, чанараар нь 17, хонины ноосыг өнгө, төрлөөр нь 14 ангилахаар тусгагдсан болно.

ҮХАА-н сайдын 2013 оны А/135 дугаар тушаалаар биржээр арилжих барааны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хүнсний буудай болон тосны ургамал, малыг биржээр арилжих барааны жагсаалтад оруулан батлав.

Монгол Улсын баруун, төв, зүүн бүсийн 16 аймагт түүхий эд бүтээгдэхүүний агуулахыг сэргээн засварлаж, ажиллуулж байна.

2014 оны байдлаар ХАА-н биржийн арилжаанд Санхүүгийн Зохицуулах Хорооноос биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрөл авсан 33 компани, ХАА-н бирж дээр суудлын эрх авсан 29 брокерийн компани, 30 түр итгэмжлэгдсэн агуулах, итгэмжлэл агуулахтай 18 компани, 2 итгэмжлэгдсэн тээврийн байгууллага тус тус оролцож байна. Улаанбаатар хотын 14 компани, 16 аймгийн төв, зүүн 3 аймгийн 49 сум биржийн сүлжээнд холбогдон үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөө аж ахуйн биржийг байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд “Үндсэн сүлжээний өргөтгөл шинэчлэл” төслийг хэрэгжүүлж 290 гаруй сумыг шилэн кабелиар холбосон.

Хөдөө аж ахуйн Бирж ХХК 2014 оны 12 дугаар сарын 04-ний байдлаар 168 удаа арилжаа зохион байгуулж, 6754 тонн хонины ноос/12.2 тэрбум, 1018.2 тонн тэмээний ноос/5.2 тэрбум, 6080.7 тонн ноолуур/484.9 тэрбум, 12535 тонн тосны ургамал/9.9 тэрбум, 1233.1 тонн ямааны завод ноос/29.8 тэрбум, 24 тонн тэмээний завод ноос-60 сая төгрөгөөр, 878.3 тонн хонины завод ноос/1.08 тэрбум төгрөгөөр, 12 толгой хонь/1 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 543.3 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн.

Барилгын тухай болон Орон сууцны тухай хуулийн хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна.



“Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэж байна.

Барилгын материалын парк, бөөний худалдааны сүлжээг Улаанбаатар хотын баруун, зүүн талд байгуулах ажил газрын асуудлаас шалтгаалан хойшлоод байна.

Орон нутагт барилгын материалд ашиглаж болох түгээмэл тархацтай түүхий эдийн судалгааг гаргуулах, нөөцийн геологи хайгуул хийлгэхээр аймгийн Засаг дарга нарын саналыг авч байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох журмыг боловсруулж, санал авахаар мэргэжлийн холбоодод хүргүүлээд байна.

Аймгуудад байгуулах цогцолбор үйлдвэрийн байршлыг “Боловсруулах үйлдвэрийн байршил тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд тусган, аймгуудаас үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг хүлээн авч, мэргэжлийн зөвлөмж өгч ажиллаж байна.

Орон нутгаас ирүүлсэн төслийг судлан эхний ээлжийн шаардлага хангасан төслүүдэд Монголбанкны хөнгөлөлттэй зээл олгосноор Архангай аймагт “Гүнжийн даваа” ХХК 500.0 сая, Баян-Өлгий аймагт “Мадинэ” ХХК 400.0 сая, Ховд аймагт “Ховдын тулга” ХХК 200.0 сая, Дорнод аймагт “ТОУУ” ХХК 700.0 сая төгрөгийн зээл авч үйлдвэрээ байгуулж эхлээд байна.

2012 онд шинэчлэх орон сууцны 133 лифтээс Улаанбаатар хотод 124, Дархан хотод 9 лифтийг улсын комиссоор хүлээж авсан. 2014 онд онд улсын төсвийн хөрөнгө оруулалт 11 тэрбум төгрөгөөр 250 лифт шинэчилэхээс 134 лифтийг улсын комисс хүлээлгэн өгч, 116 лифтийг шинэчлэх ажил хийгдэж байна.

2012 - 2013 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 5.5 тэрбум төгрөгөөр 133 лифт, 2014 онд 847 сая төгрөгөөр 20 лифт нийт 6.347 сая төгрөгөөр 153 лифтийг шинэчилж улсын комисст хүлээлгэн өгч, 1.888 сая төгрөгөөр 31 лифтийг шинэчлэх ажил хийгдэж байна.

Нийслэлийн хэмжээнд 2012–2014 онд нийт 287 лифт шинэчилж, 147 лифтийг шинэчлэх ажил хийгдэж байна.

Улаанбаатар хотын төвийн хөдөлгөөний нягтрал ихтэй хэсгүүдэд газар доорх инженерийн шугам сүлжээг хонгилын системтэйгээр төлөвлөх үүднээс “УБЦТС” ТӨХК-аас эхний ээлжийн ажлын зураг, урьдчилсан тооцоог хийгээд байна. Хотын төвийн хэсгийн цахилгаан хангамжийг найдваржуулах үүднээс одоо байгаа 6 кВ-ын кабель шугамыг 10 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжүүлэх, хотын төвд газар доогуур 110/10 кВ-ын дэд станц барих талаар урьдчилсан тооцоо судалгааг хийсэн.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороонд байрлах УДДТ-2-ийн 205 метр инженерийн шугам сүлжээг хонгилын системд төлөвлөх шинэчлэлтийн ажлыг 2012 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

2013 онд нийслэлийн төсвийн 2.0 тэрбум төгрөгөөр Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт инженерийн шугам сүлжээг хонгилын системд төлөвлөх ажлын зураг төслийг “Инж байгууламж” ХХК боловсруулж, хүлээлгэн өгсөн. 2014 онд Яармагийн орон сууцны хорооллын цэвэр ус, дулааны гол шугамыг хонгилын системд барих бөгөөд зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тендер зарлан дүгнэж, ажлыг эхлүүлээд байна.

Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн санг хийж байгаа ба одоогоор 10 аймаг, нийслэлийн мэдээллийг оруулаад байна.

Орон сууц хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн төсвөөс 2012-2013 онд 10 тэрбум 975 сая төгрөгөөр Сүхбаатар дүүргийн 11-р хороонд 300 айлын түрээсийн орон сууцыг барьж ашиглалтанд оруулан НИТХ-ын тогтоолоор ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан түрээсийн орон сууцны зориулалтаар ашиглаж байна. Улаанбаатар хотод ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 180 айлын орон сууцны барилгыг барих газрын асуудлыг Нийслэлийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулаад байна.

Ерөнхий сайдын 2012 оны 62 дугаар захирамжаар "Орон сууцны шинэ хотхон, хорооллыг барих, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин

төлөвлөх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг" байгуулагдан ажиллаж байна. Улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон талаар мэргэжлийн хяналтын байгууллагын шийдвэр гаргуулах шаардлагатай орон сууцны 497 барилга ашиглагдаж байгаагийн 171 барилга нь орон нутагт, 326 барилга нь нийслэлд байна. Мөн дахин төлөвлөлт хийх шаардлагатай 27 буюу нийт 44 нийтийн орон сууцны барилгын нэрсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлаж, аюулгүй байдлыг хангуулахаар ажиллав.

2013 онд "Орчлон Констракшн" ХХК нь Ашиглалтын шаардлага хангахгүй болсон ХУД-ийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай 16 айлын Гутлын 28 дугаар байр, 42 айлын Арьс ширний 27 дугаар байрыг тус тус буулгаж 380 айлын орон сууцны "Эв-Эе-27", "Эв-Эе-28" хотхоныг барин ашиглалтанд оруулсан.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянгол, Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон нийтийн зориулалттай орон сууцны дахин барилгажуулах төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэгч компаниудыг сонгон шалгаруулав.

Монгол Улсын 2014-2016 оны дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд 20 аймгийн төвд агаарын чанарыг тодорхойлох 20 автомат станц байрлуулахаар тусгаад байна.

Агаарын бохирдол ихтэй томоохон хот, аймгийн төвд 5-аас доошгүй агаарын чанарыг тодорхойлох автомат станц байгуулахаар 2013 оны Үндсэн чиглэлд тусгасан боловч санхүүжилтийн асуудлыг шийдвэрлээгүй болно. Иймд 2013 оны төсвийн тодотгол, 2014 оны Цэвэр агаарын сангийн зардлаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх саналыг хүргүүлээд байна. Агаар дахь нарийн ширхэглэлт тоосонцор PM2.5/10-ын агууламжийг тасралтгүй хэмжиж бүртгэх автомат багажийг Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод тус бүр 1-ийг суурьлуулсан.

2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид тунгаагуур 2 ширхэг, био цөөрөм барих ажлын гүйцэтгэгчээр "Сайн констракшн" ХХК шалгаран ажиллаж байна. Төсөл 2014 онд үргэлжлэн хэрэгжинэ.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 6.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хийгдэх "Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах, шинээр барих ажлын зураг, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерт олон улсын гурван компани шалгарч, ажлын зураг төсвийг 2015 оны 6 дугаар сард эцэслэн хүлээн авахаар ажиллаж байна.

"Газар дэлхий" ХХК-ийн гаргасан "Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажил"-ын эцсийн тайланд экспертизийн дүгнэлт гаргуулах, орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.

2013 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар шинээр барихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу нийт зурагжуулах талбайн 35 хувьд агаарын зураг авах ажил, байр зүйн зураг зохиох ажлыг гүйцэтгээд байна. Нийт 162 цэг бүхий GPS-ийн сүлжээг байгуулж, бодолтын үр дүнг улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн.

1:25000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлын агаарын зураг авах ажлыг 53 хувьд гүйцэтгэж 2432 планшет ортофото зураг, 736 планшет 1:25000 масштабтай байр зүйн зургийг хүлээн аваад байна. **/60 хувь/**

**35.** Санхүүгийн секторын шинэтгэлийг бодит сектор, тухайлбал, уул уурхайн бус эдийн засгийн бусад салбар, жижиг, дунд бизнесийн өсөлтийг дэмжих, хувийн даатгалын ба хөрөнгө оруулалтын сангууд, хувийн тэтгэврийн сангийн болон зээлийн батлан даалтын тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр орчин үеийн санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгоход чиглүүлэх

**Биелэлт:** Санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудыг УИХ-аар батлуулсан бол Банк бус санхүүгийн

байгууллагын тухай, Өрийн удирдлагын тухай, Баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийг батлуулахаар ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмтой тэмцэх ажлын хүрээнд “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” болон “Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль”-д өөрчлөлт оруулах хуулийг УИХ-аар батлуулснаар манай улсыг мөнгө угаах, терроризмтой тэмцэх “Ази номхон далайн бүлэг”-ийн өндөржүүлсэн хяналтаас гаргаж энгийн хяналтанд шилжүүлэхээр боллоо.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хувийн болон хамтын сан нэр бүхий 12 төрлийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой болсон. Энэ харилцаатай холбоотой “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүрдүүлэх тухай журам”-ыг тус тус баталсан ба 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт 3 компанид хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоод байна.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, төгөлдөржүүлэх, хөгжүүлэх, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчлан сэргийлэх, түүнчлэн санхүүгийн тогтолцоог эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжиж чадах нөөц боломжтой болгох стратегийн хүрээнд төрөөс алсыг харсан санхүүгийн зах зээлийн хөгжлийн иж бүрэн бодлогыг бий болгохын тулд “Монгол улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын Хороонд хүргүүлэв.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах үзэл баримтлалын эхний төслийг боловсруулаад байна. Нийгмийн даатгалын шинэчлэлийг эрчимжүүлэх, ялангуяа тэтгэврийн шинэчлэл, хувийн тэтгэврийн нэмэлт тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Зээлийн батлан даалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл, бусад нөхцлийн журам, зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах зэрэг 6 журмыг батлав.

**/50 хувь/**

### **36. Олон улсын нэр хүндтэй банк орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх**

**Биелэлт:** Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг батлуулснаар олон улсын нэр хүндтэй банк орж ирэх эрх зүйн орчин бүрдсэн.

Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах V дахь үе шатны хэлэлцээг 2013 оны 12 дугаар сарын 16-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцээний хүрээнд үйлчилгээний худалдааны тухай хэлэлцээг хийж байна. **/50 хувь/**

**37. Нутаг дэвсгэрийн геологийн зураглал, эрэл, хайгуулын ажилд зарцуулж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлж, геомэдээллийн санг баяжуулах, эрдэс баялгийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг дэмжих**

**Биелэлт:** “Тандан судалгааны төв” байгуулах ТЭЗҮ боловруулах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээнд заагдсан радио давтамжийн зохицуулалт, сургалт, гэрээний ерөнхий загвар боловсруулах, газрын хяналтын болон нөөц станцуудын оновчтой газар орныг судалж сонгох зэрэг ажлууд графикийн дагуу хийгдэж байна.

Геологи судалгааны ажилд 2012 онд 4.0, 2013 онд 6.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан бол 2014 онд 10.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөөд байна.

Хөрөнгө оруулагчид 2012 онд 332.0 тэрбум төгрөгийг ашигт малтмалын геологи, хайгуулын ажилд зарцуулсан байна.

2014 онд Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 14 удаагийн хуралдаанаар хайгуулын ажлын 113 тайланг хэлэлцэн 14 төрлийн ашигт малтмалын нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгэлээ.

Монгол орны хэмжээнд өмнө хийгдсэн геологийн судалгааны материалуудыг нэгтгэн зохиох Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нутаг дэвсгэрийн 82 хувьд хийж гүйцэтгээд байна. Монгол орны бүс нутгийн металлогений 1:1000000-ны масштабын зураг зохиох, Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг 1:1000000-ын масштабын хэтийн төлөвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны объектыг тодруулах, Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын ерөнхий тархалтыг сансрын зураг ашиглан нэгдсэн боловсруулалт, тайлалт хийх ажлууд хийгдэж байна. /60 хувь/

**38.** Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 2016 онд нийт нутаг дэвсгэрийн 40 хувийг хамруулах

**Биелэлт:** "Бага оврын сансрын холбооны хиймэл дагуул" төслийн ТЭЗҮ-г "Падеко энд Эрсдак" ХХК хийж дууссан. Сансрын холбооны хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд хиймэл дагуулын үйлдвэрлэгч болон хөөргөгчийг сонгох санал боловсруулж, уг төслийн дагуу БНХАУ-ын Хятадын сансрын технологийн академи, Япон улсын Sky Perfect, Франц улсын Астриум, Европын холбооны Талес Алена Спейс компанийн ирүүлсэн саналуудыг нэгтгэн танилцуулга бэлтгэж Монгол Улсын хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар Сансрын үндэсний зөвлөлийн хүрээнд хэлэлцүүлж, зохих зөвлөмж гаргуулахаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.

2012 оны байдлаар 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд нийт нутаг дэвсгэрийн 29.7 хувь хамрагдсан бол 2013 онд шинээр 10 төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 онд 14 төсөл, 3 бүлэгчилсэн төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр ажлыг эхлүүлснээр нийт нутаг дэвсгэрийн **36 орчим** хувь хамрагдах боломжтой болно. /70 хувь/

**39.** Геологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах

**Биелэлт:** Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах асуудлыг тусгасан. /30 хувь/

**40.** Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох

**Биелэлт:** "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого" болон Түгээмэл ашигт малтмалын тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулсан бөгөөд эдгээр хууль, бодлогод ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх асуудал тусгагдан батлагдсан болно.

УИХ-ын 2014 оны 7-р сарын 1-ний өдрийн нэгдсэн чуулганаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан. Уг хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагтай Засгийн газраас баталсан хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах болсон. Ингэснээр

орон нутаг, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд зөрчил гарахааргүй байх эрх зүйн орчин бүрдсэн.

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг солбицлоор тогтоож Засгийн газрын 2014 оны 239 дүгээр тогтоолоор батлав.

Монгол орны зүүн болон өмнөд бүсийн нутагт экологийн үнэлгээ хийж, экологийн хувьд чухал ач холбогдол бүхий зайлшгүй хамгаалах шаардлагатай газар нутгийн хилийн заагийг тодорхойлов.

Геологийн хувьд нэгдмэл тогтоцтой ордод хэсэгчилж олгосон тусгай зөвшөөрлийн хэмжээнд нэгдсэн нөөцийг бүртгэх талаар хайгуул хийсэн хувийн хэвшлүүдтэй хэлцэл хийн ажиллаж эхлээд байна. Нэгдмэл тогтоцтой ордыг иж бүрнээр ашиглах болон Уул уурхайн салбарт ашиглагдаж байгаа байгаль орчинд ээлтэй техник, технологийг нэвтрүүлэх талаар “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичигт тусгасан.

Байгаль орчны аудит хийх эрх зүйн орчин, боловсон хүчний чадавхи, суурь нөөцийг бүрдүүлж, 2014 онд уул уурхайн олборлолт эрхэлж буй “Гацуурт” ХХК-ийн “Алтны шороон орд ашиглах”, Богд-Хан уулын ДЦГ-т газар ашиглан аялал жуулчлалын цогц үйл ажиллагаа явуулж буй “Скай ресорт” ХХК-ийн төслүүдэд туршилтын аудитыг мэргэжлийн байгуулллагуудаар гүйцэтгүүлж, туршилтын аудитын үр дүнгийн тайланг Ажлын хэсгээр хэлэлцэн хүлээн авлаа.

Мөн уул уурхайн олборлолт явуулж буй “Бороо гоулд”, “Таван толгой”, “Оюу толгой”, “Энержи ресорс”, “Эрдэнэт үйлдвэр”, “Эс Жи Эс” ХХК, “МоЭнКо” ХХК зэрэг томоохон 11 аж ахуйн нэгж байгаль орчны хуваарьт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэв.

Байгаль орчны аудит хийх аргачлал, эрх олгох журмын дагуу байгаль орчны аудит хийх мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан 2 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж, 28 мэргэшсэн “Байгаль орчны аудитор”-ыг бэлтгэв. Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр шинээр 3 стандартыг баталсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг батлаад байна.

2012 онд нийт 800 аж ахуйн нэгж, байгууллагын төсөлд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийж, 215 төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг, 2013 онд нийт 613 аж ахуйн нэгж, байгууллагын төсөлд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийж, 208 төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг, 2014 онд 450 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төсөлд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийж, 200 гаруй төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хянаж, шийдвэрлэсэн байна.

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичигт “эрдэс баялгийн болон ашигт малтмалын ордын нөөцийг үнэлэх олон улсын стандартад шилжих” гэж заасан. Уг заалтын дагуу Австрали, Канад зэрэг эрдэс баялаг ихтэй 8 орныг эгнээндээ нэгтгэсэн КРИПСКО олон улсын байгууллагад Монгол Улс 9 дэх гишүүн болж элсэн олон улсад мөрддөг стандартын дагуу Монгол мэргэжилтнүүд нөөц баялагаа тайлагнаж, олон улсын биржид хөрөнгө босгох боломжтой болсон.

Багануур, Шивээ-Овоо, Шарын гол, Адуунчулууны уурхайг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад оруулан батлууллаа.

Экспортод гаргаж байгаа төмрийн хүдрийг хуурай баяжмал, нойтон баяжмал болгон боловсруулалтын түвшинг дээшлүүлэх чиглэлээр ажлыг эхлүүлээд байна.

Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар экспортод гаргаж байгаа төмрийн хүдэрт

экспортын татвар ногдуулах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгын төслийг боловсруулав.

Уул уурхайн олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг болох асуудлыг “Төрөөс эрдэс баялагийн талаар баримтлах бодлого”, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгасан. **/70 хувь/**

**41.** Эрдэс баялгийн экспортыг нэгдсэн “Нэг цонх”-ны бодлогоор хэрэгжүүлэх

**Биелэлт:** Уул уурхайн сайдын 2013 оны 240 дүгээр тушаалаар экспортын нэг цонхны зарчмаар үйл ажиллагаа явуулах, эрдэс бүтээгдэхүүнд баримтлах жишиг үнийг тогтоож буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, санал дүгнэлтийн эхний хувилбарыг боловсруулсан бөгөөд стратегийн ач холбогдол бүхий ордын 10 хувьд ногдох хувьцааг дотоодын хөрөнгийн биржээр борлуулах асуудлыг судлаж байна. **/30 хувь/**

**42.** Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх

**Биелэлт:** УИХ-ын 2014 оны 7-р сарын 1-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 35.9-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжинд стандартын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээ бүхий Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид давуу эрх олгоно” гэсэн зохицуулалт орсон. **/90 хувь/**

**43.** Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг шинэчлэн, томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулахыг эрчимжүүлэх. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулж, Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу иргэдэд давуу эрхийн хувьцаа олгоно.

**Биелэлт:** Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад Хөшөөтийн чулуун нүүрс, Цайдам нуурын нүүрс, Гацууртын алт, Хотгор, Мушгиа худаг, Лугийн гол, Халзан бүргэдэйн газрын ховор металлын ордуудыг шинээр оруулах талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарсан.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод нийцүүлэн Гацуурт, Цайдамнуурын ордыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамааруулахаар дахин боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан.

2009-2013 онд нөөц нь тогтоогдсон Гурвансайхан, Дулаан уул, Хайрхан, Хараат, Өлзийт, Зөөвч овоо зэрэг ураны ордуудыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад оруулахаар ордуудын танилцуулга, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад байна.

Гурванбулаг ураны ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Эмээлт майнз” ХХК-иас боловсруулсан тус ордын боловсруулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд Шинжээчдийн ажлын хэсэг томилон ажиллуулж байна.

Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулах зорилтын хүрээнд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоолоор “Эрдэнэт” УБҮ-ийн Монголын талын хувь, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг “Эрдэнэс МГЛ” ХХК-д шилжүүлсэн.

Төрийн өмчит “Мон-Атом” ХХК болон “Арева Монгол” ХХК-ууд “Арева Майнз” ХХК байгуулахаар 2013 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” байгууллаа.

Бороо, Төмөртэйн овооны ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар яриа хэлэлцээ хийх, гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг хуулийн дагуу 34 хувийг төр эзэмшиж, хөрөнгө оруулалт 1,031 сая ам.долларын 34 хувь буюу 350,54 сая ам.долларыг төрөөс гаргахаар төсөл боловсруулж хэлэлцүүлсэн боловч төр хувь эзэмших шаардлагагүй гэж УИХ шийдвэрлэсэн.

Төрийн өмчит компаниудын судалгаа, олон улсын нэр хүнд бүхий төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа, тэдгээрийн онцлог, хөрөнгийн зах зээл болон бусад хэлбэрээр санхүүжилт босгох боломж, хөрөнгө оруулалтын сан байгуулах, төрийн өмчийн компанийн корпорацийн хэлбэрт оруулан ажиллах эрх зүйн орчинг боловсронгуй болгох зэрэг судалгааны материалыг цуглуулах, баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг хийж байна.

Засгийн газрын 2013 оны 347 дугаар тогтоолоор “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулж давуу эрхийн 3.0 сая ширхэг хувьцаа гаргах болсон бөгөөд бүртгэлийн ажил хийгдэж байна. Бүртгэлийн ажил дууссаны дараа ногдол ашиг тараах асуудал хөндөгдөнө. **/30 хувь/**

**44.** Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгох

**Биелэлт:** “Алттай хүдэр, элс олборлож баяжуулах, хүлээлцэх, хадгалах хамгаалах, тээвэрлэх, худалдах журам”-ын төслийг боловсруулсан.

Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх асуудлыг Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгаж УИХ-аар батлуулсан. **/100 хувь/**

**45.** Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах

**Биелэлт:** Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох газруудтай хамтран ажиллаж байна. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төр, засгаас бодлогоор дэмжиж, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” /2013-2025 он/ болон Ашигт малтмалын тухай хуульд тусгасан. **/70 хувь/**

**46.** Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачлага, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх

**Биелэлт:** Олборлох үйлдвэрлэл эрхлэгч 200 аж ахуйн нэгжийн 2012 оны тайлангийн нэгтгэлийг аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан.

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн барьлаа.

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага” зарчим болон шалгуурыг тус санаачлагын Ажлын албатай хамтран хэрэгжүүлж байна.

“Монголын уул уурхайн үндэсний ассоциаци”, “Хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ-тай хамтран уул уурхайн үйлдвэрлэлд хариуцлагатай уул уурхайн зарчим, стандартыг нэвтрүүлэх судалгаа хийж байна. **/50 хувь/**

**47.** Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгальд ээлтэй уул уурхайг хөгжүүлэх

**Биелэлт:** “Хилийн заагийг тогтоох тухай” Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор Монгол орны гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 109 нэгж талбайн 6958 цэгийн солбицлоор, ойн сан бүхий талбайн хилийн заагийг 31089 нэгж талбайн 1.7 сая цэгийн солбицлоор, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг 4460 нэгж талбайн 57313 цэгийн солбицлоор тогтоож, эдгээр хилийн зааг бүхий талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг бүрэн хориглосон.

Гэвч уг тогтоолоор баталсан хилийн зааг цэг, солбицлын алдаа ихтэй, кадастрын дүрс зургийн мэдээллийн санд оруулах боломжгүй байсан тул Монгол орны гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийн дахин тогтоох ажлыг гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор баталсан хилийн заагт хамаарах алтны шороон ордын ашиглалтын улмаас байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тусгай зөвшөөрөл тус бүрээр тооцож, энэ тооцоог аж ахуйн нэгжүүдээс нэхэмжилсэн нөхөх олговрын хэмжээтэй харьцуулсан судалгааг хийлээ.

Туул голын дагуух элс хайрганы орд, Налайхын уурхайн нүүрсний орд, Цагаан хадны гаалийн хяналтын талбай, Таян нуурын төмрийн хүдрийн ордоос Бургастайн боомт хүртэлх зам дагуу уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээ тогтоох, нөхөн сэргээх зардал тооцох ажлыг байгаль орчны үнэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаар хийлгэх ажлыг зохион байгуулж тайланг хүлээн аваад байна.

Ашигт малтмал хайх, олборлохыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт 2013 оны байдлаар ашигт малтмалын 422 лиценз давхцалтай байгааг тогтоосон. Үүнээс 239 ААН-ийн хохирлыг тооцон нөхөн сэргээлтийн зардлыг тооцоод байна. **/30 хувь/**

**48.** Байгалийн нөөцийн эдийн засгийн статистикийг шинэчилж, улсын эдийн засаг, санхүүд эрдэс баялгийн салбарын үзүүлж байгаа нөлөөллийн үзүүлэлтийг системтэй тооцоолох аргачлалыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох

**Биелэлт:** Байгаль орчны статистик үзүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллах санамж бичгийг 2014 оны 2 дугаар сард байгуулж, байгаль орчны статистик мэдээллийн БОХ 1-10 нийт 22 маягтыг шинэчлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 4 маягтын төслийг шинэчлэн боловсруулаад байна. **/30 хувь/**

**49.** Эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангахын тулд ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттай багасгах, түүнчлэн экспортолж байгаа бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг олон улсын стандартад нийцүүлэн шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтлах

**Биелэлт:** УИХ-аар 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар газрын тос, занар болон нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөхөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.

Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төслийн хүрээнд байгуулагдах Зэс, Төмөр, Коксын үйлдвэр, Дулааны цахилгаан станцын зориулалтаар импортоор оруулах



технологийн тоног төхөөрөмж, тусгай зориулалтын барилгын материалыг гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төслийн хүрээнд холбогдох судалгааг хийж байна.

2013 оны төсвийн тухай хуульд “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах” ТЭЗҮ боловсруулахад зориулан 1.4 тэрбум, “Зүүн бүсийн холимог металлын ордын түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах” ажлын судалгаанд 100.0 сая төгрөгийн хөрөнгийг тусгасан ч сонгон шалгаруулалтын шаардлага хангасан санал ирээгүй тул “Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолоор гэрээ байгуулагдаагүй ажлуудыг зогсоох тухай шийдвэрлэн дээрх ажлыг санхүүжүүлэхгүй болсон.

Нүүрсний ангилал MNS 6456:2014, Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2014 Монгол Улсын стандартуудыг Стандартчиллын үндэсний зөвлөл баталж, 2014 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар болон бусад холбогдох байгууллагын төлөөллөөс багтсан ажлын хэсгээс боловсруулсан “MNS 6249:2013 Төмрийн хүдэр, түүний баяжмал болон металлургид хэрэглэх төмрийн хүдэр, түүний баяжмалд тавих ерөнхий шаардлага ба ангилал” болон “MNS ISO 11323 : 2013 Төмрийн хүдэр, баяжмал ба боловсруулсан шууд ангижруулсан төмөр-Тайлбар толь” стандартын төслийг боловсруулсан.

Түүхийгээр гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний судалгааг гаргаж Гаалийн тарифын болон Гаалийн татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шилдэг технологийг дэмжих санал боловсруулсан.

Зэсийн баяжмалыг боловсруулан цэвэр зэс үйлдвэрлэх технологийн сонголтыг хийж, Австралийн TSL технологийг сонгосон. Урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Эрдэнэт үйлдвэр”-ийн хүч хөрөнгөөр хийж байна. Мөн “Монгол зэс” хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. **/40 хувь/**

**50.** Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор үйлдвэр барих

**Биелэлт:** Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордын цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Ерөөгийн хүдрийн уурхайн цахилгаан хангамжийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Ерөө дэд станцын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж дуусган техникийн комисс ажиллалаа.

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг өргөтгөн, Дархан-Сэлэнгийн бүсийн Төмөртолгой, Төмөртэй, Баянгол, Хуст-Уулын төмрийн ордуудыг түшиглэн 2010-2015 онуудад “Уул уурхай-хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлж байна.

Дархан хотод байгуулах төмөрлөгийн цогцолборын ТЭЗҮ-ийг боловсруулах ажилд шаардагдах 1.6 сая ам.долларыг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж байна. ТЭЗҮ-ийг боловсруулах I шатны ажлын тайланг хүлээн авч, II шатны ажлыг эхлүүлсэн.

“Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” Засгийн Газрын 2014 оны 69 дугаар тогтоолоор Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг концессын гэрээний хугацаанд “Кью Эс Си” ХХК-д олгохоор шийдвэрлэв. 2015 онд үйлдвэрлэлийг өргөтгөн хар төмөрлөгийн цогцолбор байгуулахаар “Кью Эс Си” ХХК-тай хамтран ажиллаж, одоогоор 81,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна. Тус үйлдвэр Төмөртолгой, Төмөртэй, Хуст уулын төмрийн хүдрийн ордуудаа түшиглэн шинээр уурхай нээх, үйлдвэрлэлээ өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээд байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших Төмөртэй төмрийн хүдрийн ордыг түшиглүүлэн жилд 1 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай нойтон баяжуулах үйлдвэрийг барьж Улсын комисст хүлээлгэн өгөөд байна.

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг шинэчилж төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр барих, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, Дарханы төмөрлөгийн гангийн үйлдвэрт хийгдэх өргөтгөлийн ажлуудад шаардлагатай хөрс, ус, геофизик болон гидрогеологийн судалгааны төсөл хэрэгжиж байна.

II шатны ажлын хүрээнд “Дархан Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордуудын төлөөлөх дээжээр төмрийн хүдрийн нойтон баяжмал үйлдвэрлэн туршилтад илгээх компанийг сонгон шалгаруулах” болон “Төмрийн хүдрийн нойтон баяжмалаар аргалж, хорголж үйлдвэрлэх хагас үйлдвэрлэлийн туршилт хийх компанийг сонгон шалгаруулах” ажлын техникийн даалгаврыг баталж “Монгол ган” нэгдэл, БНХАУ-ын Бээжин Шоуганг компаниудтай гэрээ байгуулан, ажлыг эхлүүлээд байна. **/70 хувь/**

**51.** Гадаадын шууд хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах, уул, уурхай, эрчим хүч, газрын тосны салбарт өмнө нь байгуулсан тогтвортой байдлын, хөрөнгө оруулалтын, бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдэд өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох өөрчлөлтүүдийг хөрөнгө оруулагч талтай харилцан тохиролцож хийх

**Биелэлт:** Хөрөнгө оруулалтын тухай шинэ хуулиар гадаадын хөрөнгө оруулагчтай хийх тогтвортой байдлын гэрээний зохицуулалтыг өөрчилсөн болно.

Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахтай холбогдуулан гарсан Улсын Их Хурлын шийдвэрүүд, тус төслийн хэрэгжилтийн явцад гарч байгаа зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах талаар хөрөнгө оруулагч талтай өмнө нь хийсэн яриа хэлэлцээг үргэлжлүүлэх үүрэг бүхий Засгийн газрын Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Оюутолгойн уулын баяжуулах үйлдвэрийг Улсын комисс хүлээж авсан.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын УИХ-ын 2014 оны 7-р сарын 01-ний өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан. Уг хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно гэж заасан. Үүний дагуу Газрын тосны газар гэрээлэгчтэй хэлэлцээр хийж байна. Бусад гэрээнүүдийн хувьд үндсэн заалтуудыг гэрээнд зааснаар хэвээр үлдээхээр тусгасан.

Нарийн сухайтын нүүрс, Төмөртэйн овооны хар тугалга, цайрын ордын Тогтвортой байдлын гэрээ хүчинтэй үргэлжилж байгаа бол Бороогийн алтны ордыг ашиглаж байгаа “Бороо гоулд” ХХК-ийн тогтвортой байдлын гэрээний хугацаа энэ онд дууссан. Гэрээний хугацаанд Засгийн газраас тус компанид 68.9 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлсэн байна. Одоогоор ордын ашиглах боломжтой нөөцийн үлдэгдэл 4.03 тн бөгөөд “Бороо гоулд” ХХК татварын ямар нэг хөнгөлөлтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Төмөртэйн овооны хар тугалга, цайрын ордыг ашиглаж байгаа “Цайрт минерал” ХХК-ийн Засгийн газартай байгуулсан Тогтвортой байдлын гэрээний хугацаа гэрээний заалтын дагуу 2 жилээр сунгагдсан. **/70 хувь/**

**52.** Тавантолгойн орд газрыг төрийн мэдэлд байлгах. Тус орд газрыг ашиглах зорилгоор олборлох үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компанийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар байгуулан ажиллуулна. Улмаар Тавантолгойн орд газрыг түшиглэн дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцааг худалдах ажлыг Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу зохион байгуулна.

**Биелэлт:** “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 409 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа худалдаж авсан аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг үндэслэн тэдний худалдаж авсан хувьцааг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон эргүүлэн хүлээн авч, төлсөн төлбөрийг буцаан олгохоор шийдвэрлэсэн.

Энэ тогтоолын дагуу аж ахуйн нэгжүүдийн төлбөрийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан буцаан олгоод байна.

Ерөнхий сайдын 2014 оны 135 дугаар захирамжаар “Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, нээлттэй уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан этгээдтэй хэлэлцээ хийж, холбогдох гэрээ байгуулах” үүрэг бүхий ажлын хэсэг уралдаант шалгаруулалтад шалгарсан “Чайна Шэнхуа Энержи”, “Сумитомо корпораци” болон “Энержи Ресурс” ХХК-ийн түншлэлтэй хэлэлцээ хийж байна. /40 хувь/

### 53. Тусгай зөвшөөрлийн арилжаанд ил тод байдлыг бүрдүүлэх

**Биелэлт:** Тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх ажлын хэсэг 54 байгууллагын хүрээнд үйлчилж байгаа 914 тусгай зөвшөөрөл нэг бүрийг хэлэлцэн 404 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 447 тусгай зөвшөөрлийг хэвээр үлдээхээр тогтож, Зөвшөөрлийн тухай, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслүүдийг шинээр боловсруулан УИХ-д өргөн барив. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд шилжүүлэх” төслийн танилцуулга боловсруулсан. /50 хувь/

54. Байгаль орчинд ээлтэй, шилдэг техник, технологийг уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, эвдрэлд орсон талбайн тооллого хийж буруутай этгээдээр нөхөн сэргээлгэж, цаашид нөхөн сэргээлтийн зардлыг улсын төсвийн тусгай санд байршуулдаг болгох

**Биелэлт:** “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг баталж, нөхөн сэргээлтийн хөрөнгийг урьдчилан байршуулах ажлыг зохион байгуулж байна.

Ашигт малтмалын олборлолт явуулах үед байгаль орчныг хамгаалах болон олборлолт явуулсны дараа байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Байгаль хамгаалах санд төвлөрүүлж байна.

Байгаль орчны бохирдол, доройтол, байгалийн нөөцийн ашиглалтад тавих хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын тогтоолоор баталж, 2013 онд хяналт шалгалтыг өмнөх жилтэй харьцуулахад 20 хувиар бууруулж төлөвлөн, үйл ажиллагааныхаа 40 хувьд хяналт шалгалт, 60 хувьд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөлтийг хийж, зөвхөн хяналт шалгалтаар бус зөвлөн туслах үйлчилгээ, салбарын сургалт, байгууллагын сургалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, бууруулах талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх шинэ арга хэлбэрийг нэвтрүүлэн ажиллалаа.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн мэдээллийн санг суурилуулах, хүлээн авах ажлыг зохион байгуулж “Нөхт жео” ХХК-ийн боловсруулсан программ хангамжийг байршуулав.

Налайх, Толгойт, Дөвөнтийн уурхайн ашигласан талбайд судалгаа хийж, нөхөн сэргээлт хийх шаардлагатай талбайн хэмжээ, байршлыг тодорхойлон холбогдох чиглэлээр ажиллаж байна. БНСУ-ын “Мерико” компанитай байгуулсан санамж бичгийн дагуу тус компани уул уурхайн компаниудын өмнө нь ашиглаж байгаад орхигдсон талбайнуудыг нөхөн сэргээх ажлыг эхлүүлээд байна.

2014 оны 6 дугаар сарын 5-ны байдлаар ашигт малтмалын 2844 тусгай зөвшөөрөл эзэмшигч 12432618,41 га талбайд үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 7,9 хувийг эзэлж байна. Үүнээс ашиглалтын 1329 тусгай зөвшөөрөл бүхий 981404,44 га, хайгуулын 1515 тусгай зөвшөөрөл бүхий 11451213,97 га талбай байгаа бөгөөд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нь 320 гаруй аж ахуйн нэгж байгууллага байна.

2014 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд уул уурхайн хайгуул олборлолтын үйл ажиллагааны улмаас 24637.1 га талбай эвдрэлд орж үүнээс үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн эвдрэлд оруулсан талбай 19895,1 га,

техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай нь 10263,1 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 6781,5 га байна. /60 хувь/

**55.** Уул уурхайн салбарын түүхий эдэд нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэн хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, экспортолж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор хөхиүлэн дэмжих

**Биелэлт:** УИХ-аар 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.

Мөн Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт баригдах үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлүүлэхээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, нэмэлт судалгааг хийж байна.

Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөгдөх жагсаалт батлах тухай Засгийн Газрын 2014 оны 191 тоот тогтоолд Төмөрлөг, металл боловсруулах үйлдвэр, Биохийн үйлдвэр, Хийн түлшний үйлдвэр зэргийг хамруулан батлуулав.

Хөрөнгө оруулагчдын олборлож байгаа ашигт малтмалыг дотоодын үйлдвэрт эхний ээлжинд нийлүүлэх тухай асуудлыг Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд тусгасан. Мөн Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн дагуу боловсруулсан журмын төсөлд “уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах” тухай тусгахаар ажиллаж байна. /40 хувь/

## 1. Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого

**56.** Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн анхны паркийг Дорноговь аймгийн Сайншанд хотод байгуулах

**Биелэлт:** Төрийн өмчийн хорооны 2012 оны 495 дугаар тогтоолоор “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор” Төрийн өмчит ХХК-ийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээ.

2013 онд улсын төсвийн 9.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын “Газрын доорх усны нарийвчилсан хайгуул”-ын ажлыг “Тунгалаг ус” ХХК гүйцэтгэж Сайн-Ус, Бор хөөвөр дэх газар доорх усны нөөц нь 291 л/сек гэсэн дүгнэлтийг, Бүс нутгийн хооронд ус тээвэрлэх боломжийн судалгаа ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах ажлыг “Монхидроконстракшн” ХХК гүйцэтгэж газар доорх усны таамаг нөөц 200 литр/сек ус, гадаргын урсацын боломжит нөөц 2500 литр/сек гэсэн дүгнэлтийг тус тус гаргасан байна. Мөн Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын Суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийх ажлыг “Гоби Трэйвэл” ХХК, Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг “Натур Фрейндли” ХХК гүйцэтгэж тайланг хүлээлгэн өгөх шатанд байна.

Хөгжлийн банкны 14.2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтээр “САҮЦ-ын байгаль орчны нарийвчилсан үнэлгээ”, “САҮЦ-ын хуулийн зөвлөх сонгох”, “САҮЦ төслийн ерөнхий гүйцэтгэгч зөвлөх компанийг сонгох”, “Суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах” ажлуудыг сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлж байна.

“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын инженер геологийн судалгаа явуулах ажлын гүйцэтгэгчээр “Сойл трейд” ХХК-ийг шалгаруулан, гэрээ байгуулах ажлыг түр түдгэлзүүлээд байна.

Эрчим хүчний дэд станц барьж байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах нээлттэй тендер шалгаруулалт 3 удаа зарласан боловч шаардлага хангасан нэг ч санал ирүүлээгүй тул гүйцэтгэгч шалгараагүй болно.

БНХАУ-ын “Синохидро” компани САҮЦ-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад оролцож, дэд бүтцийн ТЭЗҮ хийх сонирхлоо илэрхийлсэн бөгөөд 2014 оны 1 дүгээр сард хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

Сайншандын аж үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулахад шаардлагатай Чойр дэд станцын өргөтгөлийг Концессын хуулийн дагуу хэрэгжүүлэхээр шийдвэрлэн гүйцэтгэгчээр “Баялаг арал” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулсан. Чойр 220/110; 35/10/6 кВ-ын дэд станцын өргөтгөлийн ажлыг “Түлхүүр гардуулах” нөхцлөөр уралдаант шалгаруулалтыг зарлаж БНХАУ-ын Sanbian Sci-tech ХХК хамгийн өндөр оноо авч шалгараад байна. Гэрээний хэлэлцээр хийх бэлтгэл ажил хийгдэж байна.

“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын цахилгаан хангамжийг Багануурын нүүрсний ордыг түшиглэн 700 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих замаар шийдвэрлэхээр цахилгаан станцыг барих ТЭЗҮ-ийг Эрчим хүчний хөгжлийн төв боловсруулж байна. /30 хувь/

**57.** Дархан хотын төмөрлөгийн үйлдвэрийг шинэчилж, хүдэр баяжуулдаг болох

**Биелэлт:** Төмөртэйн төмрийн хүдрийн уурхайд цагт 750 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай хуурай соронзон баяжуулах үйлдвэрийг 2014 оны 7-р сард ашиглалтанд оруулсан. Төмөртэйн уурхайгаас Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн түүхий эд татан авах зорилгоор 34,5 км төмөр замын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгчээр дотоодын байгууллагууд ажиллаж байна. Төмөртэйн ордыг цахилгаан эрчим хүчээр хангах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөө дэд станцын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэж төмөртэйн уурхай руу цахилгаан дамжуулах агаарын шугам татсан.

Төмөртолгойн төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн хамт байгуулан, бүрэн хүчин чадлаар ашиглалтад оруулсан. Хоногийн нийт хүчин чадал 5000,0 тн, баяжмалын гарц 65-70%, металл авалт 82%, баяжмал дахь төмрийн агуулга 56-62% байна.

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд жилд 1 сая тонн төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн барилгын ажил бүрэн дуусч, тоног төхөөрөмжийн угсралтын ажил 90 хувьтай байна. Үйлдвэрийн цэвэр, бохир усны шугам татах ажлыг эхлүүлсэн.

Хуст Уулын төмрийн хүдрийн уурхайн ТЭЗҮ боловсруулсан бөгөөд орон нутгийн засаг захиргаанаас газрын зөвшөөрөл авах ажил хойшлогдож, 2013 оны 4 сард ордын ашиглах газрын зөвшөөрлийг Дарханы Төмөрлөгийн үйлдвэрт олгосон. /80 хувь/

**58.** “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгах

**Биелэлт:** Чөлөөт бүсүүдийн хөгжлийн төслийн харилцан уялдааг хангах, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнгийн байдалд дүгнэлт өгөх Ажлын хэсэг байгуулагдаж, дүгнэлт гаргасан. Үүний дагуу “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, “Цагааннуур” ХЧБ, “Замын-Үүд” ЭЗЧБ-ийн ерөнхий төлөвлөгөөг УИХ-аар батлуулахаар ажиллаж байна.

“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс одоогоор 110/35/6 кВ-ын “Сүхбаатар” дэд станцаас 21.4 км 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар тэжээгдэж байна. “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн төслөөр хүчин чадал нэмэгдэх тул Сүхбаатар дэд станцаас тэжээгдэх 110 кВ-ын ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ-ийг хийж баталсан.

Баруун бүсийн болон Алтай-Улиастайн эрчим хүчний системийн горимын тооцоог хийж байна. Тооцооны дүнгээс "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийн цахилгаан хангамжийг шийдэх боломж тодорхой болно.

"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн дулааны станцын ТЭЗҮ, бүсийн доторх автозамын зураг төсвийн ажил, бохирын шугам хоолойн барилга угсралтын ажлууд хийгдэж байгаа бөгөөд дараах гүйцэтгэлтэй явагдаж байна. Үүнд:

1. Дулааны станцын ТЭЗҮ /бүсийн болон сумын доторхи дулаан хангамжийн шугам, дулааны станцын зураг төсөл боловсруулах ажил/ Гүйцэтгэл - 90%
  2. Сүхбаатар-Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолой, өргөлтийн насосны станцын ажил /ЦДАШ: 18,9 км Тулгуур: 198ш Трансформатор хүчин чадал: 100 кВа-10ш, 50кВа-2ш Нийт хүчин чадал: 1100кВа/
    - а/ Шугам хоолойн ажил – 90%
    - б/ Өргөлтийн насосны станцын ажил-10%
    - в/ Цахилгаан дамжуулах агаарын шугам-100%Гүйцэтгэл - 66.6%
  3. Гааль, худалдааны зам талбайн ажлыг дуусгаж, Улсын комисс 2014 оны 10 дугаар сарын 2-нд хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэл - 100%
  4. Үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг хийж гүйцэтгэн Улсын комисс 2013 оны 12 дугаар сарын 23-нд хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэл - 100%
- "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийг 2014 оны 6 дугаар сарын 22-нд нээж, үйл ажиллагааг нь эхлүүлэв.

"Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах" төслийн хүрээнд:

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр /нийт өртөг 58.8 сая ам.доллар/ санхүүжүүлж байгаа бөгөөд 4 багц ажил хийгдэж 2015 онд Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Үүнд: /Нийт гүйцэтгэл 92.5%/

1. Дулаан хангамж /90MW, Замын-Үүд суманд 7 ш дулаан дамжуулах төв, 7.6 км шугам хоолой, Чөлөөт бүсэд 5 ш дулаан дамжуулах төв 13 км шугам хоолой/ Гүйцэтгэл - 90%
2. Усан хангамж, ариутгах татуургын байгууламж /Өдөрт 3000м<sup>3</sup> ус боловсруулах хүчин чадалтай ус цэвэршүүлэх үйлдвэр, цэвэр усны гүний 3 худаг, УДШ-1, 2 ,3 болон гэр хорооллын шугам хоолой, 3200м<sup>3</sup> хүчин чадалтай бохирын цэвэрлэх байгууламж, бохирын шахалтын насос станц 4 ширхэг, бохир болон саарал усны холболтын шугам хоолой/ Гүйцэтгэл - 100%
3. Цахилгаан хангамж /Замын-Үүдийн 110кВ-ын трансформаторын дэд станцын өргөтгөл, Чөлөөт бүсэд 110 кВ-ын трансформаторын дэд станц, хуваарилах ТП болон 16 ширхэг 10/0.4кВ-ын дэд өртөө, 10 кВ-ын кабель шугам 30 км, 110кВ-ын агаарын шугам 3 км, 10 кВ-ын агаарын шугам 17 км/ Гүйцэтгэл - 100%
4. Авто зам, холбоо /Чөлөөт бүсэд 13.5 км автозам гэрэлтүүлэг, холбоо мэдээллийн сувагчлалын ажил/ Гүйцэтгэл - 80%

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд 2013 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах ажуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Замын-Үүд сум, "Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсэд цаашид шаардагдах цэвэр усны эх үүсвэрийн хайгуул судалгааны ажил хийгдэж, БОНХЯ-ны усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж нөөцийг баталгаажуулсан. Гүйцэтгэл - 100%
2. "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн 2-р ээлжийн дэд бүтцийн байгууламжийн ажлын зураг, төслийг боловсруулах ажил дахь Багц-2 авто зам, борооны ус зайлуулах шугам, холбоо мэдээллийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэл - 100%
3. "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн 2-р ээлжийн дэд бүтцийн байгууламжийн ажлын зураг, төслийг боловсруулах ажил дахь Багц-1 Дулаан хангамж, цахилгаан хангамж, Усан хангамж, Ариутгах татуургын зураг төсөл боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэл - 100%
4. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн шалган нэвтрүүлэх байгууламжид 150 тоннын хүчин чадалтай хэмжилтийн пүү байрлуулах ажил бүрэн дууссан. Улсын комисст 2013 оны 11 дүгээр сарын 8-нд хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэл - 100%

59. “Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг барьж байгуулах

**Биелэлт:** Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад “Чойр”, “Багахангай” ложистик төвийн эхний ээлжийн дэд бүтцийг барьж байгуулах төсөл ороогүй. /0 хувь/

60. Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, манлайлалтай боловсруулан хэрэгжүүлэх. Уул уурхайн салбарын экспортын орлогын тодорхой хэсгээс уул уурхайн бус экспортын хөгжлийн сан байгуулах

**Биелэлт:** “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийг “Экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 239 дүгээр тогтоолоор батлан, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж байна. Хөтөлбөрийн хүрээнд байгуулагдах “МонЭкс” болон “Бүтээн байгуулалт лизинг” ТӨХК-ийн дүрмийн төслийг боловсруулав.

Хөтөлбөрийн хүрээнд Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахаар хэлэлцээ хийж, 2014 оны 7 дугаар сард зарчмын тохиролцоонд хүрсэн болно. Монгол Улс Европын Холбооны тогтвортой хөгжил, сайн засаглалыг дэмжих тарифын хөнгөлөлтөд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хамрагдаж эхэллээ. ЕХ-ны хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдсанаар манай улсын 7200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн Европын зах зээлд ирэх 10 жилийн хугацаанд тарифын хөнгөлөлт эдэлнэ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгыг бэлтгэн, хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусган боловсруулав. /30 хувь/

61. Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын механизмыг ашиглан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах асуудлыг шийдвэрлэх

**Биелэлт:** Хүнсний улаанбуудайн импортын гаалийн албан татварын хувь хэмжээг уян хатан байлгах асуудлыг судалж, “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төсөл, үзэл баримтлалыг боловсруулан 2011 онд УИХ-д өргөн мэдүүлсэн.

УИХ-ын тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцүүлэх саналыг 2013 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 01/447 дугаар албан бичгээр УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Гурил, хүнсний ногооны гаалийн албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх талаар судалж байна. /30 хувь/

62. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах

**Биелэлт:** “Хөтөлийн цемент шохой” ХК-ийн үйлдвэрийн өргөтгөлд зориулан “Бэйзмент” ХХК-д Хөгжлийн банкнаас 5 жилийн хугацаатай 8.8 хувийн хүүтэй 60.0 сая ам.долларын зээл олгосон. Мөн бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 20.0 тэрбум төгрөгийн зээлийг 5.5 хувийн хүүтэй олгосон. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн өргөтгөлийн ажил дуусаж жилийн хүчин чадал 1.0 сая тонноор нэмэгдсэн.

Хөтөлийн цементийн үйлдвэр 2013 онд 130.0 мянган тонн цемент үйлдвэрлэжээ.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дахь Хөх цавын шохойн чулууны ордод түшиглэн жилд 130.0 мянган тонн шохой, 2.0 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий Цемент-шохойн үйлдвэрийн цогцолборын төслийг “Монголын алт” ХХК хэрэгжүүлж байна. Цементийн үйлдвэрт шаардагдах түүхий эдийн судалгаа, шинжилгээний ажлууд бүрэн хийгдэж, үйлдвэрийн барилгын ажил 82 хувьтай байна.

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн түүхий эдийн шугамыг нэмэгдүүлэх, үйлдвэрийг өргөтгөх төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

“Бэрэн групп” ХХК-ийн Орхон аймагт арматур боловсруулах үйлдвэр байгуулах төслийг бондын зээлээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. “Бэрэн групп” ХХК Японы “Марубени” корпорацитай хамтран ажиллахаар гарын үсэг зурснаар шинэ үйлдвэр барих ажил эхлээд байна.

“Төмөрлөгийн үйлдвэрийг дэмжих тухай” Засгийн газрын 2013 оны 256 дугаар тогтоолоор 50.0 сая хүртэл ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Монгол Металл Майнинг” ХХК, “Мон-Лаа” ХХК, “Монголросцветмет” ХК-ийн нойтон аргаар баяжуулах үйлдвэр болон “Бэрэнгрупп” ХХК-ийн арматурын үйлдвэрт олгох шийдвэр гарсан.

Засгийн газрын 2014 оны 164 дүгээр тогтоолоор “Монполимет” ХХК-ийн цементийн үйлдвэрийн төсөлд 65 сая доллар, Баян-Өлгий аймгийн “Даваат” ББН, “Эрчим” ХХК-иудын цементийн төсөлд 4.7 сая долларын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн.

Монголбанкнаас “Ногоон газар” ХХК-ийн полистрол бетон хавтан, блокны үйлдвэр, “Арга барил” ХХК-ийн хөнгөн дүүргэгчтэй блокны үйлдвэр байгуулахад 730.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. **/60 хувь/**

**63.** Сэргээгдэх эрчим хүчний бодлогыг татварын орчноор хөхиүлэн дэмжиж гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцөлийг бүрдүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор сэргээгдэх эрчим хүчний импортын техник, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлсөн шийдвэр гаргуулан мөрдөж байсан бол “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2013 оны 303 дугаар тогтоолоор байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмж импортолсон аж ахуйн нэгжийг Аж аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэлээ.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах” ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. “Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний хууль, эрх зүйн орчин, хөгжлийн бодлогын шинэчилсэн загвар боловсруулах судалгааны ажил”-ыг боловсруулж дуусгав.

Монгол улсын нар, салхины эрчим хүчний нөөцийн цахим атлас бэлэн болсон бөгөөд түүнийг <http://globalatlas.irena.org/> цахим хаягаар орж татаж авч танилцаж боломжтой болсон.

Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд 2014 оноос Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорноговь аймгийн Улаан-Уул, Өмнөговь аймгийн Ханбогд, Дундговь аймгийн Мандалговь гэсэн 4 газарт салхины нөөцийг тодорхойлох нарийвчилсан судалгааг хийж эхэлнэ.

Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийн санхүүжилтээр 5 цэгт нарны цахилгаан станц байгуулах нарийвчилсан судалгааг хийж байна. Үүнд: Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Дундговь аймгийн Мандалговь, Говь-Алтай аймгийн Тайшир, Ховд аймгийн Дөргөн сумдад нарны цахилгаан станц болон нарны дулааны цахилгаан станц барих талаархи судалгааг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв хийж байна.



“Шүрэнгийн усан цахилгаан станц” төслийн техникийн зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороог шинэчлэн байгуулж, Дэлхийн банкны төслийн хүрээнд эхний ээлжинд ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай урьдчилсан судалгааны ажлыг хийж байна. Дараагийн шатанд хийгдэх УЦС-ын ТЭЗҮ, байгаль орчны эрсдэлийн үнэлгээг ОХУ-ын холбогдох байгууллагуудаар хийлгэх тухай саналаа 2013 оны 7 дугаар сард Оросын талд хүргүүлсэн.

Монгол орны нөхцөлд тохирсон нарны дулааны цахилгаан станц байгуулах боломжийн талаар ТЭЗҮ боловсруулах тендерт “Мон энержи консалтинг” ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Нарны цацрагийн хэмжилтийн станцыг Өмнөговь, Дорноговь, Архангай, Хэнтий аймгуудын төвд суурилуулан судалгааны ажлыг хийж байна. Судалгааны дүнг үндэслэн дээрх дөрвөн байршлаас Дорноговь аймгийн Сайншанд сумыг сонгон нарны станцын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахыг зөвлөсний дагуу гүйцэтгэгч компани нарны дулааны цахилгаан станц барих судалгааны ажил болон Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих станцын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, салбарын ШУТЗ-ийн 2014.10.15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн шийдвэр гараад байна. /50 хувь/

**64.** Эдийн засгийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний суурь дэд бүтцийг бий болгох зорилгоор ДЦС-5-ыг барьж, ДЦС-4-ийг 100 МВт-р өргөтгөх

**Биелэлт:** Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Дулааны V станц төсөл”-ийн концессийн гэрээг “Фифт Комбайнд Хийт энд Пауэр Планта” ХХК-тай барих-ашиглах-шилжүүлэх нөхцлөөр байгуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт зөвшөөрсний дагуу 2014 оны 6 дугаар сарын 20-ны өдөр дээрх гэрээг байгуулав. Дагалдах 6 төрлийн гэрээний төслийг бэлтгэж байна. Эрчим хүчний сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд инженерийн шугам сүлжээнүүдийн асуудлуудыг шийдвэрлэх уулзалтыг 2014 онд 3 удаа, хэсэгчилсэн уулзалтыг 5 удаа хийж концесс эзэмшигчидтэй хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар ДЦС-5-ыг барьж байгуулах түншлэлтэй концессын гэрээний хэлцэл явагдаж байна. ДЦС-5-ыг Сонгино 220/110/35 дэд станцтай холбох 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцын ТЭЗҮ-ийг боловсруулж, шугамын зураг төсөв, дулаан дамжуулах магистрал шугамын өргөтгөлийн ажлыг хийж байна.

ДЦС-4-ийн 100 МВт-ын өргөтгөлийн барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж дуусган ажлыг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авсан. Нийт ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Төслийн санхүүжилт 63 сая ам.доллар буюу 93 хувьтай байна. /50 хувь/

**65.** Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн 60-100 МВт-ын дунд чадлын цахилгаан станц барих

**Биелэлт:** Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн дунд чадлын дулааны цахилгаан станц барих тойм мэдээллийн судалгаа хийгдсэн. Нүүрст хотгорын уурхайг түшиглэн дулааны цахилгаан станц барих ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг Эрчим хүчний хөгжлийн төв гүйцэтгэж, 2014 оны 3 дугаар сарын 21-нд Баруун бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн ДЦС барих ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яамны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн шийдвэр гарсан. Тус станцыг барих асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхээр бэлтгэл хангаж байна. /30 хувь/

**66.** Улаанбаатар хотын цахилгаан, дулааныг дамжуулах дэд бүтцийг шинэчлэх

**Биелэлт:** “Амгалан” дулааны станцыг барьж байгуулах газрын 70 хувийг чөлөөлснөөр барилгын бүтээн босголтын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлөөр 2013

оны 8 дугаар сард эхлүүлсэн. 2014 оны гүйцэтгэлээр Амгалан дулааны станцын үндсэн барилга, тоног төхөөрөмжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 92 хувьтай. Цэвэр ус хангамж, бохир ус зайлуулах шугам сүлжээний хөрөнгө оруулалтыг Хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан бөгөөд 2015 оны 7 дугаар сарын 30-ны дотор багтаан графикт ажлаа гүйцэтгэхээр ажиллаж байна.

Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын туршилт тохируулгын ажлууд хийгдэж байна. Газар чөлөөлүүлэх ажил болон цэвэр ус хангамж, бохир ус зайлуулах шугам сүлжээний санхүүжилт хасагдсанаас БУА графикт хугацаанаас хоцорч, он дамжин хэрэгжихээр болсон. Дулааны станцын эхний ээлжийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгөхөөр урьдчилсан байдлаар төлөвлөж байна.

“Дэд бүтэц эрчим хүч” төслийн 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 10а магистралын өргөтгөлийн ажил багтсан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажлаа эхлүүлсэн. Барилга угсралтын ажил бүрэн дууссан бөгөөд улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан.

“Их тойрог 110 кВ шугам” хөтөлбөрийн хүрээнд улсын төсөв болон Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын 4 нь 2014 онд бүрэн дуусаж техникийн комисс хүлээж авсан бол үлдсэн 6 ажил 70-80 хувийн гүйцэтгэлтэй 2015 онд хүлээлгэн өгнө.

2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 26 дэд станц барьж, 0.4-10 кВ-ын 162.94 км шугам татаж, 68.819 км кабель шугамын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын 7 дүүргийн 5891 айл өрхийн хүчдэлийн уналтыг сайжруулах, цахилгаан хангамжийг найдвартай болгох зорилгоор 355,5 км 0,4 кВ-ын ЦДШ, 6-10 кВ-ын км 30,4 ЦДАШ, 3,0 км кабель шугам, 66 дэд станцыг барьж байгуулахаар нийт 16 багц, хотын төвийн 28 байрлалд 6, 10кВ-ын 24,3 км кабель шугамын нийт 9 багцад гэрээ байгуулсан. Нийт 16 багцын 12 багцын ажил бүрэн дуусч техникийн болон улсын комисс ажилласан. 4 багцын БУА-ын явц 80-90 хувьтай байна. **/70 хувь/**

#### **67. Дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлогч улс болох**

**Биелэлт:** Улс орныг эрчим хүчээр хангах, экспортлох чадавхийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын бичгийг боловсруулж байгаа ба эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бие даасан эх үүсвэр барьж байгуулахтай холбогдсон зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна.

АХБ-ны техникийн туслалцаагаар хэрэгжсэн Монгол Улсын “Эрчим хүчний салбарын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх төсөл”-ийн дунд шатны тайланг хүлээн авч хэлэлцэв.

Эрчим хүчний салбарын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2013 оны 11 дүгээр сард албан ёсоор хүлээн авч, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн “Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газрын 2013 оны 317 тоот тогтоолоор батлагдсан Концессийн зүйлийн жагсаалтанд Дорнодын дулааны цахилгаан станцын өргөтгөл төсөл арга хэмжээ шууд гэрээ байгуулахаар тусгагдсаны дагуу сонирхсон төслийн мэдээллийг 2014 онд 13 компанид хүргүүлж 6 компани саналаа ирүүлсэн. Гэрээний хэлэлцээрт орох оролцогч богино жагсаалтын нэгдүгээрт эрэмбэлэгдсэн “Альфа Ассет Менежмент” ХХК-ийн холбогдох хүмүүстэй ЭХЯ болон ЭЗХЯ-ны хамтарсан ажлын хэсэг гэрээний хэлэлцээрийн өмнөх уулзалтыг зохион байгуулж холбогдох мэдээ, мэдээлэл, шаардлагатай бусад материалыг өгөн ажиллаж байна. Гэрээний хэлэлцээр хийх бэлтгэл ажил хийгдэж байна.

Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих ажилд Чингис бондоос 50.0 сая ам.доллар зарцуулах тухай асуудлаар "Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2013 оны 71 дүгээр тогтоол гарч, төлөвлөсөн ажил графикийн дагуу явагдаж байна. Японы Марубени корпораци, Японы Кансай Электрик, "GDF Suez" ба Солонгосын "Posco Energy"-ийн хамтарсан консерциум, мөн Солонгосын "Daewoo E&C" компани, консорциумд 2014 оны 6 дугаар сард төслийн нөхцөл шаардлага, холбогдох харилцаануудыг зохицуулах гэрээ, мөн ус, газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлүүд бүхий Арилжааны даалгаврыг боловсруулан хүргүүлсэн. Оролцогчид саналаа 2015 оны 2 дугаар сард ирүүлэх ёстой.

2014 онд Концессийн зүйлийн жагсаалтанд орсон "Багануурын цахилгаан станц" уралдаант шалгаруулалтыг зарлаж шаардлага хангасан санал ирүүлсэн БНХАУ-ын Цөмийн эрчим хүчний корпораци /China Nuclear Industry and Construction Co.,Ltd/-тай концессийн гэрээний хэлцэл эхлүүлэхээр гэрээний төсөл дээр ажиллаж байна. Ажлын хэсэг 2015 оны 1 дүгээр сард багтаан хэлэлцээрийг дуусгаж Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.

ХБНГУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Дарханы ДЦС-д турбогенератор шинээр суурилуулах төслийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байсан ОХУ-ын АСЕН компани туслан гүйцэтгэгчид төлбөрөө шилжүүлээгүйтэй холбоотойгоор тухайн ажлын туслан гүйцэтгэгчдийн ажлын явц графикаас удааширсан. Уг асуудлыг Эрчим хүчний яам, Дарханы дулааны цахилгаан станцын зүгээс анхааран ажиллаж ХБНГУ-ын Сэргээн босголтын банк, ОХУ-ын Интерпром банк, АСЕН компанитай удаа дараалан уулзалт зохион байгуулсан, албан бичгээр харилцан ажиллаж байна. Үүний үр дүнд АСЕН компаниас эхний ээлжийн тоног төхөөрөмжүүдийг 2015 оны 1 дүгээр сард нийлүүлэх тухайгаа мэдэгдээд байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий гүйцэтгэгч - АСЭН компани, төслийн зөвлөх - GOPA Intec компаниудад зээлээс 8290683.43 евро буюу төслийн зээлийн (10.5 сая евро) 78.96 хувийг төлсөн байна. Дотоодын хөрөнгө оруулалтаас нийт 3 тэрбум буюу төлөвлөсөн хөрөнгө (5 тэрбум)-ний 60 хувийг ашигласан байна. 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдөр гэрээний хугацаа дууссан. Төслийн ажил графикаас хоцрогдолтой, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орох боломжгүй байна.

Германы сэргээн босголтын банкнаас Эрдэнэтийн цахилгаан станцын тоног төхөөрөмжийг сэргээн сайжруулах, өргөтгөх ажлын зөвлөхийн сонгон шалгаруулалтыг зарласан ба 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдөр материалыг хүлээн авч, техникийн саналыг үнэлж байна.

ДЦС-3-ын 9 дүгээр зуухыг сэргээн босгох ажил дуусч техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэж, улсын комиссийн бэлтгэл хангах ажил үргэлжилж байна.

Монголбанкнаас Эрчим хүчний салбарын компаниудад олгож буй хөнгөлөлттэй зээлээс Багануур, Шивээ-Овоогийн уурхайн өргөтгөл шинэчлэлийн ажилд зориулан 18.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг гаргахаар болсон.

Дэлхийн банкны төслийн нэгжээс Багануурын нүүрсний уурхайн өргөтгөлийн ТЭЗҮ боловсруулах, нүүрсний ордод геологийн нэмэлт хайгуул хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгчээр Монголын Эрдгео, Канадын Норвест компанийн консерциум шалгарч, гэрээний дагуу 2014 оны 9-11-р сард 14168 тууш метр өрөмдлөг хийхээс 14466,3 тууш метр өрөмдлөгийн ажлыг богино хугацаанд чанартай хийж, хээрийн ажлаа дуусгаж суурин боловсруулалтын ажилдаа ороод байна. Хайгуулын тайланг 2015 оны 2 дугаар улиралд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

УБ-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барих талаар урьдчилсан судалгаа хийгдсэн. ХБНГУ-ын KfW банкны санхүүжилтээр Японы Хитачи компанийн алдагдал багатай утсаар УБ-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих техникийн сонголтын судалгааны ажлыг гүйцэтгэх зөвлөхийг шалгаруулах тендер зарласан бөгөөд тендер үнэлгээний шатандаа явж байна.

50 МВт-ын хүчин чадалтай "Салхит" салхин цахилгаан станцыг 2013 оны 7 дугаар сарын 8-нд ашиглалтад хүлээн авч төвийн эрчим хүчний системд холбосон.

Багануур-Өндөрхаан-Чойбалсангийн 220 кВ цахилгаан дамжуулах шугам, дэд станцыг барих ажлын зураг, төсвийг хийж байна. /30 хувь/

## 2. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого

**68.** Ноолуурын салбарын зээлийн санг 300 тэрбум, арьс ширний салбарын зээлийн санг 300 тэрбум, ноосны салбарын зээлийн санг 50 тэрбум, махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг 100 тэрбум төгрөгт хүргэх

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны “Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай” 126 дугаар тогтоолоор ноолуурын салбарт техник технологийн шинэчлэл хийхэд Чингис бондоос 68.0 сая ам.долларын, “Эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 125 дугаар тогтоолоор ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгөд Монголбанкны хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн.

Голомт банкнаас ноолуур боловсруулах 37 үйлдвэрт 65.8 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Засгийн газрын 2014 оны “Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 87 дугаар тогтоолоор ноолуур боловсруулах үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн зээлийг Монгол банкны эх үүсвэрээр олгох шийдвэр гаргасны дагуу 2014 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 22 үйлдвэрийн хүсэлтийг арилжааны банкуудад хүргүүлснээс 8 үйлдвэрт 39.0 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гарч, үйлдвэрүүдтэй бодлогын гэрээг байгуулж, 4 үйлдвэрт 24.0 тэрбум төгрөгийн зээлийг түүхий ноолуур барьцаалан олгоод байна. Энэ зээлд хамрагдаж байгаа үйлдвэрүүд нийтдээ 38.8 тэрбум төгрөгийн 541 тонн ноолуур худалдан аваад байна.

“Монгол ноосон даавуу” төслийн санхүүжилтэд Засгийн газрын 2013 оны 141 дугаар тогтоолоор Чингис хаан бондоос 45.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Уг зээлд хамруулахаар ноосны 39 төслийг дэмжин Голомт банкинд хүргүүлснээс 12 үйлдвэрт 48.5 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2013 оны махны хэрэгцээнд зориулан 87.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 11.4 мянган тн нөөцийн мах бэлтгэж, зээлийг хуваарийн дагуу 100 хувь буцаан төвлөрүүлсэн. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2014 оны хэрэгцээнд зориулан “Нөөцийн махны менежер” 4 аж ахуйн нэгжид 77.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 14.5 мян.тн нөөцийн мах бэлтгэж, зээлийг хуваарийн дагуу Монголбанкинд буцаан төвлөрүүлээд байна. Мөн 2015 оны хаврын улирлын нөөцийн мах бэлтгэлд зориулж шалгарсан 6 компанид 50.0 гаруй тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгож нөөцийн мах бэлтгүүлэхээр МХЕГ, ОБЕГ-уудтай хамтран дөрвөлсөн гэрээг байгуулаад байна.

Улаанбаатар хотын жилийн нийт махны хэрэгцээний 15.4 хувийг 2013 онд нөөцийн махаар бүрдүүлсэн бол 2014, 2015 онд 16.2 хувийг бүрдүүлж байна. Энэ хугацаанд махны жижиглэн худалдаалах үнийн хэлбэлзэл (жилийн дундаж өсөлтөөр тооцов) 2013 онд өмнөх 3 жилийн дунджаас 2.3 дахин бага байсан бол 2014 онд өмнөх оныхоос 2.3 дахин бага, хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнөх 3 жилийн дунджаас 5.1 дахин бага байна.

“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолын дагуу арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгоход зориулж 140.4 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн. /70 хувь/

**69.** Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг боловсруулж, зах зээлд нийлүүлдэг болох

**Биелэлт:** Ноос, ноолууран бүтээгдэхүүний олон улсын чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулах ажлын хүрээнд 2012 онд улсын төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмжийг худалдан авч Нэхмэлийн хүрээлэнд суурилуулсан.

2013 оны улсын төсөвт дахин 250.0 сая төгрөгийг лабораторийн тоног төхөөрөмж худалдан авахад зориулан тусгагдсаны дагуу тендерийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй тул санхүүжилт хураагдсан.

Боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос тушаасан малчдад урамшуулал олгоход зориулан 2012 онд улсын төсөвт 30.0 тэрбум төгрөг тусган 21 аймгийн 332 сум, нийслэлийн 6 дүүргийн 103.2 мянган малчин, мал бүхий этгээдийн үндэсний 154 үйлдвэрт тушаасан 14.7 мянган тонн хонь, тэмээний ноосны урамшуулалд 29.4 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг Хүний хөгжил сангаар дамжуулан олгосон байна.

2013 оны улсын төсөвт ноосны урамшуулалд 25.0 тэрбум төгрөгийг тусган 189 үндэсний үйлдвэрт тушаасан 117400 малчны 18400 тонн хонь, тэмээний ноосны урамшуулалд 36.0 тэрбум төгрөгийг олголоо.

Улсын хэмжээнд 2012 онд нийт бэлтгэсэн ноосны 82.5 хувь, 2013 онд 92 хувийг үндэсний үйлдвэрт нийлүүлсэн байна. 2014 онд ноосны урамшуулалд мөнгө тусгагдаагүй. Урамшууллын үр дүнд улсын хэмжээнд малчин өрхийн ноосноос олох орлого дунджаар 289.2 мянган төгрөгөөр нэмэгдэн үндэсний үйлдвэрүүдийн хэвийн ажиллагаа хангагдаж, хонины ноосоор үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний нэр төрөл олширч байна.

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 235 дугаар тогтоолын хүрээнд 2012 онд орон нутагт түүхий эд бэлтгэлийн загвар хоршоодыг бий болгохоор 20 аймгийн 20 хоршоонд нийт 900.0 сая, 11 аймагт Түүхий эд бэлтгэлийн төв бий болгох зорилгоор 14 аж ахуйн нэгжид 1.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн.

“Сум” төслийн хүрээнд сум бүрт Арьс ширний анхан шатны тордолтын цехийг мал нядалгааны цэгүүдийг түшиглэн байгуулах зураг төсвийг зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлж, хүлээн авсан.

Аймаг, бүсүүдэд байгуулах арьс ширэн эдлэлийн үйлдвэрийн урьдчилсан судалгааг хийж, Засгийн газрын үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төслүүдийг шалгаруулаад байна. **/40 хувь/**

**70.** Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын гадна байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжих

**Биелэлт:** “Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 249 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх явцад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа арьс шир боловсруулах үйлдвэрүүд болон Дархан-Уул аймгийн иргэд Арьс ширний үйлдвэрлэлийн цогцолборыг Дархан-Уул аймагт байгуулах асуудлыг дэмжихгүй байсан тул уг асуудлыг Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 10 дугаар тэмдэглэл гарган, байршлыг орон нутгийн саналыг харгалзан сонгон шалгаруулж, дэд бүтэц байгуулах ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Арьс ширний үйлдвэрийн цогцолборыг байгуулахад Улаанбаатар хотын Багануур дүүрэг газрын байршил, төлөв байдал, дэд бүтцийн хувьд тохиромжтой гэж сонгогдсон тул усны нөөцийн судалгаа хийж байна.

Цөмийн технологи ашиглан хаягдал усыг цэвэршүүлэх, ариутгах, аж үйлдвэр, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, агаарын бохирдлыг бууруулах, цацрагийн аюулгүй байдлын хяналтын асуудлын хүрээнд цөмийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэхээр Нийслэлийн Засаг дарга болон Цөмийн энергийн газар хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулж, ажлын төлөвлөгөөг батлав. **/30 хувь/**

### 3. Уламжлалт мал аж ахуй, мах, сүүний чиглэлээр хэрэгжүүлэх бодлого

71. Малын индексжүүлсэн даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг бүртгэж даатгах

**Биелэлт:** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг УИХ-ын 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн чуулганаар нийт 7 бүлэг 27 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд уг хуульд заасны дагуу давхар даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан малыг олон улсын давхар даатгагчид даатгуулахаар шийдвэр гаргасан тохиолдолд малыг давхар даатгуулах тухай зохицуулалт орсон. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 360 дугаар тогтоолоор “Давхар даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” баталсан. Засгийн газрын 2014 оны 280 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгалын компани байгуулагдсан.

Малын эрсдэлийн даатгалыг 2013 оны эхний хагас жилийн байдлаар “Бодь”, “Монгол даатгал”, “Монре”, “Тэнгэр”, “Практикал”, “МИГ”, “Номин” зэрэг даатгалын компаниудаар дамжуулан бүх аймагт сайн дурын хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Малын индексжүүлсэн даатгал нь үндэсний хэмжээнд буюу манай улсын бүх аймаг сумдад хэрэгжиж эхлээд даруй 2 жил болж байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт малчин өрхийн 14.5 орчим хувь энэхүү даатгалд хамрагдаад байна.

*170 хувь!*

72. Хангайн бүсийн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлэх

**Биелэлт:** “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах зорилгоор “Мах, мах-сүүний чиглэлийн үхрийн, махны чиглэлийн хонь, гахай, тахианы цогцолбор аж ахуйг шинээр байгуулах, өргөжүүлэх” төслийн сонгон шалгаруулалтыг явуулж, 160 иргэн, аж ахуйн нэгжийн төслийг хүлээн авч, төслийн үр ашгийн тооцоо, эрсдэлийн үнэлгээг хийж, төслийн ач холбогдол, зах зээлд шинэ мах нийлүүлэх хүчин чадал, төсөл хэрэгжүүлэх боломж зэрэг шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн эхний ээлжинд 43 аж ахуйн нэгжид 46.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.

Үүнээс: “Өехийн хутаг” ХХК, “Аз нь арвин групп” ХХК-ууд Булган аймгийн нутагт махны чиглэлийн үхрийн цогцолбор аж ахуй байгуулахаар бэлтгэлээ ханган ажиллаж байна. Монголбанкны 2014 оны мэдээгээр Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 24 аж ахуйн нэгжид 38.1 тэрбум төгрөгийн зээл олгосноос махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэж буй 14 аж ахуйн нэгжид 24.7 тэрбум төгрөгийн зээл олгов. Төслийн үр дүнд махны чиглэлийн үхрийн фермийн аж ахуй 32, цэвэр, эрлийз үхрийн тоо 11300 толгойгоор нэмэгдэж байна.

#### Махны чиглэлээр өсгөн үржүүлж буй үхрийн тоо

Бүс	2013 он		2014 он	
	Аж ахуйн тоо	Үхрийн тоо	Аж ахуйн тоо	Үхрийн тоо
<b>НИЙТ</b>	<b>508</b>	<b>14789</b>	<b>351</b>	<b>12705</b>
Баруун	12	287	26	1189
Хангайн	363	5926	180	3698
Төвийн	120	6732	89	6239
Зүүн	12	1742	53	1315
УБ	1	102	3	264

*Эх сурвалж: МААБХЗГ*

Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 2012 онд сүүний үхрийн 25 аж ахуйн нэгжид 400.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай олгосон. Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд сүүний 70 үнээтэй цогцолборыг улсын төсвийн хөрөнгөөр бий болгов.

Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор Булган, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Архангай аймаг, Улаанбаатар хотын сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 74 аж ахуйд 1.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэв.

Хот суурин газрын хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, мах, сүү үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд сүү-махны чиглэлийн Монтбелиард үүлдрийн 242 үхрийг импортлон авчирч нутагшуулан Төв аймгийн Архуст, Баянчандмань, Цагааннуур, Өвөрхангай аймгийн Тарагт сумдад үржүүлж байна. Өндөр ашиг шимт сүүний үхэр импортоор худалдан авч нутагшуулснаар үхрийн сүүний хангамж 1.8 сая литр, ямааны сүүний хангамж 202.0 мянган литрээр нэмэгдэх боломж бүрдлээ.

Нийслэлийн хүн амын сүүний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Баянчандмань милк” ХХК 50, “Нүүдэлчин групп” ХХК 160, бүгд 210 толгой “Монбиллиард” үүлдрийн үхрийг Францаас импортоор авч, нутагшуулан үржүүлж байна.

Хүн ам олноор төвлөрсөн хот суурин газрын хүн амыг шингэн сүүгээр хангаж импортын сүүг тэглэх зорилгоор 27.7 сая ам.долларыг Голомт банкинд байршуулж, 2013 оны 12 дугаар сарын байдлаар сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 7 аж ахуйн нэгжид 6.6 тэрбум төгрөгийн зээл олгов.

“Стратегийн хүнсний биотехнологийн үйлдвэрлэл, хөгжлийн загвар бүс” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Мөнх-Агит” ХХК-ийн боловсруулсан “Сүүний чиглэлийн загвар аж ахуй байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлж 2013 оны эхний шатны санхүүжилтэд 50.0 сая төгрөг олгосон.

### Сүүний чиглэлээр өсгөн үржүүлж буй үхрийн тоо

Бүс	2013 он		2014 он	
	Аж ахуйн тоо	Үхрийн тоо	Аж ахуйн тоо	Үхрийн тоо
<b>НИЙТ</b>	<b>912</b>	<b>37518</b>	<b>1554</b>	<b>59799</b>
Баруун	108	1957	89	1744
Хангайн	124	2421	576	6702
Төвийн	424	20464	512	22041
Зүүн	84	5743	129	11394
УБ	172	6933	248	17918

Эх сурвалж: МААБХЗГ

Мах-сүүний хонины аж ахуй эрхлэх иргэн, аж ахуй нэгжийн тоо 2013 онд 10259, түүнд өсгөн үржүүлж байгаа хонины тоо 1558.4 мянган толгойд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд иргэн, аж ахуйн тоо 43 дахин, хонины тоо 6 дахин нэмэгдсэн байна.

Бүс	2012 он		2013 он		2013/2012 (-;+)	
	Фермерийн тоо	Хонины тоо	Фермерийн тоо	Хонины тоо	Фермерийн тоо	Хонины тоо
Баруун	37	19447	8431	119197 2	8394,0	1172525, 0
Хангайн	45	57594	453	130296	408,0	72702,0
Төвийн	30	80691	1365	233903	1335,0	153212,0
Зүүн	117	96078	10	2275	-107,0	-93803,0
<b>Дүн</b>	<b>229</b>	<b>25381 0</b>	<b>10259</b>	<b>155844 6</b>	<b>10030,0</b>	<b>1304636, 0</b>

Улсын төсвөөс “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2009 оноос 2012 онд нийт 7189.1 сая төгрөгийг зарцуулсан бол 2013 онд 2170.5 сая төгрөгийг төсөвлөн зарцуулжээ.

№	Чиглэл	2011	2012	2013	2014*
<b>Бүгд</b>		<b>1650</b>	<b>1706</b>	<b>13943</b>	<b>3438</b>
1	Сүүний үхрийн ферм	901	977	912	1554
2	Махны үхрийн ферм	64	78	88	351
3	Мах, ноосны хонины ферм	200	229	10259	236
4	Гахайн ферм	187	181	314	476
5	Тахиан ферм	217	152	319	405
6	Зөгийн ферм	81	89	35	382
7	Мах, сүүний үхрийн ферм	-	-	420	-
8	Сүүний чиглэлийн ямааны ферм	-	-	898	4
9	Туулайн ферм	-	-	698	30

2014\*- урьдчилсан байдлаар

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2013, ҮСХ

Тариалангийн гол бүс нутаг болох Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Булган аймагт дэмжлэг үзүүлснээр 2013 онд сүүний үхрийн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж 10.9 хувиар буурсан ч тэдгээрт өсгөн үржүүлж байгаа сүүний үхрийн тоо 29.8 хувиар, мах-сүүний үхрийн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн тоо 2 дахин, түүнд өсгөн үржүүлж буй мах-сүүний үхрийн тоо 41.8 хувиар өссөн байна.

Аймаг	Сүүний үхэр				Мах-сүүний үхэр			
	2012		2013		2012		2013	
	Аж ахуйн тоо	Малын тоо	Аж ахуйн тоо	Малын тоо	Аж ахуйн тоо	Малын тоо	Аж ахуйн тоо	Малын тоо
Булган	35	1135	25	979	6	576	25	1225
Дархан-Уул	27	2042	10	582	10	423	38	2343
Сэлэнгэ	99	2281	80	6283	10	3545	10	3032
Төв	224	10250	228	12550	15	710	15	850
Дүн	385	15708	343	20394	41	5254	88	7450

Тэжээл үйлдвэрлэлийн хангамжийг сайжруулах зорилгоор 2013 онд 2-3 тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай хүчит тэжээлийн 17 үйлдвэрийг 400.0, ногоон тэжээлийн 15 үйлдвэрийг 500.0, өвс хуйлж боох 45 техникийг 500.0, нийт 1400.0 сая төгрөгийн худалдан авах ажлыг зохион байгуулан, иргэн аж ахуй нэгжид олгох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Сэлэнгэ, Төв аймаг болон нийслэлийн ойролцоох эрчимжсэн мал аж ахуйг хүчит тэжээлээр хангах зорилгоор тэжээлийн үйлдвэрийн 5 иж бүрдлийг аж ахуйн нэгжүүдэд олгох ажлыг зохион байгуулав.

Тэжээлийн нэг наст ургамлын тариалалтыг дэмжих зорилгоор 37.0 тонн хошуу будаа, 5.0 тонн эрдэнэ шишийн үрийг 8 аймгийн 37 иргэн, аж ахуйн нэгжид олгон улсын хэмжээнд 21.9 мянган га талбайд тариалалт хийж 45.9 мянган тн ногоон тэжээл хураан авав. Мөн 32.3 мянган га талбайд тосны ургамал тариалж, 14.7 мянган тн ургац авав.

Говь-Алтай аймгийн Аргалантын аймаг дундын отрын бүс нутагт 100 тн багтаамжтай тэжээлийн агуулах, өвсний саравч барьж, Чилэн болон Хэрлэнбаян-Улаанд тус бүр 30 га талбайд царгас, 30 га-д овъёос тариалж 91.0 тн ногоон тэжээл бэлтгэв.

Улсын хэмжээнд 2013 онд 1.1 сая тн байгалийн өвс, 21.7 мянган тн сүрэл, 42.2 мянган тн ногоон тэжээл, 40.7 мянган тн үйлдвэрийн тэжээл, 45.9 мянган тн гар тэжээл



бэлтгэсэн нь 2012 онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 0.5, гар тэжээл 6.4 хувиар буурсан байна.

2014 оноос хүчит тэжээлийн үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулснаар мал аж ахуйн салбарт бэлтгэсэн өвс, тэжээлийн 30-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэх боломжтой болно.

### Хадлан, тэжээл бэлтгэл

	2013 он	2014 он
Байгалийн өвс, сая тн	1.1	1.2
Сүрэл, мянган тн	21.7	22.7
Ногоон тэжээл, мянган тн	42.2	39.2
Үйлдвэрийн тэжээл, мянган тн	40.7	29.6
Гар тэжээл, мянган тн	45.9	37.4
Дарш, ногооны хаягдал, мян.тн		3.5
Давс, хужир шүү, мян.тн		126.4

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл 2013, Статистик бюллетень 2014/12

**/70 хувь/**

**73.** Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий хөдөө аж ахуйн биржийг байгуулах

**Биелэлт:** “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит ХХК-ийг байгуулснаар тус компани хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий 29 брокерт гишүүнчлэл олгож, 30 агуулах, 2 тээврийн компанид түр итгэмжлэл олгон арилжаанд оролцуулсан бөгөөд улсын итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллаж байна.

16 аймгийн төв, зүүн 3 аймгийн 49 сум, Улаанбаатар хотын 14 компани биржийн сүлжээнд холбогдон үйл ажиллагаа явуулж байна. Уг биржийн үйл ажиллагаа тогтворжин 2013 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 131 удаагийн арилжаа зохион байгуулж 6382.1 тн ноолуурын 385.2, 1005 тн хонины ноосны 1.5, 1048 тн тэмээний ноосны 5.0, 14912 тн тосны ургамлын 11.9, нийт 403.6 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ.

2014 онд Биржийн арилжааны зуучлагч-брокерын үйл ажиллагааг эрхлэх брокерын компани байгуулах ажлыг аймаг бүрт зохион байгуулж байна. Одоогоор 15 аймагт брокерийн компани байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна.

ХАА-н биржийн арилжаа нь олон улсын биржүүдийн ажилладаг зарчмын дагуу цахим арилжааны системээр хийгдэх бөгөөд онлайн арилжааны системд шилжихээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд олон төрлийн хөрөнгө арилжих боломжууд нь бүрэн батлагдсан арилжаа, клиринг-төлбөр тооцооны цогц систем худалдан авахаар 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Насдак Омкс” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Улаанбаатар хотын 14 компани, 16 аймгийн төв, зүүн 3 аймгийн 49 сум биржийн сүлжээнд холбогдон үйл ажиллагаа явуулж байна.

Фьючерсийн арилжаа зохион байгуулах ажлын хүрээнд орон нутгийн брокерын компаниудад TCP-IP протоколоор холбогдож арилжаанд оролцох API (application program interface)-г боловсруулж Хэнтий, Завхан аймгийн брокерын компанийг холбож туршилт хийж байна. Баянхонгор, Хэнтий аймгийн Өндөр хаан сум, Завхан аймгийн Улиастай суманд захиалгын бүртгэлийн онлайн сүлжээ нэвтрүүлсэн. **/70 хувь/**

**74.** Сумын хөгжлийн сангийн эх үүсвэрийг 150 саяаас доошгүй, аймаг, дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санг 3 тэрбумаас доошгүй, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн эх үүсвэрийг 500 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулах

**Биелэлт:** 2012 оны 12 сард 24.0, 2013 оны 3 дугаар сард 24.0, нийт 48.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 21 аймгийн 330 суманд хуваарилснаар “Сум хөгжлийн сан”-гийн эх үүсвэрийг 150.0 сая төгрөгт хүргэсэн.

2013 онд 2011 оны зээлийн эргэн төлөлтөөс 2.1, 2012 оны санхүүжилтээс 20.8, 2013 оны санхүүжилтийн 24.0 тэрбум төгрөг зэрэг эх үүсвэрүүдээс Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлсэн.

Тус сангаас 2013 онд хүнсний үйлдвэрийн 1000, хөнгөн үйлдвэрийн 1696, газар тариалангийн 951, мал аж ахуйн 1215, барилгын 497, худалдаа, үйлчилгээний 790, бусад салбарын 827, нийт 7486 төсөл дэмжигдсэний үр дүнд 7359 шинэ, 1821 түр ажлын байр бий болж, 6840 ажлын байр хадгалагдсан байна.

Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/39 тоот тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гийн зээлийн эргэн төлөлтөөс төвлөрсөн 14.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүдэд тус бүр 500.0 сая төгрөгийн эх үүсвэрийг хуваарилсан.

“Жижиг дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс 627 төслийг дэмжсэнээр 6310 шинэ ажлын байр бий болж, 2778 ажлын байр хадгалагдсан байна.

Эдийн засгийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Засгийн 2014 оны 176 дугаар тогтоолоор Хөгжлийн банкнаас ЖДҮХС-д 100.0 тэрбум төгрөгийг хуваарилсан ба үүнээс 30.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/118 тоот тушаалаар орон нутагт хуваарилан санхүүжилтийг шийдвэрлэв. 2014 эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 8533,2 сая төгрөгийн зээлийг олгосноор 1950 хүн байнгын ажлын шинэ байраар хангагдаж, 883 ажлын байр хадгалагдсан байна.

Ажлын байрыг дэмжих, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор Экспортыг дэмжих, импортыг орлох-888 төслийн хүрээнд 325 төслийг 78,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр дэмжиж 3856 ажлын байр бий болсон байна. **/60 хувь/**

**75.** Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулах

**Биелэлт:** Мал хамгаалах сангаас эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих чиглэлээр 2012 онд 88 иргэн, аж ахуй нэгжид 3.1, 2013 онд 106 иргэн, аж ахуй нэгжид 2.1, нийт 5.2 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлжээ.

Арга хэмжээ	Дэмжлэг үзүүлсэн ААН-ийн тоо	2013	
		Батлагдсан төсөв /мян.төг/	Гүйцэтгэл (мян. төг)
Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх	74	1550,0	1630,5
Гахайн аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	16	300,0	330,0
Өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор тахианы аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	11	250,0	160,0
Зөгийний аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх	5	70,5	50,0
<b>Дүн</b>	<b>106</b>	<b>2170,5</b>	<b>2170,5</b>

2012 онд 510.9 мянган тонн сүүг дотоодод үйлдвэрлэж, импортоор 729.6 мянган литр шингэн сүү, цөцгийн тос, 6243.0 мянган литр өтгөрүүлсэн хуурай сүү, цөцгий тус тус худалдан авч дотоодын хэрэгцээг хангасан байна.

Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 2012 онд сүүний үхрийн 25 аж ахуйн нэгжид 400.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай зээл олгосон. Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд сүүний үхрийн 70 үнээтэй цогцолбор, Өвөрхангай аймгийн Уянга, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдад тус

бүр сүүний чиглэлийн 20 үнээ бүхий аж ахуйг улсын төсвийн хөрөнгөөр бий болгов. Үүний үр дүнд сүүний фермерийн тоо 76, сүүний цэвэр үүлдрийн үхэр 5375-аар тус тус нэмэгдсэн.

Сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор Булган, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Архангай аймаг, Улаанбаатар хотод сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 74 аж ахуйд нийт 1.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэв.

### Сүү үйлдвэрлэл

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2011 он	2012 он	2013 он
1	Үнээний сүү /биет хэмжээгээр/	мян.тн	298.8	338.6	380.8
2	Дотоодын үйлдвэрт боловсруулсан сүү	мян.тн	42.67	53.18	50.1

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2013, УСХ

Хот суурин газрын хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, мах сүү үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд сүү-махны чиглэлийн Монтбелиард үүлдрийн 242 үхрийг импортлон авчирч нутагшуулан Төв аймгийн Архуст, Баянчандмань, Цагааннуур, Өвөрхангай аймгийн Тарагт сумдад үржүүлж байна. Өндөр ашиг шимт сүүний үхэр импортоор худалдан авч нутагшуулснаар үхрийн сүүний хангамж 1.8 сая литр, ямааны сүүний хангамж 202.0 мянган литрээр нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн.

Дэмжлэгийн үр дүнд өндөр ашиг шимт үхрийн тоо 2012 оноос 4639 толгойгоор нэмэгдсэн байна.

Бүс	2012		2013		2013/2012	
	Фермерийн тоо	Үхрийн тоо	Фермерийн тоо	Үхрийн тоо	Фермерийн тоо	Үхрийн тоо
Баруун	101	1692	108	1957	106,9%	115,7%
Хангайн	244	3981	124	2421	50,8%	60,8%
Төвийн	410	15379	424	20464	103,4%	133,1%
Зүүн	82	5924	84	5743	102,4%	96,9%
УБ	140	5900	172	6933	122,9%	117,5%
Дүн	977	32876	912	37518	93,3%	114,1%

Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Төв, Орхон аймаг, Улаанбаатар хотын гахайн аж ахуй эрхлэгч 16 аж ахуйн нэгжид нийт 330.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэв.

2013 оны үзүүлэлтийг 2012 онтой харьцуулахад фермерийн тоо 133, гахайн тоо 13726 толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

Бүс	2012		2013		2013/2012	
	Фермерийн тоо	Гахайн тоо	Фермерийн тоо	Гахайн тоо	Фермерийн тоо	Гахайн тоо
Баруун	12	189	32	608	266,7%	321,7%
Хангайн	38	1338	104	4120	273,7%	307,9%
Төвийн	90	7168	142	9261	157,8%	129,2%
Зүүн	36	1294	29	1515	80,6%	117,1%
УБ	5	7786	7	15997	140,0%	205,5%
Дүн	181	17775	314	31501	173,5%	177,2%

Эрчимжсэн гахайн аж ахуйн тоо 2013 онд өмнөх онтой харьцуулахад 77.2 хувиар, гахайн тоо 13.7 мянган толгойгоор буюу 73.5 хувиар нэмэгджээ.

2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр гахайн махны импорт 1606.5 кг болж, өмнөх оноос 7.1 хувиар буурсан нь дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбоотой.

Он	Гахайн мах /мянган кг/	Гахай, шувууны өөх /мянган кг/
2012	1728,6	1646,2
2013	1606,5	1952,7
Өсөлт	92,9%	118,6%

Улаанбаатар хот, Дархан-Уул аймгийн тахианы аж ахуй эрхлэгч 11 аж ахуйн нэгжид нийт 160.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэв. 2013 оны жилийн эцсийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулан үзэхэд аж ахуйн нэгжийн тоо 2 дахин нэмэгдэж, өндөглөгч тахианы тоо 9.4 хувиар буурсан байна. 2014 онд шувууны аж ахуй эрхэлдэг 3 аж ахуйн нэгжид 8.6 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгийг үзүүлээд байна.

Бүс	2012 он		2013		2013/2012	
	Фермер-ийн тоо	Тахианы тоо	Фермер-ийн тоо	Тахианы тоо	Фермер-ийн тоо	Тахианы тоо
Баруун	11	6832	17	3359	154,5%	49,2%
Хангайн	38	14441	134	9821	352,6%	68,0%
Төвийн	66	148250	90	180817	136,4%	122,0%
Зүүн	14	3613	60	3444	428,6%	95,3%
УБ	23	421300	18	346793	78,3%	82,3%
Дүн	152	594436	319	544234	209,9%	91,6%

Тахианы аж ахуй эрхлэгчийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч дотоодын эрэлт хэрэгцээг бүрэн хангах боломжоор дутмаг байна.

#### Өндөгний үйлдвэрлэл, хангамж

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2012	2013	2014*
1	Импортоор оруулсан өндөг	сая.ш	91.9	103.0	87.3
2	Өндөг	сая.ш	56.6	58.4	-
3	Өндөгний хангамж	%	25.3	26.9	-

2014\*-урьдчилсан байдлаар

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2013, УСХ

Гаалийн ерөнхий газрын импортын 2014 оны урьдчилсан дүнг өмнөх онтой харьцуулахад 87.3 сая ширхэг өндөг оруулж, өмнөх оноос өндөгний импорт 15.7 сая ширхэгээр буурсан нь дотоодын өндөг үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой юм.

**/60 хувь/**

**76.** Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахыг дэмжих

**Биелэлт:** “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоолоор сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 27.7 сая ам.долларыг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэж “ТЭСО” ХХК-д 5.0 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд үйлдвэр 2014 оны 10 дугаар сард ашиглалтад орлоо. Үүний үр дүнд жилд 700 тн хуурай сүү үйлдвэрлэж, импортыг 15 хувиар бууруулах боломж бүрдэнэ. Дархан-Уул аймгийн “Поликом” ХХК-д 6.0 тэрбум төгрөгийн зээл олгох ажил хэлэлцүүлгийн шатанд байна.

“СНФ” Олон улсын байгууллагатай хамтран Сэлэнгэ аймгийн Мандал суманд өдөрт 2 тн сүү боловсруулах үйлдвэр байгуулах төсөл боловсруулж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Өвөрхангай аймгийн Уянга, Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий суманд хоногт 1000 тонн сүү боловсруулах үйлдвэрийг байгуулж, туршилт тохируулга хийн, ажлыг жигдрүүлсэн.

Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 27.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтын зээлийг Голомт банкаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд олгох шийдвэр гаргаснаас сүү боловсруулах 4 үйлдвэрт нийт 12.3 тэрбум төгрөг, сүү боловсруулах цехийн 15 төсөлд 2.2 тэрбум төгрөгийн зээл тус тус батлагдсан байна. **150 хувь!**

**77.** Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх

**Биелэлт:** УИХ-аас 2012 онд баталсан Хүнсний тухай хуульд махны урамшуулал олгох талаар тусгуулсан.

Махны урамшуулалд улсын 2015 оны төсөвт 14.0 тэрбум төгрөг тусгасан боловч дэмжигдээгүй хасагдсан.

Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу 2013 онд 6.4 мянган тн хонь, адууны мах экспортлох зөвшөөрлийг 11, 143.0 тн үхрийн мах импортлох зөвшөөрлийг 3 компанид тус тус олгов.

2012 онд хөдөө аж ахуйгаас 220.4 мянган тн мах бэлтгэн, нийт хүн амын махны дундаж хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, 16.4 мянган тн махыг үйлдвэрийн аргаар боловсруулан, 3.7 мянган тн мах экспортолж, 47.7 тн мах импортолсон бол 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.2 сая толгой мал хүнсэнд хэрэглэж, хөдөө аж ахуйгаас 238.2 мянган тн мах бэлтгэн, 22.1 мянган тн махыг үйлдвэрийн аргаар боловсруулан, 3.0 мянган тн мах экспортолсон байна.

#### **Махны нөөц, хангамж**

	2012 он	2013 он	2014УГ
ХАА-д бэлтгэсэн мах, мян.тн	220.4	249.7	-
Махны экспорт, мян.тн	3.7	3.8	2.57
Махны импорт, мян.тн	7.24	13.24	13.93
Махны нөөц, мян.тн	227.6	259.2	-
Хүн амын махны хангамж,%	127.1	141.9	-

*Эх сурвалж:ҮСХ-ны судалгаа, Гаалийн статистик*

Улсын хэмжээнд жилд дунджаар 8.2 гаруй сая толгой мал хүнсэнд хэрэглэж, 200 гаруй мянган тн мах үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж байна.

Хөдөө аж ахуйгаас 2013 онд бэлтгэсэн махны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 17.8 мянган тн буюу 7.4 хувиар, үйлдвэрийн аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүний хэмжээ 5.7 мянган тн буюу 34.7 хувиар нэмэгдсэн.

Хөдөө аж ахуйн биржээр арилжих барааны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, малыг биржээр арилжих барааны жагсаалтад тусган батлав. Биржээр мал арилжих бэлтгэл ажлыг хангаж байна.

Улаанбаатар хотын махны бөөний худалдааны давамгайл байдлыг арилгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх, дүүрэг бүрт махны төрөлжсөн агуулах бүхий бөөний худалдааны төв байгуулах төслийн сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан, нийт 33 аж ахуйн нэгжийн төслийг Монголбанкинд хүргүүлсэн. Үүнээс 27 аж ахуйн нэгжид харилцагч арилжааны банкуудаас нийт 74.9 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Дэмжлэгийн үр дүнд мах хадгалах агуулахын хүчин чадал 19.5 мянган тн, төмс, хүнсний ногооны зорь 66,5 мян тн, худалдааны төвийн агуулахын багтаамж 6.0 мян тн-оор тус тус нэмэгдэх боломжтой болно. Эдгээрээс 9 аж ахуйн нэгж зорь байгуулах ажлаа бүрэн дуусгасан, 8 аж ахуйн нэгж зорь байгуулах ажил 70-90 хувийн гүйцэтгэлтэй, 7 аж ахуйн нэгж 20-50 хүртэл хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 3 аж

ахуйн нэгж тайлан ирүүлээгүй байна. Мөн төрөлжсөн худалдааны 3 төв байгуулаад байна.

“Загасны үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулах” сонгон шалгаруулалтыг зарлаж “Солархаус” ХХК-тай гэрээ байгуулан Архангай, Хөвсгөл, Завхан, Ховд, Говь-Алтай зэрэг аймгуудын нутаг дэвсгэрт орших томоохон нууруудад гидробиологи, загас, орчны (шувуу, хөхтөн амьтан, ургамал, шавж) суурь судалгааг гүйцэтгэсэн. Судалгааны дүнг үндэслэн Архангай аймгийн Тэрхийн цагаан нуурыг загасны аж ахуйн үйлдвэр байгуулах тохиромжтой бүс гэж сонгосон. Мөн “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” төслийг 2014 оны 4-р сараас хэрэгжүүлж эхлээд байна. **/50 хувь/**

**78.** “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мал эмнэлэг, үржлийн төрийн үйлчилгээний албыг бүх суманд бэхжүүлэх

**Биелэлт:** Малын генетик нөөцийн тухай хуулийн үзэл баримтлалыг баталж, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Малын эрүүл мэндийн тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Мал сүргийн ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн 2013 оны урьдчилсан мэдээгээр өссөн дүнгээр 7.1 сая малыг ээмэгжүүлсэн бол мөн онд шинээр 1.7 сая мал ээмэгжүүлснээр биелэлт 95 хувьд хүрлээ.

2014 онд малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 22 аймаг, нийслэлийн нийт 339 сум, дүүргийн 76.1 мянга малчин өрх, 7.8 мянган мал бүхий өрхийн нийт 1837.2 мянган мал, үүнээс үхэр 956.4 мянга, хонь 562.4 мянга, ямаа 310.8 мянга, тэмээ 3.5 мянга, адуу 4,2 мянга орсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад малын тоо 576.8, малчин өрх, мал бүхий иргэний тоо 25.6 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

#### Малын тоо, мянган толгой

	2012 он	2013 он	2014 он
Адуу	2330.4	2619.4	2995.8
Үхэр	2584.6	2909.5	3413.9
Тэмээ	305.8	321.5	349.3
Хонь	18141.4	20066.4	23241.8
Ямаа	17558.7	19227.6	22008.9
<b>Бүгд</b>	<b>40920.9</b>	<b>45144.3</b>	<b>51982.6</b>

Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2012 онд 1906.0 тэрбум төгрөгт хүрч, мах 219.7, сүү 510.9, ноос, ноолуур 25267 мянган тонн, арьс шир 8.5 мянган ширхэгийг тус тус үйлдвэрлэж, мөн онд 44968.9, 2013 онд 3791.6 тонн мах, дайвар бүтээгдэхүүнийг тус тус экспортолсон байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт баригдах “Малын удмын сангийн үндэсний цогцолбор”-ын бүтээн байгуулалтад 2014 онд нийт 170 гаруй хүн ажилласан ба эхний ээлжинд гүйцэтгэх ажлын явц 87.5 хувьтай, нийт 9.9 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэжээ.

Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтыг жил бүр явуулж, 2011 онд бодын техникч 42, богийн техникч 46, 2012 онд бодын техникч 31, 2013 онд бодын техникч 28, богийн техникч 31, нийт 178 техникчийг бэлтгэсэн байна. Үүнээс 38 техникч Малын удмын сангийн үндэсний төвтэй гэрээ байгуулан, зохиомол хээлтүүлгийн үйл ажиллагааг явуулж байна.

Малын үр үйлдвэрлэлийн ажлын хувьд 2012 онд 3 үүлдрийн бух, 4 үүлдрийн хуц, 1 үржлийн хэсгийн ухнаас үр авч, нийт 7429 тун үрийг технологийн дагуу гүн хөлдөөсөн бөгөөд дотооддоо үйлдвэрлэсэн үрийн тоо өмнөх жилээс 6.1 дахин өссөн байна.

2013 онд 3 үүлдрийн бух, 6 үүлдрийн хуц, 4 үүлдэр, омгийн ухнаас нийт 11600 үр үйлдвэрлэснээс стандартын шаардлага хангасан 9549 тун үрээр генийн санд

баяжилт хийсэн нь өмнөх жилээс 28.5 хувиар өсчээ. Үрийн дээжийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн шинжилгээнд тогтмол хамруулж байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн Генийн банкинд 2014 оны эцсийн байдлаар үхрийн 6, богийн 15 үүлдэр, үржлийн хэсгийн 46.1 мянган тун үр технологийн дагуу хадгалагдаж байна. Үүнээс 2014 онд тоо толгой нь цөөрч, удмын сан нь алдагдахад хүрч байгаа 4 үүлдрийн шилмэл 5 хээлтүүлэгч, үржүүлэгт эрчимтэй ашиглагдаж буй 2 үүлдрийн шилмэл 2 хээлтүүлэгч болон “Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан”-ийн бүртгэлийн үр дүнгээр шилэн сонгосон Симменталь, Алатау үүлдрийн шилмэл 2 бухнаас нийт 6248 тун үрийг үйлдвэрлэн генийн санд баяжилт хийгдсэн.

Засгийн газрын 2014 оны 239 тоот тогтоолоор Баяннурууны аймаг дундын отрын бэлчээрийг шинээр байгууллаа. Баяннурууны отрын бэлчээр шинээр нээгдсэнээр аймаг дундын отрын бэлчээр 783.2 мян/га болж нэмэгдлээ.

Уламжлалт мал аж ахуйн эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор 2012 онд бэлчээрт хөнөөл учруулдаг үлийн цагаан оготнотой 13 аймгийн 90 сум, отрын 5 бэлчээрийн 500.4 мянган га талбайд энгийн механик аргаар, 1 аймгийн 6 сумын 120.0 мянган га талбайд микробиологийн аргаар, царцаа устгалыг 4 аймгийн 21 сумын 123.1 мянган га талбайд химийн аргаар тэмцэх ажлыг аймаг, сумын мэргэжлийн байгууллага, аж ахуй нэгж, малчидтай хамтран гүйцэтгэсэн байна.

2013 оны жилийн эцсийн мэдээгээр үлийн цагаан оготнотой энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг 13 аймгийн 88 сум, 2 отрын бэлчээрийн 645.0 мянган га талбайд хийж, өмнөх оноос 20.0 мянган га талбайгаар нэмэгдүүлсэн.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 онд гүний худгийн өрөмдлөгийн зориулалт бүхийн 4 иж бүрдэл машиныг импортоор худалдан авч Баян-Өлгий, Төв, Дундговь, Хөвсгөл аймгуудад эргэн төлөгдөх нөхцөл бүхий түрээсийн гэрээгээр хуваарилан олгов. Бэлчээр усжуулах арга хэмжээнд 2014 онд улсын төсвөөс нийт 10.0 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Аймаг, нийслэлээс ирүүлсэн урьдчилсан мэдээгээр улсын хэмжээнд 2014 онд уст цэгийн тоо 43.6 мянга, үүнээс инженерийн хийцтэй 12.8 мянга, энгийн уурхайн 29.7 мянга, усан сан 1.12 мянган ширхэг байна. Нийт уст цэгээс ашиглахад бэлэн байгаа 42.8 мянган ширхэг уст цэг байна.

2014 онд шинээр 1.128 мянган ширхэг худаг уст цэгийг шинээр гаргаж, үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 465, гадаадын төсөл, хөтөлбөрөөр 54, орон нутгийн хөрөнгөөр 309, малчдын санаачлагаар 326 худаг гарган, 72 худагт сэргээгдэх эрчим хүчээр ажиллах ус өргүүрийг суурилуулж усны хангамжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв. Үүний үр дүнд 166.0 мянган малчин өрх, мал бүхий өрх усаар хангагдах нөхцлийг бүрдүүлсэн.

Шүлхий өвчний халдвар 2014 онд зүүн бүсэд гарсантай холбогдуулан өвчин гарсан аймгууд болон эрсдэл бүхий аймаг, сумын нутагт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж нийт 9 аймгийн 14.8 сая толгой малыг шүлхийн урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулав. 2014 онд давхардсан тоогоор нийт 40.4 сая толгой мал хамрагдахаас 39.6 сая толгой малыг хамруулж, вакцинжуулалт 98.0 хувийн биелэлттэйгээр гүйцэтгэсэн. Үүнээс бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 16.0 сая толгой мал хамрагдахаас 15.5 сая толгой малыг хамруулж, вакцинжуулалтын гүйцэтгэл 97.3 хувийн биелэлттэй байна. /50 хувь/

#### **4. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого**

**79.** Аялал жуулчлалын салбарын бодлогыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэх

**Биелэлт:** Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хувилбарыг 2015 оны I дүгээр улиралд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

“Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр”-ийн төслийг ТББ-ууд болон яамдын саналыг авч, тусган эцэслэн боловсруулсан.

Засгийн газрын 2014 оны 186 тогтоолоор Монгол Улсад жуулчлахаар ирэх 42 улсын иргэнд Монгол Улсын хилийн боомт дээр виз олгохоор болов.

Аялал жуулчлалын гадаад сурталчилгааны “**Mongolia nomadic by nature**” уриа үгийг Засгийн газрын 2014 оны 51 дүгээр тогтоолоор батлуулж, Монголын аялал жуулчлалын байгууллагуудыг нэгдсэн байдлаар эх орноо сурталчлахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Засгийн газрын 2013 оны 183 дугаар тогтоолоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад болох “**И Ти Би-2015**” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс түнш орноор оролцох болсон. Тус үзэсгэлэнд Монгол Улс 3 талбайд төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд оролцох бөгөөд үзэсгэлэнг Монгол Улсын Ерөнхийлөгч нээж, нээлтийн үндэсний урлагийн тоглолт, албан ёсны хүлээн авалт, 3 хэвлэлийн бага хурал зэрэг олон арга хэмжээг гардан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна.

ССАЖ-ын сайдын А/56 дугаар тушаалын дагуу “**Морин аялал, ан агнуур-Загасчлах**”, олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцуулах ажлыг зохион байгууллаа.

21 аймагт тусгай сонирхлын аяллын маршрут боловсруулах ажлын хүрээнд орон нутгаас албан ёсоор санал авч төрөлжүүлсэн хөтөлбөр боловсруулах ажил хийгдэж байна. Мөн бүх аймгаас тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, чиглэлийн талаар санал авч чиглэл маршрутыг нэгтгээд байна. **/50 хувь/**

**80.** Монгол Улсын байгалийн үнэт баялаг болсон хангайн бүсэд ашигт малтмал олборлохыг хуулиар хязгаарлаж, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх

**Биелэлт:** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УИХ болон Засгийн газрын шийдвэрээр хамгаалалтад авсан, хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний хүрээлэн байгаа орчинд ашигт малтмал эрж хайх, олборлох үйл ажиллагааг бүр мөсөн хориглох, шинээр боловсруулагдсан Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн төслүүдэд ашигт малтмал олборлохыг хориглосон заалтыг зөрчсөн этгээдэд ногдуулах ял, шийтгэлийн хэмжээг тусгаад байна.

Өмнөговь аймгийн “Шар цав” хэмээх газарт илэрсэн үлэг гүрвэлийн мөрийн олдворт газрыг улсын тусгай хамгаалалтад авлаа. Ингэснээр тус палеонтологийн олдворт газарт ашигт малтгалыг хайх, олборлох үйл ажиллагаа явагдахгүй байх эрх зүйн орчин бүрдэв.

2014 оны 5-р сард батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулинд “дэлхийн өв”, “үндэсний соёлын өв” болох газар нутагт ашигт малтмал олборлохгүй байх, соёлын үл хөдлөх өвийн хамгаалалтын болон орчны бүсэд шинээр барилга байгууламж барих, газар хөндөх, тэсэлгээ явуулах зэрэг үйл ажиллагааг хориглохоор тусгасан. **/50 хувь/**

**81.** Аялал жуулчлалын дэд бүтэц, барилга, байгууламжийг тухайн нутгийн онцлог, нөөцөд тулгуурлан хөгжүүлэх

**Биелэлт:** Аялал жуулчлалын байгууллагын стандартыг Нийслэлийн аялал жуулчлалын газар болон Аялал жуулчлалын үндэсний төвтэй хамтран шинэчлэн боловсруулж Стандартчилал, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.



Аялал жуулчлалын бүс нутагт утсан холбоо интернэтийн үйлчилгээ хүргэхэд шаардлагатай харилцаа холбооны дэд бүтцийг бий болгох, бүсийн харилцаа холбоог сайжруулах чиглэлээр аялал жуулчлалын харилцаа холбоо, интернэтийн дэд бүтэц байгуулах цэгүүдийг Мэдээлэл технологи шуудан харилцаа холбооны газартай хамтран тогтоосон.

“Гэст хаус”-ийн стандартыг шинээр, “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927:2008”, “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартыг боловсруулах ажил хийгдэж байна.

“Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал, жуулчлалын байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ын стандартыг шинээр баталсан. **/30 хувь/**

**82.** Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зах зээлийн эрэлтэд нийцсэн парк, музей, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтарсан хөрөнгө оруулалтаар барьж байгуулахыг дэмжих

**Биелэлт:** Өвөрхангай аймгийн Хархорин суманд байгуулах “XIII зуун” цогцолборын зураг төсөв боловсруулахад 250.0, Хөвсгөл аймагт байгуулах цаатан угсаатны музейн зураг төсөв боловсруулахад 50.0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо гарган, ажлын саналыг боловсруулаад байна.

Олон жилийн археологийн судалгааны үр дүнд олдсон ордоны туурь, хотын үйлдвэрлэлийн түүх дурсгалыг ил музей цогцолбор болгон хөгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлээд байна. Энэ хүрээнд ХБНГУ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурахад бэлэн болоод байна. **/10 хувь/**

**83.** Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу нийтийн ариун цэврийн газар, иж бүрэн үйлчилгээ бүхий түр буудаллах цэг байгуулахыг дэмжих

**Биелэлт:** “Бага хүч чадлын цэвэрлэх байгууламж. Техникийн ерөнхий шаардлага” багц стандартыг “Ногоон сууц” ТББ-аас боловсруулан холбогдох байгууллагуудын саналыг тусган Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлуулав.

Бага хүч чадлын цэвэрлэх байгууламжийг “МАК” ХХК-ийн Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хар зүрхний хөх нуур дахь жуулчдын бааз болон Улаанбаатар хотод “Хасу мегаватт” ХХК-ийн металл эдлэлийн үйлдвэрт тус тус ашиглалтад оруулсан.

Олон улсын стандартад нийцсэн ариун цэврийн өрөө, хоолны газар, түргэн тусламжийн хэсэг, хогийн цэг, мэдээллийн самбараас бүрдсэн 6 аймагт байрлах түр амрах цэгүүдийг үе шаттайгаар бүтээн байгуулах төслийг Концессийн жагсаалтад оруулахаар ажиллаж байна. **/30 хувь/**

**84.** Монгол Улс руу чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг хоёр дахин нэмэгдүүлэх

**Биелэлт:** БНСУ-тай 2014 оны 4 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд хэлэлцээ хийж, Бусан нислэгийн цэгт 2016 оны зуны улирлаас нислэгийг эхлүүлэхээр, Улаанбаатар-Сөүл нислэгийн шугаманд “нэг чиглэл-нэг тээвэрлэгч” зарчмыг 2020 он хүртэл баримтлахаар, хоёр орны хооронд визийг чөлөөлөх нөхцөлд энэ зарчмыг эргэн харахаар, Сөүл-Дели чиглэлд Монголын агаарын тээвэрлэгч, БНСУ-ын агаарын тээвэрлэгчтэй аялалын дугаар хуваан ашиглах зарчмаар нислэг гүйцэтгэх, асуудлыг БНЭУ-ын талаас холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр судлан хэрэгжүүлэхээр тус тус тохирч, тохиролцсон асуудлаар Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

БНКаЗУ-тай 2014 оны 5 дугаар сарын 27-ны өдөр нислэгийн цэгийг 2-оор нэмэгдүүлж, хоёр орны хооронд гүйцэтгэх нислэгийн багтаамжийг 7 хоногт 800 суудал байхаар тохирч Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийг байгуулав.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг-Конгийн Засгийн газар хоорондын “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-ээр нислэгийн давтамжийг 11 болгон нэмэгдүүлж, “Гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран эзэмших тухай Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав.

2013 оны 11 дүгээр сард болсон Япон Улсын Иргэний нисэхийн удирдах газар, Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар хоорондын “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийн үеэр нислэгийн давтамжийг 7, багтаамжийг 10.5 болгож, нислэгийн цэгүүдийг нэмэгдүүлж, гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран эзэмших зохицуулалтыг тохирч, маршрутын хуваарь болон хоёр улс хоорондын “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийн зарим хэсгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

ӨАБНУ-ын Дурбан хотод болсон “Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Олон улсын агаарын харилцааны хэлэлцээр”-ий 6 дугаар хурлын үеэр ИБУИНВУ, Канад, Швейцарь, Австри, Сингапур, Шинэ Зеланд улсуудтай аяллын дугаар хуваан ашиглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх асуудлыг тохирч, холбогдох баримт бичгээр баталгаажууллаа.

Аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалтыг бүрдүүлснээр Монголын талын тээвэрлэгчид тухайн чиглэлд шууд нислэг гүйцэтгэхгүй ч эдгээр улсын агаарын тээвэрлэгчийн аяллын дугаарыг хуваан эзэмших зарчмаар нислэгийн сүлжээгээ өргөжүүлэх боломж бүрдсэн.

“Хүннү Эйр” ХХК нь Улаанбаатар-Бангкок, Улаанбаатар-Шанхайн чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэж байгаа бөгөөд Улаанбаатар-Парис чиглэлд нислэг гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн.

Ачааны агаарын тээврийн “Эйркарго Монгол” ХХК-ийг Улаанбаатар-Москва, Улаанбаатар-Новосибирск, Улаанбаатар-Иркутск, Улаанбаатар-Тяньжинь чиглэлд ачаа тээврийн олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилж, үйл ажиллагааг эхлүүлж байна.

Ингэснээр 2013 онд олон улсын 11, орон нутгийн 15 чиглэлд нислэг үйлдэж байна. 2014 онд олон улсын нислэгийн чиглэл 2-оор /Сингапур, Франкфурт/ нэмэгдэж 13 болсон байна.

	Олон улсын нислэгийн чиглэл	Орон нутгийн нислэгийн чиглэл
2012 он	13	14
2013 он	11	15
2014 он	13	12

“МИАТ” ТӨХК нь 2014 оны 9 дүгээр сарын 24-нөөс эхлэн Улаанбаатар-Бээжин-Сингапур-Улаанбаатарын чиглэлд нислэг үйлдэж эхлээд байна. 2014 оны “Хүннү Эйр” компани 2014 оны 6 дугаар сарын 9-нөөс Парисын чиглэлд, “МИАТ” ТӨХК нь 2014 оны 6 дугаар сарын 19-нөөс Франкфуртын чиглэлд тус тус шинээр нислэг гүйцэтгэсэн.

АНУ-ын “Боинг” компаниас худалдан авах Боинг-767-300ER агаарын хөлгийн төлбөрт шаардлагатай 114.450.0 мянган ам.долларын эх үүсвэрийг Засгийн газрын богино хугацааны баталгааг үндэслэн дотоодын санхүүгийн зах зээлээс санхүүжүүлэх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн.

Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2013 оны 20 дугаар тогтоолоор АНУ-ын “EXIM” банкнаас урт хугацаатай зээл авах хүртэлх хугацаанд Боинг 767-300ER агаарын хөлгийн санхүүжилт болох 78.550.000 ам.долларыг АНУ-ын “Боинг” компанид төлж, агаарын хөлгийг хүлээн авав.

Худалдаж авах АНУ-ын Боинг компанийн 767-300ER загварын 1, “Боинг”-737-800 загварын 2 агаарын хөлгийн санхүүжилтийг АНУ-ын “EXIM” банктай урт хугацаат зээлээр санхүүжүүлэх талаар урьдчилан тохирч урьдчилгаа төлбөрийн үнийн дүнгийн 1 хувь буюу 1.695.350 ам.долларыг төлсөн. АНУ-ын “EXIM” банкны Баталгаат зээлийн

нөхцөл болох Засгийн газрын баталгааг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2014 оны төсөвт тусгасан. /70 хувь/

**85.** Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулах

**Биелэлт:** Хужирт-Төвхөн-Улаанцутгалан чиглэлийн 90 км авто замын барилгын ажлыг 2012 онд эхлүүлсэн боловч, 2012 оны төсвийн тодотголоор хөрөнгийг нь хассан тул барилга угсралтын ажлын гэрээг цуцласан. Одоогоор хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна.

Сайншанд-Хамрын хийд чиглэлийн 42 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил дууссан. Улсын комисс хүлээн авсан.

Элсэн тасархай-Арвайхээр чиглэлийн 40 км замын барилгын ажлын явц 94.0 хувьтай байна.

Мөрөн-Хатгал чиглэлийн 98.8 км авто замын 1-р багц болох 50 км хатуу хучилттай авто замын ажилд Улсын комисс ажиллаж даалгавар өгсний дагуу нэмэлт ажлыг хийж дуусгав.

Хатгал нисэх буудлын хөөрч буух шороон зурваст 2012 онд 430,9 сая төгрөгийн, Хархорин нисэх буудлын хөөрч буух шороон зурваст 2012 онд 80 сая төгрөгийн их засвар тус тус гүйцэтгэсэн. 2014 онд Дадал нисэх буудалд нислэг үйлдэх бэлтгэлийг хангах зорилгоор хөөрч буух зурвасын даацыг тодорхойлж, нислэгийн талбайн хэмжилтийг хийн, ил, харааны тэмдэгтийг байрлуулсан. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тус нисэх буудлуудад нислэг үйлдэх бүрэн боломжтой болсон. Дадал, Хатгал, Хархорины нисэх буудлууд нь цагт 50 зорчигч хүлээн авах хүчин чадалтай ба багаас дунд оврын агаарын хөлөг хүлээн авах шаардлагыг хангаад байна.

Турк Улстай хамтран Хархорины нисэх буудлыг олон улсын статустай нисэх буудал болгон шинэчлэн байгуулах талаар ерөнхий мэдээлэл, танилцуулга, санал, төслийг боловсрууллаа.

Орон нутгийн нисэх буудлуудын үйл ажиллагааг сэргээх ажлыг “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д тусгасан “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн хүрээнд шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна.

**/60 хувь/**

**86.** Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын хөтөлбөр хөгжүүлэх

**Биелэлт:** Аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрт орон нутгийн байгууллагуудаас санал авч хөтөлбөр боловсруулахаар судалгаа хийгдэж байна. Нийт 21 аймгаас уг дэд хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын нөөцийн судалгааг авч эхний ээлжинд тогтмол зохиогдох арга хэмжээнүүдээр аялал жуулчлалын “Цаглабар 2013, 2014”-ийг эмхтгэн хэвлүүлж гаргалаа. Орон нутагт уламжлал болон зохион байгуулагддаг олон улсын аялал жуулчлалын 25 эвент арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

2013 онд Баянхонгор аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, 2014 оны 5 сард Сүхбаатар аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө тус тус батлагдав. Аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрт орон нутгийн байгууллагуудаас санал авч хөтөлбөр боловсруулахаар судалгаа хийж байна.

ССАЖЯ болон БОНХЯ-тай хамтран Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаар Бурхан Халдун хайрханыг “Монгол түмний “Үндэсний бахархалт хайрхан” гэж зарлахаар болж Засгийн газрын тогтоолыг батлууллаа. Бурхан халдун ууланд аялах аяллын маршрутыг бий болгож батлуулав.

Богдхан уул, Хангайн нуруу, Говь гурван сайхан зэрэг тусгай хамгаалалттай нутаг, түүний орчны бүс нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн аялал жуулчлалыг

хөгжүүлэх судалгааны ажил гүйцэтгэх гэрээг “Итгэлт бээс” ХХК-тай байгуулж судалгааны ажлыг хүлээн авсан болно. Хөвсгөл нуур түүний орчны бүсийг ногоон хөгжлийн загвар нутаг болгон хөгжүүлэх төсөл боловсруулан Азийн хөгжлийн санд хүргүүлсэнээр төсөл дэмжигдэн 2015 оноос 2.5 сая долларын дэмжлэгтэйгээр ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. /30 хувь/

**87.** Улаанбаатар хот, говийн аймгуудад үлэг гүрвэлийн цогцолбор музей, палеонтологийн лабораторийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах

**Биелэлт:** Өмнөговь аймагт шинээр барих музейн барилгын зураг төслийн ажил бүрэн хийгдэж, экспертизээр оруулсан. Газрын асуудлыг эцэслэн шийдвэрлэж баталгаажуулах ажил үргэлжилж байна.

Палеонтологи, археологийн лабораторийн барилгыг 2014 оноос эхлэн барихаар төлөвлөж байна. Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд үлэмж биетний өргөө барих газрыг товлоод байна. Мөн Дундговь аймагт палео адал явдалт динозаврын задгай хүрээлэн байгуулахаар судалгааг хийж байна.

Улаанбаатар хот Бага тэнгэрийн аманд байрлах 13-р зууны үеийн хадны сүт зургийг түшиглэн нийт 8 га газарт Соёлын аялал жуулчлалын бүсийг тогтоох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Чингис хаан цогцолборын зураг төслийн уралдааныг зарлан шалгаруулсан. 2014 онд ТЭЗҮ боловсруулна. /30 хувь/

**88.** Орон нутагт Аяллын төвүүдийг байгуулж тухайн нутгийн үзмэр, бизнес, брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах түшиц болгон ашиглах

**Биелэлт:** Горхи Тэрэлжийн бүс нутагт аяллын төв байгуулах газрыг шийдэж, зураг төслийг боловсруулж байна. ССАЖЯ-ны төслийн нэгжтэй хамтран Бурхан халдун, Богд уулын судалгаа хийгдэж байна. Аялал жуулчлалын үндэсний төвтэй хамтран Богдхан ууланд явган аяллын тэмдэг тэмдэглэгээ, амрах цэг, отог бүхий аяллын төвийг байгуулсан.

Гар урлалын өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2013 онд нийт 56 төсөлд 1 110,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон бөгөөд 246 шинэ ажлын байр бий болгож, 154 ажлын байр хадгалагдсан байна.

Олон улсын туршлагыг судалж, гар урлалын үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд ЮНЕСКО-гийн Суурин төлөөлөгчтэй гар урлал эрхлэгчдэд орон нутгийн онцлогийг харуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрлийг сайжруулах чиглэлээр 2014 онд хамтран ажиллахаар санал солилцов.

/30 хувь/

## **5. Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого**

**89.** Их, дээд сургуулиудыг түшиглэн өндөр технологийг дэмжих сургалтын тогтолцоо бий болгож, өндөр технологийн салбарт суралцагсдын тоог нэмэгдүүлэн, гадаад орнуудтай багш солилцох ажлыг өргөжүүлэх. Энэ чиглэлд сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хангана.

**Биелэлт:** МУИС болон ШУТИС зэрэг их сургуулиуд технологи дамжуулах бодлогоо шинэчлэн, технологи дамжуулалт хариуцсан нэгжийн үйл ажиллагаа, оюуны өмчийн бодлогоо шинэчлэн боловсруулж байна. Эдгээр бодлогуудтай уялдуулан их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд гарааны компани байгуулан ажиллах журмын төслийг боловсруулав.

Гадаадын зээл тусламжийн хүрээнд үндэсний судалгааны төв байгуулах асуудлаар санал боловсруулж байна. Эхний ээлжинд нүүрсний хими, шатдаг занарын

чиглэлээр үндэсний судалгааны төвийг байгуулах, улмаар химийн аж үйлдвэрийн суурийг бий болгох талаар судалгааны материал боловсруулж бэлэн болгов.

Хэрэглээний био технологийн үндэсний судалгааны төв байгуулах талаар судалгаа хийж байна.

Мэдээллийн технологийн үндэсний парк дээр хэрэгжүүлсэн “Силикон Хаус” төслийн бүрэлдэхүүнд Эмбеддэд систем хөгжүүлэлтийн лаборатори, Компьютерийн вишн лаборатори, Мэдээллийн технологийн мэргэшлийн сургалтын төв, Мэдээллийн технологийн төрөлжсөн номын санг шинээр ашиглалтанд оруулсан.

Их, дээд сургуулиудыг түшиглэн өндөр технологийг дэмжих ажлын хүрээнд "Яриаг таньж кирилл бичгийн текстийн файл болгох, кирилл бичгийн текстийг яриа болгох" ухаалаг программ хангамжийг боловсруулж дуусгав. **/30 хувь/**

**90.** Шинжлэх ухааны бүтээлийг дэмжих, чанарыг сайжруулах, зах зээлд нэвтрүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, технологийн сангаас олгох хөрөнгийг их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын дунд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах замаар хуваарилдаг болох

**Биелэлт:** Шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжүүлэх судалгаа боловсруулалтын ажлыг сонгон шалгаруулахад Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, салбарын эрдэмтдийг оролцуулан хэлэлцүүлж, дүгнэлт гаргаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Шинжлэх ухаан, технологийн салбарт 2009 оноос хойш хэрэгжиж байгаа судалгаа боловсруулалтын ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргах ажлыг анх удаа зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн эрдэмтэн, судлаачдын хэрэгжүүлж байгаа 60 инновацийн төслийн явц, үр дүнтэй танилцан 33 төслийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, 16 төслийн үр дүнг дуусгавар болгон хүлээн авахаар тогтсон байна.

Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлууллаа.

Улсын Их Хурлын 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-т “Ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, 2030 онд 3 хувьд хүргэн, ногоон хөгжлийн хурдасгуур болгоно” гэсэн заалтыг тусгасан.

2013 онд Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр нийт 660 гаруй сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төслийг эхлүүлээд байна. Тухайлбал: Нефть, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон газрыг байгаль орчинд ээлтэй аргаар цэвэрлэх, Цаг агаарыг урьдчилан тооцоолох загварчлалд супер компьютерийн технологи ашиглах зэрэг ногоон технологийн чиглэлийн төслүүд гэх мэт. Ногоон хөгжлийн технологийн чиглэлийн судалгаанд зарцуулах хөрөнгийн хэмжээ 300 орчим сая төгрөгт хүрсэн. 2014 онд Хот, суурин газрын утааны тоосонцорын концентраци, хорт хийн хэмжээг бууруулах техник технологийн судалгааны төслийг эхлүүлсэн.

Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр 2015 оноос хэрэгжүүлэх ногоон хөгжил, байгалийн нөөц, экосистемийн судалгааны чиглэлийн 12 төслийн санал боловсруулав. **/50 хувь/**

**91.** Мэдээлэл холбоо, нано, биотехнологийн чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах үйл ажиллагааг хөгжүүлж, эдгээр мэргэжлээр 300-гаас доошгүй оюутныг дэлхийн шилдэг сургуулиудад оюутан солилцоогоор сургах

**Биелэлт:** Азийн хөгжлийн банкны “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд судалгааны их сургууль, засаглал, санхүүжилт, удирдлага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, инженерийн хөтөлбөрийн туршлага судлах зэрэг чиглэлээр их, дээд сургуулийн 9 профессор багш АНУ-д сургалтад хамрагдсан байна.

2012-2013 оны хичээлийн жилд МУИС, ШУТИС, Жонон зэрэг их, дээд сургуульд биотехнологи, нано шинжлэх ухаан, нано биотехнологи, нано инженерчлэл, цөмийн технологи, цөмийн эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч зэрэг мэргэжлээр 280 суралцагч шинээр элсэн суралцаж байгаа нь өмнөх оныхоос 140-өөр нэмэгдсэн байна.

2014-2015 оны хичээлийн жилд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/220 дугаар тушаалаар нано технологи, инженерчлэл, био технологи, цөмийн инженерчлэлийн бакалаврын хөтөлбөрөөр дотоодын 7 их дээд сургуульд 370 оюутан сургахаар баталжээ.

Монгол Улсад 2013-2014 оны хичээлийн жилд инженерийн бакалаврын хөтөлбөрөөр 16011 оюутан суралцсан бөгөөд магистрантурт 1014, докторантурт 221 суралцагч суралцсан байна.

Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шаардлага хангасан 98 иргэнийг суралцуулахаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/219 дүгээр тушаалаар шийдвэрлэсэн болно. Үүнд улсын төсвөөс нийт 2.528.3 мянган ам.доллар зарцууллаа. Дэлхийн шилдэг их сургуульд суралцаж байгаа эдгээр суралцагчдын 60 хувь инженер технологийн мэргэжлээр суралцаж байгаа юм.

Засгийн газар хоорондын болон Сургалтын төрийн сангийн зээлээр оюутан сургах ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллав. Тухайлбал: БНЭУ-ын Засгийн газрын тэтгэлгийн хүрээнд 2014-2015 оны хичээлийн жилд 40 хүртэл оюутныг тус улсад инженер, технологийн чиглэлээр бакалавр, магистр, докторын сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн байна.

Улсын Их хурлын 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар "Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай" хууль батлагдсаны дагуу "Инженер, технологийн дээд боловсролын төсөл"-ийг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд төслийн хүрээнд аж үйлдвэрийн салбарын эрэлтэд нийцсэн практик чадвар бүхий 1000 инженер, техникийн мэргэжилтэн бэлтгэгдэнэ. 2014-2015 оны хичээлийн жилд тус төслийн хүрээнд "Коосэн" хөтөлбөрөөр 48 оюутан суралцаж байна. **/70 хувь/**

**92.** Төлбөр тооцоо, бүртгэлийн бүх үйл ажиллагааг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хийж гүйцэтгэх орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

**Биелэлт:** Санхүүгийн тайлангийн И-баланс программыг шинэчлэн сайжруулахаар 2012 оны 11 дүгээр сараас эхлэн "Интерактив Би Ай" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус шинэчлэлийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын 2013 оны I дүгээр улирлын санхүүгийн тайланг шинэчилсэн маягт болон шинэчилсэн программаар хянаж, хүлээн авлаа.

Мөн аж ахуйн нэгж, байгууллагууд улирал, жилийн санхүүгийн тайлангаа өөрсдийн ашигладаг санхүүгийн программаасаа "XBRL" схемийн дагуу илгээх боломжийг И-баланс программд нэвтрүүлээд байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2015 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн зөвхөн цахим хэлбэрээр хүлээж авах нөхцөлийг бүрдүүлж, Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 17-ны 242 дугаар тушаалаар "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, мэдээллийг ашиглах" журамд нэмэлт, өөрчлөлтүүдийг хийж батлав.

Бүх аймгийн газрын албанд E-Land программ хангамжийг нэвтрүүлж, газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн солбицолын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажил хийгдэж байна. **/70 хувь/**

## **6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого**

**93.** Импортоор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болж, төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг болох

**Биелэлт:** 2014 оны байдлаар хүнсний ногооны үр үйлдвэрлэгч 44 иргэн, 3 байгууллага таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж, төмс болон голлох хүнсний ногооны таримлын үрээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байна.

2013 онд буудайн үрийн хангамж 60 хувьтай байсан. Ган болон өвчинд тэсвэртэй, ургац өндөртэй Дархан 144 сортын 175 тонн үрийг үржүүлэн аж ахуй нэгжүүдэд гэрээгээр өгч тариалалт хийлгэсэн. ОХУ-аас Алтайский 320 сортын 1200 тонн үрийг импортоор оруулан үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг 50 аж ахуй нэгжид гэрээгээр олгон үржүүлж байна.

Тэжээл, тос, техникийн таримлын тариалалтын техник, тоног төхөөрөмжийн хангамж 2013 оны байдлаар 35 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5 хувиар өссөн дүнтэй байна.

2012 онд 316.9 мянган га талбайд уринш бэлтгэснээс 148.4 мянган га талбай химийн уринш хийсэн. 2013 онд 311.1 мянган га талбайд чанар сайтай уринш боловсруулж бэлтгэснээс 135.0 мянган га талбайд цомхотгосон уринш хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 12.6 мянган га талбайгаар буурсан үзүүлэлттэй байна.

Ургацын чанарыг сайжруулах, өвчин, хортонтой тэмцэх ажлын хүрээнд 702 аж ахуйн нэгжид 358.4 мянган литр ургамал хамгааллын бодис, 640 тонн эрдэс бордоог 30 хувийн урьдчилгаа төлбөр төлөх нөхцөлтэйгээр зээлээр олгов.

“Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд 2012 онд Импала, Гала, Солист сортуудын 131.4 мянга, 2013 онд 125.0 мянган бичил булцуу тус тус үйлдвэрлэв. Төмсний үр шинэчлэлийн хүрээнд 2013 онд аймгуудын ХХААЖДҮГ-аар дамжуулан 130 тн элит үрийг олгож, 2014 оны тариалалтад 520 тн элит үрээр тариалалт хийх нөхцөлийг бүрдүүлэв. Элит үрийн хангамжийн хэмжээ 60 хувьд хүрээд байна.

	2012 он	2013 он	2014.XII
Жишсэн хүн амын тоо, мянган хүн	2584.2	2917.52	2981.82
Төмсний хэрэгцээ, тн	111885,5	114366.90	116887.32
Төмсний үйлдвэрлэл, тн	245935.0	191619.2	161488.5
Хүнсний ногооны хэрэгцээ, тн	208358,9	212979.2	217672.8
Хүнсний ногооны үйлдвэрлэл, тн	98917.6	101761.6	104791.9
Төмсний хангамж, %	219.8	167.55	138.16
Хүнсний ногооны хангамж, %	47.4	47.78	48.14

*Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл 2013, Статистикийн бюллетень 2014/12*

2012 оны байдлаар жилд 15.4 тонн хүнсний ногоо боловсруулах хүчин чадалтай 8 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байсан бол 2013 оны байдлаар улсын хэмжээнд хүнсний ногоо боловсруулж нөөшилдөг 44 аж ахуйн нэгж ажиллаж байгаа бөгөөд үүнээс 4 аж ахуйн нэгж шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Улсын 2013 оны төсөвт 100.0 сая төгрөг батлагдан хүнсний ногооны өрхийн бичил үйлдвэрлэл “СТ-100” үндэсний сүлжээг 5 аймагт нэвтрүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний техник тоног төхөөрөмжийн механикжилтын түвшин 2013 онд 30 хувь, 2014 онд 45 хувьтай байна.

2012 онд 150 тонн жимс хадгалах багтаамж бүхий хөргүүртэй 24 агуулахыг жимс, жимсгэний тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд олгосон.

2013 оны улсын төсвийн 289.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 110 тонн жимс хадгалах зөөврийн, огцом хөлдөөх хөргөлттэй агуулах 11 ширхэгийг нийлүүлэн 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай зээлийн гэрээгээр аж ахуйн нэгжүүдэд олгох ажлыг зохион байгуулснаар хураасан чацаргана, жимсийг чанарыг нь муутгалгүй хадгалах, боловсруулах үйлдвэрт нийлүүлэх боломжийг бүрдүүлэв.

Жимсний хөргөлтийн агуулахын нийт багтаамж 2013 онд 260 тонн болж, нийт шаардагдах агуулахын 10 хувийг хангаж байна.

#### **Жимс жимсгэний тариалалт**

	Тариалсан	Ургац /тн/
--	-----------	------------

	талбай /мян.га/	
2012 он	4.5	1043
2013 он	5.1	1422
2014 он	5.6	1733

“Чацарганы суулгац зээлээр олгох” төсөл сонгон шалгаруулалтад шалгарсан 82 иргэн байгууллагад 404.5 сая төгрөгийн үнэ бүхий 188 575 ширхэг чацарганы суулгацыг зээлээр олгоод байна. Мөн 28 аж ахуйн нэгжид 1.05 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж, жимст цэцэрлэгийн талбайг 100 га-гаар нэмэгдүүлэх боломж бүрдүүлэв.

Хоногт 1000-аас доошгүй литр сүү хүлээн авч боловсруулах үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх тендерт шалгарсан “Монгол тариалан нэгдэл” ХХК-тай хөргөлтийн төвтэй, 1.8 сая литр сүү боловсруулах хүчин чадалтай 5 үйлдвэр байгуулахаар гэрээ байгуулаад байна.

	2012 он	2013 он	2014.XII
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сая төгрөг	40519.0	44492.4	53567.3
ХАА-д үйлдвэрлэсэн сүүний хэмжээ, мянган тн	511.0	575.2	765.4

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл 2013, Статистикийн бюллетень 2014/12

Сүүний чиглэлээр өсгөн үржүүлж буй үхрийн тоо 2013 онд 37518 байсан бол 2014 онд 59799 болж 59.4 хувиар өссөн нь ХАА-д үйлдвэрлэсэн сүүний хэмжээ 33 хувиар өсөхөд нөлөөлжээ. Жишсэн дундаж хүний жилийн сүүний хэрэгцээ 63 кг, жишсэн хүн амын жилийн сүүний хэрэгцээ ойролцоогоор 200 мянган тонн байдаг бөгөөд энэ хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг, Борнуур сумын Нарт багуудад “Мон-Фреш” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар өдөрт 5 тн сүү хүлээн авах хүчин чадалтай, хөргөлтийн иж бүрэн систем бүхий, тус бүр 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай сүүний хөргөлтийн төв ашиглалтад орж, нийт 540 тн сүү хүлээн авч өөрийн үйлдвэрт нийлүүлжээ.

“ТЭСО” ХХК нь хоногт 100 тн шингэн сүү боловсруулан 10 тн хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэрийг 2014 оны 10 сард ашиглалтанд оруулсан бол “АПУ” ХХК нь хоногт 150 тонн шингэн сүү хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий бүрэн автомат сүүний үйлдвэрийг 2014 оны 6 сард ашиглалтанд оруулав.

2013 онд улсын хэмжээнд тараг, аарц зэрэг уурагт бүтээгдэхүүний үйлдвэрийн тоо 6, цехийн тоо 45-аар нэмэгдэж, урьдчилсан дүнгээр 29 үйлдвэр, 152 цех ажиллаж байна.

2013 оны 12 дугаар сарын байдлаар сүүний үхрийн аж ахуй эрхэлдэг 7 аж ахуйн нэгж 6.6 тэрбум төгрөгийн зээл авч, 8 аж ахуйн нэгж зээл авах банкны шалгуур үзүүлэлтийг хангаад байна.

2013 оны улсын төсвөөр сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулж, 12 аймаг, нийслэлийн сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 74 аж ахуйд нийт 1.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэж, хэрэгжилтийг зохион байгуулав.

Эрчимжсэн тахианы аж ахуйн эрхэлж буй аж ахуйн нэгжийн 2014 оны судалгааг өмнөх оныхтой харьцуулахад баруун бүс болон нийслэлд тахианы тоо 557-8257 толгойгоор тус тус буурч, хангай, төв болон зүүн бүсийн тахиан тоо 1869-211979 толгойгоор тус тус нэмэгдсэн байна. “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2014 онд шувууны аж ахуй эрхэлдэг 3 аж ахуйн нэгжид 8.6 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгийг үзүүлээд байна. **/60 хувь/**

**94.** “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-гийн үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоо бүхий корпораци болгон зохион байгуулах



**Биелэлт:** “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг үе шаттайгаар хувьчлахаар тусгаж, Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, 27 дугаар тэмдэглэл гарч, УИХ-д өргөн барихаар боллоо. /40 хувь/

**95.** Баруун бүсэд газар тариалан эрхлэлтийг хөгжүүлж, бүсийн гурилын хэрэгцээгээ хангадаг болох

**Биелэлт:** Баруун бүсэд 2012 онд нийт 11.8 мянган га талбайд улаанбуудай тариалж 9.2 мянган тонн ургац хураан авч хэрэгцээт буудайн 17.3 хувийг хангасан.

2013 онд уг бүсэд 12.9 мянган га талбайд үр тариа, үүнээс 12.4 мянган га-д буудай, 1.7 мянган га-д төмс, 1.7 мянган га-д хүнсний ногоо, 3.0 мянган га-д тэжээл, 200 га-д тосны ургамал, нийт 19.5 мянган га-д тариалалт хийж 10.8 мянган тонн үр тариа, үүнээс 10.0 мянган тонн буудай, 19.2 мянган тонн төмс, 19.8 мянган тонн хүнсний ногоо, 12.0 мянган тонн тэжээлийн ургамал, 140 тонн тосны ургамал тус тус хураан авч, 2040 га-д уринш бэлтгэв. Жилийн хэрэгцээт буудайны 25 хувийг дотооддоо үйлдвэрлэсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 7.7 пунктээр өсчээ.

“Алслагдсан бүсэд газар тариаланг сэргээн хөгжүүлэх”, “Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих, нутагшуулах, сорт сорилтын төвүүдийг сэргээх”, “Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл нийлүүлэлтийн хэлхээн дэх ложистик урсгалын судалгаа”-ны ТЭЗҮ-ийг “Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо” ТББ, Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн, “Монголын ложистикийн холбоо” ТББ-аар гүйцэтгүүлж хүлээн авлаа.

2013 оны улсын төсөвт тусгагдсан 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баруун бүсэд Ховд аймгийн “Буянт” услалтын системийн 3 дугаар ээлж, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын “Цонжийн хөдөө”, Толбо сумын “Шумек”-ийн услалтын системийн 2 дугаар ээлжийг шинээр барьж, сэргээн засварлан ашиглалтад оруулав.

Баруун бүсийн усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 2013 онд 17436.9 га талбай байгаа нь өмнөх оныхоос 436.9 га-аар нэмэгдсэн.

2014 онд баруун бүс нутагт 17495 га-д тариалалт хийснээс улаанбуудайг 10322 га-д тариалж нийтдээ 8027 тонн үр тариа хураан авсан. Увс аймгийн Түргэн сумын Засаг даргын Тамгын газрын өмчлөлийн “Кола” услалтын системийн барилгын ажлыг улсын комиссоор хүлээн авч 60 га талбайн ус хангамжийг сайжруулж усалгаатай ашиглах боломж бүрдэв. Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЗДТГ-ын өмчлөлийн “Хэрсэн толгойн” услалтын системийг барилгын ажлыг улсын комиссоор хүлээн авч 35 га талбайн ус хангамжийг сайжруулж усалгаатай ашиглах боломж бүрдэв.

**/40 хувь/**

**96.** Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг бүрэн хангах

**Биелэлт:** Хүнсний ногооны үр, үрсэлгээ үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулж, 31 иргэн, 1 аж ахуйн нэгжид 106.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Төсөлд Баянхонгор, Увс, Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Дорнод аймгийн ногооны үр үйлдвэрлэгчид хамрагдав. Дэмжлэгийн үр дүнд эрт ургацын байцаа, шар лууван, манжин, сонгино, сармис, гоньдны үр үйлдвэрлэл өмнөх оныхоос 1.2 хувиар нэмэгдлээ.

ҮХАА-н сайдын 2014 оны А/58 тушаалаар 10 нэр төрлийн 11172.4 кг ногооны үрийг хуваарийн дагуу 21 аймаг, нийслэлийн сум, дүүргүүдэд аймгуудын ҮХААГ, хотын ХААГ-аар дамжуулан олгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Үүний үр дүнд 550 гаруй га талбайд ногоо тарьж, 6.2 мянган тн ургац хурааж авлаа. 2014 онд Усалгаатай төмс, хүнсний ногооны талбайн хэмжээг 1.1 мян.га-аар нэмэгдүүлэв.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 25 морины хүчтэй бага оврын 5250 трактор худалдан авч, 2012 онд 540, 2013 онд 356 тракторыг иргэн, аж ахуйн нэгжид 50 хувийн урьдчилгаа төлбөртэйгээр 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан олгов. Өрхийн тариаланг механикжуулах зорилгоор төмс, хүнсний ногооны иж бүрдэл 528 техник (мотоблок) худалдан авсан бөгөөд 156 техникийг иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцөлөөр гэрээгээр олгосон байна.

2013 онд улсын төсвийн 1331.0 сая төгрөгийн хөрөнгөөр бага оврын тракторт нийцсэн хүнсний ногооны сийрүүлүүр, үрлүүр, хураагчийн 110 иж бүрдэл, төмсний 38 үрлүүр, 38 хураагч, үрсэлгээ суулгагч 33 машиныг иргэн, аж ахуйн нэгжид 20 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай лизингээр олгож байна.

Хүнсний ногооны тариалан эрхэлдэг иргэд, ногоочдын бүлэг, хоршоодыг усалгааны тоног төхөөрөмжөөр тоноглоход зориулж 3 хүртэл га талбайг услах хүчин чадал бүхий 280 ширхэг зөөврийн усалгааны систем, усан сангийн иж бүрдлийг 20 хувийн урьдчилгаатай 4 жилийн хугацаатай зээлээр олгохоор шийдвэрлээд байна.

2013 онд хүнсний ногооны үйлдвэрлэлийн техник хангамж 40 хувьтай болж, 600 га талбайн тариалалт хураалтыг механикжуулах, 840 га талбайн усан хангамжийг сайжруулах боломж бүрдлээ.

2013 онд улсын хэмжээнд хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээ 53.4 мянган га боллоо.

2012 оны байдлаар улсын хэмжээнд 170.0 мянган тоннын багтаамжтай хүнсний ногооны зорийг ашиглаж байсан.

“Улаанбаатар хот орчимд хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн зоорь, агуулах, махны дагнасан болон төрөлжсөн бөөний, жижиглэн худалдааны төв шинээр байгуулах, өргөжүүлэх” чиглэлээр төсөл шалгаруулж 27 аж ахуйн нэгжид харилцагч арилжааны банкуудаас нийт 74.9 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Үүний дүнд төмс, хүнсний ногооны зорийн багтаамж 37 хувиар нэмэгдэж 248.7 мянган тоннд хүрч жилдээ хураан авах төмс, хүнсний ногооны зорийн хангамж 71,0 хувьд хүрнэ. 2014 онд нийт хүнсний ногооны 6800 тонн зоорь ашиглалтанд орсон. **/50 хувь/**

**97.** Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээг хангах, аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих

**Биелэлт:** 2013 онд 4.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараах услалтын системүүдийг ашиглалтад оруулснаар 1076 га талбайг нэмж усалгаажуулах, үүнээс усалгаатай төмс, хүнсний ногооны талбайн хэмжээг 1.1 мянган га-аар нэмэгдүүлэх боломжтой болсон. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын “Цонжийн хөдөө”-гийн 150 га талбайг услах хүчин чадал бүхий услалтын системийн 1-р ээлж
- Толбо сумын Шумекийн 114.4 га талбайг услах хүчин чадал бүхий услалтын системийн 2 дугаар ээлж
- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 20 га талбайг услах хүчин чадал бүхий Эхийн голын услалтын систем
- Баянлиг сумын 60 га талбайг услах хүчин чадал бүхий Баянлигийн услалтын систем
- Галуут сумын 84.7 га талбайг услах хүчин чадал бүхий Талын толгойн услалтын систем
- Баянцагаан сумын 64.9 га талбайг услах хүчин чадал бүхий Цагдуултайн услалтын систем
- Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 13 га талбайг услах хүчин чадал бүхий Найрын дэнжийн услалтын систем
- Төв аймгийн Борнуурын 2 дугаар ээлжийн 2 дугаар хэсгийн
- Дархан-Уул аймгийн 5 га талбайг услах хүчин чадал бүхий Бүрэнтолгойн услалтын систем
- Ховд аймгийн Ховд сумын Буянтын услалтын системийн 3 дугаар хэсэг

2012 онд хүнсний нарийн ногооны усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 50.9 мянган га байсан бол 2013 онд талбайн хэмжээг 2468 га-аар нэмэгдүүлэн, нийт усалгаатай талбайн хэмжээг 53.4 мянган га-д хүргэлээ.

2014 онд 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Баянхонгор, Төв, Орхон, Өвөрхангай аймагт төрийн болон орон нутгийн өмчлөлийн 7 услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлаж ашиглалтанд оруулснаар усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 2015 онд 674.0 га-аар нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. 2014 онд усалгаатай талбайн хэмжээг 525 га-аар нэмэгдүүлснээр нийт усалгаатай газар тариалан 54.0 мянгад хүрч өмнөх оныхоос 0.9 хувиар өсч зорилтот түвшингийн биелэлт 67.5 хувь байна.

Улсын 2014 оны төсвийн 256.1 сая төгрөгөөр гүйцэтгэх Орхон аймгийн Жаргалант сумын Хангалын голын 305.0 мянган шоо метр багтаамж бүхий ус хуримтлуулах шороон боомтыг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгч “Монгол менежмент төв” ХХК-тай гэрээ байгуулж улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулав. Уг байгууламжийг ашиглалтад оруулснаар 200 га талбайн усан хангамж сайжирч, ус хуримтлуулах усан сангийн хэмжээ 11.1 сая.шоо метрт хүрэв.

**/60 хувь/**

**98.** Боловсруулах үйлдвэр байгуулан Монгол Улсад олборлож байгаа ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрт эхний ээлжинд нийлүүлдэг болох

**Биелэлт:** УИХ-ын 2014 оны 7-р сарын 1-ний өдрийн нэгдсэн чуулганаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан. Уг хуулийн 35.11-д “Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ” гэсэн зохицуулалт орсон. **/90 хувь/**

**99.** Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт тусгасны дагуу газрын тос боловсруулах үйлдвэр барьж, боловсруулах үйлдвэрийн төрийн эзэмшлийн хувь хэмжээ болон үйлдвэрийн байршлыг оновчтой тогтоох

**Биелэлт:** “Дархан” газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төслийг ҮАБЗ-ийн 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцээд “*Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах*” Зөвлөмжийг гаргасан.

“Дархан” газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төслийг Монгол улсын төр засгаас гаргасан бодлогын баримт бичгүүдтэй (ҮАБГ-ын Зөвлөмж, “Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”, “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”, “Газрын тосны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга) уялдуулан, хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан аж үйлдвэрийн шинэ төвүүд болон газрын тосны ирээдүй бүхий ордуудтай аль болох ойр байршуулах боломжийг судалж байж шийдвэрлэхээр болсон. **/30 хувь/**

**100.** Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг бий болгох

**Биелэлт:** Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журмыг “Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн талаар авах зарим арга хэмжээний” Засгийн газрын 2012 оны 126 дугаар тогтоолоор баталсан.

Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээнд гарсан өөрчлөлттэй уялдуулан Засгийн газрын 2013 оны 352 дугаар тогтоолоор 2014 онд бүрдүүлэх компанийн

нөөцийн хэмжээг 2012 оны 126 дугаар тогтоолоор заагдсан 70200 тонноос нэмэгдүүлэн 80480 тонн болгон шинэчлэн тогтоолоо.

Рашаантын газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилга угсралтын ажлын санхүүжилт 2013 оны төсөвт тусгагдаагүй тул ажил зогсоод байна. Иймд уг байгууламжийн ажлыг БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар үргэлжлүүлэн санхүүжүүлэх талаар хэлэлцээр хийж байна.

ОХУ-аас худалдан авч байгаа газрын тосны бүтээгдэхүүний хамаарлыг бууруулах ажлын хүрээнд БНХАУ, БНСУ, Швейцарь Улс зэрэг олон эх үүсвэртэй яриа хэлэлцээр явуулсны дүнд БНХАУ-ын "Чайна Ойл" компаниас сард 10000 тонн бүтээгдэхүүн импортоор авах гэрээг "НИК", "Магнай Трейд", "Шунхлай" компаниуд байгуулж, Монгол Улсын жижиглэнгийн зах зээлд "Монгол-93" нэртэйгээр борлуулж эхэлсэн.

Түүнчлэн БНСУ-аас сард 5000-10000 тонн бүтээгдэхүүн авахаар харилцан тохирч гэрээ байгуулах шатанд явж байна.

Швейцарийн "Ганвор" компаниас 2013 оны эхний 3 сарын байдлаар нийт 120000 тонн газрын тосны бүтээгдэхүүн аваад байна. Цаашид тус компанийн зүгээс манай импортлогч аж ахуйн нэгж байгууллагад тавьж буй худалдааны үндсэн нөхцөлүүдийг Монголын талд таатай байхаар яриа хэлэлцээг үргэлжлүүлж байна.

Кувейт, АНЭУ, Япон улсаас газрын тосны бүтээгдэхүүн авахаар яриа хэлэлцээрийг үргэлжлүүлж байна. Японы "Сожицү" корпорацитай эхний хэлэлцээрийг хийсэн бөгөөд бүтээгдэхүүний үнэ, төлбөрийн нөхцөлийн талаар харилцан санал солилцоод байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хувьд ОХУ-ын "Роснефть" компаниас 98 хувийн хараат байсныг задалж, 30 хувийн хамааралтай болгон зах зээлийн төрөлжүүлэлтийг амжилттай хийж чадлаа.

2014 оны эхний хагас жилийн байдлаар импортолсон нийт шатахууны 74 хувийг ОХУ-аас, 5 хувийг БНХАУ-аас, 9 хувийг БНСУ-аас, 9 хувийг Белорусаас үлдэх хувийг бусад улсаас тус тус импортлосон байна. **/90 хувь/**

**101.** Шатахууны бөөний худалдаанд татварын хөнгөлөлт эдлүүлдэг тогтолцоог өөрчилж, жижиглэнгийн үнийг тогтворжуулах бодлого барих

**Биелэлт:** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хүрээнд импортын автобензин, дизелийн түлшний гааль, онцгой, нэмэгдсэн өртгийн албан татварыг зарим салбарын онцлогийг харгалзан Засгийн газар ялгавартай тогтоох тухай холбогдох хуулиудад нэмэлт оруулах тухай хууль, тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр баталсан.

Тус хуулийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгаж, ханшийн болон хилийн үнийн өсөлтийн эрсдэлээс хамгаалах зорилгоор "Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2013 оны 236 дугаар тогтоолоор импортын газрын тосны бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг шинэчлэн тогтоов.

Засгийн газрын 2012 оны 134 дүгээр тогтоолоор уул уурхайн болон газрын тосны салбарын онцлогийг харгалзан газрын тосны зарим бүтээгдэхүүний гааль, онцгой албан татварыг бөөний болон жижиглэнгийн борлуулалтын хувьд ялгавартай тогтоож байхаар шийдвэрлэсэн. Энэ тогтоолоор жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах, харин бөөний худалдаа нь зах зээлийн зарчмаар явах нөхцөлийг бүрдүүлж өгсөн. **/100 хувь/**

**102.** Төрөөс нүүрсний салбарт баримтлах бодлогыг тодорхойлох

**Биелэлт:** УИХ-аас баталсан "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын хүрээнд "Нүүрс", "Төмөр", "Хайлуур жонш", "Газрын ховор элемент", "Зэс", "Барилгын ашигт малтмал" зэрэг хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Үүний дагуу "Нүүрс" хөтөлбөрийн урьдчилсан загварыг боловсруулан, нүүрсний уурхай эрхлэгч, хувийн хэвшил, боловсруулах үйлдвэр болон төрийн бус байгууллагад танилцуулж, хэлэлцүүлэн гарсан саналыг хүлээн авч, холбогдох өөрчлөлтийг хийж байна.

Японы "ЖАЙКА" байгууллагатай хамтран "Нүүрсний салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г боловсруулаад байна. /30 хувь/

**103.** Нүүрснээс хий, шингэн түлш гаргах ажлыг эрчимжүүлж, шатдаг занар, нүүрсний химийн үйлдвэрийг хөгжүүлэх судалгааг хийх

**Биелэлт:** 2013 оны улсын төсөвт нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажилд 1.5 тэрбум төгрөг зарцуулахаар тусгасан. "Нүүрснээс шингэн түлш, хий үйлдвэрлэх үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах" зөвлөхөөр "Техностар" ХХК-ийг шалгаруулж, тайланг хүлээн авсан.

Нүүрс шингэрүүлж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 аж ахуйн нэгжид олгоод байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд тус бүртээ жилдээ 456 мянган тонн дизель түлш, 450 мянган тонн бензин, 100 мянган тонн шингэрүүлсэн хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүдийг байгуулж, 2017-2018 ашиглалтанд оруулах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулж, Эрдэс баялагийн зөвлөлөөр оруулж батлуулсан. Мөн түүнчлэн дотоодын түүхий тосон дээр түшиглэсэн газрын тос боловсруулах 1-2 сая тонны хүчин чадалтай үйлдвэрүүд байгуулахаар аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрлөө аваад ажиллаж байна.

"Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх тухай" Засгийн газрын 2013 оны 246 дугаар тогтоолоор Нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулах төрийн өмчийн 51 хувийн оролцоотой хувьцаат компани байгуулахаар шийдвэрлэсний дагуу Төрийн өмчийн хорооны 2013 оны 631 дугаар тогтоолоор хувьцаат компанийг байгуулаад байна.

Хүрэн нүүрс хийжүүлж нийлэг хийн түлш гарган авах үйлдвэр байгуулах чиглэлээр БНХАУ-ын "Синопек" групптэй хамтран ажиллахаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

"Жени ойл шейл Монголиа" ХХК-тай 5 жилийн хугацаатай шатдаг занарын чиглэлээр суурь судалгаа хийх гэрээг 2013 оны 4 дугаар сарын 12-нд байгуулсан. 2013 онд тус компани Төв, Булган, Дундговь аймгуудын 16 сумдын нутаг дэвсгэрт шатдаг занарын судалгааны гэрээг хэрэгжүүлж байгаа бөгөөд 5000 км<sup>2</sup> талбайд 1:50000 масштабтай геологийн зураглалын ажил, 1674 физик цэгт хүндийн хүчний судалгааны ажил хийсэн. Мөн 508 тууш метр ба 552 тууш метрийн гүнтэй 2 цооног өрөмдөн дээж авч шинжлүүлсэн байна. Шинжилгээний дүнд гэрээт талбайн шатдаг занар нь 12-23 хувийн органик нүүрстөрөгчийн агуулгатай, хүхэр болон чийгийн хэмжээ бага, керогеноос тос үүсэх гарц өндөр тул цаашид судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай гэж дүгнээд байна. Энэ ажлын хүрээнд Төв аймгийн Эрдэнэсант суманд эрлийн ажил хийж, хэд хэдэн газар өрөм тавьсан боловч Эрдэнэсант сумын удирдлага болон орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч ажил зогссон.

2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Японы Шинэ эрчим хүчний байгууллага (NEDO)-с Монгол Улсын хүрэн нүүрс боловсруулж, хагас коксон утаагүй цэвэр түлш үйлдвэрлэх туршилтын үйлдвэр барьж байгуулах нээлттэй тендер зарлаад байна.

/90 хувь/

**104.** Хийн түлшний аюулгүйн ажиллагааг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хийн түлшний тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, борлуулалт зэрэг үйл ажиллагаанд тавих стандарт, нормыг сайжруулах

**Биелэлт:** "Төрөөс хийн түлшний талаар баримтлах бодлого", хийн түлшний талаар хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулав.

Хийн түлшний тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, борлуулалтад тавих стандартыг Газрын тос, байгалийн хийн стандартын дэд хороогоор хэлэлцүүлэн батлуулахаар боловсруулаад байна.

Засгийн газрын 2011 оны 297 дугаар тогтоолоор баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын болон гаалийн тарифаас чөлөөлөх хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж байна.

2013-2014 оны Стандартчиллын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Газрын тос, байгалийн хийн аюулгүй байдлын стандарт “Биодизелийн түлш. Техникийн шаардлага MNS 6381:2013”, “Хийн тоолуур. Хэмжил зүйн болон техникийн ерөнхий шаардлага” OIML R 1376.1;2 стандартыг үндэсний стандартаар тус тус баталсан.

Шингэрүүлсэн шатдаг хийн түлшний техник ашиглалт, аюулгүйн ажиллагааг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хийн түлшний тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, борлуулалт, ашиглалт хэрэглээ зэрэг үйл ажиллагаанд тавих стандарт, нормыг сайжруулах төслийг боловсруулж байна. **/50 хувь/**

## **7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого**

**105.** Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, тус салбарын хэмжээнд мөрдөх стандарт, ёс зүйн дүрэм, үйлчилгээний зэрэглэл, тарифын зохицуулалтыг батлах эрх олгох

**Биелэлт:** Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, тус салбарын хэмжээнд мөрдөх стандарт, ёс зүйн дүрэм, үйлчилгээний зэрэглэл, тарифын зохицуулалтыг батлах эрх олгох зохицуулалтыг бий болгохтой холбоотой хуулийн төслийг боловсруулж байна. **/30 хувь/**

**106.** Аж үйлдвэрийн болон экологийн тэргүүлэх хөгжлийн бүсүүдийг тогтоож, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлэх

**Биелэлт:** Боловсруулах үйлдвэрийн чиглэл, байрлалыг тогтоох талаар санал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

“Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” төслийн судалгааны ажлыг хийж, ажлын эхний тайланг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авав.

Мөн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг өргөтгөх, Дархан-Сэлэнгийн бүсийн Төмөртолгой, Төмөртэй, Баянгол, Хуст уулын төмрийн ордуудыг түшиглэн 2010-2015 онуудад “Уул уурхай-хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төслийн хэрэгжилт 50 хувьтай байна.

“Дархан-Уул аймагт арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний “R&F” компанитай гэрээ байгуулан ТЭЗҮ боловсруулах ажлыг гүйцэтгүүлж 2013 оны 12 сард хүлээн авлаа.

“Хот байгуулалтын талаар төрөөс баримтлах бодлого”-ын төсөл, үзэл баримтлал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах тухай” 141 дүгээр тогтоол батлагдсан. **/40 хувь/**

**107.** Улсын Их Хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот” хөтөлбөр, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан төмөр замыг барьж байгуулах

**Биелэлт:** “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын 3.2.2, 3.2.4-т заасан төмөр замын Техник-эдийн засгийн үндэслэлийг “МакКинсей энд Компани”-иар ахлуулсан зөвлөх баг боловсруулж дуусгасан. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь эхний болон хоёр дахь үе шатны нийт 1766 км төмөр замыг хамруулсан. Үүнд:

Тавантолгой-Сайншанд чиглэлийн 468 км, Сайншанд-Хөөт чиглэлийн 450 км, Хөөт-Чойбалсан чиглэлийн 155 км, Хөөт-Нөмрөг чиглэлийн 380 км, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 46 км.

Геологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 14 компаниар трассын дагуух 1:50000 масштабтай гидрогеологийн зураглалыг хийж дуусгасан бөгөөд 1165 км-ын дагуух трассд 1:1000 масштабтай байр зүйн зураглалыг гаргасан.

Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд баригдах 267 км орчим төмөр замын суурь бүтцийг барих ажлын хүрээнд “Энержи Ресурс Рейл” ХХК-ийн “Samsung C&T” компанитай байгуулсан гэрээний эрх, үүргийг зохих журмын дагуу шилжүүлэн авч барилгын ерөнхий гүйцэтгэгчийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай Зам, тээврийн сайд, Төрийн өмчийн хорооны даргын хамтарсан тушаал гарсан.

“Samsung C&T” ХХК-тай гэрээ байгуулснаар Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд баригдах төмөр замын барилгын ажлыг 2013 оны 5 дугаар сард эхлүүлэв.

2014 оны 11 сарын байдлаар Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын нийт явц 51.2 хувь, газар шорооны ажил 79.5 хувь, Дам нуруун гүүр болон дөрвөлжин гүүрийн ажил 65.8 хувь, хоолойн ажил 63.7 хувьтай байна. Зүүн чиглэлийн төмөр замын зураг төсөл дууссан одоогоор тендерийн бичиг баримт боловсруулалт дуусах шатандаа орж байна зураг төсөл 100 хувь, тендерийн бичиг баримт боловсруулалт 78 хувьтай байна.

2014 оны 12 дугаар сарын байдлаар Тавантолгой-Сайншанд, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт зэрэг Тус чиглэлийн Техникийн зөвлөхөөр Япон улсын “Nippon Koei” ХХК-ийг олон улсын нээлттэй тендерээр шалгаруулж, 2013 оны 5 дугаар сарын 14-ний өдөр “Зөвлөх үйлчилгээ байгуулж ажлыг эхлүүлсэн ба одоогийн байдлаар техникийн зөвлөх нь тендерийн бэлтгэл ажил 70 хувьтай техникийн зураг төслийн нийт явц 100 хувьтай байгаа бөгөөд Ухаахудаг-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан-Эрээнцав, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын техникийн зураг төслийг боловсруулж дуусаад байна.

2014 оны 12 дугаар сарын байдлаар төслийн хүрээнд 2013 оны 28 дугаар тогтоолоос 25.40 сая ам.долларын санхүүжилт, 82 дугаар тогтоолоос 189.67 сая ам.долларын санхүүжилт, нийт 215.07 сая ам.долларын санхүүжилтыг зарцуулаад байна.

“Богдхан төмөр зам”-ын 170 км замын суурь бүтэц барих урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж, төслийн урьдчилсан зураг төслийг 6 хувилбараар боловсруулсан. Мөн Зам тээврийн сайд, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах санамж бичигт “Богдхан төмөр зам”-ын төслийг тусган төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. “Богдхан төмөр зам”-ын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах техникийн даалгаврыг баталсан.

Австралийн “Trimble” компанитай уулзалт хийж Мандал-Зуунмод-Мааньт чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтэц барьж байгуулах трассыг сонгосон бөгөөд УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-нд тусган батлуулсан. /50 хувь/

**108.** Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах

**Биелэлт:** - Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам - 50%

- Уньт-Тариалан чиглэлийн 88 км авто зам - 28.7%
- Тариалан-Мөрөн чиглэлийн 79 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дууссан.
- Тариалан-Мөрөн чиглэлийн 86.3 км замын барилгын ажлын 3 багцын гүйцэтгэл:
  - “Хотгор зам” ХХК /32 км/ - 99.0%
  - “Их монгол барилга” ХХК, “Хэрэм зам” ХХК-ийн түншлэл /25 км/ - 99.0%

- “Пик девелопмент” ХХК /29.3 км/ - 100%
- Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн 132.6 км хатуу хучилттай авто зам – 84.0%
- Улаангом-Наранбулаг чиглэлийн 90 км хатуу хучилттай авто зам - 100%
- Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам - 100%
- Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замын ажил дууссан.
- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 94 км авто замын 4 багцын барилгын ажил:
  - “Хансуун зам” ХХК /27 км/ - 98.0%
  - “Гашууны гол” ХХК /27.75 км/ - 100%
  - “Насны зам” ХХК /30 км/ - 100%
  - “33Б” ХХК-ийн түншлэл /10.65 км/ - 100%
- Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн 45.3 км хатуу хучилттай авто зам - 100%
- Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127 км хатуу хучилттай авто зам - 37.8%
- Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.5 км, Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 127 км, Алтай-Дарви чиглэлийн 263 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замын ажил эхлээгүй.
- Халзанбүргэдэй-Солонготын давааны чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам- 52%
- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам - 100%
- Элсэнтасархай-Хархорин чиглэлийн 77 км хатуу хучилттай авто зам - 72.0%
- Налайх /4-р зөрлөг/-Зуунмод чиглэлд 25 км хатуу хучилттай авто замын ажил дууссан.
- Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км авто зам - 100%
- Улаангом /Тээлийн гүүр/-Хяргас нуур чиглэлийн 100 км авто зам - 100%
- Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 107 км хатуу хучилттай авто замын ажил дууссан.
- Алтай-Баянхонгор чиглэлийн 128 км хатуу хучилттай авто замын ажил дууссан.
- Манхан-Дарви чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам - 100%

Ховд-Улаангом чиглэлийн 190 км, Тосонцэнгэлийн баруун талд орших 4 замын уулзвараас Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км, Улиастай-Дөрвөлжин чиглэлийн 113 км, Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн 104 км, Дөрвөлжин-Сархайрхан чиглэлийн 159 км, Сархайрхан-Мянгадын гүүр чиглэлийн 158 км, Улиастай-Алтай чиглэлийн 139 км, Өндөрхаан-Норовлин чиглэлийн 200 км, Даланзадгад-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 251 км, Баянзүрхийн товчоо-Налайх чиглэлийн авто замын зураг боловсруулагдсан, зам барилгын ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна. /60 хувь/

#### 109. Улаанбаатар хотын хатуу хучилттай авто замыг бүрэн шинэчлэх

**Биелэлт:** Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах чиглэлээр “Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын төсөв, Хөгжлийн банкны санхүүжилт, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2013 онд нийт 53.44 км авто замыг өргөтгөн шинэчилж, 24.1 км замыг шинээр барьсан байна. Улс, нийслэлийн төсөв, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод 2012-2014 онуудад нийт 138,64 км авто замыг өргөтгөн шинэчилсэн.

Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах чиглэлээр Монгол улсын төсөв, “Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөр”-ийн хүрээнд Хөгжлийн банкны санхүүжилт, гадаадын зээл тусламж, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2012 - 2014 онуудад нийт 66.98 км авто замыг шинээр барьсан. /50 хувь/



**110.** Улаанбаатар хотын авто замын сүлжээг тойрог замын системд шилжүүлж, гүүрэн гарц, хоёр түвшний уулзварыг шаардлагатай газарт барьж байгуулах

**Биелэлт:** БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Улаанбаатар хотод 6 гүүрэн гарц, олон түвшний огтлолцол барих төслийн гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулсан.

Уг ажлын хүрээнд Баруун 4 замын уулзвар, Яармагийн гүүрийг хос болгон өргөтгөн шинэчлэх, Замын цагдаагийн газрын баруун уулзвар дээр баригдах гүүрэн гарц, олон түвшний огтлолцлын зураг төслийн болон барилгын ажлын гэрээг БНХАУ-ын “Чайна Интернэшнл Рэйлвэй”, “Төмөр замын 20 товчооны групп корпораци” компаниудтай тус тус байгуулсан.

ЭЗХЯ-наас эдгээр 3 ажлыг гэрээ хийгдээгүй бусад ажлуудын хамт зогсоон “Гудамж” төслийн хүрээнд баригдах хурдны замын төлөвлөлттэй уялдуулж хийхээр шийдвэрлэсэн.

Баруун 4 замын уулзвар, Баянбүрд дээр баригдах олон түвшний огтлолцол, Толгойт-Сонсголонгийн замын уулзварт баригдах гүүрэн гарцын талаар тодорхой шийдвэр гараагүй. **/10 хувь/**

**111.** Транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам барьж ашиглалтад оруулах

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 99 дүгээр тогтоолын дагуу “Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн хурдны авто зам төсөл”-ийн концессын гэрээний нөхцөлийн талаар “Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” түншлэлтэй гэрээний хэлэлцээ хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд байна.

Гэрээний дагуу тус түншлэл 9 сарын дотор ТЭЗҮ, зураг төслийг боловсруулан батлуулж, санхүүжилтийн гэрээг байгуулах бөгөөд 3 жилийн дотор зам барилгын ажлыг гүйцэтгэнэ. **/10 хувь/**

**112.** Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярант, Ховд-Улаангом чиглэлийн авто замыг ашиглалтад оруулах

**Биелэлт:** - Ховд аймгийн Бага улаан даваа-Манхан чиглэлийн 103.3 км, орон нутагтай холбосон 20 км авто зам - 80.0%

- Тэмээнхүзүү-Бага улаан даваа чиглэлийн 110.8 км хатуу хучилттай авто зам- 100%
- Манхан-Ховд чиглэлийн 85.3 км хатуу хучилттай авто зам- 100%
- Өлгий-Цагааннуур чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам-90.0%
- Хашаатын даваа-Өлгий чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам- 100%
- Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25 км хатуу хучилттай авто замын ажил эхлээгүй. **/80 хувь/**

**113.** Улаанбаатар-Замын-Үүдийн авто замыг тэргүүн ээлжид ашиглалтад оруулж, Замын-Үүдийн хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлснээр инфляцийн зохиомол хөөрөгдлийг бууруулах

**Биелэлт:** Чойр-Сайншанд чиглэлийн 176.4 км хатуу хучилттай авто зам - 100%

Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 124 км хатуу хучилттай авто зам - 100%

Замын-Үүдийн Шалган нэвтрүүлэх цогцолборын өргөтгөлийн зам талбайн ажил бүрэн дууссан бөгөөд 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хөдөлгөөн нээсэн. Улсын комисс ажиллаж байна. **/90 хувь/**

**114.** Далайд гарцгүй орны хувьд агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин хөгжүүлэх

**Биелэлт:** УИХ-ын 2013 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого” батлагдсан. /90 хувь/

**115.** Хөшигийн хөндийд шинээр барих олон улсын нисэх онгоцны буудлыг олон улсын зорчигч болон ачаа тээврийн өрсөлдөх чадвар бүхий төв болгох

**Биелэлт:** Төслийн барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч “Мицубиши, Чиёда” компаниудын түншлэлтэй ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, нисэх буудлын барилгын ажлыг 2013 оны 6 дугаар сард эхлүүлсэн.

Зам тээврийн яамны дэргэд Ложистикийн нэгж байгуулж ажлыг АХБ-тай хамтран гүйцэтгэж байна.

Улаанбаатар холимог тээврийн нэгдсэн терминалыг Хөшигийн хөндий дэх шинэ нисэх онгоцны буудлын дэргэд байгуулахаар тохиролцон, “Улаанбаатар хотын 2020 он хүртэл ерөнхий төлөвлөгөө”-нд тусгасан.

“Шинэ хотыг байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулж байна.

Хөшигийн хөндийд баригдах олон улсын шинэ нисэх буудлыг даган бий болох хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай 500.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг 2013 оны улсын төсвийн тухай хуульд тусгуулан батлуулсан ч төсвийн тодотголоор хасагдсан тул зөвлөхийн тендер шалгаруулалт хүчингүй болсон. /50 хувь/

**116.** Агаарын тээврийн салбарыг өмчийн олон хэлбэртэй, чөлөөт өрсөлдөөнтэй болгох бодлогыг 2016 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлэх

**Биелэлт:** Иргэний нисэхийн ерөнхий газраас “Агаарын навигацийг хөгжүүлэх төсөл”, “Нисэх буудлыг хөгжүүлэх төсөл”-ийн зээлийн эргэн төлөлтийг 2014 онд дуусгах, бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй уялдуулан “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын зарчмаар ажиллуулах асуудлыг хойшлуулсан.

Нислэггүй байгаа нисэх буудлын зах зээл, багтаамжийг судлаж нислэг үйлдэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Зам, тээврийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тушаалаар үүрэг өгч судалгааны ажлыг гүйцэтгэж байна. Орон нутгийн нисэх буудлуудын менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх судалгааны ажил хийгдэж байна.

Говь-Алтайн нисэх буудлын ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд цагт 100 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай, өөрийн бие даасан халаалт, дэд бүтэцтэй нисэх буудлын барилга байгууламжийг шинээр ашиглаж эхэлсэн бөгөөд хөөрч буух зурвасын барилгын ажлыг 80 хувьтай гүйцэтгэж байна.

Донойн нисэх буудлын перонд шинээр газардуулга хийсэн бөгөөд зорчигч үйлчилгээний барилгын их засварын ажлыг “АЧТТР” ХХК гүйцэтгэж байна. Мөн хатуу хучилт бүхий аэродромын барилга угсралтын ажил 68 хувьтай байна.

Сүхбаатар, Мандалговийн нисэх буудлуудын хөөрч буух шороон зурваст засвар хийсэн.

Хужирт, Эрдэнэт, Баруун-Урт, Арвайхээр, Өндөрхаан, Мандалговь нисэх буудлын үйл ажиллагааг сэргээх зорилгоор дээрх нисэх буудлуудын одоогийн байдал, үйл ажиллагааг сэргээхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх тооцоо, судалгааг хийж дуусгаад байна.

Баруун-Уртын чиглэлд татаастай нислэг үйлдэх эдийн засгийн тооцоог хийж, нислэг үйлдүүлэх тендерт “Тэнгэрийн улаач шинэ” ХХК шалгарч долоо хоногт тогтмол 1 удаа нислэг хийж байна. /40 хувь/

**117.** “МИАТ” ХК-д үндэсний агаарын тээвэрлэгчийн статус олгож, түүний 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгах

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 72 дугаар тогтоолоор “МИАТ” ТӨХК-д “Үндэсний агаарын тээвэрлэгч” статус олгож, тус компанийн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулж байна.

“МИАТ” ХК-ийн 49 хүртэл хувийг дотоодын агаарын тээврийн компаниудад давуу эрхээр хувьчлах заалтыг “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-оос хассан.

“Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн Төрийн эзэмшлийн хувийг бууруулах буюу Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалтад “МИАТ” ТӨХК орсон бөгөөд компаний 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 49 хувийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахаар тусгаад байна. /60 хувь/

**118.** Автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг боловсронгуй болгож, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэн авто тээврийн хөдөлгөөнийг улсын хэмжээнд хянах төв байгуулах

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 336 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төвийг аж ахуйн тооцоотой төрийн өмчит компани болгон өөрчлөн байгуулсан. Үүнтэй холбогдуулан тус төвийн үйл ажиллагааны дүрэм болон бүтцэд нэгдсэн тээврийн судалгаа, мэдээллийн алба байгуулахаар тусган хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

Тээврийн хэрэгслийн нэгдсэн хяналтын төвийг Автотээврийн үндэсний төвийн бүтцэд оруулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

Тээврийн удирдлага, хяналтын шинэ төвийн GPS программд холбогдох дэлгэц болон бусад төхөөрөмжийг Орхон, Дархан, Сэлэнгэ, Баянхонгор, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Ховд зэрэг аймгуудад суурилуулаад байна.

Нэгдсэн тээврийн судалгаа, мэдээллийн төв байгуулах эдийн засгийн үндэслэл, тооцоо, судалгааны ажлыг хийж байна. Холбогдох албан хаагчдыг БНСУ-д сургаж, мэргэшил дээшлүүлсэн.

Улсын чанартай авто зам дагуу шилэн кабель суурилуулах хөрөнгө 2014 оны төсөвт тусгагдаагүй. /60 хувь/

**119.** Олон улсын жишигт нийцсэн орчин үеийн терминал төвийг Замын-Үүд, Алтанбулаг, Улаанбаатар хотод байгуулах

**Биелэлт:** Замын-Үүдэд жилд 6.0 сая тонн ачаа боловсруулах хүчин чадалтай холимог тээврийн ачааны терминал, ложистикийн төв байгуулах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр Замын-Үүдийн холимог тээврийн терминал, ложистикийн төвийг байгуулахад зориулж 40.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 5.0 сая ам.долларын буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэсэн болно.

Замын-Үүд олон улсын жишигт нийцсэн орчин үеийн терминал төв байгуулах хүрээнд дараах ажлыг хийгээд байна:

- 2013 оны улсын төсөвт нийт 9.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгуулсан;
- 400 га газар эзэмших гэрчилгээг Төмөр замын газрын нэр дээр авч, кадастрын зургийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж улсын бүртгэлд бүртгүүлсэн;
- Австралийн “SMEC” компанитай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн;

2014 оны 9 дүгээр сарын 20-ны байдлаар улсын чанартай АН-3 авто замаас ложистикийн төв хүртэлх 1.6 км авто замын барилгын ажлын явц 87%, төмөр зам дээгүүр баригдах 19 м урт төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил 88 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ложистикийн төвийн бусад зураг төсөл, барилгын ажлын гүйцэтгэл 2014 оны байдлаар:

- “Ийстерн рөүд” компаний хийж буй Ложистикийн төвийн 1.6 км авто зам болон төмөр зам дээгүүр баригдах 19 м урт төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил– 98%
- “Баясал төгс” ХХК-ийн хийж буй Ложистикийн төвийн гадна цахилгаан хангамжийн зураг төсөв боловсруулах ажил– 100%
- “Лийд линк” ХХК-ийн Ложистикийн төвийн гадна холбоо хангамжийн ажлын гүйцэтгэл – 64,6% байна. /50 хувь/

**120.** “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, гурав дахь үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтэц (нийт 3600 орчим км)-ийн судалгааг дуусгах

**Биелэлт:** Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудал Оросын талын идэвхгүй байдлаас шалтгаалан зогсонги байдалд байна.

2014 оны 10 дугаар сарын 13-15-нд хуралдсан Монгол-Оросын Засгийн газар хоорондын комисс, түүний дэргэдэх Тээврийн ажлын хэсгийн хурлаар хоёр талын Тээврийн яамд эрх хэмжээнийхээ хүрээнд 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх шаардлага байгаа эсэх, үндэслэлийг хамтран судлахаар тохиролцож хуралдааны протоколд тусгасан.

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хорооны 2013 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдааны үеэр “Улаанбаатар төмөр замыг 2015 он хүртэл хөгжүүлэх, техникийн шинэчлэл хийх хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрийн эхний шатны хэсгийг хэрэгжүүлэх, цаашид Улаанбаатар төмөр замын дамжин өнгөрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар төмөр замыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулахаар ажиллаж байна.

2014 оны 9 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр “Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”-ийг байгуулсан. Тус хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын баруун бүс нутгаар дайрах төмөр замын дамжин өнгөрөх шинэ коридор байгуулах асуудлыг Монгол, Орос, Хятад гурван талаараа хамтран судлах, эдийн засгийн үндэслэлийг хамтран тодорхойлох нь зүйтэй гэж үзэж Оросын талтай тохиролцсон.

Гурав дахь үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтцийн Техник-эдийн засгийн урьдчилсан үндэслэлийг хийлгэхэд шаардагдах 9.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг “Хөгжлийн банкны санхүүжилтээр 2014 онд улсын хэмжээнд хийх ажлын төлөвлөгөө”-ний төсөлд тусгаад байна. /30 хувь/

**121.** Далайн тээврийн салбарт тэргүүлэгч орнуудтай хамтран далайн тээврийн үйл ажиллагааг эхлүүлж, тухайн салбарт үндэсний ажилтан, мэргэжилтнүүдийг ажиллуулах арга хэмжээ авах

**Биелэлт:** Монгол, Солонгосын Далайн тээврийн хамтын ажиллагааны 5 дахь удаагийн уулзалтыг 2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулж БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яамтай далайн тээврийн хамтарсан компани байгуулах гэрээнд гарын үзэг зурсан.

Монгол, Солонгосын далайн тээврийн салбарын хамтын ажиллагааны ээлжит ажлын уулзалтыг Улаанбаатар хотноо 2014 оны 11 дүгээр сарын 3-6-ны өдрүүдэд зохион байгуулж, БНСУ-ын “САММОК Шиппинг” компаниас Монголын талаас энэ удаа ямарваа шалтгаангүйгээр хуваарийн дагуу оруулах ёстой хөрөнгө оруулалтыг 2014 оны 11 дүгээр сард багтаан хийсэн тохиолдолд тухайн оны 12 сарын эхээр хамтарсан

компанийг БНСУ-д бүртгүүлэх талаар БНСУ-ын Далайн хэргийн яамнаас дэмжлэг хүлээн авна гэж тохирсон.

БНСУ-ын Бусан хотын Далайн тээвэр, загас агнуурын технологийн дээд сургуульд 10 оюутанг сургаж төгсгөөд байна. БНСУ-ын Далайн Их сургуульд хөлөг онгоцны механик инженерийн /бакалавр/ мэргэжлээр нэг оюутан суралцаж байна. Мөн тус улсын Далайн тээвэр, загасны аж ахуйн технологийн дээд сургууль (KIMFT)-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу далайн мэргэжлийн ажилтан бэлтгэх 1 жил 8 сарын сургалтад 10 хүнийг сонгон шалгаруулж, суралцуулав. **/70 хувь/**

**122.** “Шинэ Улаанбаатар” төслийн хүрээнд хот төлөвлөлтийг шинээр хийж, нэгдсэн бодлогоор инженерийн дэд бүтцийг байгуулан, иж бүрэн 17 хорооллыг байгуулах. Нийслэлийн алслагдсан дүүрэг, дагуул хотын хөгжлийг бодлогоор дэмжиж, иргэдийн суурьших бүсийг тэлнэ.

**Биелэлт:** УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-г баталсан.

“Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бүсчлэл, инженер геологи, газар хөдлөлийн мужлалын нарийвчилсан зураг төсөл боловсруулах” ажлын гүйцэтгэгчээр Нийслэлийн зураг төслийн хүрээлэнг шалгаруулж, ажлыг эхлүүлээд байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Налайх дүүргийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар “Нью Урбанизм” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Улаанбаатар хотын Багануур дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг баталж, “Арт констракшн” ХХК, “ХБХДТ” ХХК-иудын түншлэлтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Төв аймгийн “Шинэ Зуунмод”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаагүй тул ажил хийгдээгүй байна.

Засгийн газрын 2013 оны 118-р тогтоолоор Улаанбаатар хотод орон сууцны 10 хороолол болон гэр хорооллын 12 байршилд инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний 91 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. Эдгээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 415 тэрбум 989,0 сая төгрөг шаардлагатайгаас 2013 онд 199 тэрбум 697 сая төгрөг шаардагдах бөгөөд санхүүжилтийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан үе шаттай санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

“Шинэ яармаг”, “14-р хороолол”, “Ирээдүй цогцолбор” хорооллын цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил үргэлжилж байна.

Баянгол 110/35/10 кВ-ын 2х40 МВА дэд станц, Сонгино дэд станцаас Баянгол дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт, 22 км ЦДАШ-ын барилга угсралтын ажил, 110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, хоёр хэлхээт ЦДАШ-ын ажлын зураг төсөл, барилга угсралтын ажил графикийн дагуу хийгдэж байна.

2013 онд Буянт-Ухаа хороололд цэвэр усны эх үүсвэрийн 20 гүний худаг, 2800 м<sup>3</sup>-ийн багтаамжтай усан сан 2, ф400мм-ийн 2863 м хос шугам, 10.0 мянган м кольцо шугам, бохир усны ф200мм-ийн 2242 м хос шугам, 2 насос станц, Баянголын аманд цахилгааны 33 иж бүрдэл хуваарилах байгууламж, 59.9 км кабель шугам, 10 кВ-ын кабель шугам, цахилгааны дэд өртөөнүүдийг барьж дуусган, ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2013 оны 12-р сард ажиллуулсан.

Буянт-Ухаа хороололд баригдах 20000 м<sup>3</sup> хүчин чадалтай бохир усны цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Мөн Ирээдүй болон Яармагийн гүүр орчмын хорооллын инженерийн дэд бүтцийн ажлууд хийгдсэн. 2013 оны төлөвлөгөөт ажил бүрэн биелсэн.

2014 онд Яармагийн орон сууцны хорооллын цэвэр, бохир ус, дулааны гол шугамын ажил, Ирээдүй, Солонго хорооллын цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах

татуурга, VII, XIV, МҮОНРТ-ийн орчмын хорооллын ЦТП, гэр хорооллын дэд бүтцийн ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгэж байна.

"Улаанбаатар хотын холбооны сувагчлалын шинэчилэл, худаг сувагчлалын цагираган сүлжээ байгуулах" төслийн хүрээнд 2013 онд 12 км, 2014 онд 18 км худаг сувагчлалын ажлыг хийлээ. **/50 хувь/**

**123.** Бүх аймгийн төв болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгон өөрчлөх

**Биелэлт:** Аймгийн төвүүд болон 15000-аас дээш хүн амтай суурин газруудыг улсын зэрэглэлтэй хот болгох тухай танилцуулгыг оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэгт тулгуурлан бэлтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, тогтоолыг гаргуулж ирүүлэх үүргийг нийслэл болон аймгийн Засаг дарга нарт өгч, хариуг хүлээн авч нэгтгэн боловсруулсан.

"Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг бэлтгэн Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Ерөнхий сайдын 2014 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 03 дугаар захирамжаар "Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох тухай" асуудлын хууль, эрх зүйн орчныг судлан дүгнэлт гаргах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

"Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох тухай" асуудалтай холбогдуулан аймгийн болон аймгийн төв-хотуудын оршин байгаа сумын Засаг дарга, Тамгын газар, Хотын захирагч, Захирагчийн ажлын алба давхцан ажиллах үндэслэлийг авч үзэж, "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулав. **/40 хувь/**

**124.** Хот, суурин газрыг иргэддээ нээлттэй, иргэдийн оролцоотойгоор асуудлаа шийдвэрлэхэд чиглэсэн дүрэмтэй болгох

**Биелэлт:** Улаанбаатар хотын Үндсэн дүрэм болон бусад салбар дүрмийн төсөл дээр ажиллах зөвлөхийн нээлттэй сонгон шалгаруулалтыг Азийн сантай хамтран зохион байгуулсан. Төслийн гүйцэтгэгч байгууллага, Азийн сангийн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр дараах дүрмийн төслийг боловсруулж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын саналыг авч тусган олон нийтээр хэлэлцүүлэхэд бэлэн боллоо. Үүнд: Сургуулийн сурагчдыг тээвэрлэх үйлчилгээний дүрэм, Такси үйлчилгээний тээврийн хэрэгслийн дүрэм, Замын хөдөлгөөний зохицуулалт, аюулгүй байдлын дүрэм, Ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын дүрэм, Мал, тэжээвэр амьтны дүрэм, Гудамж, зам, талбайн дүрэм, Хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дүрэм, Галын аюулгүй байдлын дүрэм зэрэг 28 дүрэм. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ухаалаг Улаанбаатар хөгжлийн хороогоор 2 удаа, Хууль, төрийн байгууллалтын хороогоор 1 удаа, Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн 2014 оны 9-р сарын 17-ны өдрийн хурлаар "Хотын дүрэм боловсруулах" төслийн явцыг танилцуулсан.

Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж нийслэл хотын дагуул, харьяа хотыг сонгож, хотын багц дүрмийг баталж, хэрэгжүүлэхээр болсны дагуу Налайх, Багануур хотын Үндсэн дүрмийн төслийг боловсруулж 2014 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдөр Налайх, Багануур дүүргийн иргэдээр хэлэлцүүлээд байна.

**/50 хувь/**

**125.** Иргэдийн оролцоотойгоор хотын дахин төлөвлөлтийг хийж, гэр хорооллын цахилгаан, цэвэр ус, авто замын асуудлыг нэгдсэн байдлаар, бусад дэд бүтцийг бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэх замаар Орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

**Биелэлт:** Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн.

Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөх замаар инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн ИТХ-ын 2013 оны 7/29 дүгээр тогтоолоор батлан, 12 байршилд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

“Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 118 дугаар тогтоолоор 12 байршилд инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээ барих санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, 2013 онд 85.7 тэрбум төгрөгийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөн, 9 байршилд цахилгааны техникийн нөхцөлүүдийг олгосон.

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор 8 дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсуулж байна.

Улаанбаатар хотын Нисэхийн 2000м<sup>3</sup>/хон хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчилж, 2014 оны 12 дугаар сарын 24-нд ашиглалтад оруулав. /40 хувь/

**126.** Ажилтай хүн бүр орон сууцны зээлд хамрагдах бодлогыг хэрэгжүүлж, гэр хорооллыг орон сууцжуулах, дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хот, аймаг, суманд хэрэгжүүлэх

**Биелэлт:** 2013 онд “Улаанбаатар хотын VII, XIY хорооллын орон сууц, VII, MҮОНРТ орчмын хорооллын дэд бүтцийн төсөл”-ийн барилга угсралтын ажил 30,0 гаруй хувьтай байна. Төслийн хүрээнд VII, XIV хороололд 2592 айлын орон сууцны 35 барилга баригдах бөгөөд газар чөлөөлөлт бүрэн дуусаж, бүх барилгын угсралтын ажил эхэлсэн. Энэ ондоо багтааж орон сууцны барилгуудыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

2014 оны байдлаар “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7-р хороолол” дэд станц, “Радио телевиз” дэд станцын барилга угсралтын ажлууд 23,3 хувьтай байна. “Улаанбаатар” дэд станцаас “7-р хороолол” дэд станц хүртэл 14.9 км, “7-р хороолол” дэд станцаас “Радио телевиз” дэд станц хүртэл 8.4 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур угсралт, цахилгааны агаарын шугамын угсралтын ажлууд нь 78,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөл”-ийн хүрээнд:

**Баянхонгор аймагт:** Баянхонгор хотын усны эх үүсвэрийн гүний 2 худгийн барилгыг засварлан, насос, тоног төхөөрөмжийн хамт, хлоржуулах байгууламжийн барилга, 2х1000 м<sup>3</sup> усан сан, гэр хороололд цэвэр усны 9.1 км шугам сүлжээг ус түгээх 5 байрын хамт шинээр барьж, ус түгээх 9 байрыг засварлаж, цэвэр усны төвлөрсөн сүлжээнд холбосон. Хотын төвийн 4.3 км бохир усны гол шугам, бохир ус цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн.

Мөн цэвэр ус дамжуулах 1.3 км шугам сүлжээг шинээр барьж, орон сууцны айл өрхүүдэд усны тоолуур суурилуулав.

**Өвөрхангай аймагт:** Ундны усны эх үүсвэрийн гүний 1, 2, 3-р цооногийг өрөмдөж, гүний худгийн болон 2х100 м<sup>3</sup> багтаамжтай усан сангийн барилгын ажлыг бүрэн хийсэн. Гэр хороололд ус түгээх 16 байр барьж, цэвэр усны 41.5 км шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж хүртлэх ф400 мм-ийн 2.9 км шугамыг шинээр барьж, 2014 онд барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.

**Говь-Алтай аймагт:** Усны эх үүсвэрийн гүний 3 худгийн барилгыг засварлах, насос, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хотоос 3.3 км зайд худаг гаргаж, насос, тоног төхөөрөмжийг суурилуулан цэвэр ус дамжуулах 2.2 км /Харзат багт/, 3.3 км /Олон нуурын бүс/ шугам сүлжээг шинээр угсрах, гүний худгуудын гадна цахилгаан дамжуулах агаарын 4.8 км шугам татах, дэд өртөө угсрах, хотын төвийн хэсэгт цэвэр усны 2.3 км, гэр хороололд 2.8 км шугам угсрах, ус түгээх 7 байр барих, цэвэр усны

шугамд холбох, орон сууцны бохир усны 1.7 км шугам сүлжээ, бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлыг 100 хувь гүйцэтгэлээ. 2014 онд барилга байгууламжийг ашиглалтад оруулсан.

АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл”-ийн хүрээнд:

Өмнөговь аймагт: Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн зураг төслийг боловсруулж байна.

Даланзадгад хотын инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсвийг баталгаажуулсан.

Гурвантэс суманд гүний худаг, усан сан, цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг 2014 онд ашиглалтад оруулсан. Ханбогд, Цогт-Цэций сумдад ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн угсралтын ажил хийгдэж байна.

Даланзадгад хотод ундны усны эх үүсвэрийн гүний худаг, түүний барилга, дагалдах насос, тоног төхөөрөмж, хамгаалалтын хашаа, цахилгааны 1.6 км, цэвэр ус дамжуулах 1.4 км, 1000 м<sup>3</sup> усан сан, гэр хорооллын бохир усны 4.7 км шугам угсрах ажлуудыг гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Дорноговь аймагт: Сайншанд болон Замын-Үүд суманд цэвэр, бохир усны шугам сүлжээ шинээр барих ажлын гүйцэтгэгчээр “Эс энд Эй Трейд” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Барилга угсралтын ажил 2015 онд үргэлжлэн хэрэгжинэ. **/50 хувь/**

#### **127. Аймаг бүрт “1000 айлын орон сууц” төсөл хэрэгжүүлэх**

**Биелэлт:** Аймаг бүрд “1000 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Булган, Говьсүмбэр, Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн төвийн орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг баталсан.

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталж, Булган аймгийн Булган хотын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн дэмжээд байна.

Хэнтий, Ховд, Дорнод, Завхан аймгийн төвийн орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталсан.

Булган, Баянхонгор, Дундговь, Хэнтий, Говьсүмбэр аймгийн төвдүүдэд баригдах “1000 айлын орон сууц”-ны инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “21 аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам, сүлжээ, 2013-2015 он, 62.0 тэрбум төгрөг”, мөн 2014 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “Дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 2014-2015 он, 5.6 тэрбум төгрөг/”, “Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум, 2014-2015 он, 4.5 тэрбум төгрөг/” төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдэх 27 ажлаас 13 ажлыг эхлүүлсэн, 2014 онд 14 ажлыг эхлүүлэхээр тендерийг зарлаад байна.

Дархан-Уул аймгийн Орхон сумын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх ажил 2014 оны төсөвт 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгагдсан. Угсралтын ажил бүрэн дууссан. **/40 хувь/**

**128.** Барилгын салбарын стандартыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэн канад стандартыг нэвтрүүлж, шинээр барих барилгын зураг төсөлд эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатай шийдлүүдийг тусгах



**Биелэлт:** "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм", "Барилга байгууламжийн давхар, зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх, өргөтгөл шинэчлэл хийхэд тавих шаардлага, зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг баталсан.

Канад модон барилгын техник технологи, галын аюулгүй зэрэглэлийн 72 стандартыг орчуулж Норм нормативын сангийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлдэж байна.

"Кайзер систем, угсармал-цутгамал төмөр бетон бүтээц, угсармал төмөр бетон хашлага элемент, техникийн ерөнхий шаардлага, төмөр бетон бүтээцийн ган туйвангийн механик холбоо, зуурмаган дүүргэгчтэй муфтэн холбоо, техникийн шаардлага MNS...2013" зэрэг стандартыг боловсруулж байна.

"Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм", "Урьдчилан хучитгэсэн төмөр бетон бүтээц" барилгын норм, дүрмийг орчуулж, боловсруулах ажлын техникийн даалгаврыг баталлаа.

Барилгын материал ба бүтээгдэхүүний дулаан-техникийн шинж чанар-уур нэвтрүүлэх чанарыг тодорхойлох зэрэг 24 стандартыг батлав.

"Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж", "Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт", Үйлдвэрийн барилгын цахилгаан хангамжийг төлөвлөх", "Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж"-д нэмэлт, өөрчлөлт оруулах дүрмийн төслийг салбарын ШУТЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүллээ.

**/40 хувь/**

**129.** Аймгийн төвд төрөөс иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын орчныг утасгүй интернетийн бүсэд хамруулах

**Биелэлт:** Аймгийн төвүүдийн худаг сувагчлалын судалгааг хийж цаашид багтаамжийг өргөтгөх, шинээр баригдаж байгаа байгууламжуудтай уялдуулах талаар судалгаа хийж байна.

Дотоодын интернэтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 21 аймгийн төв, 2 дүүрэг, 2 суурин газарт утасгүй интернэтийн бүс байгууллаа.

Сумдад өндөр хурдны өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулах төслийн хүрээнд 21 аймгийн төв, нийслэлийн 3 дүүрэгт утасгүй интернэтийн бүс байгуулж, 52 сумын Засаг даргын Тамгын газар, эмнэлэгт интернэтийн үйлчилгээ оруулах тоног төхөөрөмжийг суурилуулав.

2013 онд 21 аймгийн төв, нийслэлийн Налайх, Багануур, Багахангай дүүрэг, Био комбинат, Шувуун фабрик гэсэн газруудад утасгүй интернетийн төхөөрөмжийг суурилуулж, "МЦХ" ХХК интернэтийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. **/90 хувь/**

**130.** Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэж, өмчилсөн газраа санхүүгийн эргэлтэд оруулах бодит боломжийг бүрдүүлэх

**Биелэлт:** Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлж, хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр тогтсон.

Газрын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцүүлэх явцад Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг боловсруулах дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газар Газрын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаас эргүүлэн татан авсан.

2013 онд Архангай аймгийн Эрдэнэбулган, Завхан аймгийн Улиастай, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Дорнод аймгийн Хэрлэн, Чойбалсан, Хэнтий аймгийн Хэрлэн, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дундговь аймгийн Сайнцагаан, Дорноговь-Сайншанд, Булган аймгийн Булган, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Хөвсгөл аймгийн Түнэл, нийслэлийн Сонгинохайрхан, Налайх, Багахангай дүүргийн иргэнд өмчлүүлэх боломжтой нийт 29005,5 га газрын байр зүйн зургийг хийж, газрын төлөв байдал

чанарыг тодорхойлон, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, аймаг орон нутаг болон ГХГЗЗГ-ын мэдээллийн төвд хүлээлгэн өгсөн.

2014 онд уг ажлыг Баянхонгор-7 га, Завхан-4 га, Говь-Алтай-4 га, Баян-Өлгий-7 га, Увс-7 га, Ховд-8 га, Дорнод-4 га, Хэнтий-6 га, Сүхбаатар-6 га, Говьсүмбэр-5 га, Дорноговь-4 га, Өмнөговь-5 га, Дундговь-4 га, Булган-12 га, Сэлэнгэ-11 га, Төв-18 га, Хөвсгөл-4 га буюу сумдад нийт 52 822,2 га талбайд хийсэн. **/50 хувь/**

### **131.** Нийтийн эзэмшлийн газрыг гэрчилгээжүүлэх

**Биелэлт:** Газрын кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлж, хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр тогтсон боловч Засгийн газар Газрын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлаас эргүүлэн татан авсан.

Энэхүү хуулийн төсөлтэй уялдуулан “Нийтийн эзэмшлийн газарт гэрчилгээ олгох журам”-ын төслийг боловсруулж байна. **/50 хувь/**

**132.** Төв, суурин газарт эдийн засгийн үр ашгийг нь харгалзан дулаан хангамжийн төвлөрсөн болон бие даасан систем бий болгох

**Биелэлт:** Аймаг, сумын төвд баригдах дулааны станц, зуухны газар, дулаан дамжуулах төв, дулааны шугам сүлжээний нэг маягийн зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хавсралтаар батлагдах дулаан хангамжийг сайжруулах хөтөлбөрийн төсөл боловсруулсан.

2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс, Хөвсгөл, Ховд аймагт шинээр дулааны станцыг барьж ашиглалтад хүлээлгэж өгсөн. Солонгосын “КОЙКА” байгууллагын санхүүжилтээр Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын дулааны станцыг барьж ашиглалтад хүлээлгэж өглөө.

Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Төв, Хэнтий аймгийн төвд шинээр дулааны станц, дулааны шугам сүлжээ барих ажлын зургийн даалгавар, техникийн шаардлагад хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усаар хангах технологитой байхаар тусгасны дагуу ТЭЗҮ, зураг төсөв боловсруулсан. Гэрээний дагуу төрөөс олгох санхүүжилтийн дэмжлэг шийдвэрлэгдээгүйн улмаас ажлын явц удаашралтай байна.

“Сумдын хөгжлийн загвар болон түүнд хамаарах нэг маягийн загвар зургийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Дундговь, Архангай, Хэнтий аймгийн дулаан хангамжийн системийн шинэчлэлтийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг цуцалсан.

Ховд аймгийн Манхан, Цэцэг, Булган, Завхан аймгийн Тосонцэнгэл, Хөвсгөл аймгийн Тариалан, Цагаан-Уул сумын төвийн дулаан хангамжийн эх үүсвэрийг шинэчлэхээр 2014-2016 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаад байна. **/40 хувь/**

**133.** Хотуудын усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх. Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулна. Усыг зүй зохистой ашиглах бодлого явуулна.

**Биелэлт:** Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын мастер төлөвлөгөөг “ЖАЙКА” Олон Улсын байгууллага боловсруулан эцсийн шатны тайланг хүлээлгэн өгөөд байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2013 онд боловсруулан гаргах норм, дүрмийн жагсаалтыг гаргаж, барилгын салбарын норм, нормативын сангийн хөрөнгөөр боловсруулахаар зөвлөхийг шалгаруулан гэрээ байгуулан ажиллаж байна.

2012-2013 онд ундны усны хатуулаг, эрдэсжилт ихтэй 80 суманд усны чанар сайжруулах тоног төхөөрөмжийг суурилуулсан.

2013-2014 онд 16 аймгийн 46 сумын усны эх үүсвэрийн 60 худгийн барилгад засвар хийж, ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг эхлүүлээд байна. Нийт 21 аймгийн 164 суманд ус зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулсан.

Бохир усны Туул 1 коллекторыг барих ажлын хүрээнд нийтдээ 30 км бохир усны шугам сүлжээг шинээр барина. Үүнээс: 1, 2-р хэсгийг ашиглалтад оруулан бохир усны Өмнөдийн коллектортой холбосон Улаанбаатар хотын Багануур дүүргийн 15 км ус хангамжийн шинэчлэлийн ажлыг Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2012-2013 онд үе шаттайгаар гүйцэтгэн ашиглалтад орсон.

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Чулуун-Овоотын гэр хорооллын цэвэр, бохир усны шугамын ажлыг гүйцэтгэсэн боловч цэвэр, бохир усны шугам хоолойг шахаж шалгах сорилтын үед алдаа, доголдол илэрсэн тул гүйцэтгэгч компанид гэмтэлийг засч ашиглалтад оруулах үүрэг даалгаврыг удаа дараа өгсөн ба байнгын ашиглалтад оруулах, комисс ажиллах нөхцөл бүрдээгүй байна. **/40 хувь/**

**134.** Аймаг, сумын төвийн ногоон байгууламжтай талбайг хоёр дахин нэмэгдүүлэх

**Биелэлт:** Хот, тосгоны ногоон байгууламжийн тухай хуулийн болон үзэл баримтлалын төслийн эхний хувилбарыг боловсруулаад байна.

БОНХЯ-аас аймаг, сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт зөвлөмж хүргүүлсэн.

Мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх, тарьц суулгацын хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор тарьц, суулгац ургуулах зориулалттай нийлэг хальсан хүлэмж 92 ширхэг, бороожуулагч усалгааны систем 30 ширхэг, модны суулгацны нүх ухагч өрөм 60 ширхэг, мод үржүүлгийн зориулалттай хөрс боловсруулах гар багаж 100 ширхэгийг аймгийн Ойн анги, Ойн сургалтын байгууллагууд болон зарим мэргэжлийн аж ахуйн нэгжүүдэд олгоод байна.

Улсын хэмжээнд 2012 онд 7284 аж ахуйн нэгж, 190900 иргэн оролцож 1562,9 мян.ш, 2013 онд 11324 аж ахуйн нэгж байгууллага, 198,0 мянган иргэн оролцож 1212.6 мян.ш, 2014 онд 7100 аж ахуйн нэгж байгууллага, 150300 иргэн оролцон 1368,6 мян.ш мод, сөөгийг төв суурин газарт тарьж ургуулсан байна. 2013-2014 онд улсын хэмжээнд 18429 аж ахуй нэгж байгууллага, 348,3 мян. ард иргэд оролцож, 2581,2 мян. ширхэг модыг тарьсан нь 2012 оны түвшинтэй харьцуулахад 2,5 дахин нэмэгдсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж байна. **/60 хувь/**

**135.** Аймгуудын нэгдсэн захыг эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв болгох

**Биелэлт:** 2014 оны байдлаар Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн битүү дээвэртэй хүнсний зах ашиглалтад ороод байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд олон улсын жишигт нийцсэн Хүнсний лавлагаа лаборатори байгуулахаар 2012-2013 оны улсын төсөвт 4.3 тэрбум төгрөг тусгагдсанаас 2012 онд 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдсэн бөгөөд 2013 оны улсын төсөвт 3.1 тэрбум төгрөгийг тусган хүнсний лавлагаа лабораторийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хийгдэж байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Малын эрүүл мэнд” төслөөс Хүнсний захуудын мал эмнэлгийн лабораторийг шинжилгээний зарим тоног төхөөрөмжөөр хангах ажил хийгдэж байна. **/50 хувь/**

**136.** Аймгуудын төвийг дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаатай хот болгон хөгжүүлэх

**Биелэлт:** Дархан хотыг "Жишиг хот" болгон хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүллээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2012 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэчлэн боловсруулсан. Баян-Өлгий аймгийн Өлгий хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж байна. /10 хувь/

**137.** Аймгийн төвийн иргэдийн амьдрах ая тухтай, эрүүл орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд төвлөрсөн дулаан хангамжийг сайжруулж, хэрэгцээний халуун усны системийг бүрдүүлэх

**Биелэлт:** Багануурын Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийж улсын комисс ашиглалтад хүлээн авсан.

Дарханы хэрэгцээний дулаан хангамжийг хаалттай системд шилжүүлэх ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж улсын комисс ашиглалтад хүлээн авсан.

Аймаг бүрт 1000 айлын орон сууцны хороолол барьж байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аймгийн төвүүдийн нийтийн зориулалттай орон сууцны барилгууд хэрэгцээний халуун усны шугам сүлжээтэй болох нөхцөл бүрднэ. Ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:

1. Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Орхон, Сүхбаатар, Төв аймгуудын төвд баригдах 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн.

2. Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгуудын инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын тендер шалгаруулалт явагдаж байна. Завхан аймгийн "XXI зуун" орон сууцны хорооллын зураг төсөв хийгдсэн боловч 2014 оны төсөвт 00 дүнтэйгээр тусгагдсан. Хөрөнгийн эх үүсвэрийг 2014 онд шийдвэрлэх шаардлагатай.

3. Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Увс, Ховд аймгуудад 1000 айлын орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах хөрөнгийг шийдвэрлэх шаардлагатай байна.

4. Говьсүмбэр, Дундговь аймгуудад хийгдэх ажлын зураг төсөв бэлэн боловч угсралтын хөрөнгө шийдээгүйгээс ажил эхлээгүй байна. Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд аймгуудад хийгдэх 1000 айлын гадна ИШС-ний зураг төслийг боловсруулах ажлын тендерийг зарлаад байна. /30 хувь/

**138.** Бүх аймгийн төвд кинотеатр, усан бассейн бүхий үйлчилгээний цогцолбор байгуулах

**Биелэлт:** Кино үзвэрийн сүлжээг сэргээх, сумын соёлын төвүүдэд жишиг цэг байгуулах зорилгоор нийслэлийн 2 дүүргийн соёлын ордон, 18 сумын соёлын төвд жишиг кино үзвэрийн цэгийг байгуулж, орчин үеийн дуу, дүрсний өндөр чанартай кино гаргалтын иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулж, дэлгэцийн тоог 20-иор нэмэгдүүллээ.

2012-2014 онд Дархан хотод 2200 хүний суудалтай спорт цогцолбор, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод 300 суудал бүхий усан бассейн, Дорноговь аймгийн Хатанбулаг, Өвөрхангай аймгийн Уянга суманд спорт цогцолбор, Архангай аймгийн Эрдэнэбулган суманд усан бассейн, Дорнод аймгийн Хэрлэн суманд усан бассейн, Ховд аймгийн Манхан суманд спорт цогцолбор, Завхан аймгийн Улиастай сумын спорт цогцолбор, Увс аймгийн Улаангом сумын усан бассейн, нийслэлийн Хан-Уул дүүргийн өвлийн спортын цогцолбор, Налайх, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн спорт цогцолборын барилга угсралтын ажлыг хийж байна.

2014 оны хөрөнгө оруулалтаар Баянхонгор, Өвөрхангай аймаг, нийслэлийн Баянгол дүүргийн спорт цогцолбор, Өмнөговь аймгийн Баян-овоо сумын спорт цогцолбор, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын соёл амралтын хүрээлэн, Сүхбаатар

аймгийн Баруун-Урт сумын усан бассейн, Завхан аймгийн Улиастай сумын Баруун бүсийн тамирчдын бэлтгэлийн төвийн барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. /30 хувь/

**139.** Аймгийн эмнэлгүүдийг орчин үеийн оношилгооны төвтэй болгох

**Биелэлт:** Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймагт Ерөнхий сайдын хөрөнгө оруулалтын багцын төсвийн хөрөнгөөс “Оношилгооны төв” байгуулан компьютер томографи, дурангийн оношилгооны тоног төхөөрөмж, хэт авиан дижитал аппарат, дижитал рентген аппарат, лабораторийн тоног төхөөрөмж, нүд, чих, хамар, хоолой, шүдний тоног төхөөрөмж зэрэг 24 нэр төрлийн нийт 19,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, оношилгооны төвийн барилгын засвар, тоног төхөөрөмжийн өрөөний засварт 2,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн.

2014 оны 8 дугаар сарын байдлаар нийт 197,904 иргэн, нэг аймагт дундажаар 17,991 иргэн үйлчлүүлсэн байна. Оношилгооны төв байгуулагдсан аймгуудын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт дунджаар 20-30 хувиар нэмэгдлээ. /50 хувь/

**140.** Аймаг, нийслэл, дүүрэгт усан сан бүхий спортын ордон барих ажлыг үргэлжлүүлж, дугуйн болон гүйлтийн зам, мөсөн гулгуурын талбай шинээр барьж хүн бүр биеийн тамир, спортоор хичээллэх, хот, суурин газар, байгууллага, хамт олон, өрх гэр бүлд эрүүл амьдралын орчин нөхцөлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

**Биелэлт:** 2013 онд нийслэлийн Чингэлтэй дүүргийн спортын цогцолборын барилгын суурийн ажил, Баянзүрх, Налайх дүүргийн спорт цогцолборын барилгын ажлын гэрээг тус тус хийж, Дархан-Уул аймгийн 25 м-ийн усан бассейн барилгыг ашиглалтад оруулахаар төлөвлөн одоогоор барилгын ажил 60 хувьтай явж байна.

Сүхбаатар, Өмнөговь аймагт 850-1000 хүний суудалтай усан бассейн бүхий спортын цогцолборын ажил 40 хувьтай, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт 700 хүний суудалтай спортын ордны ажил 80 хувьтай байна.

Спортын дунд сургуулийн судалгааг гаргаж, тэдгээрийн хүчин чадал, барилгын хэмжээ, бүтцийг тодорхойлон спортын сургуулиудад зөвлөмж хүргүүллээ.

Баянхонгор, Архангай аймаг, Дорнод аймгийн Хүүхэд, залуучуудын соёл үйлчилгээний төв, Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын спорт цогцолборын барилга угсралтын ажил эхлээд байна. Мөн Булган, Увс аймагт барих усан бассейны барилгын зураг төслийн ажил хийгдэж байна.

Одоогоор нийслэлийн 24-26 ерөнхий боловсролын сургуулийн гаднах биеийн тамирын талбайг өвлийн улиралд мөсөн гулгуурын талбай болгон тохижуулж ашиглаж байна.

Сэлэнгэ, Өмнөговь, Сүхбаатар, Архангай, Дархан-Уул, Завхан, Увс аймгийн усан бассейн бүхий спортын цогцолборын ажил, нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Налайх дүүргийн усан бассейн бүхий спорт цогцолборын ажлууд 2015 онд үргэлжлэн явагдана. /50 хувь/

**141.** “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх

**Биелэлт:** “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2013 оны улсын төсөвт нийт 35.0 тэрбум төгрөг туссан.

“Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр”-ийг 100 хүртэл суманд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ ажлын хүрээнд: Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийг Архангай аймгийн Тариат, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Булган аймгийн Хутга-Өндөр, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Өвөрхангай аймгийн Богд, Дорнод аймгийн Баян-Уул, Дундговь аймгийн Өлзийт, Завхан аймгийн Тосонцэнгэл, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Төв

аймгийн Лүн, Увс аймгийн Тэс, Ховд аймгийн Зэрэг, Хэнтий аймгийн Биндэр, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумуудад хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Одоогийн байдлаар БХБЯ нийт 16 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг тухайн аймаг орон нутгийн холбогдох хүмүүстэй хамтран батлуулаад байна. 2014 оны 12 дугаар сарын байдлаар санхүүжилт 56.8 тэрбум төгрөг, ажлын гүйцэтгэл дундажаар 71.6 хувьтай байна.

Засгийн газрын 2014 оны 60 дугаар тогтоолоор тус төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг дарга нарт шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу БХБ-ын сайд аймгийн Засаг дарга нарт эрх шилжүүлэх 2014 оны 32 дугаартай тушаал гаргаж аймгуудад хүргүүлээд байна. Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явцыг эрчимжүүлэх үүднээс 8/835-8/849 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

“Шинэ сумын төв” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан, Баянлиг сумын төв ашиглалтад орсон. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын шинэчлэлийн ажил 2015 онд үргэлжилнэ.

“Орон нутгийн мэдээлэл холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах, ТН-01/12” төслөөр 2012 онд 8, 2013 онд 14, 2014 онд 13, 2015 онд 14 суманд нэг цэгийн төвийг байгуулах бөгөөд 2012 онд байгуулсан 8 төвийг байнгын ашиглалтад оруулав. Мөн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар 2013 онд Сүхбаатар аймгийн Дарьганга суманд “Нэг цэгийн үйлчилгээний төв” байгуулсан.

“Сумдад өндөр хурдны түгээх сүлжээ байгуулах” төслийн хүрээнд 19 аймгийн 250 суманд өргөн зурвасын түгээх сүлжээ байгуулахаас 2012 онд 16 аймгийн 38 сумын Засаг даргын Тамгын газар, эмнэлгийг, 2013 онд 3 дүүрэг, 21 аймгийн төв болон 18 аймгийн 52 сумыг шилэн кабелиар түгээх сүлжээнд холбож, сумын төвд утасгүй интернэтийн бүс байгууллаа.

Улсын хэмжээнд шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй үлдсэн 39 сумын 25 нь холбогдох боломжтой бөгөөд эдгээр сумаас Дорнод аймгийн Баянтүмэн сумыг шилэн кабелиар, Төв аймгийн Борнуур сумыг “Мобиком” ХХК өөрийн сүлжээгээр холбосон байна. /40 хувь/

**142.** Дулаан алдагдал багатай барилгын технологийг нэвтрүүлж, дулаалгын материалд монгол хонины ноос ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

**Биелэлт:** “Эко ноос” ХХК нь хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрийг Дархан-Уул аймгийн Дархан суманд байгуулахаар Япон улсаас тоног төхөөрөмж оруулж ирээд байна.

Мөн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн, “Ноосон эдлэл үйлдвэрлэгчдийн холбоо”, “Монгол ноос” ХХК хонины ноосон дулаалгын материал үйлдвэрлэхээр ажиллаж байна.

Чехийн “People in need” байгууллага “Хонины ноосоор байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх сүлжээ байгуулах төсөл” хэрэгжүүлэхээр хамтран ажиллах санал, “Сүтэй уул” ХХК, “Чин ван констракшн” ХХК-иуд ийм төрлийн дулаалгын материал үйлдвэрлэх төслөө ирүүлээд байна.

Одоогоор “Баянхонгор” ХХК өөрсдийн 10 гаруй жилийн ажлын үр дүнд хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэлийн технологийг гарган авч, жижиг хэмжээний үйлдвэрлэл явуулж бүтээгдэхүүнээ Японд экспортлох гэрээ хэлцэл хийж, амжилттай ажиллаж байна. “Таван богд инсулэшн” ХХК Австриас хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрийн технологи нэвтрүүлж, 4,8 см-ийн зузаантай дулаалгын цулхай үйлдвэрлэн дотоодын зах зээлд гаргаад байна. /30 хувь/

**143.** Сумдад дэд бүтэц барьж байгуулах ажлыг дэмжиж, ахуйн үйлчилгээний цогцолбор төвүүдийг байгуулах.

**Биелэлт:** НҮБХХ-ийн “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийг сайжруулах” төслийн хүрээнд Ховд аймгийн Зэрэг сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг шинээр, Өмнөговь аймгийн Булган сумын

төвийн ус хангамжийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Ховд аймгийн Дөргөн, Манхан, Мянгад, Говь-Алтай аймгийн Баян-Уул, Төгрөг, Бигэр, Тонхил, Баянхонгор аймгийн Баянговь, Шинэжинст, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын төвүүдийн ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний зураг төслийг боловсруулж, магадлал хийлгэн баталгаажуулж хүлээлгэн өгсөн.

Ахуйн үйлчилгээний төвийн цогцолбор барилгыг 10 аймгийн төвд /Архангай, Баянхонгор, Орхон, Дорнод, Хөвсгөл, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Хэнтий, Сүхбаатар/ шинээр барихад 30.0, 9 аймгийн төвд бэлэн болсон барилгыг худалдаж авахад 4.8, 109 суманд шинээр барихад 109.0, 73 суманд худалдаж авахад 8.7, 119 суманд сэргээн засварлахад 8.7, нийслэлийн 8 дүүрэгт шинээр барихад 24.0, 1 дүүрэгт сэргээн засварлахад 1.2 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоо судалгааг хийсэн.

Эхний ээлжинд 10 аймгийн төвд ахуйн үйлчилгээний цогцолбор төв байгуулахад шаардлагатай 30.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг БНХАУ-ын Засгийн газраас олгож буй буцалтгүй тусламжийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор батлагдсан “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2014 онд шинээр 138 суманд ахуйн үйлчилгээний төв байгуулагдан, энэхүү төвүүдэд 1080 шинэ ажлын байр бий болсон байна. **150 хувь**

### **Хөдөлмөр эрхлэлтийн бодлого**

**144.** Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан бүтцийг нэгтгэн зохион байгуулах

**Биелэлт:** УИХ-аас 2012 оны 8 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 12-т “12/Хөдөлмөрийн яам”, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 15-д “15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайд” гэж оруулсан нь бие даасан Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн сайдтай ажиллах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлсэн.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Хөдөлмөрийн сайдын эрхлэх ажил, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Хөдөлмөрийн яамны бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлсон.

“Хөдөлмөрийн хэлтэс байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 36 дугаар тогтоол, Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/22 тоот тушаалаар аймаг, дүүргийн “Хөдөлмөрийн хэлтсийн дүрэм”, бүтэц, орон тоог баталсан. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүдийг хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, жижиг дунд үйлдвэр, мэргэжлийн боловсрол, сургалт хариуцсан нийт 750 ажилтны орон тоотойгоор зохион байгууллаа.

Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд сум, хорооны хөдөлмөрийн ажилтан /хөдөлмөрийн алба/ ажиллуулах тухай нэмэлт, өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн хүрээний бодлогын хэрэгжилтийг сум, хороонд зохион байгуулах, хэрэгжүүлэх хөдөлмөрийн ажилтан /хөдөлмөрийн алба/-ны үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалт, орон тооны төслийг боловсруулан, 2014 оноос эхлэн 21 аймгийн 321 сум, 15 тосгонд 34 хөдөлмөрийн алба, 412 ажилтан, нийслэлийн 9 дүүргийн 150 хороонд 86 хөдөлмөрийн алба, 250 ажилтан, улсын хэмжээнд нийт 120 хөдөлмөрийн алба, 662 ажилтан ажиллахаар тооцож, орон тооны хязгаар батлуулах саналыг тусгасан.

“Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв” улсын төсөвт үйлдвэрийн газар, “Хөдөлмөрийн судалгааны институт”-ийн үйл ажиллагааны дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан. /100 хувь/

**145.** “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлж 150.000 хүний ажлын байр шинээр бий болгох

**Биелэлт:** “Ажилтай, орлоготой Монгол хүн” Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2013 оны 154 дүгээр тогтоолоор баталлаа.

Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, эрүүл, аюулгүй, хоггүй эко орчин бүрдүүлэх “Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд 508 ногоон ажлын төслийг хэрэгжүүлж 114 иргэдийн бүлэг, 232 нөхөрлөл, хоршооны 17175 иргэнийг, 1643 удаагийн нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж 17011 ажилгүй иргэнийг тус тус хамруулсан байна. Нийтийг хамарсан ажлын хүрээнд 2014 онд нийт 15945 ажилгүй иргэдийг хамруулж нийт 2045551,1 мянган төгрөгийн хөлс болон хөдөлмөрийн аюулгүй байдлын арга хэмжээг олгож зохион байгуулсан.

2014 онд нийт 60818 ажлын байр бий болсны 18839 нь байнгын, 41979 нь түр ажлын байр байна. Түүнчлэн 5927 иргэнийг мэргэжлийн ур чадварын сургалтанд хамруулсан бөгөөд ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд 356 иргэнийг ажлын байраар хангасан, 150 гаруй ажил олгогчид санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгосон байна. Хөтөлбөр, төслийн хүрээнд 9626 залуучууд, 3239 ахмад мэргэжилтнийг түр ажлын байраар хангасан.

Гадаадаас буцаж ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Эх орондоо ажиллаж амьдарцгаая” өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 48 байгууллага, аж ахуйн нэгж оролцож 834 ажлын байр санал болгожээ. Мөн гадаадад хөдөлмөрлөж байсан 4349 ажил хайгч иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Өдөрлөгийн үеэр 1864 ажил хайгчийг бүртгэж, 368 ажил хайгч иргэнийг бодит ажлын байранд зуучилсан байна. БНСУ-ын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг шинэчлэн байгуулсан бөгөөд уг санамж бичигт хөдөлмөрийн гэрээний хугацаанд ажлын байрандаа тогтвортой ажилласан иргэний ур чадварыг үнэлэн тодорхойлох, карьерийн сертификат олгох, эх орондоо ирсэний дараа ажлын байраар хангах үйлчилгээг талууд хамтран зохион байгуулахаар тусгасан юм.

Хөдөлмөрийн яам, АНУ дахь Монгол Улсын элчин сайдын яам, АНУ дахь Монгол оюутны холбоод хамтран “АНУ дахь Монголчуудын Хөдөлмөрийн яармаг-2014”, “Монголдоо сайхан амьдарцгаая” уулзалт хэлэлцүүлэгийг эх орондоо эргэн ирж ажиллахад туслах, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөх, ажлын байранд зуучлах зорилготойгоор зохион байгууллаа. /40 хувь/

**146.** Залуучууд болон 40-өөс дээш насны ажил олоход хүндрэлтэй байгаа иргэдийг ажлын байраар хангах

**Биелэлт:** “Монголын залуучуудын холбоо”, “Залуучуудын хөдөлмөрийн төв бирж”-тэй “Ажилтай, орлоготой Монгол залуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай санамж бичиг”-т гарын үсэг зурснаар их, дээд сургуулийн оюутан залуучуудыг зуны амралтын хугацаанд нь их бүтээн байгуулалт болон сум, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах түр ажлын байраар хангаж, орлогыг нь нэмэгдүүлэх зорилготой “Сумын залуус”, “Ажлын гараа” төслүүдийг шинээр хэрэгжүүлсэн ба “Сумын залуус” төслийн хүрээнд 21 аймгийн 278 суманд 1109 оюутан, “Ажлын гараа” төслийн хүрээнд 21 аймгийн 21 суманд 315 оюутан ажилласан бөгөөд “Их бүтээн байгуулалт”-ын чиглэлээр авто болон төмөр зам, шинэ барилга, уул уурхайн салбарт 7 багийн 105 оюутан, нийт 1529 оюутан залуучуудыг түр ажлын байранд хамруулан 432.0 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон байна.



2014 онд “Сумын залуус” төсөлд 20 аймгийн 281 суманд 1723 оюутан, “Ажлын гараа” төсөлд 21 аймгийн 300 суманд 7009 иргэн, “Бүтээн байгуулалтын арга хэмжээ”-нд 894 оюутан залуусыг хамруулж, нийт түр ажлын байраар 9626 хүн хамрагдаж, 1 тэрбум 881 сая төгрөгийг орлого нэмэгдүүлэхэд зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2012 оны 4 дүгээр тогтоолоор “40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлснээр 3651 иргэн хамрагдсан байна. 2014 онд 40-өөс дээш насны иргэдийн боловсруулсан 1047 төслийг шалгаруулж, 1,16 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон бөгөөд уг арга хэмжээний үр дүнд 1300 орчим ажлын байр бий болсон байна. /70 хувь/

**147.** Ажлын байр бий болгох зорилго бүхий Засгийн газрын тусгай сангуудыг нэгтгэх

**Биелэлт:** Ерөнхий сайдын 2013 оны 49 дүгээр захирамжаар Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, сангуудын хөрөнгийн удирдлага, өр төлбөрийг тодорхойлох, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох талаар санал боловсруулах ажлын хэсгийг байгуулан, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, өөрчлөн зохион байгуулах төслийг УИХ өргөн мэдүүлээд байна. /70 хувь/

**148.** Бүх сум, дүүрэгт ажил хайгч, ажил олгогчийг шууд холбох хөдөлмөр зуучлалын мэдээллийн биет болон онлайн сүлжээг нэвтрүүлэх

**Биелэлт:** Хөдөлмөрийн төв бирж нь “Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем”-ийг гүйцэтгэгч компаниас хүлээн авч, эцсийн шатны тестийг хийж дуусгав.

Цахим мэдээллийн нэгдсэн санд байгаа ажлын байрны мэдээллийг хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор 21 аймаг, 9 дүүрэг, интернетийн сүлжээнд холбогдсон 141 сум, нийслэлийн 134 хороо, төрийн зарим байгууллагын нийт 355 байршилд Е-Биржийг суурилуулан ажиллуулж байна. Уг системд 2013 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар ажил хайгч 42.8 мянган иргэн, 51917 ажлын шинэ байр, 26089 ажил олгогчийн мэдээлэл бүртгэлтэй байна. 2014 онд улсын хэмжээнд цахим Е-биржид 307973 удаа хандаж иргэд үйлчилгээ авсан байна.

“Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт /тарифаар тооцож/ олгох тухай” Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/92 дугаар тушаалыг гаргаж, хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлж байсан хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн.

2013 онд 47 байгууллагад Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосноор тэдгээр хувийн биржид 370 ажил олгогчоос 14216 ажлын байрны захиалга, 2567 ажил хайгч бүртгэгдсэнээс 1036 иргэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгч, 1419 ажил хайгчид ажлын байр санал болгож, 61 иргэнийг ажилд зуучилж оруулсан байна.

2014 онд 45 байгууллагад Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосноос одоогоор 44 хөдөлмөрийн хувийн биржийн ажиллаж байгаагаас 22 хөдөлмөрийн хувийн бирж идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. /90 хувь/

### **Нийгмийн хамгааллын бодлого**

**149.** Эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх тэтгэмж, дэмжлэгийн эрх зүйн орчныг бий болгож хэрэгжүүлэх

**Биелэлт:** Нийгмийн халамжийн тухай хуулийг зөвхөн зорилтот хэсэгт чиглүүлж, хүн амын өсөлтийг дэмжих, жирэмсэн эх болон хүүхэд асарч байгаа, олон хүүхэд төрүүлсэн эхийг дэмжихэд чиглэсэн бодлогыг нэгтгэн Олуулаа болох тухай хуулийн төслийг боловсруулав.

Энэ хуулиар жирэмсэн эхийн тэтгэмж, жирэмсэн эхэд олгох хүнсний дэмжлэг, 4 хүртэлх насны ихэр хүүхдийн нэг удаагийн тэтгэмж, 2 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, 3 дахь хүүхдээ төрүүлсэн эхийн хүүхэд асарсны тэтгэмж, ажил, хөдөлмөр эрхлээгүй эхчүүдийг хүүхэд асарч байх хугацаанд нь сайн дурын даатгалд хамруулах, 4 ба түүнээс дээш хүүхдээ өсгөж хүмүүжүүлж байгаа эхийг татварын хөнгөлөлтөд хамруулах асуудлуудыг тусгалаа.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд ихэр хүүхэдтэй эхчүүдэд амаржсаны тэтгэмжийг 6-аас 12 сарын хугацаанд нөхөн, 4 хүртэл насны ихэр хүүхэд тус бүрт 1.0-3.0 сая төгрөг хүртэлх тэтгэмжийг нэг удаа олгох арга хэмжээг 2013 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

2013 оноос эхлэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 16822 өрхийн 119187 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээний хүрээнд хүүхдэд 5000, насанд хүрсэн хүнд 10000 төгрөгийн хүнсний эрхийн бичгийг сар бүр олгож байгаа бөгөөд 2 болон түүнээс дээш ихэр хүүхэдтэй тодорхой тооны өрхийн гишүүдэд хүнсний эрхийн бичиг олгон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 15131 өрхийн 87718 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 2014 оны 4 дүгээр сарын 1-ээс эхлэн олгож байна.

2014 оны 12 дугаар сарын байдлаар 2 ихэр хүүхэдтэй 498 өрхийн 996 хүүхэд, 3 ихэр хүүхэдтэй 2 өрхийн 6 хүүхдийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамруулж нийт 59,760.0 сая төгрөгийн хүнсний эрхийн бичгийг олгосон байна. **/60 хувь/**

#### **150. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх**

**Биелэлт:** Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэврийн нас /эрэгтэй, эмэгтэй/, тэтгэвэр бодох хувь хэмжээг өөрчлөх тухай бодлогын даалгавар боловсруулж, хэтийн нөлөө, тооцоог хийж байна.

Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бий болгох Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд 2015 оны эхний улиралд УИХ-д өргөн мэдүүлэх юм. Энэхүү тэтгэврийн шинэчлэлийн үзэл баримтлалыг УИХ-аас баталсны дараа Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.

“Ирээдүйн тэтгэврийн сан”-г бий болгох, хуримтлал үүсгэх, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар хуулийн төслийг боловсруулаад байна. Түүнчлэн төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын үзэл баримтлалын төсөлд “Ирээдүйн тэтгэврийн нөөц сан” байгуулах асуудлыг тусгасан.

“Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хөтөлбөр”-ийн төслийг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэв. Тус шинэчлэлийн бодлогын төсөлд ахмад настны нийгмийн баталгааг хангах, нийгмийн шударга хуваарилалтыг баталгаажуулах, тэтгэврийн даатгалд хамрах хүрээг өргөжүүлж, албан бус салбарт ажиллагчид болон малчдыг нийгмийн даатгалд хамруулж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, сангийн бие даасан байдлыг хангах, тэтгэврийн насыг оновчтой тогтоох, нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох асуудлуудыг тусгаад байна.

Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг тусгай хөтөлбөрийн хүрээнд нийгмийн даатгалд хамруулах замаар тэтгэврийн 2 дахь давхаргыг бий болгох ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр “Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын хөтөлбөрийг нэвтрүүлэх төсөл”-ийг 2014 оноос хэрэгжүүлэхээр болоод байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар 23.7 мянган малчин нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан нь өмнөх оноос 11.2 мянгаар нэмэгдсэн байна. **/50 хувь/**

**151.** 1990-1995 оны хооронд өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас ажил хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэдийн ажилласан жил тасарсныг ажилласнаар нөхөн тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх

**Биелэлт:** УИХ-аас 2012 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар журам баталж, ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулахаар хүсэлт гаргасан иргэдийг бүртгэх ажлыг 2012 оны 11 дүгээр сарын 15-наас 2013 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж дууслаа.

Иргэдийн ажилласан хугацааг нөхөн тооцох бүртгэлийг бүх аймаг, дүүрэг /сум/-ын Нийгмийн даатгалын хэлтэс /байцаагч/ дээр хийж, иргэдийн хүсэлтээр бүртгэх хугацааг 2014 оны 8 дугаар сарын 1-нийг хүртэл сунган ажилласан.

Улсын хэмжээнд 572.6 мянган иргэн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулах хүсэлт гаргасан бөгөөд тэдний 24 хувь нь 5 хүртэл жилээр, 76 хувь нь 5-11 жилээр ажилласан хугацаагаа нэмэгдүүлэх боломжтой болсноор одоо авч байгаа болон ирээдүйд тогтоогдох тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэх нийгмийн хамгааллын томоохон арга хэмжээ боллоо.

2013 онд даатгалын бүртгэлд нөхөн хамрагдсан 572.6 мянган иргэнээс одоо тэтгэвэр авч байгаа 70.5 мянган иргэний ажилласан хугацаа нь дунджаар 7 орчим жилээр нэмэгдсэнээр тэдний тэтгэврийн нэмэгдэлд 2014 онд 31.0 тэрбум төгрөг зарцуулах тооцоотой байна. /100 хувь/

**152.** 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон буюу 1995 оноос өмнөх ажилласан жил, авсан цалингаасаа тооцож тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн зөрүүг арилгах

**Биелэлт:** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор даатгуулагчийн тодорхойлж ирүүлсэн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах 1990-2010 оны орлого буюу цалинд үндэслэн боловсруулав.

Ингэснээр иргэдийн 1995 оноос өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг иргэдийн 1995 оноос хойшхи хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлоготой ижил түвшинд хүргэх бололцоотой болж байна.

Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох болон цэргийн албан хаагчийн 200,0 мянга хүртэлх төгрөгийн тэтгэврийн хэмжээг 27,0 мянган төгрөгөөр, 600,0 мянга хүртэлх төгрөгийн тэтгэврийн хэмжээг 22,0 мянган төгрөгөөр, түүнээс дээш тэтгэврийн хэмжээг 20,0 мянга төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх зарчмыг 15 дугаар тогтоолоор батлав. Тогтоолын хавсралтаар 2014 оны 2 дугаар сарын 1-нээс хойш буюу шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдэд мөрдөх тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг батласан болно. Мөн Нийгмийн даатгалын сангийн 2015 оны Төсвийн тухай хуулинд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг тусгасан ба энэ арга хэмжээний дагуу тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх болно. /90 хувь/

**153.** Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлэх

**Биелэлт:** 2013 онд зорилтот бүлэгт үзүүлэх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний чанарын шалгуур, стандартыг боловсруулах, олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгэх ажлуудыг хэрэгжүүллээ.

Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 4 стандарт, шалгуурын /сургалт явуулах, өдрийн үйчилгээ, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ/ төслийг боловсруулж дуусгав.

2013 онд нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 136 байгууллагад бүртгэлийн гэрчилгээ олгон 7 төрлийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлжээ.

2014 онд нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 176 байгууллагад бүртгэлийн гэрчилгээ олгон 9 төрлийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлжээ.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг 2013 оноос хэрэгжүүлж байна.

Хүн амын хамгийн бага хэрэглээтэй 16535 өрхийн 97918 иргэнд хүнсний эрхийн бичиг олголт хийгдэж байна. Үүнээс нийслэл болон аймгийн төвийн 6978 өрхийн 42758 гишүүнд цахим хэлбэрээр, орон нутагт 9557 өрхийн 55160 иргэнд цаасан хэлбэрээр тус тус хүнсний эрхийн бичиг олгож байна.

Хүнсний эрхийн бичигт хамрагдсан дээрх өрхийн гишүүн-иргэдийг нийгмийн бүлгээр ангилж үзвэл нийт 97918 иргэнээс 50372 буюу 51.4 хувь нь 18 хүртэл насны хүүхэд байна. Харин хүнсний эрхийн бичигт 2646 ахмад настан хамрагдсан байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас цаасан болон цахим хүнсний эрхийн бичгийн дагуу зорилтот өрх-иргэний хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх нийт 668 дэлгүүрийг орон нутагт сонгон шалгаруулж, хүнсний эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох ажлыг зохион байгуулж байна.

Тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2014 оны 6 дугаар сарын 16-наас 2014 оны 7 дугаар сарын 16-ны хооронд зохион байгуулж, нийт 1822 иргэнийг бүртгэлд хамруулан мэдээллийн санд бүртгэжээ. Эдгээр иргэдээс бичиг баримтгүй 428 иргэнийг Амьдрах ухаан, сургалт үйлдвэрлэлийн тусгай төвд байрлуулж бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулсан байна.

"Улсын хэмжээнд судалгаа хийх тухай" Засгийн газрын 2013 оны 269 дүгээр тогтоолын дагуу өрхийн амьжиргааны түвшинг "Орлогыг орлуулан тооцох аргачлал"-аар тодорхойлон Өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх улсын хэмжээний судалгаа явуулж, улсын нийт 768263 өрхийн 90 орчим хувийн мэдээллийг цахим хэлбэрт оруулан мэдээллийн санг бүрдүүлж байна.

2013 онд "Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу ядуу, заавал хөгжих нийт 15000 өрхийн 65599 иргэнтэй "Өрхийн хөгжлийн төлөвлөгөө" боловсруулан ажиллаж байна.

2014 онд 13798 өрхөд Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллалаа. /70 хувь/

**154.** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг аймаг, дүүрэгт байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж халамжийг нэмэгдүүлэх, энэ зорилгод өөрсдийн оролцоог нь дэмжих

**Биелэлт:** "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийн төслийг боловсруулж дуусган яамдаас саналыг нь авч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах, тэдний гэр бүлд зөвлөгөө өгөх, дэмжин туслах хөгжлийн төвүүдийг бүх аймаг дүүрэгт үе шаттайгаар байгуулах ажлын хүрээнд 2012-2013 оны Хүний хөгжил сангийн үлдэгдэл 5 тэрбум гаруй төгрөгөөр нийслэлийн 4 дүүрэг, Архангай аймагт барихаар холбогдох газрын асуудлыг шийдвэрлэн барилга барих тендерийг зарлаад байна.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн корпорацийн төсөл"-ийг боловсруулж, барилгын зураг төсвийг 2014 онд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэв.

Урт хугацаанд асаргаа, сувилгаа нөхөн сэргээх, хөнгөвчлөх эмчилгээ шаардлагатай иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, энэ чиглэлээр үндэсний хэмжээнд мэргэжил арга зүй, сургалт, судалгаа явуулах чиг үүрэг бүхий "Сувилгаа, хөнгөвчлөх

эмчилгээний газар"-ыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх зүйлийн жагсаалтад оруулахаар ажиллаж байна. /30 хувь/

**155.** Монголын ахмад мэргэжилтнүүдийн Үндэсний сүлжээг зохион байгуулж, байгууллагуудад зөвлөгөө өгөх, гэрээгээр түр хугацаагаар ажиллуулах зэргээр мэдлэг, туршлагыг нь өвлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх

**Биелэлт:** Ахмад настан, залуучуудын төрийн бус байгууллага, ахмадууд, бодлого боловсруулагч байгууллагын төлөөлөл 120 гаруй хүмүүсийг хамруулан "Ахмад мэргэжилтнүүдээсээ суралцъя", "Ахмад, залуу үеийн хамтран ажиллах боломж", "Ахмад, залуу үеийн залгамж холбоог сайжруулах салбар дундын бодлого, зохицуулалт" зэрэг цуврал уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

"Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл"-ийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж байна. Төсөлд аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй 3-аас доошгүй гишүүнтэй тэтгэврийн насны ахмад, мэргэжилтнүүдийн баг, бүлэгт зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах төслийг нэг сая хүртэл төгрөгөөр дэмжих ба 330 сум 152 хорооноос 964 ахмадын бүлэг, 3000 ахмадуудад 1080.0 сая төгрөг, Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ТББ, холбоод мэргэжлийн зөвлөхүүдийн баг ажиллуулахад 135.0 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулахаар шийдвэрлэсэн.

2014 онд хагас жилийн байдлаар нийт 61 зөвлөх багийн төсөлд 38,7 сая төгрөгийн санхүүжилт олгож 193 ахмад мэргэжилтэн түр ажлын байртай болсон байна.

"Монголын ахмадын холбоо", "Монголын чөлөөт ахмадын холбоо", "Таны зүтгэлийн төлөө" ТББ, "Ачлалт дэлхий ээж" ТББ гэсэн нийт 4 ахмадын байгууллагын 85 багийн 276 ахмад мэргэжилтэн хамрагдаад байна. /70 хувь/

**156.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай сан байгуулах асуудлыг судлаж шийдвэрлэх

**Биелэлт:** Хөдөлмөрийн яамнаас "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг 2013 онд хэрэгжүүлэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2013 оны төсөвт хөгжлийн бэрхшээлтэй иргэн хувиараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэхэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгт 1 тэрбум төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусгайлсан байнгын ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудад үзүүлэх санхүүгийн дэмжлэгт 300 сая, нийт 1,3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Үүний дагуу 21 аймаг, 9 дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж ахуй эрхлэх чиглэлээр сонгон шалгаруулсан төслүүдийн хүрээнд ахуй үйлчилгээний 237, хүнсний үйлдвэрлэлийн 74, хөнгөн үйлдвэрлэлийн 160, барилгын материалын үйлдвэрлэлийн 42, хөдөө аж ахуйн 71, газар тариалангийн 132, өрхийн үйлдвэрлэлийн 201 буюу нийт 917 төсөлд 979 сая 900 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноор 1089 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгайлсан байнгын ажлын байраар хангахад ажил олгогчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгт 26 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хамрагдан, 299 сая төгрөг зарцуулж 91 байнгын тусгайлсан ажлын байр бий болгосон. /50 хувь/

**157.** Өндөр настны асрамжийн төв байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжих

**Биелэлт:** Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа иргэний хоол хүнс, хувцас, эм, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн нэг хүнд ногдох зардлын норматив, эдэлгээний хугацаа, нас барсан иргэнийг оршуулах зардлын нормативыг батлав.

Зардлын нормативыг шинэчлэн баталснаар улсын болон хувийн асрамжийн газрыг ажиллуулах жишиг, эрх зүйн орчин бүрдсэн юм.

Одоогийн байдлаар Сонгинохайрхан дүүрэгт "Гэрэлт ирээдүй" ТББ-ын хувийн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асруулж, санхүүжилтийг улсын төсвөөс олгож байна. Ватиканы асрамжийн төв нийслэлийн 2 дүүрэгт ахмад настны асрамжийн үйлчилгээг үзүүлж байна.

Цаашид хувийн асрамжийн газарт олгох санхүүжилтийн зохистой хэмжээний талаар тооцоо судалгаа хийж байна. Өндөр настны асрамжийн газрын үйл ажиллагаанд мөрдөж буй "Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага"-ыг шинэчлэн сайжруулж Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлууллаа. /90 хувь/

#### **158. Хүүхдийн мөнгийг дахин олгож эхлэх**

**Биелэлт:** "Хүний хөгжил сан"-гийн 2013 оны төсөвт хүүхдийн мөнгөнд зориулж 1.0 сая хүүхдээр тооцон нийт 240.0 тэрбум төгрөгийг тусган УИХ-аар батлууллаа.

Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор "Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам"-ыг баталсны дагуу 2012 оны 10 дугаар сараас эхлэн сар бүр хүүхдийн мөнгийг олгож байна. 2014 онд "Хүний хөгжил сан"-гийн 2014 оны төсөвт хүүхдийн мөнгөнд зориулж 1.0 сая хүүхдээр тооцон нийт 239 тэрбум төгрөгийг тусган УИХ-аар батлуулсан бөгөөд нийт 238.4 тэрбум төгрөгийн санхүүжүүлт хийгдсэн байна.

Хүүхдийн мөнгөнд төсөвлөгдсөн хөрөнгөөс зарцуулагдаагүй үлдэгдлийг зөвхөн хүүхдийн хөгжлийг дэмжих зориулалтаар дараа жилийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусган зарцуулах асуудлыг Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулан батлуулав. /100 хувь/

**159. Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг хангах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламж, бий болгосон хөрөнгийг зориулалтын дагуу хүүхдийн төв байгууллагын мэдэлд шилжүүлэх, өмчлүүлэх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж, менежментийг нь хүүхэд, залуучуудын хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцэхүйц түвшинд хүргэх**

**Биелэлт:** Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг хангах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламжид улсын хэмжээний үзлэг явуулж, зориулалтын дагуу ашиглагдаж байгаа эсэхийг тогтоон дүгнэлт гаргах, зориулалт нь өөрчлөгдсөн барилга, байгууламж болон хөрөнгийг хүүхдийн байгууллагын мэдэлд шилжүүлэх, өмчлүүлэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий салбар дундын Ажлын хэсэг хүүхэд, залуучуудын хөгжлийг хангах зориулалт бүхий нэр бүхий томоохон 11 барилга, байгууламжид улсын үзлэг, шалгалт хийж, тодорхой санал, дүгнэлт боловсруулан ажиллалаа.

Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй "Залуучуудын хөгжил 2013-2017" төслийн хүрээнд 2013-2014 онд нийт 9 хөгжлийн төвийг Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Ховд, Увс, Завхан аймагт байгуулан орон нутгийн өсвөр үе, залуучуудад чиглэсэн хөгжлийн үйлчилгээ, сургалт, нөлөөллийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Тус хөгжлийн төвүүдэд ажиллах зохицуулагч, нийгмийн ажилтнуудын ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт, төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 6 сарын 30-ны өдрийн А/72 тоот тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /70 хувь/

**160. Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, бодит цалин хөлсний өсөлт, амьжиргааны доод түвшинг харгалзан жил бүр шинэчлэн тогтоох**

**Биелэлт:** 2014 оны Төсвийн тухай хуулиар нийгмийн халамжийн тэтгэвэр, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.1-д заасан тэтгэмжийг нэмэгдүүлэхэд зориулж 2013 оны төсвийн хэмжээнээс 11.0 тэрбум төгрөгөөр илүү нэмж баталсан. Иймд энэхүү төсөвтэй уялдуулан 2014 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 66098 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 8767 хүүхдэд олгох нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 11 хувиар, 31292 иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг 10 хувиар тус тус нэмэгдүүлэхээр санал, тооцоог боловсрууллаа.

“Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 2014 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ сард 115000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээ 52800 төгрөг болж нэмэгдлээ. /90 хувь/

**161.** Нийгмийн хамгааллын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд санхүүгийн шинэ үйлчилгээ, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, оролцогч талуудад нээлттэй мэдээллийн сан бий болгох

**Биелэлт:** Эрүүл мэндийн даатгалын албан журмын даатгалын тухай хуулийн төсөлд эрүүл мэндийн цахим карттай байхаар тусгасан. Энэхүү хуулийн төсөл нь Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд хуулийн төслийг УИХ-д 2014 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр өргөн бариад байна.

Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлэх, түүний оновчтой шийдлийг бий болгох судалгааны багийг шалгаруулж, “Секьюрити солюшн сервис консалтинг” ХХК-тай хамтран ажиллаж байна.

Иргэд, даатгуулагчдад цалингийн мэдээлэл, шимтгэл төлөлт болон тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээллийг цахимаар хүргэх ажлын хүрээнд иргэдийн и-мэйл хаяг, утасны дугаарыг бүртгэх вэб програмд 2013 оны байдлаар 117407 даатгуулагч утасны дугаар, 53065 даатгуулагч имэйл хаягаа бүртгүүлжээ.

Нийгмийн даатгалын үйлчилгээнд 2014 оны 5 сараас НДЕГ, нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст “НДҮ” цахим машин суурилуулж 5 төрлийн лавлагааг цахимаар олгож эхлэв.

Даатгуулагч (иргэд) сайн дурын даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж, лавлагааны хураамжийг Төрийн банкны “Цахим банк”, Хаан банкны “Ухаалаг банк” үйлчилгээг ашиглан ухаалаг гар утас, интернетээр төлөх үйлчилгээг нэвтрүүлсэн нь орон зайнаас хамаарахгүйгээр төлбөр төлж, цаг хугацаа хэмнэх боломжийг иргэдэд олголоо.

Даатгуулагч <http://www.ndaatgal.mn/regnd/> цахим хаягт хандан бүртгүүлж, өөрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нэрийн дансны үлдэгдэлийг цахим шуудангаар авах боломжийг бүрдүүлэв. 2014 оны байдлаар 50 мянга орчим даатгуулагч бүртгүүлж мэдээллээ цахимаар авсан байна.

Хүн ам олноор төвлөрөн суурьшсан, Нийгмийн даатгалын тасагтай 7 сумыг нэгдсэн өгөгдлийн санд интернэтээр холбож ажиллах боломжийг бүрдүүлсэн.

“Улсын хэмжээнд судалгаа хийх тухай” Засгийн газрын 2013 оны 269 дүгээр тогтоолын дагуу өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох, өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх улсын хэмжээний судалгаа явуулж, улсын нийт 768263 өрхийн 90 орчим хувийн мэдээллийг цахим хэлбэрт оруулан мэдээллийн сан бүрдүүлэв.

2013 оны 8 дугаар сараас Салбар дундын мэдээллийн системийг ашиглалтад оруулж онлайн хэлбэрт шилжүүлснээр шилжилт хөдөлгөөн болон бусад шалтгааны улмаас үүссэн үйлчилгээний давхардлыг бүрэн арилгаж, цаасан эрхийн бичгийн хуваарилалтыг нэгдсэн журмаар програмаас хийдэг болсноор үйлчилгээ илүү хялбаршсан. Мөн аймаг, дүүргийн НХҮХ-ийн мэдээллийн сангуудыг нэгтгэж, нэгдсэн сантай болсноор олголтын файлыг багаас сум, сумаас аймаг, аймгаас мэдээллийн нэгдсэн санд ирүүлж нэгтгэдэг байсан шат дамжлага байхгүй болсон. /70 хувь/

**162.** Орон сууц, сургууль болон үйлчилгээний газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг байгуулах

**Биелэлт:** Шинэчлэн найруулж байгаа Хот байгуулалтын тухай хуулийн төсөлд хот байгуулалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хангах зарчмыг баримтлахаар тусгаж, заалтуудыг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Магадлал хийгдсэн барилга байгууламжийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг тусгуулж, барилгын холбогдох норм, дүрмийн шаардлагыг хангуулан ажиллаж байна.

“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийг Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлан, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын болон техникийн комиссын бүрэлдэхүүнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулж, хамтран ажиллах, тэдний санал, хүсэлтийг сонсож, холбогдох арга хэмжээг авахуулан ажиллаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг хангуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/690 дүгээр захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. **/70 хувь/**

**163.** Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогыг нийгэм, эдийн засаг, байгаль орчин зэрэг хөгжлийн бүх үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх

**Биелэлт:** Улс орны хөгжлийн бодлогыг боловсруулахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тэнцвэртэйгээр төлөвлөх зарчмыг баримтлах болон салбар хоорондын уялдааг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

УИХ-ын хэлэлцүүлгийн шатандаа байгаа Монгол Улсын төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлогын төсөлд “*Байгаль орчныг хамгаалж, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн чиг хандлагыг баримтлах*” зарчмыг тусгасан. Хүн амын хөгжлийг хангахад чиглэсэн аливаа үйл ажиллагаанд байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль экологид ээлтэй техник, технологийг хэрэглэх зарчмыг баримтлана гэсэн үзэл баримтлалыг бодлогод тусгаж өгсөн нь салбар дундын уялдааг хангаж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогыг хүн амын хөгжлийн бүх үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа юм.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг боловсруулах эхний судалгааны ажлыг “Засаглалыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийсэн. НҮБХХ-ийн “Ядуурлыг бууруулах хөтөлбөр”-ийн хүрээнд хийсэн судалгааны дүнд үндэслэн шалгуур үзүүлэлтийн эхний төслийг гаргаад байна. **/30 хувь/**

## **ХОЁР. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ МОНГОЛ ХҮН**

**164.** Иргэний эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийг хийх

**Биелэлт:** Эрүүл мэндийн даатгалын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, даатгуулагчийн эрхийг хамгаалах, тэдний хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээг хүргэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагыг бие даалгах, эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгох даатгалын тогтолцоог шинэчлэх шаардлагын үүднээс “Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд бүх яамдаас санал авч боломжтой саналыг хуулийн төсөлд тусгасан. Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд хуулийн төслийг УИХ-д 2014 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр өргөн бариад байна. **/50 хувь/**



**165.** Эх орондоо чанартай оношилгоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чиглэлийн дагуу 14 дэд ажлын хэсэг эрүүл мэндийн салбарт мөрдөж байгаа нийт 613 стандартад улсын үзлэг хийж 395 стандартыг өнөөгийн нөхцөл байдал, шаардлагад нийцэж байна гэж үзэн хэвээр үргэлжлүүлэн мөрдөх, 90 стандартыг хүчингүй болгох нь зүйтэй гэж дүгнэжээ.

“Эрүүл мэндийн салбарын 2013-2015 онд боловсруулах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжийн чиглэл”-ийг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 290 дүгээр, “Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого”-ыг 176 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллагуудын судалгааг гаргаж, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх аливаа гэрээнд тухайн тоног төхөөрөмжийн угсралт, 3-5 жилийн хугацааны засвар үйлчилгээний асуудлыг нийлүүлэгч аж ахуй нэгж хариуцах заалтыг тусган ажиллаж байна.

2012 онд оношлогоо, эмчилгээний чанарын стандартыг шинэчилж, эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Артерийн даралт, чихрийн шижингийн эмнэлзүйн Удирдамжийн гардан үйлдэл”, “Ангиографийн оношилгоо Зүрхний шигдээсийн титэм судсан дотуурх эмчилгээ”, “Элэгний хавдрын тэжээгч судсыг бөглөх эмчилгээ” зэрэг 3 стандартыг шинээр баталсан.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 74 дугаар тушаалаар бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг, 2014 оны 177 дугаар тушаалаар элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг тус тус баталсан нь Монгол оронд элэг, бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг нэвтрүүлэн өвчтөнд оношилгоо-эмчилгээ, хяналтанд авах боломжтой боллоо. 2014 оны 6 сарын байдлаар Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эрхтэн шилжүүлэн суулгах төвөөр гадаад, дотоодод бөөр шилжүүлэн суулгасан нийт 145, элэг шилжүүлсэн суулгуулсан 143 иргэнийг байнгын хяналт, тусламж үйлчилгээнд хамруулж байна.

2014 онд оношлогоо, эмчилгээний чанарын стандартыг шинэчилж, эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөнгөн ус, түүний нэгдлүүдийн хордлогын оношилгоо, эмчилгээ, Нүүрс төрөгчийн дутуу исэл (СО)-ийн цочмог хордлогын оношилгоо, эмчилгээ, Цууны хүчлийн цочмог хордлогын оношилгоо, эмчилгээ зэрэг 7 стандартыг шинээр баталсан. **/50 хувь/**

**166.** Орлого багатай иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулахад дэмжлэг үзүүлэх

**Биелэлт:** Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орлого багатай иргэдийн дараах шимтгэлийг төрөөс хариуцахаар тусгалаа. Үүнд:

- Хүүхдээ 2 /ихэр бол 3/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;
- Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;
- 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
- 18 хүртэлх насны хүүхэд;
- Нийгмийн даатгалын, эсхүл нийгмийн халамжийн сангаас олгох хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагч;
- Цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэн зэрэг болно.

**/30 хувь/**

**167.** Импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх

**Биелэлт:** УИХ-ын 2014 оны 57 тоот тогтоолоор Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг батлав. Энэхүү төрийн бодлогод тусгагдсаны дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд эмийн чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээг сайжруулах талаар тусгаж хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон үзэл баримтлалыг боловсруулаад байна.

“Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4”-ийн “Эмийн аюулгүй байдлын төсөл”-ийн хүрээнд Нэгдсэн төв лабораторийн Эм, биобэлдмэлийн лабораторийг ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 1.1 сая ам.долларын тоног төхөөрөмжөөр нэмж хангав. Мөн ISO-17025 стандартыг хангуулах зорилгоор олон улсын шинжээчийн болон орчны үнэлгээ хийлгэж, гарсан зөвлөмжийг Эм, биобэлдмэлийн лабораторийн барилгын зурагт тусгуулан нэмэлт хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын талд тавьж шийдвэрлүүлээ.

Лабораторийн удирдлагын болон ажиллагсдын сургалтыг хийх, чанарын менежментийн систем нэвтрүүлэх, олон улсын стандартын шаардлага хангуулж, түүнийг баталгаажуулах, лабораторийн удирдлага, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоход техникийн туслалцаа үзүүлэх ажлыг хийж эхлээд байна. Ингэснээр Нэгдсэн төв лабораторийн Эм, био бэлдмэлийн лабораторийг 2016 онд ISO-17025 стандартыг хангуулж олон улсын итгэмжлэлд хамруулах боломж бүрдэнэ.

Эмийн аюулгүй байдлын мэдээллийн системийг цогц байдлаар хийхээр судалгааг хийсэн. Түүнчлэн иргэдэд эрүүл мэндийн даатгалын ухаалаг цахим үнэмлэх олгох асуудлыг цахим иргэний үнэмлэхтэй холбох талаар ажиллаж байна. Мөн Эм борлуулах цэг буюу аптек байгуулах тусгай зөвшөөрөл олгох системийг хийж, хэрэгжүүлсэн. Програм хангамжийн үндэсний компаниудаас “Эмийн болон хүнсний аюулгүй байдлын систем”-ийн төслийг боловсруулан танилцуулсан боловч энэхүү ажлыг хэрэгжүүлэх төсөв суугаагүй болно.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.6 дахь заалтад “импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгонд агуулагдах мэдээлэл монгол эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна” гэж тусган батлуулж 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний 98 нэр төрлийн бүтээгдэхүүнд 261 үзүүлэлттэй байсныг 53 нэрийн бүтээгдэхүүний 102 үзүүлэлтийг нэмж тусган, нийт 151 нэрийн бүтээгдэхүүний 363 үзүүлэлттэй байхаар боловсрууллаа.

2013-2014 оны стандартчиллын ажлын төлөвлөгөөнд хүнсний салбарт 5 стандарт шинээр, 3 стандартыг хянахаар, олон улсын 16 стандартыг үндэсний болгохоор тусгаад байна.

2013 оны улсын төсөвт мал, амьтны өвчнөөс сэргийлэх, эмчлэх, шинэ технологийг үйлдвэрлэлийн өргөн туршилтад нэвтрүүлэхэд 20.5 сая, биобэлдмэлийг хянан баталгаажуулахад 110.7 сая, халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын үр дүнг тооцох судалгаа, хяналтын зардалд 92.0 сая төгрөгийг тусгасан.

2014 онд малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй 10 аж ахуйн нэгжийн 44 нэрийн 44 цуврал бүтээгдэхүүн, 28 аж ахуйн нэгжийн 133 нэрийн 220 цуврал импортын бүтээгдэхүүн, 9 аж ахуйн нэгжийн 15 нэрийн 64 цуврал дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг эмийн бүртгэлд бүртгүүлэхээр тус тус шалгаж, дүгнэлт гаргасан байна.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори улсын хэмжээнд эм, эмийн бодисын үлдэгдлийг илрүүлэх шинжилгээ хийдэг байсан бол 2013 онд ШУТИС-ийн харьяа Хүнсний лавлагаа лаборатори, МХЕГ-ын Үндэсний лавлагаа лаборатори ийм шинжилгээ хийх техник, тоног төхөөрөмжийн чадвартай болсон.

Малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 8, импортлох тусгай зөвшөөрөлтэй 79 компани, Улаанбаатар хотод малын 20 эмийн сан, аймгуудад малын эмийн ханган нийлүүлэх сүлжээний 22 аж ахуйн нэгж, хөдөө орон нутагт хувийн мал эмнэлэг үйлчилгээний 800 гаруй нэгжийн эмийн сангаар дамжуулан мал бүхий иргэдийг улсын бүртгэлд бүртгэгдсэн 520 нэр төрлийн чанарын баталгаатай, өндөр идэвхитэй эмээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Улсын хэмжээнд 2012 онд хүнсний салбарт хүчин төгөлдөр мөрдөж байгаа 667 стандартаас 44.7 хувь нь олон улсын болон бүс нутгийн түвшинд хүрсэн бол 2013 онд хүнсний салбарт хүчин төгөлдөр мөрдөж байгаа 753 стандартаас 44.6 хувь нь олон улсын болон бүс нутгийн түвшинд хүрээд байна. /50 хувь/

#### 168. Монгол хүний эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах

**Биелэлт:** Эрүүл мэндийн даатгал төлөгч нь бялдаржуулах, чийрэгжүүлэх клубт хичээллэсэн тохиолдолд төлбөрийн тодорхой хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас төлдөг байх зохицуулалтыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд оруулах боломжийг судалж байна.

Хүрээлэн буй орчноос хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох нөлөөллийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэхээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: “Эрүүл ахуйн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тогтолцоо, зохицуулалтыг хангах /3 дугаар бүлэг/ бүлгийг нэмэлтээр оруулж, үзэл баримтлал батлуулав.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үндэсний хэмжээний үнэлгээг хийлээ.

2013 онд хүний эрүүл мэндэд орчны нөлөөлөх байдалд дараах судалгаа, үнэлгээг хийсэн. Үүнд:

- “Өмнөговь аймгийн уурхайн нөлөөллийн хүрээний сумдын малчдын ахуй амьдрал, эрүүл мэндийн байдлын үнэлгээ”;
- Баянхонгор аймгийн хүн амын дунд “Мөнгөн усны эрүүл мэндийн нөлөөллийг тогтоох үнэлгээ”;
- “Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагын агаар дахь мөнгөн ус” судалгаа
- “Химийн бодис хэрэглэдэг байгууллагуудын эрсдэлийг тогтоох судалгаа”
- “Хүүхдийн тоглоомны химийн бодисын бохирдол, эрсдэлт хүчин зүйлийн судалгаа”

Аймаг, нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх тогтолцоог 3.5 код бүхий “Ундны усны чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар шалган сумдын хүн амын ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн төлөв байдлыг тодорхойлж, нийслэлд 4 худаг, дамжуулах болон хлоржуулалтын станц, ус түгээх 149 байр, 32 гол мөрөн, булаг шанд, аж ахуйн нэгж байгууллага, иргэний гаргасан 116 худаг, нийт 297 дээж, 300 сумын ундны усны 830 эх үүсвэрээс дээж авч, хими, нян судлалын шинжилгээнд хамруулан үнэлгээ дүгнэлт өглөө.

2014 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын нөхцөл байдалд хот хөдөөгийн нийт 85 байгууллагыг хамруулан судалж, дүн шинжилгээ хийсэн. Судалгааны тайлан дүгнэлтэд үндэслэн эрүүл мэндийн байгууллагын эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэл гарсан үед авах арга хэмжээний талаар эрүүл мэндийн байгууллагын түвшинд авч хэрэгжүүлэх 28, эмнэлгийн мэргэжилтний түвшинд авч хэрэгжүүлэх 16 заалт бүхий зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргэсэн байна.

Улаанбаатар, Дархан, Орхон, Төв аймгийн 2002-2011 оны агаарын түгээмэл бохирдуулагчид хүхэрлэг хийн 928, азотын давхар ислийн 946, нарийн ширхэглэгт тоосонцрын 161, нүүрстөрөгчийн дутуу ислийн 149 шинжилгээний дүн болон цаг уурын хэмжилтүүдийн тоон мэдээлэл, 2002-2011 оны хүн амын дунд тохиолдсон амьсгал, зүрх судас, хавдар, дутуу төрөлт, төрөлхийн хөгжлийн гажиг зэрэг 1653799 өвчлөл болон дээрх өвчлөлийн нас баралтын 28876 тохиолдолд эрүүл мэндийн судлгааны арга зүйгээр үнэлгээ хийж, статистик боловсруулалтыг өвчлөл болон бохирдлын хамаарлаар тогтоолоо.

Улаанбаатар хот, 21 аймгийн хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд шалгалт хийхэд 57 хувь нь их, 43 хувь нь дунд эрсдэлтэй байна.

Нийслэл болон 11 аймгийн хүн амын суурьшлын бүсийн хөрснөөс 127 дээж авч хими, нян судлал, хүнд металлын шинжилгээнд хамруулахад 50.7 хувь нь их, 34.9 хувь нь дунд, 14.3 хувь нь бага бохирдолтой ангилалд хамаарч байна.

Халдварт өвчний гаралт, эрсдлийг бууруулах зорилгоор жил бүр улсын төсөвт зардлыг тусган хэрэгжүүлж байна. Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлгийн арга хэмжээнд 2012 онд 24489.0 сая, 2013 онд 22545.0 сая, 2014 онд 17938.8 сая төгрөгийг тус тус улсын төсөвт тусган хэрэгжүүлсэн.

Хяналт шалгалтын явцад зөрчилтэй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд улсын байцаагчийн 135 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, улсын байцаагчийн 66 дүгнэлт үйлдэж, 12.1 сая төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авсан байна.

Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартуудад чанарын удирдлагын үйл ажиллагааны чиглэл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг үнэлэх үнэлгээний заалтыг тусгайлан тусгасан.

“Сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц”, “Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц”-ыг тус тус батлаад байна. /60 хувь/

**169.** Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн сүлжээний хөрөнгө оруулалтын хэмжээг 2016 он гэхэд тав дахин нэмэгдүүлж, бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах

**Биелэлт:** Оношлогооны төв байгуулах үндэслэл, тооцоо боловсруулж 25.7 тэрбум төгрөгийг батлуулж, 11 аймагт “Оношлогооны төв” байгуулахад Ерөнхий сайдын багцаас 19.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 2177,2 төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр бэлэн болоод байна.

Эрүүл мэндийн сайдын төсвөөс 2013 онд Улсын хоёрдугаар төв эмнэлэгт 1004.0, Улсын 3 дугаар төв эмнэлэгт 982.6, Хавдар судлалын үндэсний төвд 305.0, Хүүхдийн төв сувилалд 266.3, Арьсны өвчин судлалын үндэсний төвд 333.0, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 1013.2, эмнэлгүүдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийг тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад 590.4, Дархан-Уул аймгийн Хүүхдийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд 795.1, Нэгдсэн эмнэлгийн техник, тоног төхөөрөмжид 933.7, нийт 6.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлээд байна.

Кувейтийн Засгийн газраас нийт 274615 ам.доллар буюу 392.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлэхээр шийдвэрлэж, 189.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлээд байна.

2013 онд түргэн тусламжийн албадыг тоноглоход 1.5 тэрбум төгрөг батлагдсан ч төсвийн тодотголоор хасагдан 800.0 сая төгрөгөөр батлагдан, 590.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулсан. 2014 оны 1 дүгээр улиралд багтаан тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 200.0 сая иенийн хөрөнгө оруулалтаар түргэн тусламжийн автомашин нийлүүлэхээр шийдвэрлэж, машины техникийн үзүүлэлт, тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн үзүүлэлтийг тус байгууллагад хүргүүлээд байна.

Эрүүл мэндийн сайдын төсвөөс 2013 онд 796.0 сая төгрөгөөр 39 автомашин нийлүүлээд байна.

2014 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг 29.3 тэрбум төгрөгөөр батлуулсан байна. 2014 онд хөрөнгө оруулалтаар 909,6 сая төгрөгийн “Эмнэлгүүдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах”-аар төсөвлөн худалдан авах үйл ажиллагаа явагдаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлээр 1165,0 сая төгрөгийн 25 түргэн тусламжийн үйлчилгээний авто машин нийлүүлсэн. /40 хувь/

**170.** Эрүүл мэндийн даатгалын санг бие даалган, даатгалын санхүүжилтийг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд хуулийн төслийг УИХ-д 2014 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр өргөн бариад байна.

Энэхүү хуулийн төсөлд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгох, тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, төлбөрийн хэмжээг тогтоох, эрх зүйн чадамжтай, эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн Үндэсний зөвлөлийн удирдлага, хяналтын дор үйл ажиллагаа явуулдаг, даатгуулагчийн өмнөөс чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээ худалдан авагч, даатгуулагч төвтэй байгууллага болгон чадавхижуулах зэрэг тодорхой асуудлууд тусгагдсан болно. **/50 хувь/**

**171.** Оношилгоо, эмчилгээний чанарын хяналтын үнэлгээг үндэслэн улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг тарифийн ялгаваргүйгээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 145 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 150 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах удирдамж”-ийг тус тус шинэчлэн баталсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 247 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу анх удаа шалгагдаж байгаа эрүүл мэндийн байгууллагад 2 жилийн хугацаатай, давтан магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 3-5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэл олгохоор болж байна. Өмнө нь мөрдөгдөж байсан журмаар магадлан итгэмжлэлийн батламжийг 3 хүртэлх жилийн хугацаатай олгодог байсан юм.

Төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа, сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд ЭМД-ын сангаас улсын эмнэлэгтэй ижил тарифаар санхүүжүүлэх зохицуулалтыг ЭМСайд, ХАХНХСайд, Сангийн сайдын 2013 оны 459/280/182 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Төрийн гүйцэтгэж чадахгүй байгаа, эсвэл ачааллаа дийлэхгүй тусламж, үйлчилгээг үзүүлж буй хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын тухайн тусламж, үйлчилгээг улсын эмнэлэгтэй ижил тарифаар санхүүжүүлэх зохицуулалт бүхий “Хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЭМСайд, ССайд, ХАХНХСайдын хамтарсан тушаалын төсөл, холбогдох тооцоо, танилцуулгыг бэлтгэн 2014 оны 1а/4959 албан бичгээр ХАХНХЯ, СЯ, НДҮЗөвлөлд хүргүүлээд байна. **/70 хувь/**

**172.** Өрхийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийнхээ төлөө хүлээх гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өрхийн нэг гишүүний эрүүл мэндтэй холбоотой санхүүгийн хүндрэл тулгарсан үед гэр бүлийн бусад гишүүний тухайн жилдээ зарцуулах ЭМД-ын тусламж үйлчилгээний зардлаас нь шилжүүлэн ашиглах талаар тусгасан. Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан бөгөөд анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хийлээ. **/50 хувь/**

**173.** Эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг төрийн албаны бүтцээс гаргаж, нэгдсэн эмнэлэг, үндэсний төвүүдийн санхүүгийн бие даасан үйл ажиллагааг хангаж, эмч, сувилагчдын ажлын ачаалал, ур чадварт суурилсан цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн ажилтны цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 75 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын улсын төсөвт 28.6 тэрбум төгрөгний санхүүжилтийг нэмэлтээр тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчдын цалин 10 дугаар сарын 01-ний өдрөөс 15 хувиар нэмэгдсэн.

“Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний тогтолцооны шинэчлэлийн хөтөлбөр”-ийн төсөл, “Эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх журам, шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын төслийг боловсруулав.

Эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг төрийн албанаас гаргах зорилт нь “Нийтийн албаны тухай” хуулийн хүрээнд шийдвэрлэгдэх тул уг хуулийн боловсруулалтын ажилтай уялдан хүлээгдэж байна. **/50 хувь/**

**174.** Эрүүл мэндийн салбарын ажилтны хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох

**Биелэлт:** “Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай” хуулийн үзэл баримтлалыг Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар дэмжсэн тул Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдаар үзэл баримтлалыг батлан яамдуудаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. **/50 хувь/**

**175.** Иргэдийг цахим карт, хувийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сантай болгож, эрүүл мэндийн даатгалтай иргэн харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн даатгалын албан журмын даатгалын тухай хуулийн төсөлд эрүүл мэндийн цахим карттай байхаар тусгасан. Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан бөгөөд анхны хэлэлцүүлгийг УИХ-ын 2014 оны 12 дугаар сарын 26-ны нэгдсэн чуулганаар хэлэлцээд хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлсэн.

Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр ЭМД-ын цахим картыг нэвтрүүлэх, түүний оновчтой шийдлийг бий болгох судалгааны багаар “Секьюрити солюшн сервис консалтинг” ХХК-ийг шалгаруулан хамтран ажиллаж байгаа болно.

Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах зорилгоор салбарын мэдээллийн энтерпрайз архитектурыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, архитектурын төслийг дараах үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар тооцсон. Үүнд:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл мэдээллийн тогтолцоо;
2. Эрүүл мэндийн ажилтны бүртгэл, мэдээллийн тогтолцоо;
3. Эмийн мэдээллийн тогтолцоо;
4. Иргэний эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо. **/30 хувь/**

**176.** Телемедицины үндэсний сүлжээ байгуулж, зайн оношилгоог өргөтгөх

**Биелэлт:** “Телемедицин үндэсний сүлжээний ажиллах журам”-ыг шинэчлэн баталж мөрдөж байна.

Люксембургийн Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Эх, нярайн эрүүл мэндийг сайржуулахад зайн анагаахыг нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд 21 аймаг, орон нутгийн 6 нэгдсэн эмнэлгийг телемедицины сүлжээнд холбов.

Мөн Люксембургийн Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Улсын гуравдугаар төв эмнэлэг болон 21 аймагт зүрхний тусламж, үйлчилгээг сайжруулах төслийг хэрэгжүүлж, алсын зайн оношлогоог эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 320 дугаар тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний албыг 5 мэргэжилтний орон тоотойгоор ажиллуулахаар зохион байгуулсан.

2012 онд 5 аймаг, 2013 онд нийт 12 аймгийг шинээр телемедицины сүлжээнд холбосноор бүх аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедицины үндэсний төвтэй холбогдлоо.

"Сумдад өндөр хурдны түгээх сүлжээ байгуулах" төслийн хүрээнд 2013 онд нийслэлийн 3 дүүрэг, 21 аймгийн төв, 52 сумын эмнэлгийн телемедицины суурь дэд бүтцийг байгуулан ажиллаж байна.

ЭМХТ, 21 аймаг, 4 Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд телемедицины үндэсний сүлжээнд холбогдон Эрүүл мэндийн сайд болон яамны удирдлагуудаас орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын ажилтан, албан хаагч нартай 7 хоног бүрийн баасан гаригт тогтмол цахим хурлыг 2014 онд нийт 46 удаа зохион байгуулсан.

2014 оны 10 дугаар сарын байдлаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон аймгийн нэгдсэн эмнэлгүүдээс нарийн мэргэжлийн яаралтай зөвөлгөө авах үйл ажиллагааг онлайнаар 21 удаа, офлайнаар 251 удаа тус тус зайн оношлогоо эмчилгээний зөвлөгөө өгч, видео хурлыг зохион байгуулсан. ХСҮТ нь сар бүрийн 3 дахь 7 хоногийн мягмар гаригт 21 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн хавдар судлаач эмч, хөнгөвчлөх эмчилгээний эмч нарт зайн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. /70 хувь/

**177.** Эмнэлгийн яаралтай тусламжийн нэгдсэн сүлжээ бий болгож, алсын дуудлагад бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах нөхцөлийг бүрдүүлж, явуулын болон сэхээн амьдруулах тасгуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх

**Биелэлт:** 2014-2019 онд хэрэгжих “Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл” стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 496 дугаар тушаалаар батлан бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, нэгжийг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375 дугаар тушаалын дагуу шинэчлэн зохион байгуулж байна.

Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт яаралтай түргэн тусламжийн салбарыг байгуулан тусламж, үйлчилгээг иргэдэд ойртуулан ажиллаж байна. 2014 онд Чингэлтэй дүүрэгт түргэн тусламжийн салбар байгуулахаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлээд байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 310 дугаар тушаалаар 8 аймгийн 33 сумын Эрүүл мэндийн төв болон 2 нэгдсэн эмнэлэгт 671.9 сая төгрөгийн өртөг бүхий 35, мөн оны 387 дугаар тушаалаар Өвөрхангай аймгийн БОЭТ, Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд нийт 123.9 сая төгрөгийн өртөг бүхий 5 автомашин олгосон байна.

2013 онд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд 33, 21 аймаг, нийслэлийн 7 дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 49 яаралтай тусламжийн зөөврийн монитор, 38 ширхэг

дуслын автомат шахуурга, 15 ширхэг зөөврийн рентген, 4 ширхэг дефибрилятор зэрэг яаралтай тусламжид нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангасан байна.

2014 онд хөрөнгө оруулалтаар “Эмнэлгүүдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах”-аар 0.9 тэрбум төгрөг, УНТЭ-т 1.0 тэрбум төгрөг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 3.107.8 тэрбум төгрөгийн сэхээн амьдруулах тасгийн тоног төхөөрөмж, амаржих газруудад 1.2 тэрбум төгрөгийн эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахаар төсөвлөн худалдан авах үйл ажиллагаа явагдлаа. /Нийт 6.207.8 тэрбум төгрөг/ **/60 хувь/**

**178.** Нэг сувилагчид ногдох өвчтөний тоог олон улсын жишигт хүргэж өвчтөнд үйлчлэх асаргаа, сувилгааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх

**Биелэлт:** Эрүүл мэндийн сайдын 2012 оны 272 дугаар тушаалаар батлагдсан “Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийн хүрээнд Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны 12 багц төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын шинэчлэн батлагдсан стандартуудад сувилагчийн тоог тэдгээрээс үзүүлэх тусламж, үйлчилгээний чиглэл, олон улсын жишиг, ажлын ачаалалд нийцүүлэн нэмэгдүүлэхээр тусгаснаар одоо байгаа сувилагчийн тоо 2 дахин нэмэгдэхээр, туслах сувилагчийн орон тоо шинээр нэмэгдэж, 6-8 өвчтөнд нэг туслах сувилагч ажиллахаар болсон нь сувилагчийн ажлын ачааллыг тодорхой хэмжээгээр хөнгөлж, өвчтөн, үйлчлүүлэгчид сувилахуйн чанартай тусламж үзүүлэх боломжийг нэмэгдүүлжээ. Гэвч эмнэлгийн байгууллагууд төсөвтөө цалин, холбогдох зардлыг тусган, хэрэгжүүлэх асуудал удаашралтай байна. **/40 хувь/**

**179.** Анагаахын боловсрол олгох, мэргэшил дээшлүүлэх, нарийн мэргэшлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох

**Биелэлт:** ЭМЯ-ны зүгээс өөрийн харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвд эмч, мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын албыг хэлтэс болгон өргөжүүлэн зохион байгуулсан. Энэ хүрээнд гол хийсэн ажлуудыг дурдвал:

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын журам, эмнэлгийн мэргэжилтнийг төсвийн санхүүжилтээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах журмуудыг шинэчлэн боловсруулав.

“Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах журам”-ыг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 11-ний 119 тоот тушаалаар батлав.

Эмнэлгийн мэргэжилтний зохистой харьцааг бүрдүүлэх, эмч нарын хэт мэргэшихийг хязгаарлах үүднээс анх удаа үндсэн мэргэшлийн сургалтанд суралцагчийн хяналтын дээд тоог Эрүүл мэндийн сайдын 2014 оны 46 дугаар тушаалаар батлав. **/40 хувь/**

**180.** Эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

**Биелэлт:** Перинаталогийн төв байгуулахад Ерөнхий сайдын багцаас 2012 онд 750.0 сая, 2013 онд 1.4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авснаар ургийн оношлогооны тусламж, үйлчилгээ сайжирч байна. 2014 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 нэр төрлийн 613,925,700.0 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд Удам зүйн лабораторийг 2012 оны 11 дүгээр сард шинээр байгуулан, шаардлагатай 14 тоног төхөөрөмжийг суурилуулж, 2013 онд тус лабораторийг шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалжаар ханган, БНСУ-д 1 эмчийг 3 сарын хугацаатай сургажээ. Тус лабораторид кариотипийн, молекул генетикийн, цусны биохимийн маркерын шинжилгээ буюу пренатал скрининг,



пренатал оношлогоо, үргүйдлийн эмчилгээний үеийн зиготын удамшлын эмгэгийг оношлох зэрэг шинжилгээнүүдийг хийж байна.

Төсөл хэрэгжиж буй аймгуудад жирэмсний хүндрэл 33,4 хувиар, орон нутгаас лавлагаа төв рүү шилжүүлэлт 30 хувиар тус тус буурч, орон нутгийн эмч нарт зориулсан зайн сургалтын програм хангамж боловсруулах, ургийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн шинэ технологи нэвтрүүлсэн, үндэсний хэмжээнд байгуулсан сүлжээний ачаар эмч, мэргэжилтнүүд мэргэжлийн мэдээллийг цаг алдалгүй авч байгаагаас гадна ЭХЭМҮТ-ийн зөвлөх эмч нартай байнга хамтран ажиллах боломжтой болсон бөгөөд энэ нь хөдөө орон нутаг дахь эхийн эндэгдэл, хүндрэлийг бууруулахад чухал нөлөө үзүүлж байна.

“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2013 оны 416 дугаар тогтоолоор баталсан байна.

“Настанд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” шалгаруулах жилийн ажлыг зохион байгуулж, нийслэлийн дүүрэг, аймгуудын нийт 205 өрхийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд жилийн ажлын шалгуур үзүүлэлт, ээлтэй орчин бүрдүүлэлт, тусламж, үйлчилгээний сайжирсан байдал зэргээр үнэлгээ хийжээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эмнэлэг” шалгаруулах жилийн ажлыг зохион байгуулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, ээлтэй үйлчилгээ, орчин нэмэгдсэн байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн клиникт зүрх судасны мэс заслын тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулах, хүүхдийн зүрхний катетерийн лаборатори байгуулахад Ерөнхий сайдын багцаас 1.8 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр шийдвэрлэсний дагуу тендер зарлагдах шатандаа явагдаж байна. Дээрх төвд Герман улсад үйлдвэрлэгдсэн “Bi-Plane Digital angiography system artiszee” маркийн иж бүрдэл ангиографийн аппаратыг өргөтгөлийн байранд суурилуулан, хүүхдийн зүрхний катетер-ангиографийн тасгийг нээн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Дээрх төв байгуулагдснаас хойш зүрхний төрөлхийн гажигтай 5 хүүхдэд катетерын оношилгоо хийж, 6 хүүхдэд зүрхний төрөлхийн гажгийг судсан дотуурх аргаар эмчлэх ажлыг амжилттай хийсэн.

БНСУ-ын Ротари клубтэй хамтран “Хүүхдийн зүрх” төслийг хэрэгжүүлж, Сөүлийн үндэсний их сургуулийн эмнэлгийн 27 эмч, мэргэжилтнүүд 2013 оны 11 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд ЭХЭМҮТ-ийн хүүхдийн зүрхний эмч нарын хяналтад байгаа 105 хүүхдийн оношийг баталгаажуулан, 10 хүүхдийг сонгон мэс заслыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны мэс заслын тасагт амжилттай хийсэн байна. /60 хувь/

**181.** Төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар оношилгооны томоохон төвийг байгуулж, эх орондоо бүрэн оношлуулах нөхцөлийг бүрдүүлэх

**Биелэлт:** БНСУ-ын Экспорт-Импорт банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Үндэсний оношлогоо, эмчилгээний төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан байна.

Төслийн зөвлөх үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурж, хэрэгжүүлж байна. 2014 оны 12 дугаар сарын 30-нд тендерийн нээлт болж, тендерийн үнэлгээний ажил хийгдэж байна. /30 хувь/

**182.** Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой хослуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлж, рашаан сувиллын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах

**Биелэлт:** 2013 онд “Сувиллын газрын бүтэц, үйл ажиллагаа MNS 5232:2013” стандартыг батлан мөрдөж эхэлсэн. “Хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 6419:2013 үндэсний стандартыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эдгээр стандартууд батлагдан гарснаар сувиллын тусламж, үйлчилгээ, хүүхдийн сэргээн засах тусламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон байгууллагуудын үйл ажиллагаа стандартын дагуу явагдах, хяналт, үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

2014 оны эхний хагас жилд Хөвсгөл, Орхон, Архангай, Өмнөговь аймгуудад, нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх, Багахангай дүүргүүдэд нийт 25.5 сая төгрөгөөр сэргээн засах кабинет, ортопедийн цехийг байгуулсан байна. Мөн эрх зүйн орчин бүрдүүлэхэд шаардлагатай дараах ажлуудыг хийж байна. Үүнд: Зонхилон тохиолдох өвчний үед сэргээн засах эмчилгээ, оношилгооны зааврын төсөл, уламжлалт анагаах ухааны өвчний ангилал зүйн кодын багцын дагуу оношилгоо, эмчилгээний зааврын төслүүдийг тус тус боловсруулж байна. **/50 хувь/**

**183.** Орчин үеийн эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, уламжлалт эм, тангийн үйлдвэрлэлийг өргөтгөх

**Биелэлт:** “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын шаардлага хангасан үндэсний эмийн үйлдвэрүүдэд батламж олгох журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 495 дугаар тушаалаар батлав.

2014 онд Үндэсний GMP болох “Эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага стандарт” MNS 5524:2014-ыг боловсруулан СХЗГ-ын Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Одоогоор 29 эмийн үйлдвэрээс 6 нь Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ийн шаардлагыг хангах бэлтгэл ажил хангагдаад байна. Үүнээс 1 үйлдвэр нь олон улсын (GMP)-ын гэрчилгээтэй.

2014 оны эхний хагас жилд Хүний эмийн зөвлөлийн 2 удаагийн хурлаар 40 нэрийн үндэсний үйлдвэрийн уламжлалт эм улсын бүртгэлд бүртгэгдсэн. (Улсын бүртгэлд бүртгэлтэй нийт үндэсний үйлдвэрийн уламжлалт эмийн тоо-135). **/50 хувь/**

**184.** Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэнийг гурван жилд нэг удаа эрүүл мэндийн иж бүрэн оношилгоонд хамруулах

**Биелэлт:** Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Даатгуулагчийн нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлийг харгалзан урьдчилан сэргийлэх үзлэг болон урамшуулалд хамруулж болно" гэсэн заалтыг оруулсан болно.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэнийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлээс нь шалтгаалан эрүүл мэндийн иж бүрэн оношлогоонд тогтмол хугацаанд хамруулах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор 2013-2016 онд хийх ажлын төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 231/А102 дугаар хамтарсан тушаалаар батлан, төлөвлөгөөний дагуу даатгуулагч тодорхой хугацаанд хамрагдвал зохих үзлэг, шинжилгээ, оношлогооны жагсаалтын нэр төрлийг боловсруулж байна.

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны хамтарсан 459/280/182 дугаар тушаалаар дараалсан 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүртээгүй даатгуулагчийг иж бүрэн оношлогоонд хамруулах тариф 22.000 төгрөг байсныг 80.000 төгрөг болгон нэмэгдүүллээ.

2014 оны жилийн эцсийн байдлаар уг иж бүрэн үзлэг оношилгоонд хамрагдахаар 3 жил эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ аваагүй 9500 даатгуулагч уг тусламж, үйлчилгээг аваад байна. **/70 хувь/**

**185.** “Эрүүл хот, сургууль, цэцэрлэг, хотын эрүүл мэнд” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2011 оны 359 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн

хэрэгжилтэд үнэлгээ хийж 2014-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд нь анхаарч ажиллахыг зөвлөмж болгов. Хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан байна.

Хүн амын эрүүл мэндэд хотжилтын үзүүлэх нөлөөлөл, хүн амын эрүүл мэндийн байдлыг Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул, Орхон аймгууд болон нийслэлийн Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийг хамруулан НЭМҮТ, НЭМГ-тай хамтран судалгааг хийж байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 190 дугаар тушаалаар байгуулагдан ажлын хэсэг “Хотжилт ба эрүүл мэнд” хөтөлбөрийн төслийг боловсруулав. /30 хувь/

## ГУРАВ. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ МОНГОЛ ХҮН

**186.** Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, өргөтгөх замаар хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлэх

**Биелэлт:** 2013 оны улсын төсвийг барилгаар ангилбал 28276 суудалтай сургуулийн 64, 7680 ортой цэцэрлэгийн 73, 3610 ортой дотуур байрны 33, спорт заалны 29, их, дээд сургуулийн 8, аймгийн Боловсролын газрын 2, шинжлэх ухааны байгууллагын 9, бусад төрлийн 8, нийт 226 барилга угсралтын ажил гүйцэтгэхээр байсан. Гэвч 2013 оны төсвийн тодотголоор боловсрол, шинжлэх ухааны салбараас 113 барилга байгууламж, төсөл арга хэмжээний 72.6 тэрбум төгрөгийн хөрөнгө хураагдснаар барилга угсралт эхэлсэн 156 барилга байгууламжийн ажил гүйцэтгэн, 2013 онд нийт 82 цэцэрлэг, сургууль, дотуур байр, спорт заалны барилгыг ашиглалтад хүлээлгэж өглөө.

### Цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байдал 2009-2014


Цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байдал	2010	2011	2012	2013	2014	
Шинээр барьсан цэцэрлэг	29	35	59	30	30	
Нийлүүлсэн гэр цэцэрлэг	100	116	86	160	190	
Төрийн бус өмчийн цэцэрлэг				108	91	
Нэмэгдүүлсэн орны тоо	2460	3320	7810	8880	12815	
<b>Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт</b>						
Хичээлийн жил	2009-2010	2010-2011	2011-2012	2012-2013	2013-2014	2014-2015
Хүүхдийн тоо	142065	157181	164263	180969	193672	206636
Бохир жин	76.7	77.6	74.6	77.6	78.4	82.9

Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоо 13188, цэцэрлэгийн орны тоо 2900, дотуур байрны орны тоо 1105, ерөнхий боловсролын спорт заалны тоо 13-аар тус тус нэмэгдсэн байна. Мөн 2013 онд 85 сурууль, 66 цэцэрлэг, 18 дотуур байр, 6 спорт заалны барилгыг засварлаж, 14.0 тэрбум төгрөг зарцууллаа.


Улсын төсвийн хүрээнд шинээр ашиглалтад оруулсан сургуулийн тоо, хүчин чадал:



Улсын төсвийн хүрээнд шинээр ашиглалтад оруулсан спорт заалны тоо, хүчин чадал:



Улсын төсвийн хүрээнд шинээр ашиглалтад оруулсан дотуур байрны тоо, хүчин чадал:



Сургууль, цэцэрлэгийг тавилга, лабораторийн тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайгаар хангах, дотуур байрны зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор 6.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж шинээр ашиглалтад орсон 20 сургууль, 10 цэцэрлэгт түгээгээд байна.

2014-2015 оны хичээлийн жилд 90 гэр цэцэрлэг нийлүүлэхээр ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд 8455 орны хүчин чадалтай цэцэрлэгийн 77 барилгын ажил явагдаж байгаагаас 14 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад хүлээлгэн өгч, хүчин чадлыг 2075 ороор нэмэгдүүлээ.

#### Сурагчийн дүрэмт хувцасны хангалт

Хич/ жил	2013-2014	2014-2015
Хангалтын хувь	49.5	77.6

Азийн хөгжлийн банкны “Хөдөөгийн болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох нь” төслийн хүрээнд Баян-Өлгий, Хэнтий, Булган, Өмнөговь аймгийн багуудад 60 гэр цэцэрлэгийн, Дэлхийн банкны “Сургуулийн өмнөх

боловсролын төсөл"-ийн хүрээнд 100 гэр цэцэрлэгийн ном, гарын авлага, тоглоом, техник хэрэгслийг нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулав. /60 хувь/

**187.** Эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн "Зөв монгол хүүхэд" хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг монгол бахархалтай, үндэсний соёл уламжлалыг дээдэлсэн иргэн болгон хүмүүжих нөхцөлийг агуулсан сургалтын стандарттай болох

**Биелэлт:** 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы эцсийн хэлэлцүүлэгт шилжүүллээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/181 тоот тушаалаар Боловсролын хүрээлэнгийн Хүүхдийн хөгжлийн судалгааны секторыг өргөтгөж, Монгол хүүхдийн хөгжлийн судалгааны Төв болгон өргөтгөн зохион байгуулав. Төв нь 2014-2016 онд Монголын хүүхэд, залуусын хөгжлийн шалгуур, үзүүлэлт боловсруулах цөм технологийн судалгааг хэрэгжүүлнэ. Тус төв нь цаашид туршилт судалгааны үр дүн дээр тулгуурлан аргазүй, сорил-даалгаврыг сайжруулан:

1. Үндсэн судалгааны мэдээлэл цуглуулах
2. Боловсруулах
3. Хүүхэд, залуусын хөгжлийн шалгуур, загвар

цахим сорилын хувилбарт загвар, үндэсний мэдээллийн сүлжээний загварыг тус тус боловсруулахаар ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар "Сургуулийн өмнөх боловсролын бага, дунд бүлгийн сургалтын хөтөлбөр"-ийг батлан, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлэв.

Сургуулийн өмнөх боловсролын бодлого, хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй, багш нарт хүүхэд бүрийг судлах, хөгжүүлэх "хүүхэд төвт" шинэлэг арга барилыг эзэмшихэд нь туслах, шилдэг арга барилыг түгээн дэлгэрүүлэх туршилтыг 12 цэцэрлэгийн үйл ажиллагаанд туршиж байна. "Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөр" баримт бичгийг боловсруулсан.

2013-2017 онд хэрэгжүүлэх боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд "Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал", "Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал"-ыг батлан хэрэгжилтийг хангаж байна.

Бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг 2014-2015 оны хичээлийн жилд нийт ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлж байгаатай холбогдуулан бага ангийн багш нарыг арга зүйгээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг 3 үе шаттай зохион байгуулав.

Боловсролын салбарын чанарын шинэчлэл хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан Кембрижийн ерөнхий боловсролын хөтөлбөрийг Үндэсний стандарт, хөтөлбөртэй уялдуулах хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ ажлын хүрээнд 1-5 дугаар ангийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн 2012-2013, 2013-2014 оны хичээлийн жилд үндэсний лаборатори 40 сургуульд туршиж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар "Авьяс" хөтөлбөрийг батлан, хөтөлбөрийн эхний үе шатыг амжилттай хэрэгжүүлж, тайлагналаа. Авьяас" хөтөлбөрийн хүрээнд төрийн өмчийн 120 ерөнхий боловсролын сургуульд дугуйлан, секцийн тоног төхөөрөмж худалдан авахад зориулж тус бүр 10 сая, нийт 1 тэрбум 200 сая төгрөгийн зардлыг олгохоор шийдвэрлэн, шилжүүллээ.

2012-2013 хичээлийн жилд 614 сургуулийн 301500 орчим хүүхэд дугуйлан, секцэд хичээллэсний 186837 нь уг хөтөлбөрийн хүрээнд нээгдсэн 2450 дугуйлан, секцэд шинээр элсэн хичээллэсэн байна. Эдгээр дугуйлан, секцэд нийт 8519 хүн багшилснаас 766 нь орон нутгийн иргэд байна.

2013-2014 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд төрийн болон төрийн бус өмчийн бүх ерөнхий боловсролын сургуульд 121 төрлийн дугуйлан, секц хичээллүүллээ. Эдгээр дугуйлан, секцүүдэд нийт 382 000 хүүхэд суралцсанаас 43 000 хүүхэд энэ хичээлийн жилд шинээр элсэн суралцсан байна. Төрийн өмчийн ерөнхий

боловсролын сургуульд нийт 410 000 цагийн дугуйлан, секцийг 3250 багш, иргэн хичээллүүлсэн.

Хүүхэд бүрийг хөгжүүлэх Үндэсний стандарт хөтөлбөрийг боловсруулах, турших ажил цэцэрлэг, сургуулиудад хийгдэж байна.

2013-2014 оны хичээлийн жилд уг туршилтад нийт 991 бүлгийн 32527 сурагч хамрагдаж байгаа бөгөөд математик, хими, физик, биологи, англи хэл, бага ангийн нийт 1073 багш шинэчилсэн хөтөлбөрийн тохирцыг шалгах ажлыг зохион байгуулж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/51 тоот тушаалаар “Ном” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын 238 сургуулийн бага ангийн бүлэгт 1.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий “Ангийн номын сан” нийлүүлээ.

Аймаг, нийслэл бүр “Хүүхдийн ном” бүтээсэн бөгөөд тэдгээрийг нэгтгэн “Монгол хүүхдийн ном” хэвлүүлж, уг номонд цэцэрлэг, бага ангийн хүүхдийн номын сэдвээр бүтээсэн 90 фото дүр, дунд ангийн сурагчдын 90 эссэ, ахлах ангийн сурагчдын 90 илтгэл, нийт 270 бүтээлийг багтаав.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/155 дугаар тушаалаар байгуулагдсан “Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөр боловсруулах баг” монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.

2014 оны 3 дугаар сард 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 5, 9 дүгээр ангиудаас түүвэр шалгалтыг зохион байгууллаа. 5, 9 дүгээр ангийн шалгалтын дүнгээр 5 дугаар ангийн Математик, монгол хэл, байгаль шинжлэл хичээлүүдийн гүйцэтгэл 54,0 хувьтай, 9 дүгээр ангийн Математик, монгол хэл, байгалийн ухаан, нийгмийн ухаан хичээлүүдийн гүйцэтгэл 48,55 хувьтай үнэлэгдсэн болно.

Хүүхэд бүрийг хөгжүүлэх бага боловсролын сургалтын шинэ технологи, арга зүйг турших баг бага боловсролын монгол хэл, түүх, уран зохиол, ёс суртахуун, биеийн тамирын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг 39 дүгээр лаборатори сургуулийн 1-5 дугаар ангид туршиж байна.

Байгалийн түүхийн болон Үндэсний түүхийн музейн сан хөмрөгт байгаа нийт 369 үзмэрийг судлан, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийн агуулгын дагуу үзмэрийг ангилан биологи, хими, газар зүй, физик, нийгмийн ухаан, түүх, иргэний боловсрол хичээлтэй уялдуулан судлах боломжтой нийт 254 цагийн хичээлийн жагсаалт гаргалаа.

“Монгол Улсын дээд боловсролын стандартын үлгэрчилсэн загвар”-ын хавсралтын нийгмийн ухааны хичээлийн жагсаалтад “Оюуны өмчийн эрх зүй” хичээлийг заавал судлах хичээл болгон нэмж оруулсан.

2014 оны байдлаар 21 аймаг, 9 дүүрэгт тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар Насан туршийн боловсролын төв байгуулагдаад байна. **/60 хувь/**

**188.** Цэцэрлэг, сургуулийн удирдлага болон эцэг, эхчүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтран ажиллах дүрэм, арга зүйн зөвлөмжтэй болгох

**Биелэлт:** Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын байгууллагын чадавхийг бэхжүүлэх баг” сургуульд суурилсан удирдлага, менежментийг хөгжүүлж, сургуулийн удирдах ажилтныг орон нутгийн мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулах замаар томилох, чөлөөлөх зохицуулалтыг бий болгоход чиглэсэн бодлого, аргачлал боловсруулахаар ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/110 тоот тушаалаар батлагдсан “Хүүхэд бүрт ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэхэд баримтлах чиглэл”-д “Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх,

түншлэлийг бэхжүүлэх” зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тус тус тусган хэрэгжүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны Б/206 дугаар тушаалаар “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл дэх төрийн төлөөллийг шинэчлэн баталж, төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд төрийн жинхэнэ албан хаагчдыг орууллаа.

Мөн төрийн өмчийн зарим их сургуулийн захирлын ажлын байрны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулав.

Цаашид төрийн өмчийн их, дээд сургуулиудын бие даасан байдлыг дэмжих асуудлыг Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгахаар холбогдох судалгааг хийн ажиллаж байна. **/50 хувь/**

**189.** Орон нутагт гэр цэцэрлэгийг шаардлагатай багт байгуулах ажлыг зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролын хамрах сургалтыг нэмэгдүүлэх

**Биелэлт:** 2013 онд “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журам”-ыг батлан хэрэгжүүлснээр хувилбарт сургалтын санхүүжилтийг тодорхой болгон нэмэгдүүлж, хувилбарт сургалтын үйлчилгээг ээлжийн бүлэг жилд 2-оос доошгүй удаа, явуулын багш сард 2-оос доошгүй удаа, нүүдлийн бүлэг жилд 6 сар хүртэлх хугацаагаар ажиллахаар тусган баталсан нь жилд 21 хоног ажиллаж байсан хувилбарт сургалтын хугацааг 100 гаруй хоногоор уртасгаж, сургалтын чанарыг сайжруулах боломжийг бүрдүүлэв.

Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны “Хөдөөгийн болон алслагдсан өрхийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл”-ийн хүрээнд Баян-Өлгий, Хэнтий, Булган, Өмнөговь аймгийн багуудад 60, Дэлхийн банкны “Сургуулийн өмнөх боловсролын төсөл”-ийн хүрээнд 100 гэр цэцэрлэгийн, нийт 2.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, хатуу, зөөлөн эдлэлийг нийлүүлэв.

#### Нийлүүлсэн гэр цэцэрлэгийн тоо 2012-2014 он

	2012-2013	2013-2014	2014-2015
Нийлүүлсэн гэр цэцэрлэг	86	160	190
Ашиглагдаж байгаа гэр	897	1020	дүн гараагүй байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд 2013 онд малчдын болон алслагдсан дүүргийн эмзэг бүлгийн 3000 хүүхдийг шинээр багийн гэр цэцэрлэгт хамруулан сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байна. Улсын хэмжээнд нийт 815 гэр цэцэрлэг ажиллаж, хамран сургалтыг 80 хувьд хүргэлээ.

#### Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын хүүхэд

Хичээлийн жил	Тоо	Насны бүлгээр			
		2 хүртэл	2 нас	3-5 нас	6 нас
2010-2011	22277	419	2445	1867	946
2011-2012	26062	285	3069	21259	1449
2013-2014	29806	304	3881	24892	729
2014-2015	32734	320	4701	26643	1070

Япон Улсын “Хүүхдийг ивээх сан”-ийн дэмжлэгээр гэр цэцэрлэгийн ажилтнуудад зориулсан сургалтад 60 гаруй ажилтан хамруулж, “Цэцэрлэгийн хүүхдийн зохистой хоол” гарын авлагаар нийслэл, орон нутгийн гэр цэцэрлэгүүдийг хангалаа. **/70 хувь/**

## 190. “Үдийн цай” хөтөлбөрийг чанаржуулах

**Биелэлт:** Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг төрийн болон төрийн бус өмчийн нийт 699 сургуулийг хамруулан хийхэд зориулалтын гал тогоотой 350, зориулалтын бус гал тогоотой 259, огт гал тогоогүй 40 сургууль байна. Мөн орон нутгийн 121, нийслэлийн 94, нийт 215 сургуулийн гал тогоог иргэн, аж ахуйн нэгж түрээслэн “Үдийн цай”-г бэлтгэж байна.

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн үдийн цайны үйлчилгээнд тавигдах шаардлагын төслийг боловсруулаад байна.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн баталж, цэцэрлэг, тусгай болон сувилалын цэцэрлэг, дотуур байрны хоолны зардлыг 2012 оны 10 дугаар сарын 1, үдийн цайны зардлыг 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн нэмэгдүүлсэн хэмжээгээр мөрдөж байна.

### Хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдийн тоо болон санхүүжилтийн хэмжээ

Хичээлийн жил	Анги	Нэг хүүхдийн хоолны зардал /төг/	Хүүхдийн тоо	Санхүүжилт /тэрбум, төг/
2006-2007	I-II	300	116000	4.2
2007-2008	I-IV	300	196000	9.6
2008-2009	I-V	400	239800	16.5
2009-2010	I-V	400	280400	19.2
2010-2011	I-V	400	265700	16.2
2011-2012	I-V	400	255900	16.7
2012-2013	I-V	400/600	255988	17.5/24.7
2013-2014	I-V	400/600	239289	24.5

2013 онд шинээр ашиглалтад орох ерөнхий боловсролын сургуулиудад 500.0 сая, дотуур байранд 400.0 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлж эхлээд байна.

2014 онд 8 дотуур байрыг ашиглалтад өгч, хүчин чадлыг 830 ороор нэмэгдүүлээ. Шинээр ашиглалтад орох ерөнхий боловсролын сургуулиудад 580.0 сая төгрөгний гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлэв. **170 хувь!**

**191.** Сургуулийн бие засах газар, гар угаалтуурын тоог нэмэгдүүлж нөхцөлийг сайжруулах

**Биелэлт:** Азийн хөгжлийн банкны "Санхүүгийн хямралын үед нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээг хүргэх төсөл"-ийн санхүүжилтээр "Нийслэлийн гэр хорооллын сургуулийн бохирын системийг боловсон 00-той болгох" төсөл 30 хувийн хэрэгжилттэй байна.

Энэ төслийн хүрээнд нийт 21 сургуулийн хашаанд септик /3-5 жилд 1 удаа бохирыг нь соруулах бохирын ёмкост/ суулгах, 4 сургуулийг төвийн шугамтай холбох ажлыг гүйцэтгэж нийт 890.0 сая төгрөг зарцууллаа.

2013-2014 оны хичээлийн жилийн эхний хагас жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд 512 дотуур байранд 34846 сурагч байрлаж байна. Дотуур байрны суултуурын тоо 1251, угаалтуурын тоо 3596 байна. Дотуур байрны нэг суултуурт 27.8, нэг угаалтуурт 9.6 хүүхэд ноогдож байна.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм, шаардлагыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/259/197/ дугаар хамтарсан тушаалаар батлуулаад байна.



НҮБ-ын Хүүхдийн сан, Улаан загалмай нийгэмлэгтэй хамтран Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл, нийслэлийн Налайх дүүргийн 20 сургууль, 20 цэцэрлэгийн бие засах газар, ундны усан хангамжийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцүүлэн байгуулах ажлыг гүйцэтгэж байна.

НҮБХХ-ийн “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийг сайжруулах” төслийн хүрээнд Ховд аймгийн Зэрэг, Өмнөговь аймгийн Булган сумын сургууль, цэцэрлэгийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбож, байнгын ашиглалтад орууллаа.

Төв, Дундговь, Өвөрхангай, Булган аймгийн 8 сумын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгыг ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбож, бохир усыг цэвэршүүлэх байгууламж шинээр барих гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулаад байна.

Улсын хэмжээний нийт цэцэрлэг, сургуулийн 50 орчим хувийн ус хангамжийн болон ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл зохих түвшинд хүрээгүй, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй байгаа нөхцөл байдалтай байна.

2013 онд 6 аймгийн 9 сумын сургууль, цэцэрлэгт гүний худаг гаргаж өглөө. 2014 онд шинээр ашиглалтад орсон 15 сургууль, 7 дотуур байранд угаалтуур суултуурын тоог 2450 нэмэгдүүлсэн урьдчилсан дүн гарсан байна. **/50 хувь/**

**192.** Мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглаж, сурах бичиг, видео хичээл, танин мэдэхүйн цахим хуудас нээж ажиллуулах

**Биелэлт:** Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/24 дүгээр тушаалаар “Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар баримтлах бодлого (2012-2016)”-ыг баталсан бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах журмыг боловсруулан ажиллаж байна.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 25000 багшид зөөврийн лаптоп, 11340 зөөврийн лаборатори компьютер, 630 сургуульд ухаалаг самбар бүхий иж бүрэн хэрэгсэл олгох, ерөнхий боловсролын бүх сургуулийг өндөр хурдны шилэн кабель бүхий сүлжээнд холбохоор ажиллаж байна.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүнээр хангах ажлын хүрээнд 2014 онд 2,399 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулж, 300 иж бүрэн ухаалаг самбар, тоон үзэг, проекторын иж бүрдэл хүлээн авч аймаг, нийслэлийн 50 ерөнхий боловсролын сургуульд суурилуулан сургалтад ашиглаж эхлүүлсэн.

“Дээд боловсролын шинэчлэл” төслөөс Зайн сургалтын үндэсний төв, удирдлага мэдээллийн ситемийг байгуулахад БШУЯ-д 295.8 сая төгрөг, зайн сургалтын төвийг байгуулахад МУИС-д 212.5 сая төгрөг, МУБИС-д 139,0 сая төгрөг, Ховд их сургуульд 71.0 сая төгрөг, Дорнод дээд сургуульд 71 сая төгрөг төсөвлөн ажиллаж байна. **/50 хувь/**

**193.** Боловсролын байгууллагын менежментийн мэдээллийн системийг байгуулж, түүн дээр тулгуурлан багшлах боловсон хүчин мэргэжлээрээ нэгдэж, харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээллийн цахим сүлжээ байгуулах

**Биелэлт:** Улсын төсвийн 250.0 сая төгрөг, Азийн хөгжлийн банкны “Боловсролын салбарын шинэчлэл төсөл”-ийн 169000 ам.долларын санхүүжилтээр Боловсролын байгууллагын мэдээллийн нэгдсэн сан бүхий “Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний систем”-ийг боловсруулж, нэвтрүүлж эхэллээ. 2014 онд мэдээллийн системийн суурь модуль болох хүний нөөцийн болон статистик модуль бүрэн боловсруулж ажиллалаа. Системийг ашиглан 2014-2015 оны хичээлийн жилийн статистик мэдээлийг цуглуулах, нэгтгэх, тайлан гаргах зэрэг ажлыг улсын хэмжээнд хийж гүйцэтгэлээ.

Системийн ашигласнаар 2014-2015 оны хичээлийн жилд дээд боловсролын сургалтын баклаварын хөтөлбөрт элсэгчдийн томилолт олгох ажлыг цахим хэлбэрээр

зохион байгуулахад жил бүр улсын төсвөөс элсэгчдийн томилолтыг хэвлүүлэхэд зарцуулдаг зардал болох 180.0 сая төгрөгийг хэмнэсэн дүн гарсан байна.

“Эрдэмнэт” сүлжээний төвийн бүтэц, төсвийн дахин төлөвлөлтийг хийж нийт 784.7 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг байршуулав.

2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотын интернэт сүлжээнд шилэн кабелиар холбогдсон ерөнхий боловсролын 50 сургуулийг интернэт үйлчилгээ авдаг болгох ажлыг зохион байгуулав. Мөн 104 сумын төвийн 113 ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрын интернэт үйлчилгээ авдаг болгох ажлыг гүйцэтгэв. **/70 хувь/**

**194.** Ур чадвар, бүтээмж, гүйцэтгэл дээр суурилсан цалин, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх замаар багшийн ажлыг шударгаар үнэлж, мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өсгөн, цалингаараа хангалуун амьдрах, орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлсэн “Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

**Биелэлт:** Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/136 дугаар тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийг батлан Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтыг түшиглэн хэрэгжүүллээ.

Энэ хөтөлбөрийн хүрээнд 2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг бүрэн гүйцэтгэсэн. Тухайлбал: 2013 оны байдлаар “Хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй-технологи” сургалтад хот, хөдөөгийн нийт 24700 багшийг хамруулсан. Бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тэргүүн туршлага бүхий 445 зөвлөх багшийг бэлтгэсэн байна. “Багш” цогц хөтөлбөрийг 2014 онд боловсруулан батална. Нийт 21953 багш, ажилтан үндэсний хэмжээний сургалтад хамрагдлаа. “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хэрэгжилтэд 1,7 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

2013 онд Боловсролын шинэчлэл төслийн 48,7 сая төгрөгийн санхүүжилтээр “Багшийн хөгжил портал” сайтыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын цахим сургалтын алба ажиллуулсны үр дүнд 2014 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар нийт 32 чиглэлээр 5892 төрлийн арга зүй байршуулсныг 21940 тандалт хийснээр багш, ажилтан ажлын байрандаа хөгжих боломж бүрдээд байна. **/50 хувь/**

**195.** Багш бэлтгэдэг сургуулиудад тавих шаардлага, стандартыг өндөржүүлж, багшийн сургуульд элсэх босгыг дээшлүүлэх

**Биелэлт:** Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/155 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг багш бэлтгэх хөтөлбөрийг багц байдлаар шинэчлэн боловсруулж байна.

Засгийн газрын 2013 оны 181 дүгээр тогтоолоор авсан суралцагч багш бэлтгэдэг төрийн өмчийн их дээд сургуульд элсэгч элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувь, түүнээс дээш оноо авбал 100 хувь чөлөөлөхөөр шийдвэрлэн, төгсөөд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах үндсэн нөхцөлийг бүрдүүлэв.

МУБИС-ийн 2012-2013 оны хичээлийн жилд нийт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дундаж 568 байсан бол энэ хичээлийн жилд 608 болж өссөн. Тодруулбал, 2012-2013 оны хичээлийн жилд 650-аас дээш оноотой 419 оюутан элсэн орж байсан бол энэ хичээлийн жилд 923 болж 2.3 дахин өссөн бөгөөд энэ нь нийт элсэгчдийн 31 хувьтай тэнцэж байна. **/50 хувь/**

**196.** Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, элсэгчдийг ажил олгогчийн гэрээ, захиалга дээр тулгуурлан элсүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэх

**Биелэлт:** Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, нийгмийн түншлэл хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөрийн хэлтэст МБС-түншлэлийн харилцааны мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг гаргаж хүргүүлэн, 2013 оны төсөвтөө багтааж төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажил олгогч, сургалтын байгууллагын хамтын ажиллагааны идэвхи санаачлагыг өрнүүлж, үр бүтээлтэй ажиллах талаар чиглэл өгснөөр хөдөлмөрийн байгууллага, сургалтын байгууллага өөрийн чиг үүргийн хүрээнд хамтарч ажиллах эхлэл тавигдаж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын эхний 1 хүртэлх жилийг чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоонд шилжүүлэн чадамжийн үнэлгээг ажил олгогчтой хамтран явуулж байна.

Тус ажлын хүрээнд 2,5 жилийн сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгийг шинэчилж 100 хувь чадамжид суурилсан сургалтын агуулгад шилжүүлэв.

2013-2014 оны хичээлийн жилд сургууль бүр 1-2 мэргэжлийн сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу явуулж эхэллээ.

“Оюутолгой” төслийн санхүүжилтээр “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд суралцаж байгаа 6925 суралцагч болон ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээг “Ажил олгогч-Хөдөлмөрийн байгууллага-Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага-Суралцагчийн хооронд хамтран ажиллах 4 талт гэрээ” хэлбэрээр байгуулсан. Гэрээний дагуу аж ахуйн нэгж байгууллагууд хэрэгцээт мэргэжилтэй ажилтны эрэлтээ тодорхойлж, захиалгаа өгдөг, хөдөлмөрийн байгууллагууд эрэлтийн судалгааг нэгтгэж, сургалтын явцад аж ахуйн нэгж байгууллагатай хамтран үйлдвэрлэлийн дадлагын чанар үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах, төгсөгчдийг ажлын байраар хангахад чиглэгдсэн үүрэг хариуцлагыг хүлээн ажиллаж байна.

Хоёрдугаар ээлжийн 2088 суралцагч захиалгат аж ахуйн нэгж дээрээ дадлагад гарч эхлээд байна.

2011-2012 оны хичээлийн жилийн ажил хөдөлмөр эрхэлж байгаа 4287 төгсөгчийн 67.1 хувь нь буюу 2878 нь өөрийн эзэмшсэн үндсэн мэргэжлийн дагуу, 32.9 хувь нь буюу 1409 нь мэргэжлийн бус ажил эрхэлж байна. Цаашид төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувийг дээшлүүлэх улмаар 80-90 хувь болгох зорилготой ажиллаж байна.

2012-2013 оны хичээлийн жилд нийт 71 МСҮТ, Политехник коллеж 23393 мэргэжилтэй ажилтанг үндсэн сургалтаар бэлтгэн гаргаж, үүнээс 13334 буюу 57 хувь нь ажлын байртай, 3743 буюу 16 хувь нь дээд шатны сургуульд элсэн суралцаж, нийтдээ 73 хувь нь ажлын байраар хангагдан, их дээд сургуульд дэвшин суралцаж байна. /70 хувь/

**197.** Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа суралцагчдын сургалтын тэтгэлгийг бууруулахгүйгээр суралцах сонирхлыг дэмжиж ажиллах

**Биелэлт:** 2012-2013 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид 45000 төгрөгийн тэтгэлэгтэй суралцаж байсан бол 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 70000 төгрөгийн тэтгэлэгтэй суралцах болсон.

Улсын төсвийн хөрөнгөөр Хэнтий, Булган, Завхан аймаг дахь МСҮТ-ийн хичээлийн байр, Дундговь аймаг дахь МСҮТ-ийн А, Б блок, дотуур байрыг барих ажлыг эхлүүлсэн бөгөөд 2014 онд бүрэн баригдаж дуусна. Мөн Булган аймгийн ХАА-н МСҮТ-ийн хичээлийн байрыг худалдан авч сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна.

Монголын Мянганы сорилтын сангийн “Мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл”-ийн 25.0 сая ам.долларын санхүүжилтээр 22 МСҮТ, Политехник коллежийн дадлагын байрыг засварлах, өргөтгөх, сургалтын таатай орчин бүрдүүлэх, техник тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулан зарцууллаа.

“Оюутолгой” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Мэргэжлийн сургуулийн 3 хотхон шинээр барих, 4 сургуулийг өргөтгөх ажилд 20.5 сая ам.долларыг зарцуулахаар төлөвлөсөн байна.

МСҮТ-ийг дэмжих хөрөнгө оруулалтын хүрээнд нийт мэргэжлийн боловсрол сургалтын 20 байгууллагын хичээл, дадлага, дотуур байр болон спорт заалны гадна дотно, дулааны шугам сүлжээний их засварыг хийсэн байна. Үүнээс гадна 2013 оны улсын төсвөөр нийт 19 нэр төрлийн оёдлын тоног төхөөрөмжийг Мэргэжлийн боловсрол, сургалтын 14 байгууллагад олголоо. /90 хувь/

**198.** Чанаргүй их, дээд сургуулиудыг цөөлж сургалт, судалгаа, үйлдвэрлэл хосолсон, зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын системд шилжүүлж, дэргэдээ эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, туршилтын инкубатор байгуулан, өндөр технологийн компанийг бойжуулж, бүтээлээ зах зээлд нэвтрүүлэхийг төрөөс дэмжих

**Биелэлт:** “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл батлагдсаны дараагаар Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.

Их сургуулиудыг сургалт-судалгаанд суурилсан зохион байгуулалтын шинэ загварт шилжүүлэх зохицуулалтыг Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгахаар судалж байна.

Эрдэмтэн судлаачдын боловсруулсан технологи, бүтээгдэхүүнийг эрэлтэд нийцүүлэн бодит хэрэглээ болгох зорилгоор судлаачийн инновацийн 12 төслийг 2013 оноос эхлэн хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/231 тушаалаар шийдвэрлэсэн.

Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран “Хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, 2013-2015 он”, “Малчин өрхийн үйлдвэрлэлийн цогцолбор, 2013-2014”, “Эрдэм шинжилгээний бүтээл, төслийн тайлангийн нэгдсэн портал хөгжүүлэх, 2013-2014” төслийг хэрэгжүүлж байна.

Инновацийн төслүүд нь экспортыг нэмэгдүүлэх болон импортыг орлуулахуйц, эрдэм шинжилгээ, туршилт, сорилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон шинэ дэвшилтэт технологи, бүтээгдэхүүнийг зах зээлд туршин нэвтрүүлэхэд чиглэгдэж байна. 2009-2014 оны байдлаар 21 шинэ технологи, бүтээгдэхүүн, 15 технологи үйлдвэрлэл, 36 тоног төхөөрөмжийн туршилтийн загвар, стандарт, патент, техник эдийн засгийн үндэслэл, ашигтай загвар, зохиогчийн эрх, заавар зөвлөмж бий болсон байна. Үйлдвэрлэлд 10 технологи шилжсэн байна.

“Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам”-ын төслийг боловсруулан, Засгийн газрын 2014 оны 374 дүгээр тогтоолоор батлав.

Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль дэргэдээ инкубатор байгуулан ажиллаж байна.

Солонгосын Шинжлэх ухаан, технологийн хүрээлэнгээс ирүүлсэн багаж, тоног төхөөрөмжүүдээр МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль хоорондын дундын ашиглалтын лабораторийг шинээр байгуулж байна.

“Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох” журмын дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/187 дугаар тушаалын дагуу 10 судлаачийн бүтээлд тус бүр 10 сая төгрөгний тэтгэлгийг олголоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар МУИС-д 3 лаборатори /Ерөнхий физикийн лаборатори, микро организмын биотехнологийн лаборатори, Хурдас судлалын лаборатори/-ийг 368.0 сая, ЭМШУИС-ийн Нэгдсэн лабораторид гүн хөлдөөгчийг 13.0 сая, Соёл урлагийн их сургуульд Киноны лабораторийг 200.0 сая, ХААИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн сургуульд нарны цацрагийн автомат станцыг 26.0 сая, Монгол-Германы технологийн дээд сургуульд Лингафоны кабинет болон

физик, химийн лабораторийг 161.0 сая төгрөгөөр тус тус нийлүүлэн сургалтад ашиглаж байна. /40 хувь/

**199.** Инженер, технологийн чиглэлийн дэлхийн шилдэг их сургуулийн нэгээс доошгүй салбарыг байгуулахыг дэмжих

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 95 дугаар тогтоолоор Монгол-Германы хамтарсан Технологийн дээд сургуулийг байгуулахаар шийдвэрлэж, ХБНГУ-ын талаас тус сургуулийн үйл ажиллагааны эхний үе шатанд зориулан 4.0 сая еврогийн буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургуулийн 2013-2014 оны хичээлийн жилийг эхлүүлсэн бөгөөд сургуулийн элсэлтийн журамд даасны дагуу 3 оюутны сургалтын төлбөрийг 100, 3 оюутны сургалтын төлбөрийг 50 хувь тус тус хөнгөлөн суралцуулж байна.

2014-2015 оны хичээлийн жилд уул уурхайн болон механик инженер, байгаль орчны инженерийн баклавын хөтөлбөрт нийтдээ 65 оюутан суралцаж байна.

2014 онд улсын төсвийн хөрөнгөөр тус сургуульд 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 1.2 төгрөгийн өртөг бүхий физик, химийн лаборатори нийлүүлж, үлдсэн хөрөнгөөр хичээлийн байрны болон оюутны байрны тохижилт хийгджээ.

**/100 хувь/**

**200.** Их сургуулиудын хотхон байгуулах ажлыг түргэвчлэх

**Биелэлт:** Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах, батлуулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж дуусгав.

Багануур дахь их сургуулиудын хотхоны "Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах зургийн даалгаврыг баталсан.

Их сургуулиудын хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний техник, эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж, магадлалын ерөнхий дүгнэлт хийгдсэн бөгөөд ерөнхий төлөвлөгөөнд магадлал хийх хөндлөнгийн 13 экспертийн дүгнэлт гарлаа.

Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн Геологи, уул уурхайн их сургуулийн хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, 2014 оны 7 дугаар сарын 6-нд БШУЯ, Барилга, хот байгуулалтын яам, Орхон аймгийн Засаг дарга, Эрдэнэт үйлдвэрийн захирал хамтарч батлав. /30 хувь/

**201.** Багш, инженер бэлтгэх асуудалд онцгой анхаарал хандуулж, амжилттай суралцаж байгаа оюутныг дэмжих

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 181 дүгээр тогтоолоор авсан суралцагч багш бэлтгэдэг төрийн өмчийн их дээд сургуульд элсэгч элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувь, түүнээс дээш оноо авбал 100 хувь чөлөөлөхөөр шийдвэрлэн, төгсөөд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах үндсэн нөхцөлийг бүрдүүлэв.

"Шинжлэх ухаан, технологийн их сургуульд инженерийн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлж, "CDIO" загварыг Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургууль дээр турших 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г батлан, тус сургуулийн хичээлийн агуулгыг "CDIO"-ийн бодлого, агуулга, загвартай уялдуулан шинэчлэн боловсруулж, "Хөнгөн үйлдвэрлэлийн технологи" багц мэргэжлийн шинэ сургалтын төлөвлөгөөг боловсруулан 2013-2014 оны хичээлийн жилээс мөрдүүлж эхлэв.

"Инженер, технологийн дээд боловсролын төсөл"-ийг хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд төслийн хүрээнд аж үйлдвэрийн салбарын эрэлтэд нийцсэн практик чадвар

бүхий 1000 инженер, техникийн мэргэжилтэнг Япон улсад бэлтгэнэ. 2014 онд тус төслийн хүрээнд Коосэн хөтөлбөрөөр 48 оюутан элсэн суралцаж байна. **/70 хувь/**

**202.** Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, менежментийг олон нийтийн оролцоонд суурилсан, ардчилсан, хараат бус, нээлттэй зарчимд шилжүүлэх

**Биелэлт:** Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны Б/206 дугаар тушаалаар Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийг шинэчлэн төрийн жинхэнэ албан хаагчдыг орууллаа.

Цаашид төрийн өмчийн их, дээд сургуулиудын бие даасан байдлыг дэмжих асуудлыг Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгахаар холбогдох судалгааг хийн ажиллаж байна. Тухайлбал, Дээд боловсролын удирдлага бүлэгт дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн чиг үүргийг ашгийн төлөө ба ашгийн төлөө бус статусаас хамааруулан нарийвчлан зааж өгснөөс гадна сургуулийн Эрдмийн зөвлөлийн чиг үүргийг өргөжүүлэхээр тусгагдсан болно. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагын академик эрх чөлөө, суралцагчийн өөрөө удирдах байгууллага болон мэдээллийн ил тод байдлын талаар шинээр зүйл, заалтууд оруулаад байна.

2013 онд Монгол Улсын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн захирлын ажлын байрны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгууллаа.

2014 онд төрийн өмчийн Их сургуулиуд дотоод бүтцийн өөрчлөлт хийж, Удирдах зөвлөлөөрөө батлуулан ажиллаж байна. Бүтцийн өөрчлөлтийн үзэл санаа нь их сургуулийн засаглал, удирдлагын механизмыг олон улсын жишигт нийцүүлэх замаар их сургуулийн хөгжлийг хурдасгахад чиглэж байна. Бүтцийн өөрчлөлтийн дүнд Монгол улсын их сургууль 16 сургуулийг 7 сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль 16 сургуулийг 10 сургууль, Боловсролын их сургууль 13 сургуулийг 5 сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль 8 сургуулийг 5 сургууль, Анагаах ухааны шинжлэх ухааны үндэсний их сургууль 10 сургуулийг 8 сургууль болгосон байна.

"Боловсрол, шинжлэх ухааны яам болон харъяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх журам"-ыг баталж, дотоод аудит хийхэд олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг тусгасан болно.

"Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого" батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2014 оны 6 дугаар сард Улсын Их Хуралд өргөн барьсан. **/60 хувь/**

**203.** Сургалтын технологийн хөгжил, санал санаачлагыг дэмжин хөгжүүлэх зорилго бүхий боловсролыг дэмжих үндэсний сан бий болгох

**Биелэлт:** "Боловсролын технологийн хөгжлийн үндэсний сан"-гийн үйл ажиллагааг нээж, санд анхны 4 шилдэг арга зүй, технологийг бүртгэн, "Боловсролын технологийн цахим сан" [www.etd.edu.mn](http://www.etd.edu.mn) цахим хуудсыг нээн, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж байгаа багш нарын шилдэг технологийг байршуулан танилцуулж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Багшийн хөгжил" портал сайтыг бий болгох ажил хийгдэж, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дэргэд байршуулснаар багш нар туршлага солилцох, мэдээлэл олж авах, Боловсролын технологийн хөгжлийн үндэсний санд байршуулах арга зүй, технологийг нээлттэйгээр сонгон авах боломжтой боллоо. **/60 хувь/**

**204.** "Өрсөлдөх чадвартай монгол хүн" хөтөлбөр хэрэгжүүлэх. Судалгааны үндсэн дээр Монголын хөгжилд тэргүүлэх мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн дэлхийн шилдэг сургуулиудад 300 оюутан сургана.

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/316 дугаар тушаалаар баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам”-ыг хэрэгжүүлж эхлээд байна.

Энэхүү журамд ямар сургуулиуд хамрагдахыг тодорхой зааж өгснөөс гадна тухайн жилд суралцуулах хүний тоог жил бүрийн 2 дугаар сард багтаан, мэргэжлийн чиглэлийг өмнөх оны эхний хагас жилд багтаан тогтоож байхаар нарийвчлан журамлалаа. Түүнчлэн, дэлхийн шилдэг 20 их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчид мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр, 21-100-д багтсан сургуулийн бакалаврын хөтөлбөрт хамрагдагчид Засгийн газраас зарласан мэргэжлийн чиглэл харгалзан сургалтын зээл олгохоор боллоо.

2013 онд сургалтын төрийн сангийн зээлээр өндөр хөгжилтэй оронд магистрантур, докторантурт 115, бакалаврын түвшний сургалтад 19, нийт 134 иргэнийг шинээр сургаж байна.

Засгийн газар хоорондын гэрээний дагуу 2013-2014 оны хичээлийн жилд Монгол оюутнуудыг гадаадад илгээхдээ инженер, технологи, байгалийн ухаан, анагаах ухааны нарийн мэргэжлээр суралцуулах бодлого хэрэгжүүлэн 710 хүн 13 оронд суралцуулахаар явууллаа.

2014 онд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шаардлага хангасан 98 иргэнийг суралцуулахаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/219 дүгээр тушаалаар шийдвэрлэв. Суралцагчдын 60 хувь инженер технологийн мэргэжлээр суралцаж байна.

2014 онд нийтдээ Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд 815 оюутан шинээр элсэн суралцаж байна. Мөн сургалтын төрийн сангийн зээлээр 184 оюутан суралцуулахаар шийдвэрлэжээ. 2014 оны жилийн эцсийн байдлаар сургалтын төрийн сангийн зээлээр суралцаж байгаа оюутны төлбөрт 3.504.4 сая ам доллар зарцуулаад байна. **/90 хувь/**

**205.** Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг зориулалтын сурах бичиг, тоног төхөөрөмжөөр хангаж, коллеж, их, дээд сургуульд элсэн суралцах боломжийг дээшлүүлэх

**Биелэлт:** “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үнэлгээний журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын ажиллах журам”-ыг боловсруулж байна.

Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох, тусгай сургалтын байгууллагын зардал тооцох журам”-ын дагуу 2013-2014 оны хичээлийн жилд тусгай сургууль, цэцэрлэгүүдэд хувьсах зардлыг олгож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагчид ногдох хувьсах зардал 3 дахин нэмэгдсэнээр тусгай сургуулиудын сургалтын орчин, нэг хүүхдэд үзүүлэх үйлчилгээ бодитой сайжрах нөхцөл бүрдлээ.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7.10 заалтын дагуу 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тусгай сургуулийн нийт 1650 сурагчид нэг өдрийн үдийн хоолны зардлыг 2400 төгрөгөөр тооцон олгоно.

“Нийслэлийн Баянгол дүүргийн 70 дугаар тусгай сургуульд хичээлийн шинэ байр барьж, Баянзүрх дүүргийн 55 дугаар тусгай сургуульд их засварын ажил хийсэн. Баянзүрх дүүргийн 10 дугаар тусгай цэцэрлэгийн шинэ байрны зураг төсвийн хөрөнгийн асуудлыг шийдээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулж байна.

Олон улсын байгууллагын дэмжлэгээр Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургуульд брайль принтер, хэвлэгч, бичгийн машин, линз зэрэг сургалтын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэв.

Монгол Улсын боловсролын их сургуульд тусгай хэрэгцээт боловсролын багшийг 4 жилээр бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрийг боловсруулан 3 дугаар курсээс эхлэн тусгай хэрэгцээт боловсролын талаар тодорхой кредит цаг судлуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

2013-2014 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд 15770 хөгжлийн бэрхшээлтэй сурагч суралцаж байна.

Нийслэлийн 2 сургууль олон улсын байгууллагын тусламжийн авсан микро автобус, Орхон аймагт 1 автобусыг тусгай сургуулиудад ашиглаж байсан бол 2013 онд тусгай 55, 70, 63, 25, 116, 29, сургуулиудад сурагчийн автобус олгохоор гэрээг байгуулаад байна. /50 хувь/

**206.** Үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг дээшлүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах замаар монгол үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлэх

**Биелэлт:** Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үндэсний номын сангийн эрх зүйн байдлын тухай, Музейн тухай хуулийн төсөл, Киноны тухай хуулийн төслүүдийг боловсруулж байна.

2014 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Номын сангийн тухай” хуулийг УИХ-аар батлуулав.

Их эзэн Чингис хаан, Монголын эзэнт гүрний түүх, соёлыг харуулсан “Чингис хааны дурсгалын цогцолбор”-ыг байгуулахаар болж, Засгийн газрын 2013 оны 317 тоот тогтоолоор төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусган хувийн хэвшлийн хөрөнгөөр барьж байгуулахаар болоод байна.

2013 онд Занабазарын дэг сургуулийн бүтээлүүдийг улсын тооллогод хамруулж бүртгэн, баримтжуулж, цахим мэдээллийн санд оруулав. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт байдаг Занабазарын бүтээлүүдийг тусгайлан анхаарч хадгалалт хамгаалалтын орчныг сайжруулан шаардлагад нийцсэн шилэн хоргонд байрлуулж үзэгчдийн хүртээл болгосон.

2015 онд Өндөр гэгээн Занабазарын мэндэлсний 380 жилийн ойг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Ойн хүрээнд Өндөр гэгээн Занабазарын дэг сургуультай холбоотой судалгааны материалыг цуглуулж, судалгааны эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх, гэрэл зургийн болон эрдэм шинжилгээний ном бүтээл хэвлүүлэх, үзэсгэлэн зохион байгуулах зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байна.

2013 онд Хан Хэнтийн нурууны салбар, “Бурхан халдун уул, түүний орчмын тахилгат газар нутаг”-ийг соёлын ангиллаар Дэлхийн өвд бүртгүүлэх хүсэлт Дэлхийн өвийн хороонд хүргүүлээд байна.

2014 онд Дэлхийн өвийн хорооноос дурсгалт газрыг газар дээр нь ирж нягтлан шалгах зорилгоор Дэлхийн хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон Улсын Зөвлөлийн шинжээчид ирж ажиллав. Дурсгалт газрыг Дэлхийн өвд бүртгэх эсэх асуудлыг Дэлхийн өвийн хорооны 2015 оны ээлжит хуралдаанаар шийдэх юм.

Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театрт 523.9 сая төгрөгийн үнэ бүхий иж бүрэн гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж суурилуулав.

2013 улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: - орон нутгийн 17 музей, 2 соёлын байгууллагад 19 Фургон автомашиныг 513.0 сая төгрөгөөр,  
- 18 аймгийн 22 сумын Соёлын төвд нийт 190.0 сая төгрөгийн иж бүрэн дууны тоног төхөөрөмж,  
- 21 аймгийн 326 сумын Соёлын төвийн Номын санд зураасан код уншигч принтерын иж бүрдэл,  
- Улс, орон нутгийн 38 музей, соёлын байгууллагад 320.0 орчим сая төгрөгөөр 12 нэр төрлийн 456 ширхэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж,  
- орон нутгийн 21 музей болон “Эрдэнэзуу” музейд 780.0 орчим сая төгрөгөөр камер, дохиолол хамгааллын тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг зохион байгуулав.



2014 онд Улс, аймгийн музей, соёлын байгууллагын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд Улсын төсвөөс 1.672.877.859 төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. /50 хувь/

**207.** Улсынхаа нэрийг олимп, дэлхийн хэмжээнд гаргасан тамирчдын амьдралын баталгааг хангах бодлогыг хэрэгжүүлснээр их спортоор хичээллэх хүүхэд, залуучуудын тоог нэмэгдүүлэх

**Биелэлт:** Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 183 дүгээр тогтоолоор батлагдсан “Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах журам”, “Мөнгөн шагналын хэмжээ”, “Үндэсний хэмжээний тэмцээний мөнгөн шагналын хэмжээ, түүнийг олгох журам”-ыг шинэчилэн боловсруулж Яамдын саналыг авч нэгтгэн Засгийн газрын 2014 оны 64 дүгээр тогтоол батлагдсан. Тогтоолын дагуу мөнгөн шагналыг олгох ажлыг хэрэгжүүлж байна.

“Биеийн тамир, спортын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд биеийн тамир, спортын ажилтны нийгмийн хамгаалал, бусад салбарын хуультай нийцүүлж үйлчлэх хүрээг өргөжүүлэх өсвөр үе, залуучууд, оюутан, насанд хүрэгчдийн шигшээ багийн урамшуулал, хангамжийг шийдвэрлэх зохицуулалтуудыг тусгаж байгаа бөгөөд тус хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.

Засгийн газрын 2014 оны 64 дүгээр тогтоолоор багийн спортын тамирчдыг тоглолтын статистик үзүүлэлтээс хамаарч мөнгөн шагналыг 100 хувь авдаг байхаар журмын шинэчлэлтийг батлуулсан. Үндэсний шигшээ багийн төрөл, дасгалжуулагч, тамирчдыг сонгон шалгаруулах журмыг 2014 оны А/21 тоот тушаалаар шинэчлэн батлуулж Хууль зүйн яамаар улсын бүртгэлд бүртгүүлэн Үндэсний шигшээ багийг байнгын болон байнгын бус хэлбэртэйгээр ажиллуулахыг журамлаж өгснөөр шигшээ багийн төрөл, орон тоог нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн.

Насанд хүрэгчид, залуучуудын насны ангиллаар олимпын 12, паралимпийн 5 төрлийн 155 тамирчин, дасгалжуулагчийг амь нас, гэнэтийн ослын даатгалд хамруулж, сар бүр спортын цолны нэмэгдлийг олгож, нэгдсэн хувцсаар бүрэн хангалаа. /90 хувь/

**208.** Соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангах

**Биелэлт:** “Монгол уран бүтээл (Монгол контент)” үндэсний хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 252 дугаар тогтоолоор батлав. Уг хөтөлбөрийг 10 жилийн хугацаатай ба хэрэгжүүлэх үйл ажиллагаанд улсын төсвөөс жил бүр 10,0 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүжилт хийнэ. “Монгол уран бүтээл” хөтөлбөрийн үндсэн зорилго нь монгол уран бүтээлийг радио, телевиз, киноны зах зээл, цахим орчинд нэмэгдүүлэх замаар уламжлалт соёл, түүх, зан заншлыг өвлүүлэх, өв соёлоо хадгалж хамгаалах, үндэсний соёлоор бахархах үзлээр хүмүүжүүлэх, монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

Бүх нийтийн соёл, урлагийн боловсролыг дэмжих Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж дуусгав.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс, Монголын урлагийн зөвлөлтэй хамтран Монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, уламжлалаа нандигнан дээдэлдэг иргэн болгож төлөвшүүлэх үйл ажиллагааг албан ба албан бус боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгоход чиглэсэн хөтөлбөр боловсруулахад шаардлагатай судалгаа гарган нэгтгэж байна.

2013 онд Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулга, Улсын драмын эрдмийн театр, Улсын филармони, Морин хуурын чуулга, Дуурь, бүжгийн эрдмийн театр, Хүүхэлдэйн

театр зэрэг төвийн мэргэжлийн урлагийн байгууллагын шилдэг уран бүтээлээс бүрдсэн урлагийн явуулын хэсгийг алслагдсан суурин газар, сум, багт үйлчлэх төлөвлөгөө, батлагдсан хуваарийн дагуу аялан тоглолтоор явуулж, давхардсан тоогоор 12 аймгийн иргэд, хүүхэд, залуучуудад төвийн мэргэжлийн соёл урлагийн байгууллагын үйлчилгээг хүргэлээ.

Сумдын номын санд 50.0 сая төгрөгийн 24 нэрийн 3896 шинэ номын баяжилт хийлээ. Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордон, нийт аймгийн төв номын сангаас зөөврийн номын сангийн үйлчилгээг алслагдсан нутаг дэвсгэр, байгууллагын 30.0 мянга гаруй уншигчдад хүргээд байна. **/50 хувь/**

**209.** Соёлын байгууллагын барилга, байгууламжийг стандарттай болгож шаардлагатай музей, театрын барилгыг шинээр барьж байгуулах

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 226 тоот тогтоолын дагуу “Нэг маягийн загвар зургаар баригдах барилга, байгууламжийн эх загвар /эскиз/ зураг”-ийн хүрээнд соёлын барилгуудын зураг төсөл, стандартыг багтаан боловсруулж байгаа болно.

2014 онд Стандарт хэмжил зүйн газар “Мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагаа, орчин нөхцөлд тавигдах шаардлага”-ыг батлав.

Байгалийн түүхийн музейн барилгыг буулгах ажлын даалгавар болон шинээр барих барилгын зураг төсвийг боловсруулж бэлэн болгоод байна.

Соёлын өвийн төвийн барилга угсралтын ажлыг 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эхлүүлсэн. Соёлын өвийн төвийн барилга нь соёлын өвийн бүртгэн баримтжуулалт, сэргээн засварлалтын тусгай зориулалтын лаборатори бүхий 2 давхар барилга байх бөгөөд 2015 оны 11 сард ашиглалтад оруулах юм.

Үндэсний урлагийн ордон, Номын сангийн барилгын зураг, төсвийг боловсруулж холбогдох бичиг баримтын хамт Худалдан авах ажиллагааны газар хүргүүлж тендерийг зарласан.

2012 онд Дорнод аймгийн Хөгжимт драмын театр, Говь-Алтай аймгийн “Алтай” чуулгын барилгын ажил дууссан.

2013 онд Дорнод аймгийн номын сангийн өргөтгөл, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Соёл, спортын төв, Өвөрхангай аймгийн Есөнзүйл, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Хэнтий аймгийн Дадал, Баянмөнх, Увс аймгийн Наранбулаг сумын Соёлын төв, Дорнод аймгийн Баянтүмэн сумын Соёл урлагийн заалыг шинээр барьж ашиглалтад орууллаа.

Сэлэнгэ аймгийн Шаамар, Орхонтуул, Сүхбаатар аймгийн Наран, Баянхонгор аймгийн Баацагаан, Өвөрхангай аймгийн Уянга сумын Соёлын төвийн барилга 80, Архангай аймгийн Батцэнгэл сумын Соёлын төвийн барилга 70, Өмнөговь аймгийн Номгон сумын Соёлын төвийн барилгын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

2013 онд Архангай аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд Төв аймгийн театрын барилгыг 2014 онд эхлүүлэхээр төлөвлөөд байна.

2012 онд соёлын төвийн 7, 2013 онд 6 барилга ашиглалтад орж, 2013 онд төсөвт өртөг нэмэгдсэнээс 7 барилгын ажлын гүйцэтгэл 70-80 хувьтай байна. 2014 онд дуусна.

2013 оны эцсийн байдлаар Гандантэгчилэн хийдийн Гал тогоо аж ахуйн барилгыг ашиглалтад оруулж, Их цогчин дуганы барилга угсралтын ажил 60 орчим хувьтай байна. 2015 онд ашиглалтад оруулна.

2014 онд Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмж нийт 65,5 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс: Соёлын салбарт 40 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв батлуулсан бөгөөд 2014 оны жилийн эцсийн дүнгээр 28.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгджээ. Үүнээс 21.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр соёл урлагийн байгууллагын барилгын шинээр барих, засварлах ажил хийгдсэн байна. 2014 онд 16 аймгийн соёлын урлагийн байгууллагын барилгын засварын ажил явагдснаас 11 соёлын төвийн барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар ажилласан байна. 2014 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 5

соёлын төвийг ашиглалтад өгчээ. /Дорноговь Даланжаргалан, Хөвсгөл Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ, Дорнод Баян-Уул, Ховд Үенч/. Бусад соёлын төвийн барилгын ажил 2015 онд үргэлжилнэ.

Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 324 дүгээр тогтоолын дагуу зарим аймгийн соёлын төв, номын сангийн барилгын ажлууд зогссон болно.

**/50 хувь/**

**210.** Түүх, палеонтологи, археологийн олдворыг онцгойлон хадгалж хамгаалах

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 11 дүгээр тогтоолоор байгуулсан “Үлэг гүрвэлийн музей”-д палеонтологийн авран хамгаалах судалгаа хийх ажилтны орон тоог бий болгов.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн төсөлд тусгасан “Соёлын өвийн бүртгэл судалгааны үндэсний төв”-ийн дэргэд “Авран хамгаалах нэгж”-ийг шинээр байгуулахаар тус төвийн дүрмийн төсөлд тусгав.

ССАЖ-ын сайдын 2013 оны А/46 дугаар тушаалаар байгуулсан “Хадны оршуулгыг авран хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг” Монгол нутагт байгаа хадны оршуулгын судалгааны байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр, Зүүн салааны Одонтын гудамжинд илэрсэн хүннүгийн үеийн булшийг авран хамгаалахаар ШУТИС-иас ирүүлсэн төслийн саналыг дэмжиж холбогдох арга хэмжээг зохион байгуулав.

Мөн Өмнөговь аймгийн Номгон сумын Эрүүгийн цавд газрын өгөршилтийн улмаас илэрсэн эртний амьтны чулуужсан яс, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Хархорум хот, Эрдэнэ зуу музейн орчим, Босоогийн хонхорт илэрсэн ваар савны үлдэгдлийг авран хамгаалах судалгааны ажил, нийслэлийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын байдалд эрсдэлийн урьдчилсан судалгаа хийлгэх ажлыг тус тус зохион байгуулаад байна. **/50 хувь/**

**211.** Дэлхийн Монгол соёл судлалын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь төрөөс тусгайлан дэмжих

**Биелэлт:** Монгол судлалыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, удирдлага, санхүүжилтийн тогтолцоо бий болгох, монгол судлалын үйл ажиллагаанд төр-шинжлэх ухаан-бизнесийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, монгол судлаачдын залуу халааг бэлтгэх, мэргэшүүлэх, монгол судлалыг дотоод, гадаадад гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих зорилгоор УИХ-ын 2014 оны 5 дугаар сарын 14-ний хуралдаанаар “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж “Монгол судлалыг дэмжих сан” байгуулагдсан болно. **/90 хувь/**

**212.** Соёлын өвийг эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан түгээх үндэсний чадавхийг нэмэгдүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2014 оны 238 дугаар тогтоолоор соёлын баримтат өвийн үндэсний хэмжээний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, баримтат өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах, сурталчлах зорилготой “Соёлын баримтат өвийн хамгаалах хөтөлбөр”-ийг батлууллаа.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын Улсын үзлэг, тооллого явуулах бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс үзлэг тооллогод ашиглах программ хангамж, гарын авлагыг боловсруулаад байна. Тооллогын ажлыг 2015 онд улс орон даяар зохион байгуулахаар төлөвлөж байна.

2013 онд иргэн, хуулийн этгээдээс 166.6 сая төгрөгийн 359 ширхэг түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдан авч улс, орон нутгийн 18 музейн сан хөмрөгт хүлээлгэн өглөө.

Булган аймгийн Баяннуур сумын Шороон бумбагарын цогцолбор музей байгуулах урьдчилсан судалгаа, сэргээн засварлалт хийхэд зориулан лабораторийн контейнер хаус, техник, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулаад байна.

Шороон бумбагарын бунхныг түшиглүүлэн музей байгуулахаар барилгын зураг төсвийг боловсруулан бэлэн болгоод байна. 2014 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бунхны ханын зургийг хамгаалах, бэхжүүлэх, хэв дардас авах, хуулбар хийх зэрэг ханын зургийг чөлөөлж авах ажлын бэлтгэлийг хангахтай холбоотой ажлыг хийхээр төлөвлөж "Түүхийн дурсгалан" ХХК-иар гүйцэтгүүлж биелэлтийг хүлээн авсан. 2015 онд ханын зургийг хуулж авах ажлыг зохион байгуулна. **/50 хувь/**

**213.** Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэ шатанд гаргаж, улсын нэгдсэн бүртгэлийн цахим мэдээллийг хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын дотоод сүлжээтэй холбох

**Биелэлт:** Засгийн газрын 2014 оны 215 дугаар тогтоолоор "Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах 2 дахь шатны хөтөлбөр"-ийг батлууллаа. Хөтөлбөрийн төслийг боловсруулахад холбогдох мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид болон яамдаас санал авч нэгтгэсэн болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болж, бүртгэл, мэдээллийн урсгал шуурхай, зардал багатай шийдэгдэх, соёлын өвийн өмнө тулгарч буй эрсдэл буурах, түүнчлэн хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагыг соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай цахим сүлжээгээр холбож хулгайд алдсан соёлын өвийн талаарх мэдээллийг шуурхай түгээх боломжтой болно. Хөтөлбөрийг 2015-2016 онд хэрэгжүүлэх бөгөөд улсын төсвөөс 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ. **/50 хувь/**

**214.** Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоог спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих замаар боловсронгуй болгож, Оюутны их наадмыг 2013 онд, Монголын бүх ард түмний спортын ХИҮ их наадмыг 2014 онд, Хүүхдийн спортын их наадмыг 2016 онд тус тус бэлтгэн зохион байгуулах

**Биелэлт:** Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд салбарын санхүүгийн тогтолцоог оновчтой, хүртээмжтэй болгох зохицуулалтуудыг тусгаж байгаа бөгөөд хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Монголын оюутны спортын "Универсиад" III их наадмыг спортын 15 төрлөөр орон даяар 3 үе шаттайгаар зохион байгуулж нийт 2276 тамирчин, 176 дасгалжуулагч, 263 шүүгч оролцлоо.

Засгийн газрын 2014 оны 13 дугаар тогтоолоор Үндэсний спортын Их наадмын I шатны тэмцээнүүд аймаг, дүүргийн хэмжээнд 2014 оны 2 дугаар сараас эхлэн орон даяар, II шат буюу шигшээ тэмцээнийг 9 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд Хүй долоон худагт амжилттай зохион байгуулан явууллаа. Үндэсний спортын V Их наадамд 21 аймаг, 9 дүүргийн 35 байгууллагын 3000 гаруй тамирчид хамрагдаж нийт 150.000 сая төрөг зарцуулсан.

Засгийн газрын 2014 оны 359 дугаар тогтоолоор "Хүүхдийн спортын V их наадам"-ыг зохион байгуулах шийдвэр гарсан. **/60 хувь/**

**215.** Спортын судалгаа, шинжилгээний ажлыг эрхлэн гүйцэтгэх бүтэц байгуулж, биеийн тамир, спортыг шинжлэх ухааны үндсэн дээр хөгжүүлэх

**Биелэлт:** Биеийн тамир, спортын эрдэм, шинжилгээ судалгааны үндэсний төв байгуулах Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох журам, дүрмийг боловсруулан яамдын саналыг авахаар бэлэн болгосон. ССАЖЯ-ны харьяа Спортын бэлтгэлийн төвийн батлагдсан бүтэц, орон тоонд багтаан төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр бие даасан бүтэц зохион байгуулахаар боловсруулсан. **/30 хувь/**

**216.** Бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн, цагийг нэмэгдүүлэх, секцийн цагийн хөлсийг олгох, идэвхтэн дасгалжуулагчтай байхыг дэмжих

**Биелэлт:** Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх баг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсрууллаа. Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг "Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бага боловсролын сургалтын шинэ технологи, арга зүйг турших баг" лаборатори 39 сургуулийн 1-5 дугаар ангид туршиж байна.

2013-2014 оны хичээлийн жилд дунд, 2014-2015 оны хичээлийн жилд ахлах ангид дээр дурьдсан нэр бүхий сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, туршсаны дараа ерөнхий боловсролын нийт сургуульд мөрдөнө.

2014-2015 оны хичээлийн жилд суурь боловсролын биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийн агуулгыг хүүхэд бүрийн эрүүл өсөн хөгжих авъяасыг хөгжүүлэх агуулгаар шинэчлэн боловсруулна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 оны дүнгээр 13 спорт заал, 2014 онд 6 барилга барьж ашиглалтад оруулаад байна. 2013-2014 оны хичээлийн жилд 9 аймгийн 33 сургууль орон нутгийн төсвийн орлого болон төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр биеийн тамирын 45 талбайг шинээр байгуулсан байна.

Боловсролын хүрээлэнгийн дээд боловсролын сектор нь төрийн болон төрийн бус өмчийн 20 их, дээд сургуулийн биеийн тамирын хичээлийн агуулга, арга зүйн харьцуулсан судалгааны ажлыг хийж байна.

2013 оны эхний хагас жилд "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд секц, дугуйлан хичээллүүлсэн багш нарын урамшуулалд улсын төсвөөс нийт 1.4 тэрбум зарцууллаа. 2012-2013 оны хичээлийн жилд биеийн тамирын 35 төрлийн секцэд нийт 210000 хүүхэд суралцсан байна.

Улсын хэмжээнд 2013-2014 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн бүх ерөнхий боловсролын сургууль хэл, өгүүлэхүй (1), хараа, орон зай (2), хөдөлгөөн, тэнцвэр (3), хэмнэл, сонсгол (5), логик, харилцааны (5) мэдрэмжид суурилсан авъяасыг хөгжүүлэх 5 чиглэлээр 121 төрлийн дугуйлан, секц хичээллүүллээ. Эдгээр дугуйлан, секцүүдэд нийт 382 000 хүүхэд суралцсанаас 43 000 хүүхэд энэ хичээлийн жилд шинээр элсэн суралцсан байна. **/50 хувь/**

**217.** Сургуулийн өмнөх боловсролд зориулан хүүхэд асран хүмүүжүүлэх төв, өдөр өнжүүлэх бүлэг байгуулах

**Биелэлт:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Хүүхэд харах үйлчилгээний хууль"-ийн төслийг боловсрууллаа. Уг хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна.

Хуулийн төсөлд хүүхэд харах үйлчилгээнд 1,6-6 хүртэлх насны хүүхдийг хамруулах, Хүүхэд харах төвийг иргэн, аж ахуйн нэгж эрхэлж болох бөгөөд Хүн амын орлогын болон Аж ахуйн нэгжийн албан татвараас чөлөөлөх, эцэг эх, үйлчилгээ эрхлэгчийн харилцан зөвшилцөл дээр тулгуурлан төлбөр авах, төрөөс нэг хүүхдэд ногдох хувьсах болон хоолны зардлыг олгох, үйлчилгээ эрхлэх эрхийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хугацаагүйгээр олгох зэрэг асуудлыг тус тус тусгалаа. **/50 хувь/**

## ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН

**218.** Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох

**Биелэлт:** “НҮБ-ын Ногоон эдийн засгийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх салбаруудтай хамтран ажиллах чиглэлийг тогтоох хэлэлцүүлгийг 2014 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулж, Ногоон хөгжлийн үзүүлэлтийг боловсронгуй болгох, Ногоон хөгжлийн сургалт зохион байгуулах, Хог хаягдлын менежмент, Ногоон худалдан авалтын чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөгөөг боловсруулан зарим төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

“Т-21” загварыг ашиглан ногоон хөгжлийн дунд, урт хугацааны төлөвлөлтийг тэргүүлэх салбаруудаар хийх, загварт ногоон хөгжлийн өгөгдлүүдийг оруулах ажлын хүрээнд 2014 оны 5 дугаар 13-19-ний хооронд ЭЗХЯ-тай хамтран бүх яам, нийслэл, орон нутгийн төлөөллийг оролцуулсан сургалт, 5-р сарын 20-22-ны хооронд Ногоон эдийн засгийн “Т-21” Монгол загварыг хөгжүүлэх, динамик системийг боловсруулах сургалт зохион байгуулж, загварт шаардагдах тоон мэдээлэл цуглуулж, “Т-21” Монгол загварыг зүгшрүүлэх ажил хийгдэж байна.

2014 оны 3 дугаар сард “Барилгын салбарын эко шийдэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, “Ногоон барилга”-ын чиглэлээр ойрын үед хийх шаардлагатай ажлыг тодорхойлж, “Ногоон барилгын зэрэглэл тогтоох үнэлгээний аргачлал”-ын төсөл боловсруулав. /40 хувь/

**219.** Байгаль орчны асуудал эрхэлсэн яамыг үндсэн чиг үүргийн яам болгон өөрчлөх

**Биелэлт:** УИХ-аас 2012 оны 8 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Ерөнхий чиг үүргийн яамны 1-д “Байгаль орчин, ногоон хөгжлийн яам”, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 4-т “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд” гэж тусгагдсан нь тус яам үндсэн чиг үүргийн яам байх эрх зүйн үндсийг бүрдэж Байгаль орчин, ногоон хөгжлийн яамыг зохион байгуулсан болно.

/100 хувь/

**220.** Улаанбаатар хотын утаа, хог, түгжрэлтэй тэмцэх цогц шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх

**Биелэлт:** Авто зогсоолын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд “Хэрэглэгч төлдөг” зарчимд шилжүүлэх замаар хотын төвийн ачааллыг багасгах чиглэлээр холбогдох заалтуудыг тусгаад байна.

Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрөл систем нэвтрүүлэх төслийг Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлэх хэлэлцээ хийж 2013-2019 онд хэрэгжүүлэхээр тохирсон. Төслийн нийт өртөг 272.9 сая ам.доллар бөгөөд АХБ-аас 215.9 сая, Монгол Улсын Засгийн газар 57.0 сая ам.доллар гаргахаар тохирч санхүүжилтийг шийдвэрлэх асуудлыг 2012 оны 5 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн боловч асуудлыг хэлэлцээгүй байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай метро төслийн ТЭЗҮ-г 2013 онд хийсэн. Нарийвчилсан зураг төсөв боловсруулахад 47 сая ам.доллар шаардлагатай бөгөөд үүнийг Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх талаар Монгол улсын Засгийн газраас албан ёсны хүсэлт тавьсан. 2014 оны нийслэлийн төсөвт Монголын талаас хариуцан хийх судалгааны ажилд 1 тэрбум төгрөгийн хөрөнгийг тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх чиг хандлагын Тээврийн сүлжээний төлөвлөлтөд хотын зүүнээс баруун чиглэлд газар метроны шугам төлөвлөгдсөн бөгөөд хотын төвийн хэсгээр газар доогуур байхаар тусгагдсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар төмөр зам ХНН хамтран Амгалан-Толгойт өртөө хооронд нийтийн зорчигч тээвэрт 2014 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс Рейлбус явуулж эхлээд байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 250 их багтаамжийн автобусанд дизель-хийн түлшний хосолмол төхөөрөмжийг суурилуулсан боловч дизель-хийн хосолмол горимд шилжүүлэн ажиллуулахгүйгээр дан дизель горимд ажиллуулан хөдөлгөөнд оролцож байна. “Цахилгаан тээвэр” компани 2014 оны дүнгээр 31 дуобус үйлдвэрлэв. /40 хувь/

## **221. “Амины орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх**

**Биелэлт:** Засгийн газрын 2014 оны 151 дүгээр тогтоолоор ЗГ-ын 2013 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Орон сууцны ипотекийн ерөнхий журамд “Аймаг, сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, дэд бүтэц /цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга/-ийн шийдэл бүхий амины орон сууцыг худалдан авах иргэд болон хот төлөвлөлт, барилгын норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн өөрийн өмчлөлийн газар дээр амины орон сууц барих иргэдэд энэхүү зээлийг олгоно.” гэсэн заалтыг шинээр нэмсэн. Энэхүү шийдвэр нь уг хөтөлбөрийн гол зорилтыг шийдвэрлэсэн болно.

Амины орон сууцанд тохирсон жин хөнгөн, дулааны алдагдал бага, өртөг зардал хямд барилгын материалын үйлдвэрүүд болох “Экас” ХХК, “Нью Даниста” ХХК, “Инжир” ХХК-иудын модон барилгын, “Москва комплекс” ХХК-ийн канад барилгын, “Люксвүүд” ХХК-ийн “WPC” ХХК мод хуванцарын холимог барилгын хийцийн, “Такт” ХХК-ийн конкретол хавтангийн, “Голден хаммер” ХХК-ийн SIP хавтан хийцийн, “Зитоп” ХХК, “Үлэмж” ХХК-ийн сэндвичэн барилгын үйлдвэрийн төслүүд дэмжигдэж 3 үйлдвэрийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас шийдвэрлээд байна. /40 хувь/

## **222. Газрын харилцааны шинэчлэл хийх**

**Биелэлт:** Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газар албадан чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн.

“Монгол улсад газрын бирж байгуулах, газрын зах зээлийн таатай орчин бүрдүүлэх төсөл”-ийн эхний хувилбар болон “Газрын биржийн ажиллах журам”-ын төслийг боловсруулсан ч Газрын тухай багц хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэн батлахтай холбогдуулан уг ажлыг түр хойшлуулаад байна. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн хүрээнд “Газрын биржийн ажиллах журам”-ын төсөл, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны журам”, “Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах журам”-ын төслийг боловсруулж байна. Эдгээр журмын төсөлд газрын зах зээлийн эрх зүйн орчны талаар тусгасан болно.

GPS-ийн байнгын ажиллагаатай ажиглалтын станц байгуулах ажлын хүрээнд 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар техникийн даалгаварт заагдсан бүх байрлалд бүрэн суурилуулж дууссанаар МУ-ын 21 аймгийн төв GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд холбогдсон болно.

“Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан геодезийн цэг, тэмдэгтийн судалгаа, тооллогын ажил”-ын хүрээнд 2047 цэгийн судалгаа, тооллого, 925 цэгийн нөхөн сэргээлт, хэмжилтийг хийхээр ажиллаж байгаа бөгөөд 2014 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар техникийн даалгаварт заагдсан ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. /50 хувь/

## 223. Аймгийн төвийг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх

**Биелэлт:** 18 аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд Ховд, Говьсүмбэр, Төв, Өмнөговь, Дорноговь аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Дорнод, Завхан, Хэнтий аймгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын төсвийг баталж, гүйцэтгэн одоогоор экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулахаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд 6 аймгийн төвийн барилгажилтын бүсчлэл, улаан шугамын зураглалын ажлыг боловсруулж байна. /30 хувь/

## 224. Хаягжилтын шинэчлэлийг хийх

**Биелэлт:** Хаягжуулалтын тухай хуулийг 2013 оны 2 дугаар сарын 7-нд УИХ-аар батлууллаа. МУ-ын Ерөнхий сайдын 2013 оны 95 дугаар захирамжаар Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулахад шаардагдах гео-орон зайн мэдээллийг бүрдүүлэх, мэдээллийн загварыг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг 32 агентлагийн удирдлагыг оролцуулан байгуулсан.

Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 323 дугаар тогтоолоор Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох ажлын хүрээнд газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, хаягийн мэдээллийн систем байгуулах, гурван хэмжээст байр зүйн зургийн мэдээллийн систем байгуулах, хот суурин газрын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг шинэчлэх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад даалгасан.

Хаягийн мэдээллийн систем байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, Дорнод аймгийг хаягжуулах /хаягийн мэдээллийн систем байгуулах/-аар “Геокад” ХХК-тай 2013 оны 08 дугаар сарын 12-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. /30 хувь/

## 225. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

Шүрэнгийн УЦС-ын техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгаа хийгдэж байгаа ба ажлын явцад хяналт тавьж бодлогын удирдамжаар хангаж ажиллаж байна. Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн хүрээнд уг усан цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, судалгааны ажлын тайланг урьдчилсан байдлаар 2014 оны 3 сард ЭХЯ-ны ажлын хэсэгт танилцуулсан.

Франц улсын “Трактебел Инженеринг” компани ба Эгийн гол УЦС төслийн нэгж хамтран боловсруулсан “Эгийн голын УЦС төслийн шинэчилсэн ТЭЗҮ”-ийг салбарын ШУТЗ-ийн 2014 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэн дэмжсэн.

2014 оны Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын багцад бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад сэргээгдэх эрчим хүчийг ашиглахаар 1 тэрбум төгрөгийг хөрөнгө батлагдсан. Энэхүү хөрөнгөөр 36 худгийг нарны эрчим хүч ашиглан инженерийн хийцтэй худгийг тоноглох, 36 худгийг салхины эрчим хүчийг ашиглан ус өргөх инженерийн хийцтэй болгон тоноглох зэрэг ажлыг хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, ЖАЙКА байгууллага хооронд 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан газрын хөрсний дулааныг хөдөө аж ахуйд ашиглах тухай санамж бичиг бичгийн хүрээнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад хүлэмжийн аж ахуйд газрын хөрсний дулааныг ашиглах, газрын хөрсний дулааны чиглэлээр мэргэжилтнүүдыг дадлагажуулах ажил хийгдэж байна. /40 хувь/

## 226. Туул гол хөтөлбөр хэрэгжүүлэх

**Биелэлт:** Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Туул голын бохирдлыг бууруулах, цэвэрлэх төслийг 2014 оны 2 дугаар сард багтаан эхлүүлэхээр боллоо.



Туул голын онцгой хамгаалалтын бүсийг Хар усан тохойгоос Сонсголонгийн гүүр хүртэл 300 шонгоор тэмдэгжүүлэв.

Туул Тэрэлжийн бэлчирээс Шувуун фабрик хүртэл нийт 3260.8 км<sup>2</sup> талбайн 1:25000 масштабтай байр зүйн зураг үйлдэж, мэдээллийн санд оруулсан.

Туул голын сав газарт гадаргын усны Туул-Заамар, Бороо-Борнуур гэсэн 2 харуулыг нэмж байгуулснаар ус судлалын 8 харуул ажиллаж байнгын мэдээлэл өгдөг боллоо.

Ашигт малтмалын газраас ирүүлсэн мэдээгээр Туул голын сав газарт нийт 11 төрлийн ашигт малтмалын 443 лиценз олгогдсоноос ашиглалтын 288, хайгуулын 155 байна. Үүнээс алтны шороон ордын 98, барилгын материал, түгээмэл тархацтай ашигт малтмалын 143, нүүрсний 35, бусад төрлийн 12 лиценз олгогдсон байна.

Туул гол, түүний цутгал голуудын татамд элс, хайрга олборлох чиглэлээр 80 орчим аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 28 нь Усны тухай болон Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байсан учир газар дээр нь зогсоох арга хэмжээ авсан.

Туул голын сав газарт элс, хайрга олборлож байсан, нөхөн сэргээлт хийгээгүй 8 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлуулж, эвдэгдсэн газрыг нь нөхөн сэргээх зардлыг ашиглагчаас гаргуулах зорилгоор 9.1 тэрбум төгрөгний экологийн хохирол тооцуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж ажилласны дүнд 5 аж ахуйн нэгж нь өөрийн зардлаар нөхөн сэргээлтээ хийж гүйцэтгэн, үлдсэн 3 аж ахуйн нэгж, байгууллагыг нь хуулийн байгууллагад шилжүүлснээр өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийхээр гэрээ байгуулсан.

Туул голын сав газарт 2013 онд 482 га-д, 2014 оны эхний хагаст 400 га-д ойжуулалт, ойн нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэсэн.

2013 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр Баянзүрх уул, Гачууртын Шар хоолой, Хуандай, Мухар зэрэг амуудад нийт 420 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг ойн мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлсэн.

Цөлжилтийг сааруулах, элсний нүүдлийг багасгах зорилгоор Хан-Уул дүүргийн 14-р хороо Өлзийт хороолол, Түргэний голын сав дагуу 10 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, ногоон зурваст 5150 ширхэг навчит модны суулгац тарьж, 870 урт метр хамгаалалтын хашаа барьсан. Намрын тооллогоор ургамлын амьдралт 85 хувьтай байв.

“Туул усан цогцолбор”-ын техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааны ажлыг “Престиж групп” ХХК гүйцэтгэсэн бөгөөд Туул, Тэрэлж гол дээрх боомтын сонгосон хөндлүүрүүдтэй газар дээрх нь танилцсан. Мөн 6 мониторингийн цооног өрөмдөж, тоноглон Туул голын сав газрын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн болно. **/50 хувь/**

**227.** Ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн, “Ногоон соёл иргэншил” үзэл баримтлал, хөтөлбөрийг боловсруулж, загваруудыг бий болгох

**Биелэлт:** Ногоон хөгжлийн бодлогыг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хурлын 2014 оны 6-р сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулав.

Хан Хэнтийн нурууны Бурхан Халдун хайрхан түүний орчмын тахилгат уулсыг соёлын өвд, Монгол Дагуурын дархан цаазат газрыг байгалийн өвд хамруулах талаар судлан саналыг боловсруулж, ЮНЕСКО-д хүргүүлсэнээр ЮНЕСКО-гийн дэлхийн өвийн хороог төлөөлж IUCN, ICOMOS-ийн эксперт сонгосон газруудад өнгөрсөн 2014 оны 9 дүгээр сард ажилласан. Экспертүүд зөвлөмжөө гарган 2014 оны 12-р сард Дэлхийн өвийн хороонд хүргэгдсэн.

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ыг баталсан. Стратегийн үнэлгээ хийх аргачлалыг батлав.

Засгийн газрын 2013 оны 303 дугаар тогтоолоор Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй 41 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталлаа. Энэ жагсаалтад багтсан тоног төхөөрөмжийг худалдан борлуулсан аж ахуйн нэгжийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлж байна.

Байгаль орчинд ээлтэй техник, технологи-2013” үзэсгэлэнг 2013 оны 4 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд МҮХАҮТ, Цэнгэг ус, байгаль хамгаалах төвтэй хамтран зохион байгуулав. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр 13 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулж, “Ногоон бүтээгдэхүүн”, “Ногоон үйлчилгээ” гэрчилгээг 2 жилийн хугацаатай олгож, дотоодын зах зээлийн орчинд хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах ажлыг зохион байгуулав. /50 хувь/

**228.** Орон нутаг дахь иргэний байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргах

**Биелэлт:** “Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө”-г батлан, нийт 42 ажлыг Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүн Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, хамтран ажиллав.

Байгаль орчны төр хувийн хэвшлийн түншлэлийн чуулганаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай зөвшөөрөл, лицензийг цөөрүүлэх, иргэдэд ил тод нээлттэй байлгах үүднээс 12 зөвшөөрлийг байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх саналыг бэлтгэж байна.

2013 онд 6 аймгийн 16 агнуурын бүс нутгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах гэрээг 1 нөхөрлөлийн холбоо, 2 орон нутгийн ТББ, 1 хоршоо, 4 нөхөрлөлтэй байгуулан хамтран ажиллаж эхэллээ.

2014 оны байдлаар 4 нөхөрлөл, 2 төрийн бус байгууллага, 6 аж ахуйн нэгж нэмэгдэж агнуурын бүс нутгийн менежментийг хариуцан ажиллаж байна. /60 хувь/

**229.** Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхит болон химийн хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгох

**Биелэлт:** “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын хор аюулын зэрэглэл тогтоож, кодчилсон жагсаалт”, “Аюултай хог хаягдлыг хадгалах, устгах, тээвэрлэх болон тусгай зөвшөөрөл олгох журам”, “Аюултай хог хаягдлын бүртгэл, тайлангийн маягт”, “Аюултай хог хаягдлын жагсаалт” зэрэг аюултай хог хаягдлын менежментийн эрх зүйн үндэс бүрдүүлэх баримт бичгүүдийг боловсруулж дуусах шатандаа явж байна.

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор “Аюултай хог хаягдал устгах, боловсруулах байгууламж барих ажил”-ыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.

Аюултай хог хаягдлын эх үүсвэрийн болон устгах шаардлагатай химийн бодисын тооллогыг 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийг хамруулан хийж, тайланг нэгтгэлээ.

Цөмийн энергийн газар, Тагнуулын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Дотоодын цэрэг, Зэвсэгт хүчний жанжин штаб, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын холбогдох мэргэжилтнүүд болон Олон улсын атомын энергийн агентлагийн шинжээч нарын хамтарсан уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, “Цөмийн аюулгүй байдлыг хангах үндэсний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулаад байна.

Европын холбооноос хэрэгжүүлж байгаа “Цөмийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөр”-т хамрагдан “Монгол Улсад ураны олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаатай холбоотой хяналтын эрх зүйн орчныг бэхжүүлэх” нь сэдэвт төслийг 2014 оноос 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр гэрээ байгууллаа.

Түүнчлэн Европын холбоотой хамтран “Төв Азийн орнууд дахь ашигласан ураны орд газрын нөхөн сэргээлт, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын асуудалтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боловсон хүчин бэлтгэх”, “Монгол Улсын цөмийн энерги болон цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийг хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Мөн Олон улсын атомын энергийн агентлагийн техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Дозиметрийн тохируулга, баталгаажуулалтын лабораторийн техникийн чадавхийг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх”, “Цөмийн болон цацрагийн хяналтын техникийн чадавхийг сайжруулах” төслүүдийг хэрэгжүүлж байна.

2012 онд “Байгаль орчны засаглал-2” төсөлтэй хамтран “Байгаль орчны аудит” сургалтыг зохион байгуулж, байгаль орчны аудитын эрх зүйн орчин, олон улсын туршлага, арга, аргачлал сэдвүүдээр мэдлэг олголоо.

“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулав. /40 хувь/

**230.** Томоохон гол, мөрнүүдэд урсацын тохиргоо хийх замаар усан сан байгуулж бүс нутгийн усны хэрэгцээг хангах. Хөв цөөрмүүдийг байгуулна.

**Биелэлт:** Дэлхийн банкны 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-өөс “Орхон-Говь” төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад 3.2 сая ам.долларыг гарган санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Орхон говь төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг гүйцэтгэлийг хүлээн авч, ТЭЗҮ боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, тендер зарлах бэлтгэл ажлыг хийж байна.

Туул усан цогцолборыг байгуулах ажлыг БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ нөхцлөөр концессийн бичиг баримт боловсруулж байна.

2012 онд нийслэлийн Хан-Уул дүүргийн Түргэний гол, Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Арбулаг, Завхан аймгийн Цагаанчулуут сумын Жавцагийн булаг, Алдархаан сумын Ямаатын сайр, Хэнтий аймгийн Дархан, Дорнод аймгийн Баян-Дун сумын нутагт хөв цөөрөм байгуулсан.

Хашиж хамгаалах устай байгаа нийт 8970 булаг, 265 рашааны судалгаа гарган жил бүр улс, орон нутаг, төсөл, хувийн хэвшлийн санхүүжилтээр 1547 булаг, рашааныг хашиж хамгаалан тохижуулаад байна. 2012 онд улс, орон нутаг, төсөл, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар 205 булгийн эхийг хашиж хамгаалсан байна.

2013 онд улс, орон нутаг, төсөл, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар 186 булгын эхийг тохижуулсан, 174 ш рашааныг хашиж хамгаалж, эмчилгээ, сувилалгаа, үйлдвэрлэлийн зориулалтаар 8 рашааныг ашиглаж байна. Дархан уул аймгийн Орхон сум, Хөвсгөл аймгийн Цагаан уул суманд нийт 2 усны хөв цөөрөм, Говийн Их дархан цаазат газарт мазаалай баавгайд зориулж Шар хулс, Хөшөөтөд 2 булаг шанд сэргээн тохижуулж, 3 хөв байгуулсан.

2014 онд нийт 3 хөвийн зураг төслийн ажлыг Архангай аймгийн Хотонт сум, Төв аймгийн Баянцагаан сумын Завчирын гол, Дорнод аймгийн Дашбалбар сумын Нил өндөрт барих хөвийн зураг төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зураг төслийг боловсруулж, улсын экспертизээр баталгаажуулан хүлээн авсан.

2014 онд улс, орон нутаг, төсөл, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар 243 булгын эхийг тохижуулж, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Уугийн голын хөвийн барилгын ажлыг “Тангра-АББ” ХХК, Говь Алтай аймгийн Цогт сумын Тоонотын хоолойн хөвийг тус тус бариулж, улсын комисст хүлээлгэж өгсөн. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Дэлгэрэхийн голын хөвийн ажлыг “Онги Ээж” ХХК гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэж өгсөн. /40 хувь/

**231.** Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад хамруулж, усны менежментийн цогц бодлогыг хэрэгжүүлэх

**Биелэлт:** 2014 онд Булган, Хануй, Шишхэд, Орог нуур-Түйн гол, Хүйсийн говь-Цэцэг нуур, Мэнэнгийн тал, Идэр, Таац гол, Үенч Бодонч голын сав газрын захиргаадыг байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэнээр Монгол орны хэмжээнд 29 сав газрын захиргаад бүрэн байгуулагдаж орон нутагт хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяргас нуур-Завхан гол, Идэр, Хөвсгөл нуур-Эг гол, Улз голын сав газрын захиргаадын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг БОНХ-ийн сайдын 2014 оны А-228 дугаар тушаалаар батлуулан Усны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /70 хувь/

**232.** Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх

**Биелэлт:** ОХУ-ын Сохонд, Монгол Улсын Онон-Балжийн Байгалийн цогцолбор газрын хил дамнасан “Амарын эх” нэртэй тусгай хамгаалалттай газар байгуулах хэлэлцээрийг эцэслэн үзэглэхэд бэлэн болоод байна.

2014 оны 10 дугаар сард болсон Монгол, Оросын ЗГХК-ын ХҮИИ хуралдаанаар “Увс нуурын хотгор” хил дамнасан шим мандалын дархан газрыг өмнө нь байгуулж байсан туршлагыг тооцон үзэж, Түнхэний (Оросын Холбооны Улс) үндэсний парк болон “Хөвсгөл” үндэсний парк (Монгол)-ийг багтаасан хил дамнасан тусгай хамгаалалтын газар байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг авч хэлэлцэв.

Хан Хэнтийн ДЦГ, Онон-Балжийн БЦГ-ОХУ-ын Сохондын дархан газар, Хөвсгөлийн БЦГ-ОХУ-ын Тункений дархан газартай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, хамтарсан хяналт шалгалт, судалгааны ажлууд явуулж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийцүүлэн “Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, түүнээс гаргах журам”-ын төслийг боловсруулж, хууль батлагдсаны дараа хэлэлцүүлэхээр хойшлуулав.

2014 онд хамгаалалтын захиргаадын дэд бүтэц материаллаг баазыг сайжруулах зорилгоор хамгаалалтын захиргааны 3 байр /Зэд хантайн бүтээлийн нурууны ДЦГ-ын, Их газрын чулууны БЦГ-ын, Хан Хөхий Хяргас нуурын УТХГ-ын хамгаалалтын захиргаад/, 25 байршилд байгаль хамгаалагчийн нэг загварын байр барих, 350 байгаль хамгаалагчийг мотоциклоор хангах ажлыг зохион байгуулав.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд нь Монгол улсын хэмжээнд 16.5 сая га газрыг хамарч байгаа тусгай хамгаалалттай газар нутгийн шинэ ангиллын хүрээнд олон төрлийн ашиглалтыг дэмжиж, нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийг хэрэгжүүлснээр нийт ТХГН-ийн сүлжээг хоёр дахин өргөжүүлэх боломж бүрдэнэ.

/50 хувь/

**233.** Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах ажлыг эрчимжүүлж, зүй зохистой ашиглах, мод орлох технологийг нэвтрүүлэх

**Биелэлт:** Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-91 дүгээр тушаалын дагуу ойн хөнөөлт шавьжтай тэмцэх нийт талбайн 40-өөс доошгүй хувьд биологийн аргаар, 65-аас доошгүй хувьд онгоцоор гүйцэтгэхээр зохион байгуулж, улмаар үе шаттайгаар химийн аргаас татгалзах бодлого зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

2012 онд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгааг 2236,9 мян.га тэмцлийн ажлыг 150,0 мян.га, 2013 онд тархалтын судалгааг 2121,4 мян.га, тэмцлийн ажлыг 124,7 мян.га, 2014 онд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгааг нийт 2259,0 мян.га, тэмцлийн ажлыг 97,7 мянган га талбайд тус тус хийж гүйцэтгэсэн.

2012-2014 онд нийтдээ улсын төсвийн хөрөнгөөр нийт 372,4 мян.га талбайд хийж гүйцэтгэсэн ба өнөөгийн байдлаар жилд гүйцэтгэж байгаа ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх ажлын 70 хувийг биологийн бэлдмэл бодис болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргад шилжүүлээд байна.

2012 онд нийслэл болон 10 аймгийн ойн 1106 га талбайд арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах огтлолтыг, 13 аймгийн 101 сум, Богдхан уулын ДЦГ, нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн 2.0 сая га талбайд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтыг тогтоох судалгааны ажил, 11 аймгийн 47 сум, Богдхан уулын ДЦГ, нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн 150.0 мянган га талбайд хөнөөлт шавьж, өвчний тоо толгой, нягтшилт, тархалтыг бууруулах тэмцлийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

2012 онд ой бүхий 10 гаруй аймгийн БОАЖГ-т ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гар болон механик багаж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж нийт 400.0 сая орчим төгрөгийн техник хэрэгслийг хуваарилаад байна.

2013 онд ой бүхий Архангай, Булган, Дорнод, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий, Хөвсгөл, Дархан-Уул, Баян-Өлгий, Өвөрхангай аймаг, нийслэлийн 1-2 дугаар насны ангийн 2.0 мянган га талбайд арчилгааны огтлолтыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн, гэрэлжүүлэх огтлолтыг 185 га, тохируулах огтлолтыг 1815 га талбайд хийж гүйцэтгэлээ.

2013-2014 оны түймрийн мэдээллийг 2012 онтой харьцуулахад Улсын хэмжээнд гарсан ой, хээрийн түймрийн нийт тоо 20,6 хувь, түймэр гарсан сумын тоо 24.3 хувиар тус тус буурч, хээрийн түймэрт шатсан талбай 7.5 % нэмэгджээ.

2014 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар 18 аймгийн 101 суманд нийт 280 удаагийн ой, хээрийн түймэр гарч /урьдчилсан байдлаар/ 18275 га ой, 3.080.810 га хээр, нийт 3.099.085 га талбай шатжээ. 2014 онд ОХУ-аас Монгол Улсын хил давж 3 удаа хээрийн түймэр, БНХАУ-аас 1 удаа нийт 4 удаа хил дамнасан түймэр гарчээ.

Нийслэлийн ногоон бүсийн ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор нийт 20 гаруй км газарт түймрийн халз болон харлуулсан зурвас татаж, түймрийн харуулын цамхаг нийслэл болон орон нутагт тус бүр гурвыг байгуулав.

Мөн хил дамнасан ой, хээрийн түймрээс хамгаалах ажлын хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Хөмөл нэртэй газраас Дадал сумын Хэрэйн гол хүртэл 50-100 м өргөн, 120 км урт зурвасыг зориудын шатаах аргаар байгуулав.

Улсын хэмжээгээр 2013-2014 онд түймрийн аюулын эрсдэл өндөртэй Дорнод, Хэнтий, Сэлэнгэ аймгийн ОХУ-тай хиллэх Усын хилийн дагуу 10 м өргөн 400 км урт түймрээс хамгаалах шороон зурвас /харлуулсан зурвас/-ыг байгууллаа. Ойг түймрээс хамгаалах тухай Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2014 онд батлуулж, Дэлхийн түймрийн мониторингийн төвийн салбар Зүүн хойд Азийн түймрийн менежментийн төв Улаанбаатар хотод 2014 онд байгуулагдан ажиллаж байна. Түймрийн эрсдэл ихтэй Дорнод, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Төв, Хэнтий, Завхан, Архангай, Өвөрхангай, Сүхбаатар зэрэг аймгуудад Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах орон нутгийн Зөвлөл байгуулагдан ажиллаж байна.

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн тооцоогоор ой, хээрийн түймрийн гаралт, давтамж болон эрсдэлийн хэмжээ дунд болон түүнээс их зэрэглэлд хамрагдсан 17 аймгийн 170 суманд нэн хэрэгцээт 7 нэр төрлийн багаж хэрэгслийг хуваарилав.

Хууль бус мод бэлтгэл, тээвэрлэлтийн чиглэлээр улсын хэмжээнд гарсан зөрчлийн тоо 2012 онд 1213, 2013 онд 1102 байсан бол 2014 онд 583 болсон нь 2012 оны үетэй харьцуулахад 630 тохиолдол буюу 52 хувиар буурсан байна.

Ойжуулалтын ажлыг 2012 онд 8399 га, 2013 онд 8070 га, 2014 онд 6289 га талбайд гүйцэтгэсэн байна. 2012-2016 онд нийт 30000 мянган га талбайг ойжуулах зорилт тавьсан бөгөөд 2014 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 22758 га талбайг ойжуулж зорилтын биелэлт 75,8 хувийн биелэлттэй байгаа нь 2016 онд зорилт бүрэн биелэх боломжтой.

"Ногоон хэрэм" хөтөлбөрийн хүрээнд говь хээрийн бүсийн 15 аймгийн нутагт 106 га талбайд, Монгол-Солонгосын "Ногоон хэрэм" төслийн хүрээнд 150 га талбайд, заган ой 50 га-д, нийт 300 га талбайд ойн зурвас байгуулаад байна.

2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Гаалийн татвараас чөлөөлөх тухай, НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсаны дагуу Засгийн газрын 2013 оны 230 дугаар тогтоолоор мод, модон материалыг гааль, НӨАТ-аас чөлөөлөв.

Ингэснээр модон эдлэлийн үйлдвэрлэл өргөжиж, ажлын байр нэмэгдэн, аж ахуйн нэгж болон тэдгээрт ажиллагчдын орлого өсөх, жилд гаднаас авах модны хэмжээ нэмэгдэх, хулгайгаар мод огтлох үйлдэл багасах, Улаанбаатар хот болон бусад суурин газарт модон бүтээцтэй Канад, Орос загварын байр сууц олноор баригдах нөхцөл бүрдсэн байна. /70 хувь/

**234.** Устах аюулд орж байгаа амьтан, ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, тарималжуулах ажлыг эрчимжүүлэх

**Биелэлт:** Нэн ховор, ховор ургамлын эд, эс, эрхтэн, үрийн удмын санг хадгалах "Байгалийн ургамлын үндэсний гено банк" байгуулах ажлын зураг төсөл батлуулахаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлээд байна.

Нэн ховор, ховор болон ашиглалтад өртөмтгий ашигт ургамлын тархац нөөцийн судалгааг Архангай, Баянхонгор, Завхан аймагт гүйцэтгэн, судалгааны ажлын тайланг хүлээн авсан. Ховор ургамал болох вансэмбэрүү, сибирь арц, хар арц, монгол чаргай, ванижингарав, ягаан цээнэ, ямаан сэрдэг, сэгсгэр дэгд зэрэг ургамлыг тухайн орчинд нь хамгаалах хэрэгтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

Амьтны нөөцийг хамгаалагч нь ашиглагч байх шинэ үзэл баримтлалыг холбогдох журмуудад тусгалаа. Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч иргэн, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж нь амьтан хамгаалах төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд ховор, элбэг агнуурын амьтныг ашиглах давуу эрх эдлэх зохицуулалтыг журамлан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд 2013 онд 6 аймгийн 16 агнуурын бүс нутгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглахаар орон нутагт 1 нөхөрлөлийн холбоо, 2 орон нутгийн төрийн бус байгууллага, 1 хоршоо, 4 нөхөрлөлтэй хамтран ажиллаж эхэллээ.

Ховор амьтан агнасны төлбөрийг 100 хувь сумын дансанд төвлөрүүлж, төлбөрийн орлогын 50 хувийг тухайн агнуурын бүс нутгийн менежментийг сайжруулахад зарцуулахаар журамлалаа.

Ботаникийн хүрээлэнгийн Амгалан дахь Ботаникийн цэцэрлэгийн туршилтын талбайд 2014 оны байдлаар 183 зүйл, үүнээс Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн, байгалийн ургамлын хуулийн хавсралтанд орсон ховор, нэн ховор 43 зүйл ургамлын амьд цуглуулга бүрдсэн байна.

Нэн ховор, ховор амьтдын удмын санг хадгалах иж бүрэн лабораторийн ТЭЗҮ боловсруулах ажлыг 2014 оны БОНХЯ-ны төлөвлөгөөнд тусгаад байна.

"Монгол бөхөнгийн үржүүлгийн төв"-ийн ТЭЗҮ-ийг ШУА-ын Биологийн хүрээлэнгийн Хөхтөний экологийн лаборатори боловсруулав.

Тул бусад загас үржүүлгийн ажлыг 2 газарт зохион байгуулж байна.

АНУ-ын Сан Диегогийн Их сургуульд мазаалай баавгайн удмын санг гэрээний дагуу урт хугацаатай хадгалууллаа.

Мазаалайн генийн санг хамгаалах талаар судалгаа хийж байна. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хамтран ажиллах гэрээнд мазаалай баавгайг гаршуулан амьтны хүрээлэнд тэжээх, хулсны баавгайг лабораторийн нөхцөлд хэрхэн үржүүлж байгааг судлах, мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр хамтарч ажиллахаар тусгасан. Сэргээн нутагшуулж буй тахь адууны тоо толгой 2013 онд өмнөх оноос 50, 2014 онд 52 тоо толгойгоор нэмэгдсэн байна.

Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протоколыг УИХ-аар хэлэлцүүлэн соёрхон батлуулж Монгол Улс нэгдэн орсон.

*/60 хувь/*

**235.** Уул уурхайн нөхөн сэргээлтэд “дүйцүүлэн хамгаалах” механизмыг нэвтрүүлэх

**Биелэлт:** Уул уурхай, газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааны улмаас газрын доройтол, эвдрэлд орж, экосистемийн төлөв байдал өөрчлөгдсөн газар нутагт биологийн олон янз байдлыг боломжит өөр газарт дүйцүүлэн хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн батлав.

2015 онд уул уурхайн томоохон хоёр аж ахуйн нэгж биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тохироод байна.

“Өмнөд говийн болон зүүн өмнөд тал хээрийн бүс нутгийн эко систем”-д үнэлгээ хийж, мэдээллийн сан бүрдүүллээ. */50 хувь/*

**236.** Байгаль орчинд хохирол учруулсан талаар бодитой мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлэх

**Биелэлт:** Байгаль орчинд хохирол учруулсан талаар бодитой мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах санхүүгийн байнгын эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор байгаль орчны багц хуулиуд, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг судалж байна.

Одоо мөрдөгдөж байгаа Байгаль орчны тухай хуулиар торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хүртэл хувийг бодит мэдээлэл өгсөн, хамтран ажилласан, дэмжиж тусалсан иргэнд олгох заалттай. Ойн тухай хуулиар энэ заалтыг хэрэгжүүлэх журам боловсруулж, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар батлуулж, Сангийн сайдаар хамтран батлуулахаар хүргүүлээд байна. */40 хувь/*

**237.** Уул уурхай болон бусад томоохон төслийг санхүүжүүлэгч банкуудтай ногоон хөгжлийн бодлогыг холбох механизмыг бий болгох

**Биелэлт:** 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаанд банк, санхүүгийн байгууллага зээл, санхүүжилт олгохүй байхаар тусгасан нь уул уурхай болон бусад томоохон төслийг байгаль орчинд сөрөг нөлөө багатай хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгосон.

Банк санхүүгийн салбарт ногоон зээл, ногоон технологи, бизнесийг хөгжүүлэх, нутагшуулах чиглэлээр Төв банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулан хүргүүлсэн.

Засгийн газрын 2013 оны 230 дугаар тогтоолоор мод, модон материалыг гааль, НӨАТ-аас чөлөөлөв. Ингэснээр модон эдлэл үйлдвэрлэл өргөжиж, ажлын байр нэмэгдэн, аж ахуйн нэгж, ажиллагсадын орлого өсөх, жилд гаднаас авах модны хэмжээ нэмэгдэх, хулгайгаар мод огтлох хууль бус үйлдэл багасах, Улаанбаатар болон бусад суурин газарт модон бүтээц, хийцтэй Канад, Орос загварын байр сууц олноор баригдах нөхцөл бүрдсэн байна. */50 хувь/*

**238.** Үйлдвэрийн болон ахуйн хаягдал усыг цэвэршүүлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолоор “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс хөнгөлөх хувь хэмжээ”, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор “Ашиглалтын зориулалтаар тооцох итгэлцүүр”-ийг усны сав газар бүрээр шинэчлэн баталсан.

Засгийн газрын 2013 оны 303 дугаар тогтоолоор “Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй тоног төхөөрөмжийн

жагсаалт"-ыг баталсан бөгөөд уг тогтоолд бохир ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг тусгасан болно.

2014 онд хоногт 100 шоо метрээс илүү ус хэрэглэдэг Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр, "Оюу толгой" ХХК, "Энержи ресурс" ХХК, "Монгол Алт" ХХК, "Бороогоулд" ХХК, "Доншен" ХХК, "Цайрт менерал" ХХК зэрэг аж ахуйн нэгж, байгууллагууд хаягдлын сантай болсоноор 60-90 хувиар усыг дахин ашиглаж байна.

Ховд, Улаанбаатарын "Урьдчилсан цэвэрлэх байгууламж" НӨҮГ, "Үйлдвэрийн шинэ бүс"-д байгуулах цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Арьс ширний үйлдвэрлэлийн хаягдал усыг цэвэрлэх технологийн судалгаа хийх, технологийн шийдэл боловсруулахад улсын 2013 оны төсөвт 10.0 сая, Ховдод хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж байгуулахад 2.0 тэрбум төгрөг тусгаж Ховд аймгийн Үйлдвэр технологийн паркийн цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ, барилгын ажлын зургийг орон нутагт хүргүүлээд байна.

"Усыг эргүүлэн ашиглах цөм технологийн төсөл"-ийг ШУТИС-ын Усны нөөцийн нэгдсэн менежментийн сургалт, судалгааны төв хэрэгжүүлж байна. /60 хувь/

### **239. Хатуу хог хаягдлыг ангилан дахин боловсруулж ашиглах**

**Биелэлт:** Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах, устгах үйл ажиллагаанд дүгнэлт гаргаж, сайжруулах бодлого, арга хэмжээг төлөвлөх, нэгдсэн шийдэл гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2013 оны 175 дугаар захирамжаар байгуулан ажиллаж байна.

Эх үүсвэрээс гарах хог хаягдлын жагсаалт, тэдгээрийг хор аюулаар нь зэрэглэсэн жагсаалтыг БОНХ-ын сайдын 2013 оны А-209 дүгээр тушаалаар батлаад байна. 2013-2014 онд Улаанбаатар хот, 18 аймгийн ИТХ-аас үйлчилгээний хураамж болон хог хаягдлын нормативыг шинэчлэн батлуулсан.

"Байгальд ээлтэй орчин үеийн технологийг нэвтрүүлэх, хог хаягдлыг үйлдвэрлэл дээр нь бууруулах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг эрхлэх болон урамшуулах журам"-ын төсөл, "Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулах журам"-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.

"Импортоор оруулсан бараа бүтээгдэхүүнд экологийн татвар ногдуулах" тухай хуулийн төслийг боловсруулсан.

2014 онд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа иргэн, ААН, байгууллагын үйл ажиллагаанд зориулж улсын хэмжээнд 11.3 тэрбум төгрөгийг үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэн зарцуулж байна.

2012-2013 онуудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хог хаягдал дахин боловсруулах 5 үйлдвэр байгуулагдсан.

Байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр 866.7 сая төгрөг, үүнээс 464 сая төгрөгийг ландфиллын цэг байгуулах, 133 сая төгрөгийг хог хаягдал ялган ангилах цех байгуулахад хөрөнгө оруулалтын дэмжлэг болгосон. Үүний үр дүнд 5 аймагт хог хаягдлыг анхан шатны ялган, ангилалын цех, 7 аймаг ландфиллийн 8 байгууламжтай болсон. /60 хувь/

### **240. Цөлжилтөөс сэргийлж, бэлчээрийн талхлалтыг бууруулах зорилгоор бэлчээр, усны цогц бодлогыг хэрэгжүүлэх**

**Биелэлт:** Орхон, Туул, Онон, Хар нуур-Ховд голын сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан тухайн сав газар тус бүрт хэрэгжүүлж эхэлсэн.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Киотогийн протоколын Дасан зохицох сангийн 5.5 сая ам.долларын санхүүжилтээр "Эко системд түшиглэсэн дасан зохицох арга



хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийг Хархираа-Түргэн болон Улз голын сав газарт хэрэгжүүлж эхлээд байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг салбаруудын дасан зохицох арга хэмжээний дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхэлж, “Ой, ус, ХАА-н салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний чиглэлийг тодорхойлж, стратеги төлөвлөгөө” боловсруулаад байна.

“Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах дэд хөтөлбөр”, “Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, хүний эрүүл мэндийг хамгаалах стратеги /2011-2015 он/-ийг хэрэгжүүлж байна.

Азийн хөгжлийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран “Малчдыг нүүрстөрөгчийн зах зээлд холбож өгөх нь” сэдэвт төслийн эхний шатыг хэрэгжүүлээд байна. Энэхүү төслийн зорилго нь бэлчээрийн доройтлыг арилгах, бэлчээрийн менежментийг сайжруулах замаар карбоны шингээлтийг нэмэгдүүлэх, хөдөөгийн хүн амыг карбоны зах зээлд холбох, ингэснээр тэдний орлогыг нэмэгдүүлэх, уур амьсгалын тогтворгүй байдал, эрсдэлд малчдын эмзэг өртөмтгий байдлыг бууруулахад чиглэнэ.

Япон, Монгол Улсын Засгийн газар хооронд “Бага нүүрстөрөгч бүхий хөгжлийн түншлэл” тогтоож, хоёр орны хооронд хамтарсан кредит олгох механизм хэрэгжүүлэх тухай баримт бичигт гарын үсэг зурж, хэрэгжүүлж эхлэв. **/30 хувь/**

**241.** Цөлжилтийн явц /эрчим/-ыг хянах нэгдсэн сүлжээ байгуулж, цөлжилтөд өртсөн нутагт цөлжилттэй тэмцэх ногоон ажлын байр бий болгох замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

**Биелэлт:** Швейцарийн хөгжлийн агентлагийн “Цөлжилтийг сааруулах төсөл”-ийн дэмжлэгээр 2012 онд 10 аймагт Байгаль орчны шинжилгээний лаборатори байгуулж, цөлжилтийн чиглэлээр хийх хөрсний чанарын хяналт-шинжилгээг бүх аймагт эхлүүлэв. Улсын хэмжээнд 1500 гаруй цэг бүхий бэлчээрийн ургамлын ажиглалтын сүлжээ байгуулан ажиллаж байна.

Цөлжилтийн судалгааны төрөлжсөн хөтөлбөртэй 4 өртөө байгуулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтарч хөтөлбөрийг боловсруулж байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг дэмжих зорилгоор НҮБ-ийн санхүүжилтээр “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийг орон нутгийн тусгай хамгаалалттай 3 газарт хэрэгжүүлж байна.

Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч иргэн, нөхөрлөл, хоршоо, ААН нь хамгаалах төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд ховор, элбэг агнуурын амьтныг ашиглах давуу эрхийг эдлэхээр журамд зохицуулагдан хэрэгжиж байна. Үүний үр дүнд 2013 онд орон нутагт 1 нөхөрлөлийн холбоо, 2 орон нутгийн ТББ, 1 хоршоо, 4 нөхөрлөл 6 аймгийн 16 агнуурын бүс нутгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглахаар талуудтай хамтран ажиллаж эхэллээ.

Ховор амьтныг тусгай төлбөртэй агнасны төлбөр 100 хувь сумын дансанд төвлөрдөг болсон. Харин энэ төлбөрийн орлогоос 50 хувийг тухайн агнуурын бүс нутгийн менежментийг сайжруулахад зарцуулахаар журамлагдсан.

2014 онд Говийн бүсэд заг, нутгийн ургамал тарих ажлыг эрчимжүүлэх зорилгоор 8 иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 79.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон болно. **/50 хувь/**

**242.** Органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх эдийн засаг, санхүү банкны тааламжтай орчныг бүрдүүлж, Органик монгол үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

**Биелэлт:** 2012 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс даган мөрдөж байгаа Хүнсний тухай хуульд “Органик хүнс”-ний тодорхойлолт болон органик хүнстэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулах, органик хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд

дэмжлэг, урамшуулал үзүүлж болох тухай заалт тусгуулан батлуулсан. Хуулийн энэхүү заалтын хүрээнд Органик хүнсний тухай хуулийн болон “Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулсан.

Хүнсний тухай хуулийн 16.2-т заасны дагуу “Баяжуулагч бэлдмэл, нэмэлт, цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах тухай журам”-ын төсөлд Монгол Улсад үйлдвэрлэсэн болон импортолсон органик хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг тусгав.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг дэмжих ажлын хүрээнд “Органик хөдөө аж ахуйг дэмжих” төслийг 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулан хэрэгжүүлж эхлээд байна. “Органик хүнс, хөдөө аж ахуйн кластер хөгжлийн загвар төв байгуулах” /Улаанбаатар, Архангай, Хөвсгөл, Булган/ төслийг улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх жагсаалтад оруулав.

Органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлийн дэмжлэгийг нэгж зээлдэгчид 1.2 тэрбум хүртэл төгрөг байх, нийт 4.8 тэрбум төгрөгийн төсвийн саналыг 2015 оны улсын төсөвт тусгахаар хөрөнгө оруулалтын тооцоо хийсэн.

“Органик Монгол” хөтөлбөрөөс 2013 онд органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, түүхий эд бэлтгэгч 98 аж ахуйн нэгжид 550.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.

Сэлэнгэ аймгийн Шаамар, Сайхан, Зүүнбүрэн, Сүхбаатар сумын иргэдэд 70.0 сая төгрөгийн зээлийг олгосноор органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.5 хувиар нэмэгдсэн байна. /70 хувь/

**243.** Байгаль орчинд ээлтэй технологи, цэвэр үйлдвэрлэл, ногоон хэрэглээг урамшуулах замаар бага нүүрстөрөгч бүхий нийгэмд шилжих ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж эхлэх

**Биелэлт:** “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах” ажлын хэсгийг байгуулан хуралдаж ажлын төлөвлөгөө боловсруулан баталсан. АХБ-аас Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажилд 300.0 мянган ам.долларын техникийн туслалцаа үзүүлэхээр тохиролцоод байна. “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ыг боловсруулж байгаатай холбогдуулан 2020 он хүртэл дунд хугацаанд Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж байна.

Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг батлуулав. Уг тогтоолд ногоон хөгжлийг хангахад чухал ач холбогдол бүхий 41 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжийг худалдан борлуулсан аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөхөөр тусгасан бөгөөд сэргээгдэх эрчим хүчний /нар, салхи, усан/ цахилгаан станцын тоног төхөөрөмж, газрын гүний дулааны насос, ногоон байгууламж, ойг тарьж ургуулах дуслын усалгааны систем, модны үртэс, зоргодос, целлюлозон ширхэглэлийг шахаж зоргодсон, эслэг хавтан хийх төхөөрөмж, бохир ус цэвэрлэх, озоны давхаргад ээлтэй бодис бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж зэрэг болно.

Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хооронд “Бага нүүрстөрөгч бүхий хөгжлийн түншлэл” тогтоож, хоёр орны хооронд Хамтарсан кредит олгох механизм хэрэгжүүлэх тухай баримт бичигт гарын үсэг зуран хэрэгжүүлэх арга хэмжээ авч эхлээд байна. Уг түншлэлийн хүрээнд байгуулагдсан хамтарсан хорооны анхдугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулж, холбогдох дүрэм, журмыг батлан, уг механизмыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.

Японы БОЯ-ны дэргэдэх Гадаад хамтын ажиллагааны төвтэй “Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зохистой арга хэмжээг хэмжиж, тайлагнаж, нотолж болохуйц

байдлаар хэрэгжүүлэх чадавхи бэхжүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурж, хэрэгжүүлж байна.

Мөн Японы Даян дэлхийн Байгаль орчны стратегийн хүрээлэнтэй хамтран Монголд нүүрстөрөгчийн худалдаа хийх зах зээлийн шинэ механизмыг бий болгох чиглэлд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч эхлээд байна.

Олон улсын Даян дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичгийг байгуулан хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг эрчим хүч болон тээврийн салбарт ногоон тээвэр болон ногоон эрчим хүчний стратеги боловсруулах тооцоо, судалгааны төслийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2014-2016 оны дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд Сэргээгдэх эрчим хүчээр дулааны асуудлыг шийдвэрлэсэн, хаягдал усыг цэвэршүүлж эргүүлэн ашиглах "Ногоон оффис" санаачилгыг нэвтрүүлэх зорилгоор БОНХЯ-ны байранд "Ногоон оффис" барихаар тусгуулаад байна. /30 хувь/

### **Батлан хамгаалах бодлого**

**244.** Батлан хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан төрийн батлан хамгаалах бодлогыг шинэчлэх

**245.** Батлан хамгаалах төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэх

**246.** Зэвсэгт хүчний нэгдмэл байдлыг хангаж, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн Зэвсэгт хүчинтэй болох

**247.** Хил хамгаалах бодлогыг шинээр тодорхойлж, улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлэх

**Биелэлт:** Хилийн боомт болон Монгол, Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай 1994 оны хэлэлцээрийн шинэчилсэн төслийг харилцан солилцсон. Засгийн газар хоорондын комиссын XVI хуралдааны үеэр хэлэлцээрийг шинэчлэх, эсхүл хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар 2013 оны эхний хагаст уулзалт зохион байгуулж, дүнг 2013 оны 8 дугаар сард Оросын талд хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

Төмөр замын боомт шинээр нээхтэй холбогдуулан төмөр замын тээвэр, транзит тээврийн болон хилийн боомтын асуудлаар хөрш орнуудтай байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Хятадын талтай дипломат шугамаар хэлэлцээ хийж байна.

Улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хилийн отряд, ангиудын албаны бүтцийг шинэчлэн, орон тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авсан.

ТЕГ, ЦЕГ-ын холбогдох газар болон орон нутаг дахь салбар нэгжүүдийн хооронд хамтран ажиллах журам, төлөвлөгөөг тодотголоо.

Хамтын ажиллагааны шуурхай, тасралтгүй байдлыг хангах ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр зүүн бүсийн хилийн отряд ангиудын холбогдох тасгууд ТЕГ, ЦЕГ-ын орон нутаг дахь салбар, нэгжүүдийн сургалтыг зохион байгуулсан.

Хилийн шалган нэвтрүүлэх боомт болон боомт бус газраар ховор ан амьтан, тэдгээрийн эд эрхтэн, түүх, соёлын үнэт зүйлс, алт, үнэт чулуу, металл, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис зэргийг хууль бусаар хилээр нэвтрүүлэх 27 гэмт хэргийг илрүүлэв.

Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн талаар дээрх байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцон ажилласны үр дүнд Хилийн боомт болон боомт бус газраар хил дамнасан үйлдэгдсэн 38 удаагийн гэмт хэргийг илрүүлсэн байна. /40 хувь/

**248.** Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхийг бэхжүүлж, үндэсний байнгын хүчний тогтолцоо бүрдүүлэх

**249.** Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх. Зэвсэгт хүчинд эх оронч үзэл, хүмүүжил, хүний хөгжил, төлөвшлийн орчныг бүрдүүлнэ

**250.** Цэргийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулах

**251.** Цэргийн алба хаагчдыг шинэ бүтээн байгуулалтад оролцуулах арга хэмжээ авах

/Эдгээр зорилтын биелэлтийг Батлан хамгаалах яам нууцын журмаар танилцуулна/

### Гадаад харилцаа

**252.** Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, Засгийн газрын байгууллагуудын гадаад бодлого, гадаад харилцаа харилцан зохицуулалттай байх зарчмыг хэрэгжүүлэх

**Биелэлт:** Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.

Гадаад бодлого, олон улсын харилцааны зарим асуудлаарх манай улсын байр суурийн талаар мэдээллийг УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүдэд тухай бүр хүргүүлж ажиллав.

Бүгд Найрамдах Индонез Улсын нийслэл Жакарта хот, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нийслэл Бразилиа хотод Элчин сайдын яам нээн ажиллуулав. Лалын Бүгд Найрамдах Афганистан Улсын нийслэл Кабул хотод Элчин сайдын яамны үйл ажиллагааг сэргээсэн. Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хот, Бүгд Найрамдах Киргизстан Улсын нийслэл Бишкек хотод Ерөнхий консулын газар, БНХАУ-ын Хайлаар хот, БНСУ-ын Пусан хотод Консулын газар тус тус нээн ажиллуулав. Эдгээр ДТГ-уудын төсөв, орон тоо, цалингийн асуудлыг шийдвэрлүүлэв.

“Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн асуудлаарх байр суурийг эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж байхаар тусгагдсан болно.

“Монгол Улсын төрийн ёслолын журам”-ын төслийг шинэчлэн боловсруулав.

**/70 хувь/**

**253.** ОХУ, БНХАУ болон гуравдагч хөрш улс, холбоодтой стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцааг бататган бэхжүүлэх

**Биелэлт:** Дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалан ажиллаж байна. 2012-2014 онд дээд, өндөр түвшинд гадаадад 16, өөрийн улсад 22, нийт 38 айлчлалыг хэрэгжүүлэв.

Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, биелэлтийг хангах зорилгоор хоёр тал бүхий л түвшний уулзалт, яриа, хэлэлцээний явцад хөтөлбөрт орсон гол гол асуудлыг ярьж хэлэлцэх, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Одоогийн байдлаар тус хөтөлбөрийн хэмжээнд хэрэгжүүлж буй 65 арга хэмжээний 10 арга хэмжээ хэрэгжсэн ба 2 арга хэмжээний хэрэгжилт удаашралтай, бусад арга хэмжээ төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

“Дамжин өнгөрөх тээврийн тухай Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр”-ийг талууд 2014 оны 7 дугаар сард эрх зүйн баримт бичгийг боловсруулж НҮБ-ын АНДЭЗНК-ын Нарийн бичгийн газарт хүргүүлэхээр тохиролцоод байна.

“Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-ийг 2014 оны 12

дугаар сарын 4-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар соёрхон батлав. Энэхүү хэлэлцээрийг байгуулсан нь АНУ-тай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, цаашлаад АНУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад чухал алхам болов.

Мянганы Сорилтын Корпорацын Удирдах зөвлөл Монгол Улсыг Мянганы сорилтын корпорацын тусламжид 2 дахь удаа хамруулахаар 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр шийдвэрлэв.

Канад Улстай харилцаа, хамтын ажиллагааг 2011-2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Япон Улстай Стратегийн түншлэлийг эрчимжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг эцэслэн тохиролцож, гарын үсэг зурсан болно. Монгол Улс, Япон Улсын хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн эцэслэн тохиролцов. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн 2015 он гараад Япон Улсад хийх айлчлалын үеэр гарын үсэг зурахаар төлөвлөж байна.

Европын Холбоотой Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурж, Монголын тал хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухай мэдэгдлийг хүргүүлсэн.

2013 онд Антигуа ба Барбуда, Эритрей, Бурунди, Вануату, Палау, Суринам, Сьерра Леон, Того, Уганда, Руанда, Микронези гэсэн 11 улстай дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурж, холбогдох хууль тогтоомжийн дагуу УИХ-аар соёрхон батлуулав.

АПЕК-т гишүүнээр нэгдэх, АСЕАН-ы яриа хэлэлцээний түнш, Зүүн Азийн дээд түвшний уулзалтын оролцогч орон болох зорилтын хүрээнд идэвхтэй ажиллаж байна. АПЕК-ийн 21 гишүүнээс Монгол Улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлсэн орны тоо 10 гаруй болоод байна. Гадаад харилцааны сайд Л.Болд 2013 онд Балид болсон АПЕК-ийн дээд түвшний уулзалтад анх удаа тусгай зочноор оролцож, манай улсын АПЕК-т элсэх боломж, нөхцөлийн талаар танилцуулсан нь бусад улсын дэмжлэгийг авахад чухал ач холбогдолтой байв.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 167 дугаар тогтоолоор Монгол Улсаас АСЕАН-ы дэргэд суух Байнгын төлөөлөгчийг томилсон.

Монгол Улс АСЕАН-ы Яриа хэлэлцээний түнш болох, Зүүн Азийн дээд түвшний уулзалтад гишүүнээр элсэх хүсэл эрмэлзлэлтэйгээ 2013 онд Тайландын Ерөнхий сайдын манай улсад хийсэн албан ёсны айлчлал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сингапур, Мьянмар, Вьетнам улсуудад хийсэн төрийн айлчлал, уулзалтуудын үеэр тус тус илэрхийлсэн нь тэдний дэмжлэгийг авахад чиглэсэн чухал алхам болов. **/70 хувь/**

**254.** Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцоогоо өргөжүүлж, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалахад бодитой ахиц гаргах

**Биелэлт:** НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 68 дугаар чуулганаар Монгол Улсын НҮБ-ын хүрээнд санаачлан авч явдаг Бичиг үсгийн боловсролын тухай (85 орон хамтран зохиогчоор орсон), Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг (77 орон хамтран зохиогчоор орсон), Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай (72 орон хамтран зохиогчоор орсон) тогтоолуудыг нийтийн зөвшилцлөөр батлууллаа.

НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Супачай Паничпакти, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд НҮБ-ын Женев дэх төвийн Ерөнхий захирал Кассим-Жомарт Токаев, Ерөнхий Ассамблейн дарга Вук Еремич, Байгаль орчны хөтөлбөрийн Гүйцэтгэх захирал А.Штайнер нар тус тус манай улсад айлчилсан.

НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны 34-ийн Хорооны хуралд төлөөлөгч оролцуулах, энхийг сахиулах ажиллагаанд манай улсаас эмнэлэг, цагдаагийн төлөөлөл оролцуулах чиглэлээр ажиллаж байна.

Манай улс нэрээ дэвшүүлсэн 2022 оны НҮБ-ын Аюулгүйн зөвлөл, 2015 оны НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн сонгуулиар харилцан дэмжих тохиролцоог бусад улстай бичгээр байгуулахад анхаарч сүүлийн хагас жилд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн сонгуульд манай улсыг дэмжих орны тоог 10 (БНТУ, Литва, Эстони, Норвеги, ХБНГУ, Чад, Чили), Хүний эрхийн зөвлөлийн сонгуульд дэмжих орны тоог 14 (БНХАУ, Йордан, Морокко, Алжир, Өмнөд Судан, Уругвай, Мексик, БНСУ, Итали, Тринидад Тобаго)-аар ахиулж, ноот бичгээр баталгаажуулав. Чингэснээр АЗ-ийн байнгын бус гишүүний сонгуулиар 31 улстай, Хүний эрхийн зөвлөлийн сонгуулийн асуудлаар 55 улстай харилцан дэмжих тохиролцоо байгуулаад байна.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийн (ДГХБО-уудын ОУСТ) үйл ажиллагааг эхлүүлэх төслийн баримт бичигт Гадаад харилцааны сайд Л.Болд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Сезин Синаноглу нар 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр гарын үсэг зуран хэрэгжүүлж эхлээд байна. 2012 оны 11 дүгээр сараас хойш Армени болон Афганистан Улсаар тус олон талт хэлэлцээрийг соёрхон батлуулсан. Ингэснээр тус хэлэлцээрт нэгдэн орсон орнуудын тоо 4 боллоо. Олон талт хэлэлцээрт гарын үсэг зурсан орнуудын тоо 7 хэвээр байна.

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэн орох тухай хуулийг УИХ 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдөр баталсан.

**/70 хувь/**

**255.** Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн даргын үүргийг нэр төртэй гүйцэтгэхийн зэрэгцээ ардчиллын боловсролыг дэлгэрүүлэх ажлыг идэвхитэй үргэлжлүүлэх

**Биелэлт:** Монгол Улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг хоёр жилийн хугацаанд даргалж, 2013 оны 4 дүгээр сарын 27-29-нд АОХН-ийн Сайд нарын VII Бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

АОХН-ийн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хорооны гишүүн, мөн тус Нийгэмлэгийн хамгийн идэвхтэй ажилладаг гурван ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч АОХН-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор жил бүр 150,000 ам.долларын хандив өгч байхаар амласан. Энэ нь манай үйл ажиллагаа цаашид улам бодитой болох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна. 2014-2015 оны ажлаа төлөвлөн зохих зардлыг улсын төсөвт тусгуулан ажиллаж байна. **/90 хувь/**

**256.** Монгол Улсын ардчилал, хүний эрх, зах зээлийн эдийн засгийн замнал, туршлагыг хөгжиж байгаа бусад улстай хуваалцах зорилгоор сан байгуулж ажиллуулах

**Биелэлт:** Манай улсын ардчилал, хүний эрх, зах зээлийн эдийн засгийн замнал туршлагыг хөгжиж байгаа бусад улстай хуваалцах “Олон улсын хамтын ажиллагааны сан” байгуулав. ГХЯ-ны шинэ бүтцээр Олон улсын хамтын ажиллагааны сангийн хэлтсийг байгуулав. **/100 хувь/**

**257.** Европын Холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол Улсад нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх

**Биелэлт:** “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг Европын Холбоотой эцэслэн байгуулсан нь манай улсын Европын Холбоо, түүний гишүүн 28 улстай хөгжүүлэх харилцаа “түнш”-ийн хэмжээнд хүрч, олон салбарт хамтын ажиллагааны шинэ боломж нээгдэж байна.

Энэхүү хэлэлцээрт евро стандартыг нутагшуулах, тус холбооны төлөөлөгчийн газрыг Улаанбаатарт байгуулах, "GSP+" тарифын хөнгөлөлтийн системд үргэлжлүүлэн хамрагдах зэрэг олон чухал зорилт хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Монгол Улс Европын холбооны хооронд “Монгол Улсын стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх” тухай төслийн санхүүжилтийн

гэрээнд 2013 оны 4 дүгээр сард хоёр тал гарын үсэг зурсан бөгөөд 2014 оны 4 дүгээр сарын 1-нээс төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

Европын стандартыг нэвтрүүлэх тухай асуудлаар тогтоолын төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбогдох Олон улсын стандартчиллын ISO11269-2, MNS ASTM E 2278, MNS ASTM D5050 стандартуудыг үндэсний стандартаар батлууллаа.

“Эрчим хүчний салбарын чанарын дэд бүтцийг дэмжих төсөл”-ийг ХБНГУ-тай хамтран хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурав.

Эрчим хүчний байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглахад хүрээлэн буй орчны зүгээс тавигдах байгаль цаг уурын үзүүлэлтүүдийн шаардлагын цуврал стандартуудыг боловсруулах ажлын даалгаврыг батлуулж ажлыг эхлээд байна.

Өнөөгийн байдлаар иргэний нисэхийн 3 багц дүрэмд Европын холбооны нисэхийн аюулгүй ажиллагааны зарим стандартыг тусгахаар боловсруулалтын ажил хийгдэж байна. **/50 хувь/**

**258.** Монгол Улсын иргэдийн гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, консулын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулах

**Биелэлт:** Турк, Беларусь, Серб, ОХУ улстай бүх төрлийн паспорттой иргэд, Франц, Герман, Эстони, Итали улстай цахим дипломат паспорттой иргэд, Бруней, Колумб, Перу, Кувейт, Мьянмар, Польш, Латви улстай дипломат, албан паспорттой иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээр байгуулав.

Итали, Япон, Шинэ Зеландтай цахим дипломат паспорттой иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

ХБНГУ-ын иргэдийг 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс, Канадын иргэдийг 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс тус тус 30 хоногийн хугацаанд Монгол Улсад визгүй зорчуулах шийдвэрийг манай тал дангаараа гаргав.

Казахстан Улстай ялтан шилжүүлэх тухай хэлэлцээр, Сингапур Улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай санамж бичиг байгуулахаар тус тус санал солилцов. Ре-адмиссын хэлэлцээр байгуулах асуудлаар Гадаад харилцааны дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

ОХУ-тай байгуулах “Иргэдийг буцаан авах тухай хэлэлцээр (реадмисс) болон “Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийн төслийг ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүлээж байна. “Иргэдийг буцаан авах тухай хэлэлцээр”-ийн төсөл, хэлэлцээрийг хэрэгжүүлэх гүйцэтгэх протокол болон хавсралтын төслийг тулгалт хийхийг Оросын талд санал болгон хариу хүлээж байна.

Мөн БНХАУ-ын Хонконг Засаг захиргааны онцгой бүстэй байгуулах “Эрүүгийн хэргийн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх тухай” болон “Ялтан шилжүүлэн өгөх тухай” хэлэлцээрийн анхны хэлэлцээг амжилттай хийв. Монгол, Хонконгийн Засгийн газрын хооронд байгуулсан “Иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хоёр улсын иргэдийн визгүй зорчих хугацааг 30 хоног болгох саналыг айлын талд тавив.

Мөн БНХАУ-тай байгуулсан “Ялтан шилжүүлэх гэрээ”-г Хятадын талаар батламжуулах чиглэлээр ажиллаж байна.

2013 оны 5 дугаар сараас иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хөтлөх шинэчилсэн журмыг хэрэгжүүлэх зорилгоор хилийн чанадад суугаа ДТГ-уудын иргэний бүртгэлийн компьютерт иргэний гэр бүлийн байдлын болон биеийн давхцахгүй өгөгдлийн програмыг суурилуулан иргэний бүртгэлийн үйл ажиллагааг явуулж эхлээд байна.

Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба цахим хэлбэрээр виз хүсэх системийг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Цахим албан болон цахим дипломат паспортыг олгож эхлээд байна.

Монгол иргэд олноор суурьшсан БНХАУ, ОХУ, БНСУ, АНУ, Европын орнуудад томилж ажиллуулах Хууль зүйн атташегийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан.

2014 онд Иргэдэд туслах сангаас тусламж хүссэн 75 иргэний өргөдөл, хүсэлтийг танилцуулга хэлбэрээр боловсруулж, Иргэдэд туслах сангийн зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангаж, зөвлөлийн хурлыг 5 удаа зарлан хуралдуулсан бөгөөд Сангийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тухай бүр Сайдын тушаал гаргаж нийт 67 иргэнд 209.075.993 төгрөгийн тусламж олгох шийдвэрийг албажуулсан. 2015 оны төсвийн хүрээнд Хилийн чанадад байгаа Иргэдэд туслах сангийн зориулалтаар 224.000.000 төгрөг зарцуулахаар төсөвлөгдөөд байна.

ГХЯ-ны дэргэд 62-262222 утсыг ажиллуулан мэдээлэл авч, иргэдэд зохих дэмжлэгийг үзүүлж байна.

2013-2014 онд хилийн чанадад хар тамхи, мансууруулах төрлийн бодис хил давуулан хууль бусаар зөөвөрлөсөн ноцтой хэрэгт манай иргэд холбогдоогүй болно. Гэмт хэрэгт холбогдон хилийн чанадад ял эдэлж буй иргэдээс Хоёр талын яриа хэлэлцээ, Консулын зөвлөлдөх уулзалтуудын үр дүнд 2014 оны 12 дугаар сард Бүгд Найрамдах Казахстан Улсаас 2, 2015 оны 1 дүгээр сард БНХАУ-аас 1 иргэнийг шилжүүлэн авлаа.

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэнийг түр хугацаагаар хамгаалах байранд байлгах тухай журам”-ыг батлан мөрдөж ажиллаж байна.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа ДТГ-уудад Гадаад харилцааны яамнаас томилогдож буй мэргэжлийн дипломатуудаас гадна УИХ-ын Тамгын газар, Хууль зүйн яам, Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Тагнуулын ерөнхий газраас тус тус албан хаагчид томилогдон ажиллаж байна. **/70 хувь/**

**259.** Монгол Улсын хөгжил, үндэсний хэл, соёл, өв уламжлалыг дэлхий нийтэд сурталчлан таниулах, Монгол судлалыг дэмжих ажлыг эрчимжүүлэх

**Биелэлт:** Монгол Улсын Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг зохицуулах үндэсний зөвлөлөөс гадаад улс орнуудад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй дэлхийн монгол туургатнуудын нийгэмлэг, холбоодыг дэмжиж ажиллав.

Олон улсын нэр нөлөө бүхий “BBC” агентлаг Монголын эдийн засаг, үлэг гүрвэл, говийн амьтны талаар, Японы “NHK” телевиз тахийн талаар, “Франц-2 телевиз “ Монголын шашин, хөөмий, урлагийн талаар баримтат кино, нэвтрүүлгийн зураг авалт хийсэн. “Блүүмбэрг” телевиз 2013 оны 11 дүгээр сараас эхлэн “Mongolia Inside” цуврал нэвтрүүлэг хийж эхлээд байна. Мөн хугацаанд гадаадын хэвлэл мэдээллийн сэтгүүлч нартай хамтран ажиллах замаар Монгол Улсаа сурталчлах ажлыг үргэлжлүүлэн хийсэн. Үр дүнд нь 2012 онд гадаадын 118 сэтгүүлч ирж ажиллаж байсан бол 2014 онд 197 гадаадын сурвалжлагч болж нэмэгдэв.

ХБНГУ-ын Боннын Их сургуулийн Ази судлалын тэнхимд Монгол судлалын төв байгуулах, монголч эрдэмтэн багшийн орон тоо баталж, багш профессорыг ажиллуулах тохиролцоонд хоёр тал хүрч, үйл ажиллагааны болон санхүүжилтийн асуудлаар хэлэлцээ хийж байна.

Мөн Москва дахь манай ЭСЯ-наас Москвагийн Их Сургуульд монгол хэлний анги дахин нээгдэх гэж байгаатай холбогдуулан шаардлагатай сурах бичиг, толь бичиг, материалуудаар хангахаар ажиллаж байна.

Анкара хотын Гази их сургууль, Астана дахь Н.Гумилёвийн нэрэмжит Евро-Азийн дээд сургууль, Тайландын Таммасатын их сургууль, Нидерландын Гронинген их сургууль, Австралийн Үндэсний их сургууль, Лийдсийн их сургууль, Калифорнийн их сургууль, Сөүлийн Данкүгийн их сургууль болон Солонгосын гадаад хэлний их сургууль, ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбарын монгол буддизмын төв болон Ю.В.Кузьмин, Е.И.Лиштованный зэрэг монгол судлаач эрдэмтэдтэй хамтран монгол судлалыг дэмжиж ажиллаж байна.



Засгийн газрын 2013 оны 138 дугаар тогтоолоор түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворыг эрэн сурвалжлах, бүртгэх, цуглуулах, эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах “Палеонтологи, археологийн музейн шинэчлэл” төслийн нэгжийг байгуулсан. АНУ-ын Цагаачлалын болон Гаалийн хууль сахиулах албаны мэдэлд ирсэн өмч хөрөнгийг хүлээлгэн өгөх тухай Монгол Улс, АНУ-ын Засгийн газар хоорондын гэрээнд гарын үсэг зурснаар АНУ-ын талаас хууль бусаар хил давсан үлэг гүрвэлийн 22 олдворыг хүлээлгэн өгөв.

Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын хорооны ээлжит 8 дугаар хуралдаанаар Хүн төрөлхтөний яаралтай хамгаалах соёлын биет бус өвийн жагсаалтад “Монгол уран бичлэг” /калиграфи/-ийг, Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг тус тус бүртгүүлээд байна.

2014 онд Франц улсын Парис хотноо болсон Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын хорооны ээлжит 9 дүгээр хуралдаанаас манай улсаас нэр дэвшүүлсэн “Монгол шагайн харваа”-г хүн төрөлхтний биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэн авлаа. **/50 хувь/**

**260.** Хил орчмын худалдааг дэмжиж, орон нутгийн иргэд түр хугацаагаар хил нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх

**Биелэлт:** “Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн шинэчилсэн төсөл, “Хилийн боомт болон Монгол, Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай 1994 оны хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Оросын талд хүргүүлсэн. Оросын талаас 2014 оны 3 дугаар сард хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах Протоколын төсөл ирүүлснийг холбогдох яамд, агентлагт санал авахаар хүргүүлээд байна. **/50 хувь/**

**261.** Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн байгуулсан сайн дурын холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах

**Биелэлт:** Гадаадад байгаа Монгол иргэдийн байгуулсан сайн дурын холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжин ажиллах, тэдний зүгээс арга хэмжээ зохион байгуулахад хилийн чанад дахь Өргөмжит консулын дэмжлэгийг түлхүү авч ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар хилийн чанадад Монголчуудын холбоо, Монголын соёлын төв, Залуучуудын холбоо, Оюутны холбоо болон бусад нэрээр 33 оронд сайн дурын 64 байгууллага үйл ажиллагаагаа явуулж манай ЭСЯ-дын консулын ажилтнуудтай нягт хамтран ажиллаж байна.

Гадаад хэргийн яамнаас “Цахим өртөө” төрийн бус байгууллагатай хамтран “Бүтээлч хамтын ажиллагаа” сэдэвт хилийн чанад дахь монголчуудын холбоод, төрийн бус байгууллагуудын чуулга уулзалтыг 2014 оны 9 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, хилийн чанад дахь Монголчуудын холбоо, төрийн бус байгууллагуудын төлөөлөл 93, “Цахим өртөө” холбооны илтгэгч, судлаач 38, дотоодын байгууллагын (яамд, агентлаг) 22 төлөөлөгч, онлайнаар бүртгүүлсэн 42 нийт 195 хүн оролцов. **/70 хувь/**

**262.** Гадаадын харьяат болсон Монгол Улсын уугуул иргэний эх нутагтаа зорчих, эх хэл, соёлоо сурах, нутагтаа ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

**Биелэлт:** Гадаадын харьяат болсон Монгол Улсын уугуул иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн Монголд ирэх нөхцлийг хөнгөвчлөх, мөн монгол иргэдийн хилийн чанадад төрсөн хүүхдүүдийн Монгол Улсад зорчих, оршин суух эрхийг хөнгөвчлөх, нийгмийн халамж хүртээх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад чиглэл хүргүүлэн санал авч нийт 39

Дипломат төлөөлөгчийн газраас судалгаа мэдээллийг хүлээн авсныг нэгтгэн танилцуулга бэлтгэв. Асуудлыг Гадаад хэргийн яамны Шуурхай ажлын зөвлөлийн хуралдаанаар 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцүүлсэн. Шуурхай ажлын зөвлөлөөс энэ асуудлаар холбогдох байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

“Монгол Улсын уугуул иргэн”, “Монгол угсаа гаралтай иргэн” гэх ойлголтыг нэгмөр тодорхойлох, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцэгдэх гэж буй “Иргэний харьяаллын тухай” хуулийн төсөлтэй уялдуулахаар асуудлыг хойшлуулах, давхар харьяаллын асуудлыг хөндөхгүй байхыг анхааруулсан. /50 хувь/

**263.** Гадаад улсад амьдарч байгаа монгол иргэдийн хүүхдүүдэд монгол хэл, соёлыг сургах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааг төрөөс дэмжих

**Биелэлт:** Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газруудад түшиглэн суугаа болон хавсран суугаа орнуудад амьдарч буй цэцэрлэг, сургуулийн насны монгол хүүхдийн болон монгол хэлний сургалт явуулдаг сургалтын төвүүдийн талаарх судалгаа, мэдээллийг боловсрууллаа. Судалгаагаар, хилийн чанадад сургуулийн насны 11474 монгол хүүхэд амьдарч байгаа бөгөөд монгол хэлээр сургалт явуулдаг 1 сургууль, 18 сургалтын төв гадаадын 8 улсад үйл ажиллагаа явуулж байна.

ЮНЕСКО-ийн боловсролын салбар дахь мэдээлэл, технологийн институтын дэмжлэгтэйгээр Сургалтын нээлттэй нөөц материалын [www.oer.edu.mn](http://www.oer.edu.mn) домайн нэр бүхий цахим порталыг нээж түүнд бүх ангийн монгол хэлний сурах бичгүүдийг цахим хэлбэрээр байрлууллаа. Мөн өмнөх онуудын Монгол хэл, математик болон бусад чиглэлийн нийт 144 видео хичээлийг тус цахим порталд байрлууллаа.

Монголчууд олноор суурьшсан гадаад орны зарим хотуудад монгол хэлээр сургалт явуулдаг сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах хүрээнд хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа Монголчуудын холбооноос монгол хэлний сурах бичиг ирүүлэх хүсэлт хэд хэдэн удаа ирүүлсний дагуу холбогдох сурах бичгүүдийг хүргүүлэв. /40 хувь/

### Нийгмийн аюулгүй байдал

**264.** Аюулгүй байдлыг хангах байгууллагын хүч хэрэгсэл, техник хангамжийг сайжруулж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх

**Биелэлт:** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу аймгуудын Цагдаагийн газар, хэлтсүүдийг газар орны байрлал, бүс нутгийн онцлог байдлыг харгалзан 5 бүсэд хувааж, тус бүрт “Цагдаагийн хүрээ” байгуулсан.

Эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн болон сүүлийн үед үйлдэгдэж буй шинэ төрлийн гэмт хэргүүдийн онцлогийг харгалзан Эрүүгийн цагдаагийн газрын бүтцэд “Гэмт хэргийн судалгаа, шинжилгээ, зохицуулалтын хэлтэс”, “Байгаль орчны салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”, “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг” -ийг шинээр байгуулав.

2013 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 59 автомашиныг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хуваарилан олгосон байна.

Нийслэлийн цагдаагийн газрын парк шинэчлэлтэд зориулан 2.8 тэрбум төгрөгөөр хөдөлгөөнт эргүүлийн 75, жижүүрийн шуурхай албаны 24, 6 дүүргийн Замын цагдаагийн тасагт 30, нийт 129 автомашиныг шаардлагатай нэгжүүдэд олгосон.

2013 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн хүрээний цагдаагийн газар, хэлтсүүдийг дахин дамжуулах 5 иж бүрдэл, суурин станц 30, суурин антенн 20, гар станцын батерей 605, гар станцын антенн 300, кабелийн коннектор 215 болон бусад радио холбооны хэрэгслийг төв, орон нутгийн хэлтэс албадад хуваарилан олголоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд 17 аймгийн 23 сумдад тус бүр нь 78.2 сая төгрөгийн өртөг бүхий цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ыг 1.8

тэрбум төгрөгийн өртөгтэй барилгын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, хяналт тавин ажилласнаар 23 кобаныг бүрэн ажиллагаанд оруулав. Автомашин худалдан авах 1300.0 сая төгрөгөөр ОХУ-д үйлдвэрлэсэн УАЗ-2206, УАЗ-31514, Япон улсад үйлдвэрлэсэн Ланд круйзер-200, БНСУ-д үйлдвэрлэсэн “Хьюндэй”, “Элентра”, “Соната-7”, “Азера” маркийн 6 төрлийн 33 автомашин худалдан авч, Дорнод, Хэнтий, Булган, Сүхбаатар, Архангай, Ховд, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн цагдаагийн газарт олгосон.

Нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгсэл бэлтгэх 1.0 тэрбум төгрөг батлагдсаны дагуу БНСУ-ын “KYUNGCHANG INDUSTRY” ХХК-иас 7 нэр төрлийн 236.3 сая төгрөгийн 22000 ширхэг нэг бүрийн тусгай хэрэгсэл, БНХАУ-ын “Jiangsu jinan polise materials manufacturing” ХХК-иас 7 нэр төрлийн 478.6 сая төгрөгийн 9059 ширхэг тусгай хэрэгсэл худалдан авах гэрээ байгуулсан.

Тусгай хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх, харьяа цагдаагийн газар хэлтсүүдэд хувиарлан олгох ажлыг зохион байгуулснаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий алба хаагчдын 78.9 хувь нь нулимс асгаруулагч, 81.7 хувь нь бугуйн гав, 87.7 хувь нь резинэн бороохой, 41.5 хувь нь цахилгаан бороохой, 41.7 хувь нь гар чийдэнтэй резинэн бороохой, 95.7 хувь нь хутганаас хамгаалах бээлий, 62.3 хамгаалалтын хантааз, 61.6 хувь нь дуулга малгай, 49.9 хувь хамгаалалтын иж бүрэн хувцас, 100 хувь иж бүрэн тоногтой бүс, гаваар хангагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Хэнтий аймгийн цагдаагийн газарт 128.8 сая төгрөгөөр 3 автомашин, 4 мотоцикль, Дархан-Уул аймгийн цагдаагийн газарт 118.0 сая төгрөгөөр 7, Төв аймгийн цагдаагийн газарт 70.0 сая төгрөгөөр 1, Өвөрхангай аймгийн цагдаагийн газарт 57.0 сая төгрөгөөр 3, Булган аймгийн цагдаагийн газарт 65,3 сая төгрөгөөр 2, Сүхбаатар аймгийн цагдаагийн газарт 15.5 сая төгрөгөөр 2, Дорнод аймгийн цагдаагийн газарт 75.0 сая төгрөгөөр 3, Дундговь аймгийн цагдаагийн хэлтэст 88.0 сая төгрөгөөр 2, Орхон аймгийн цагдаагийн газарт 40 сая төгрөгөөр 1, Баянгол дүүргийн цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэст 88.8 сая төгрөгөөр 2 автомашин, 9 ширхэг мотоцикль, Баянзүрх дүүргийн цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэст 90.0 сая төгрөгөөр 3 автомашин худалдан авч өгч, парк шинэчлэлт хийгдсэн.

Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон өргөтгөн зохион байгуулсан.

Бүсийн давтан сургалтын төвүүдийг байгуулах асуудлыг ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ ОБЕГ-тай байгуулсан “Санамж бичиг”-т тусган энэ асуудлаар хамтарсан судалгаа явуулсан. Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн Б/227 дугаар тушаалын дагуу 21 аймагт 8 багийг илгээж Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүхийн шинжилгээ, Онцгой байдал, Хилийн цэргийн албан хаагч болон орон нутгийн захиргааны албан хаагчдыг хамруулан сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, 7 аймгийн засаг дарга нартай уулзаж ярилцан “Бүсийн сургалтын төв”-ийг өөрийн аймагтаа байгуулахыг санал нэгтэй дэмжлээ.

2013 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар “Зорчигчийн ачаа тээш шалгах рентген төхөөрөмж /Хөвсгөл, Говь-Алтай/” төсөл, арга хэмжээнд 208.6 сая, “Хяналт шалгалтын болон гаалийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж” төсөлд 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын харуул хамгаалалтыг сайжруулах зорилгоор машины камер 80, согтолтын зэрэг тогтоох тусгай хэрэгсэл 150, өрөөний телекамер 383, танхимын телекамер 22, зурвасын телекамер 29, талбайн камер 5, дэлгэц хуваах төхөөрөмж 73, UPS тог баригч 24, нийт 170 төхөөрөмжийг нийлүүлэв.

Гамшгийн хор уршгийг арилгах, аврах зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулахад зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд 3.5 тэрбум төгрөгийн 18 нэр төрлийн 689 аврах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг төв, орон нутгийн ангиудад олгосон байна.

2013 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 35.8 тэрбум төгрөг батлагдсанаас 2013-2014 онд шинээр баригдах 9.2 тэрбум төгрөгийн өртөгтэй Архангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Төв, Дархан-Уул аймаг, Хэнтий аймгийн Бэрх тосгон, Сэлэнгэ аймгийн

Мандал сум, нийслэлийн Багахангай дүүргийн нийт 8 аврах, гал унтраах ангийн барилга болон улсын нөөцийн Объект-03 салбарын хүнсний агуулах, Улсын нөөцийн шатахууны салбарын иж бүрэн агуулахын барилгын ажлын гэрээг байгуулаад байна.

Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Галын техник, аюулгүй байдлын төв, “ИТОЧУ” корпораци болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлж гал унтраах зориулалтын 22 автомашиныг хүлээн авлаа.

Цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед шуурхай хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгах, ослын төлөвлөлт, бэлэн байдлыг хангах асуудлаар төрийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагааны зарчим, үйл ажиллагааг нэгтгэх зорилгоор Цөмийн энергийн газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. /60 хувь/

**265.** Монгол Улсын эдийн засаг, байгаль экологийн аюулгүй байдлыг хангахад аюулгүй байдлыг хангах байгууллагын оролцоог нэмэгдүүлж, бодлогын шийдвэр гаргахад мэдээллийн бодит дэмжлэг үзүүлэх, аливаа сөрөг нөлөөлөл, үйл ажиллагаатай тэмцэх ажлыг идэвхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

**Биелэлт:** “Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа”-ны ажлын хүрээнд тохиолдож болзошгүй улс төр, эдийн засаг, нийгмийн үзэгдэл, байгалийн болон техногенийн гаралтай аюул, осол тус бүрийн эрсдэлийг тухайн аюул, ослын онцлогт тохирсон аргачлал боловсруулан үнэлж, геомэдээллийн технологи ашиглан зураглалд оруулав.

“Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах” төслийн эхний шатыг хэрэгжүүлж 2013 оны 12 дугаар сарын 5-ны өдрөөс Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийг ашиглалтад оруулан, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Мөн уг төслийн хүрээнд Газар хөдлөлтийг мэдрэх сенсоруудыг Дэрэн, Могод, Цагааннуурын голомтын бүсэд суурилуулж, сансрын холбоо ашиглан Одон орон геофизик судалгааны төвтэй холбох шийдлийг боловсрууллаа.

Улаанбаатар хотын 40 цэгт амжиж анхааруулах чанга яригч, 8 телевиз, радио, үүрэн холбооны 4 оператор компанид суурилуулах системийн судалгаа болон суурилуулалтын ажил явагдаж байна. /30 хувь/

**266.** Цахим аюулгүй байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх, техник хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

**Биелэлт:** Засгийн газрын 2011 оны 312 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газраас Улаанбаатар хотод байрладаг 88 төрийн байгууллагыг шилэн кабелийн аюулгүй сүлжээгээр холбосон.

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 312 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх хүрээнд төрийн захиргааны төв байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж, тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв. /30 хувь/

**267.** Ган, зудаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болгож, бэлэн байдлын нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох. Газар хөдлөлт болон бусад гамшгийн мэдээлэл, судалгааны газрын хүчин чадал, техник, технологийг шинэчилнэ.

**Биелэлт:** Улаанбаатар хотын 40 цэгт амжиж анхааруулах чанга яригч, 8 телевиз, радио, үүрэн холбооны 4 оператор компанид суурилуулах системийн судалгаа болон суурилуулалтын ажил явагдаж байна.

2013 оны 12 дугаар сарын 5-ны өдрөөс Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийг ашиглалтад оруулан, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

“Газар Хөдлөлийн Гамшгаас Амжиж Анхааруулах Систем” төслөөр 2014 онд 3G сүлжээнд масс мессеж хүргэх техникийн шийдлийн даалгаварыг боловсруулах, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, Налайх зэрэг газруудад СВС системийн туршилтыг хийх, газар хөдлөлийн чичэрхийлэл хэмжих төхөөрөмж суулгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

2013 онд 1.1 сая тн өвс, 42.2 мянган тн ногоон тэжээл, 40.7 мянган тн хүчит тэжээл, 65.0 мянган тн хивэг, 25.0 мянган тн тэжээлийн үр тариа бэлтгэсний 13.7 хувь нь үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээл байна.

2012 онд улсын хэмжээнд бэлчээр, хадлангийн нийт талбай 112.7 сая га байсны 0.57 хувийг аймаг дундын отрын бүсийн нөөцөд авсан байна.

**2013-2014 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг** баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн тооцоолж гаргахад нийт нутгийн 70 гаруй хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой ба тодорхой тооны мал гаднаас отроор орох бэлчээрийн нөөцтэй байв. Харин нийт нутгийн 20 гаруй хувь нь өөрийн сумын нутагт мал өвөлжүүлэх боломж муу тул бэлчээрийн даац хэтэрсэн, отор хийж өвөлжих өрх, малын тоог тохиролцон орон нутгууд гэрээ байгуулан өөр аймгийн нутагт 3253 өрхийн 965.0 мянга, өөрийн аймгийн бусад сумын нутагт 6799 өрхийн 2.1 сая, аймаг, дундын тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 743 өрхийн 473.9 мянга, улсын хилийн зурвас газарт 2780 өрхийн 864.0 мянга, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3145 өрхийн 1113.3 мянга, нийт 17.1 мянган өрхийн 5.7 сая мал отроор өвөлжиж, хаваржихаар зохион байгуулалт хийгдсэн.

Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг эдгээр аймгуудын газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хийгдсэний дараа 2015 оны төсөвт тусгахаар болсон.

Барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдлөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторийн барилга барьж байна. **/40 хувь/**

**268.** Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал булшлахыг хориглоно.

**Биелэлт:** Цөмийн энергийн тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн өөрийн орны цацраг идэвхт хаягдал булшлах асуудлыг зохицуулсан. “Ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай конвенц”, “Цөмийн аюулгүй байдлын тухай конвенц” болон “Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлт”-д нэгдэн орох бэлтгэлийг хангаж байна.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан “Цөмийн болон бусад цацраг идэвхт материалыг улсын хилээр хууль бусаар зөөвөрлөхөөс сэргийлэх асуудлаар хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”, АНУ-ын “Батлан хамгаалах 2 дугаар шугам” төслийн хүрээнд “Монгол Улсын хилийн боомтуудад цацрагийн үүсгүүр, цөмийн материалыг илрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах, боловсон хүчин бэлтгэх, холбогдох засвар үйлчилгээ үзүүлэх төсөл”-ийг 2008 оноос хэрэгжүүлж байна.

Энэ төслийн хүрээнд 2013 онд Буянт-Ухаа болон Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтод цацрагийн хяналтын 4 төхөөрөмжийг суурилуулан, ашиглалтад оруулсан.

Мөн Монгол Улсын хилийн боомтуудад суурилуулсан цацрагийн хяналтын төхөөрөмжүүдэд бүртгэгдсэн дохиоллыг шуурхай хүлээн авах зорилготой харилцаа холбооны системийн төв серверийг МХЕГ-т байрлуулсан. Тухайн серверт хилийн 6 боомтыг шууд холбож, цацрагийн хяналтын төхөөрөмжид илэрсэн цацрагийн дохиоллыг шуурхай хянах боломжтой болсон. **/70 хувь/**

**269.** Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох

**Биелэлт:** Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар батлуулж, уг хуулийн 15.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулж болох, гэрээнд татварын орчинг тогтвортой байлгах, тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнээр борлуулах, олсон орлогоо захиран зарцуулах эрхийг нь баталгаажуулах, хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, ашигт малтмалыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол багатай олборлох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бусад төрлийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, учирсан хохирлыг нөхөн төлөх талаар заалт оруулж байхаар боллоо. /100 хувь/

**270.** Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулахыг дэмжих

**Биелэлт:** “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Улаанбаатар хотын махны бөөний худалдааны давамгайл байдлыг арилгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх, дүүрэг бүрт махны төрөлжсөн агуулах бүхий бөөний худалдааны төв болон махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй байгуулахад 100.0 тэрбум төгрөгийн төсөл сонгон шалгаруулалт зарлан, төслийг хүлээн авч шалгаруулалт хийгдэж байна.

Арилжааны банкуудаас 23 аж ахуйн нэгжид 74.9 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Зээлийн хүрээнд зоорь, худалдааны төвийн барилгыг 8 аж ахуйн нэгж барьж дуусгаж, ашиглалтад оруулан, 7 аж ахуйн нэгжийн ажлын гүйцэтгэл 70-90 хувьтай, 8 аж ахуйн нэгжийн ажлын гүйцэтгэл 20-50 хүртэл хувьтай байна. Зоорь, худалдааны төвийн барилгууд шинээр ашиглалтад орсноор төмс, хүнсний ногооны зоорь 66.5 мянган тонноор, мах махан бүтээгдэхүүний хөргүүртэй зоорь, худалдааны төвийн багтаамж 25.5 мянган тонноор нэмэгдэж, үүний үр дүнд төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж 37 хувиар нэмэгдэн 248.7 мянган тоннд хүрч жилдээ хураан авах төмс, хүнсний ногооны зоорийн хангамж 71.0 хувьд хүрэх боломжийг бүрдүүлж байна. /60 хувь/

**271.** Малын хулгайтай тэмцэх асуудлын хүрээнд байнгын ажиллагаатай цахим сүлжээ, лавлах утас ажиллуулан үнэн зөв мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулдаг тогтолцоо бүрдүүлэх

**Биелэлт:** Малын хулгайтай тэмцэх хүрээнд байнгын ажиллагаатай “Тод сураг” цахим сүлжээ болон 1952 лавлах утсыг ажиллуулж байна.

Малын хулгайтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, “Малын бүртгэл, мэдээллийн сан” байгуулах чиглэлээр хулгайд алдагдсан, олдсон, алдуул мал бүртгэх программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Малын хулгайн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах асуудлыг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн 15.1-д “Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд цагдаагийн байгууллага Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу мэдээлэл худалдаж авсны төлбөр олгоно”, 15.2-т “Мэдээлэл үндэслэлтэй болох нь шүүхийн шийтгэх тогтоолоор нотлогдсон тохиолдолд

хулгайд алдагдсан малын өмчлөгч нь буцаан олж авсан малын тоо толгойн буюу хохирлоо нөхөн төлүүлсэн үнийн дүнгийн 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг мэдээлэгчид олгож болно” гэж заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон тухай шатны цагдаагийн байгууллагаас урамшуулал олгох ажлыг зохион байгуулж байна.

2013 онд малын хулгайн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн 57 иргэнд 5.5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. **/100 хувь/**

**272.** Хар тамхи, хүний болон зэвсгийн наймааны гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар тусгай боловсон хүчин бэлтгэх, гадаад улсын туршлага судлах, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах

**Биелэлт:** ГХЯ-ны Консулын газраас Улсын ерөнхий прокурорын газрын удирдлагатай 2013 оны 6 дугаар сарын эхээр хийсэн уулзалтын үеэр хар тамхи, хүний болон зэвсгийн наймааны гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар албан хаагчдыг сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллах талаар санал солилцлоо.

БНТУ-д 10 хүнийг хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Туркийн талын зардлаар сургах хүсэлт тавиад байна. Түүнчлэн 2012 оны 6 дугаар сард Тайландын Вант Улсад 8 хүнийг сургалтад хамруулсан бөгөөд энэ чиглэлээрх сургалтын давтамжийг хадгалах чиглэлээр ажиллаж байна.

Мөн Тайландын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулах “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” сэдэвт сургалтад 12 хүнийг хамруулахаар тохиров. **/50 хувь/**

**273.** “Архигүй монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

**Биелэлт:** “Архидан согтуурахаас сэргийлэх, хянах хоёр дахь удаагийн үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн төслийн боловсруулан 2014 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв.

Архи, согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төсөлд спиртийн үйлдвэрлэлийн хэмжээнд квот тогтоохоор тусган хэлэлцүүлж байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, согтууруулах ундаанд ногдуулж буй онцгой албан татварыг 3 шатлалтай болгож, 25 хувиас дээш этилийн спиртийн агууламжтай бүх төрлийн архины татварын хэмжээг 2 дахин нэмэгдүүлэн, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд архи, спирт үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хураамжийг 50.0-200.0 сая төгрөг болгон тус тус мөрдүүлж байна.

Согтууруулах ундаа, архины үйлдвэрийн тоог нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авч, архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл нэмж олгоогүй.

2012-2014 онд Засгийн газрын 7 удаагийн тогтоолоор нийт 47 компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Улсын хэмжээнд архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрийн тоо 2012 оныхоос 17 хувиар буурсан бөгөөд архины үйлдвэрийн тоог 2004 онтой харьцуулахад 3 дахин буурчээ.

Архины үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн жилүүдэд өсөлттэй явж ирсэн бөгөөд харин 2013 онд өнгөрсөн оны мөн үеийн байдалтай харьцуулахад спирт үйлдвэрлэл 41.7 хувь, архи үйлдвэрлэл 7.6 хувиар буурсан байна. **/70 хувь/**

## **ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН**

**274.** Төр засгийг иргэдэд нээлттэй, тунгалаг болгох цогц арга хэмжээ авах

**Биелэлт:** Шинэчлэлийн Засгийн газар иргэддээ ойр байж тэдний санал, хүсэлтийг олон сувгаар байнга хүлээн авч, богино хугацаанд шийдвэрлэн хариу өгөх Засгийн газрын “1111” төвийг байгуулан ажиллуулж байна.

Төрийн үйлчилгээг “ТҮЦ” машинаар дамжуулан иргэдэд хүргэх төслийг хэрэгжүүлэн нийслэлийн 78 цэгт, орон нутагт бүх аймгийн төв болон Багануур 1, Налайх 1, Баганхангай 1, Дархан 2, Эрдэнэт 2 зэрэг 28 цэгт машиныг байрлуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Одоогоор ТҮЦ машинаас 18 нэр төрлийн үйлчилгээ авч байна. Тухайлбал: Оршин суугаа хаягийн тодорхойлолт, төрсний болон гэрлэлтийн лавлагаа авах, цахилгааны төлбөр төлж, хэвлэл захиалга хийх боломжтой бөгөөд цаашид Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх талаархи лавлагаа, Иргэний үнэмлэхээ захиалах зэрэг үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх юм.

Ерөнхий сайдын төсвийн багцын хөрөнгөөр “Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн систем” төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

2014 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий Газрын Лицензийн төв, Зам тээврийн яам, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын 25 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэхээр ажиллаж байна. /50 хувь/

#### **275.** Төрийн албыг нийтийн алба болгон өөрчлөх

**Биелэлт:** Төрийн албыг иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэн зохион байгуулах зорилтын хүрээнд Ерөнхий сайдын 2013 оны 38 дугаар захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны 67 дугаар тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулсан бөгөөд “Иргэн төвтэй” төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын баримт бичгийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн тухай, Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тухай хуулийн төслийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна. /50 хувь/

**276.** Улс төрийн намыг нийтийн хөгжлийн зүй тогтолтой уялдуулан төлөвшүүлэн хөгжүүлэх чиглэлээр шинэчлэл хийх

**Биелэлт:** Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын гишүүд санаачлан боловсруулж байгаа бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт ахалж байна. Энэхүү хуулийн төслийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. /50 хувь/

**277.** Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлж, зөвшөөрөл, лиценз авдаг олон шат, дамжлагыг энгийн хэлбэрт оруулах

**Биелэлт:** Ерөнхий сайдын 2012 оны 14,16 дугаар захирамжаар бизнес эрхлэлтийг дэмжих болон бүх төрлийн тусгай зөвшөөрлийн тоог зохистой хэмжээнд бууруулах талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэг 54 байгууллагаас олгож байгаа 914 тусгай зөвшөөрөл нэг бүрийг хэлэлцэн 404 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 447 тусгай зөвшөөрлийг хэвээр үлдээхээр тогтож, 63 тусгай зөвшөөрлийг УИХ-ын гишүүдээс бүрдсэн дараагийн шатны ажлын хэсгээр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мөн тусгай зөвшөөрлийн асуудал тусгагдсан бүх л хууль тогтоомжийг шинэчлэх болон нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, тусгай зөвшөөрөл олгох механизмыг хөнгөвчлөх, шаардагдах баримт бичгийг цөөлөх талаар тусгаж Улсын Их Хуралд дахин өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.



Засгийн газрын 2010 оны 325 дугаар тогтоолоор “Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл” олгох асуудлыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.

Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн бус байгууллагууд 2011 онд нэгдсэн зохион байгуулалтад орж Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төвийг байгуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамтай хамтын ажиллагааны ерөнхий гэрээ байгуулсан.

Үүнтэй холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны “Барилгын салбар дахь төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тухай” 70 дугаар тушаал гарсан байна.

Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 49 дүгээр тушаалаар “Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг шинэчлэн баталж, уг тушаалаар барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төвд үүрэг болгон ажиллаж байна.

Ингэснээр Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны /хуучнаар/ олгож байсан Барилгын материалын үйлдвэрийн тусгай зөвшөөрөл олгох суурь нөхцөл, шалгуур үзүүлэлтүүдээр бизнес эрхлэгчдэд 17 төрлийн нөхцөл шаардагддаг байсныг 10 төрөл болгож багасгасан.

Цаашид барилгын салбарын бүх төрлийн үйлчилгээг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх зорилготой ажиллаж байна.

Уул уурхайн яам тусгай зөвшөөрөл олгох шат дамжлагыг хялбаршуулж, яамны Угтах ажилтнаар дамжуулан иргэд, байгууллагын хүсэлтийг хүлээн авч бичиг баримтын бүрдүүлэлтийн асуудлаар зөвлөгөө өгөн хууль, холбогдох журамд заасан хугацаанд шийдвэрлүүлэн ажиллаж байна.

Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн бүртгэлийн жагсаалт, үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн судалгааг тухай бүр шинэчлэн [www.mtm.gov.mn](http://www.mtm.gov.mn) цахим хуудсанд тогтмол байршуулж ажиллаж байна.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэх, нэгдсэн порталыг байгуулах төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн ба энэ хүрээнд нийт 31 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. **/70 хувь/**

**278.** Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн зөвхөн нэг цонхоор, нийтийн нэг албан хаагчтай харьцах зарчмыг тогтоож, бусад шат дамжлагад төрийн байгууллагууд хоорондоо харьцах замаар иргэдэд үйлчлэх

**Биелэлт:** Ерөнхий сайдын 2013 оны 38 дугаар захирамжаар Төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлого, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж, Төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж байна.

“Нэг цонхны үйлчилгээ”-ний төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 153 дугаар тогтоолоор “Нэг цонхны үйлчилгээний төвийн үйл ажиллагааны журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгох чиглэлийн багц 6 журмыг боловсрууллаа.

Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 48 ТҮЦ машиныг суурилуулан төрийн 10 орчим үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэж байна.

Эрчим хүчний яамны цахим хуудсанд “Иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдол” нэртэй нээлттэй булан ажиллуулж байна.

“Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлан “Нэг цэгийн үйлчилгээ” буюу Угтах үйлчилгээний ажилтныг томилон ажиллуулж байна.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн портал сайтаар дамжуулан иргэд гар утаснаасаа цагдаагийн байгууллагын талаар мэдээ мэдээлэл, гэмт хэрэг зөрчлийн талаарх дуудлага мэдээлэл авах үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр шийдэл боловсруулж байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ажиллуулж байгаа “Төрийн үйлчилгээ мэдээлэл лавлагаа”-ны [www.ub1234.mn](http://www.ub1234.mn), иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) сайтад цагдаагийн байгууллагын бүтэц, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний лавлагаа, хаяг, утасны дугаарыг шинэчлэн оруулсан. Мөн байгууллагын цахим хуудас [www.ubpolice.mn](http://www.ubpolice.mn) сайтад нийтэлсэн мэдээ, мэдээллийг фейсбүүк хуудсанд бүртгэлтэй 6500 орчим хэрэглэгч, твиттер хуудсанд бүртгэлтэй 3200 орчим хэрэглэгчид мэдээллийг давхар хүргэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, шуурхай, чирэгдэлгүй хүргэх “Нэг цонхны үйлчилгээ”-ний танхимыг байгуулж, иргэдийг хүлээн авах өрөөг тохижууллаа.

Иргэдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах 266332 болон иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 266266, 70109962 дугаар бүхий утсыг ажиллуулж эхэлсний зэрэгцээ өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр авах [infocd@gov.mn](mailto:infocd@gov.mn) e-мэйл хаягийг нээн ажиллуулж байна.

Хил хамгаалах байгууллагын [www.bro.gov.mn](http://www.bro.gov.mn) вэб сайтыг тогтмол шинэчлэн төрийн нууцаас бусад үйл ажиллагааг ард иргэдэд нээлттэй болгосон.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2012 оны а/546 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдэж буй үзлэг, шинжилгээний талаар эрх бүхий албан тушаалтанд мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ыг батлав. Уг журмыг хэрэгжүүлэх чиглэлээр лавлагааны утас 264022, [lavlagaa\\_nifs@yahoo.com](mailto:lavlagaa_nifs@yahoo.com) e-mail хаягийг тогтмол ажиллуулж, хариу өгөх ажилтныг томилон ажиллаж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр ажиллуулж байгаа эрх зүйн мэдээллийн 1982 лавлах, Архивын ерөнхий газрын [www.archives.gov.mn](http://www.archives.gov.mn). веб сайтаар болон 264361, 264914 дугаарын утсаар иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч ажиллаж байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах “[www.1284.mn](http://www.1284.mn)” цахим системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Стандартын мэдээлэл, лавлагааны төвийн [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn) сайтаар бизнес эрхлэгчдийг цахим орчинд үндэсний стандартуудтай танилцах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. **/50 хувь/**

**279.** Төрийн үйлчилгээ хүргэж байгаа төрийн байгууллага хуулиар тогтоосон хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг шинээр нэвтрүүлэх

**Биелэлт:** Төрийн албыг иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэн зохион байгуулах зорилтын хүрээнд Ерөнхий сайдын 2013 оны 38 дугаар захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны 67 дугаар тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулсан бөгөөд “Иргэн төвтэй” төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын баримт бичгийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн тухай, Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тухай хуулийн төслийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна. **/50 хувь/**

**280.** Европын Холбоо, АНУ, ISO-ийн стандартыг хангасан бүтээгдэхүүнд шууд зөвшөөрөл олгодог болох

**Биелэлт:** Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэл, үзэл баримтлалыг боловсруулж байна.

“Хэмжих хэрэгслийн загварын туршилтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”, “Хэмжлийн нэгжийн үндэсний эталон, Хэмжил зүйн үндэсний хүрээлэнгүүдээс олгож байгаа шалгалт тохируулгын болон хэмжлийн үр дүнгийн гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-т нэгдэн орох эхний үе шатны ажлын хүрээнд Жин ба хэмжүүрийн ерөнхий бага хурлын сурвалжлагч гишүүнээр элсэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд байна.

Эрчим хүчний хэмнэлтийг сайжруулахын тулд, стандартчиллын үйл явцын уялдааг хангах, хэмжил зүйн үйлчилгээг сайжруулах замаар чанарын дэд бүтцийг дэмжих зорилгоор Эрчим хүчний яам, Стандартчилал, хэмжил зүйн газар, Германы Физик техникийн хүрээлэн (РТВ) хамтран, “Эрчим хүчний салбарын чанарын дэд бүтцийг дэмжих” төслийг хэрэгжүүлэхээр гурван талт гэрээг байгуулж, 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдөр талууд гэрээнд гарын үсэг зурсан. Үүнд:

-Эрчим хүчний салбарт олон улсын буюу Европын стандартыг Монгол улсын үндэсний стандарт болгон нэвтрүүлэх

-Эрчим хүчний салбарын хэмжил зүйн үйл ажиллагааг ISO/IEC 17025 стандартын дагуу өргөжүүлэх

-Европын болон олон улсын стандартад нийцсэн дэвшилтэд техник, тоног төхөөрөмжийг Эрчим хүчний салбар дахь хэмжил зүйн лабораториудад нийлүүлэх.

**/50 хувь/**

**281.** Мэдээллийн технологийг ашиглан цаасаар үйлддэг шат дамжлагыг 50 хувиар бууруулах

**Биелэлт:** “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан Орчин үеийн шинэ технологи болох Үүлэн тооцооллыг нэвтрүүлэх төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж буй бүх шатны байгууллагуудын сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын төхөөрөмж суурилуулах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Төслийг хэрэгжүүлэх санхүүжилт улсын төсөвт тусгагдаагүй.

Төрийн бүх шатны байгууллага, түүний салбар нэгжүүдэд иргэний цахим үнэмлэх уншигч, тоног төхөөрөмж суурилуулж, программ хангамж нэвтрүүлэх ажлын хөрөнгө төсөвт тусгагдаагүй ба урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлээд байна.

“Цахим систем болон Мобайл технологид суурилсан программ хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх” төслийн багц 1-ийн хүрээнд “Төрийн энтерпрайз архитектур боловсруулах” 2 үе шат бүхий төслийг хэрэгжүүлж байна.

Өдөр тутмын хэвлэлийн эхийг орон нутагт файлаар нь дамжуулж хэвлэх технологийн боломж, холбогдох эдийн засгийн тооцог хийсэн. Хэвлэлийн цахим хүргэлтийн системийг бий болгох төслийг шинэчлэн боловсрууллаа. **/30 хувь/**

**282.** Бизнес болон хөрөнгийн бүртгэлийг долоо хоногийн дотор бүртгэдэг тогтолцоог нэвтрүүлэх

**Биелэлт:** Иргэн, хуулийн этгээдэд олгох эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн гэрчилгээг улсын ерөнхий бүртгэгч болон улсын бүртгэгчийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулдаг байсныг өөрчилж, улсын бүртгэгч дангаараа гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж олгодог болсон.

Бүртгэлийг богино хугацаанд хийх болсноор үйлчилгээний шат дамжлага буурч, үйлчлүүлэгчдийн цаг завьг хэмнэж байна.

УБЕГ-ын даргын 2014 оны 206 дугаар тушаалаар “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах “Ажлын хэсэг” байгуулагдан ММСС-ийн

“Хуулийн төслийн ажлын баг”, эрдэмтэн судлаачдын саналыг авч, уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, танилцуулга, дагалдан гарах бусад хуулийн төслийг боловсруулсан. /50 хувь/

### 283. “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

**Биелэлт:** “Цахим засаг” Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн энтерпрайз архитектур байгуулах”, “Нийтийн түлхүүрийн дэд бүтэц”, “Мобайл болон интернэтэд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх”, “Орон нутагт нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах”, “Сумдад интернэт үйлчилгээ хүргэх”, “Паспорт хяналтын нэгдсэн сүлжээг бий болгох”, “Газар хөдлөлтийн гамшгийн урьдчилан сэргийлэх систем байгуулах”, “Ховд аймагт багийг холбоожуулах” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. Мөн “Цахим эрүүл мэнд” болон “Шинэ зууны боловсрол” төслүүдийг хэрэгжүүлж байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох журам”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон бусад хуулийн этгээдийн бүртгэлийн нэгжийн журам”, “Тоон гарын үсгийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”, “Гэрчилгээ олгох журам” “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглахтай холбоотой нийтлэг журам” зэрэг журмын төслийг боловсруулж байна.

Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа бүх шатны байгууллагын сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын төхөөрөмж суурилуулах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан ч санхүүжилт улсын төсөвт тусгагдаагүй.

“Ухаалаг шуудангийн хайрцаг суурилуулах” төслөөр Улаанбаатар хотод 18 цэг, Дархан, Эрдэнэт хотуудад тус тус ухаалаг шуудангийн хайрцаг суурилуулаад байна.

“Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон систем рүү үе шаттайгаар шилжүүлэх төсөл”-ийн хүрээнд 38 сайтад тоон телевизийн тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж, дамжуулах станцуудыг хүлээн авсан.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр хөтөлж, олон нийтэд нээлттэй байлгах тухай асуудлыг Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган боловсруулж байна. /50 хувь/

### 284. Авлига, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргах

**Биелэлт:** Шинэчлэлийн Засгийн газар иргэдийн санал хүсэлт хүлээн авах “11 11 төв”-ийг 2012 оны 10 дугаар сарын 12-нд байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлж, иргэдийн санал, хүсэлтийг Засгийн газрын яам, агентлагийн эрхлэх асуудлын хүрээний дагуу хуваарилан иргэдэд холбогдох хариуг хүргүүлэн ажиллаж байна.

Яамдын ажлын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор сар бүрийн эцэст “Хариуцлага, Хэрэгжилт, Хяналт” арга хэмжээг зохион байгуулж хэвшээд байна.

Яам, агентлагт мөрдөж байсан дотоод ажилтай хэмээх өдөр, цагийг алга болгож, иргэдэд нээлттэй болгосон.

Төрийн үйлчилгээг иргэдэд шууд хүргэх зорилгоор төрийн үйлчилгээний 48 цахим (ТҮЦ) машиныг суурилуулж, иргэний бүртгэлийн 5 төрлийн мэдээллийг цахим машинаар авах үйлчилгээг нэвтрүүлсэн. Энэ онд үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Мөн төрийн 30-аад үйлчилгээг гар утас, компьютерээс авдаг болох, цахим эрүүл мэндийн үйлчилгээ, эмийн жор, төлбөр хураагч ухаалаг машин зэргийн техникийн шийдэл дээр ажиллаж байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын 2013 оны 196 дугаар захирамжаар Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх, иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх ажил, үйлчилгээний жагсаалт, хэрэгжүүлэх арга зам, хугацаа, төсвийг зохицуулах санал бүхий төлөвлөгөө болон холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

2014 онд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ 266 өндөр албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн байна. Харин улсын хэмжээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 112 байгууллагын 51579 албан хаагч мэдүүлгээ 99,99 хувьтай бүртгүүлжээ. Авлигатай тэмцэх газар 2014 онд 781 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 498 нь гэмт хэргийн шинжтэй бөгөөд энэ нь өмнөх оныхтой харьцуулахад 18 хувиар өсчээ. Хуульд заасан харьяаллын 598 холбогдогч, 721 үйлдэлтэй 239 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2013 оны мөн үетэй харьцуулахад 27.8 хувиар өссөн байна. /50 хувь/

**285.** Шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх

**Биелэлт:** Цагдаагийн албаны тухай, Тахарын албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төлбөрийн чадваргүй яллагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиудыг УИХ-аар батлууллаа. Цагдаагийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулан 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-аар батлуулсан.

Шүүхийн багц хуульд нийцүүлэн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр батлав.

Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан УИХ 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдөр батлав.

Мөрдөх албаны тухай, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлээд байна. /70 хувь/

**286.** Дотоод хэргийн чиг үүрэг давамгайлсан байдлыг халах замаар Хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болгож, хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгох

**Биелэлт:** Засгийн газрын 2012 оны 14, 63 дугаар тогтоолын дагуу Хууль зүйн яамны чиг үүргийг дотоод хэргийн чиг үүрэг давамгайлсан байсныг өөрчлөн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгосон.

Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичгийн төслийн хувилбарыг олон улсын эрх зүйн шинэчлэлийн чиг хандлагад нийцүүлэх, хүний эрхийн суурь зарчмуудад тулгуурлан дахин шинэчлэх шаардлагыг тодорхойлсон тул нэмэлт мэдээлэл цуглуулах, олон улсын туршлага судлуулах, харьцуулсан судалгаа хийх ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран хийж байна. /70 хувь/

**287.** Төрийн албан тушаалтны эрх мэдлийг тодорхойлсон хууль зүйн бодлогыг өөрчилж, төрийн албыг нийтийн эрх ашгийг хамгаалж, иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэх

**Биелэлт:** Төрийн албыг иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэн зохион байгуулах зорилтын хүрээнд Ерөнхий сайдын 2013 оны 38 дугаар захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны 67 дугаар тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулсан бөгөөд “Иргэн төвтэй” төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын баримт бичгийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн тухай, Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тухай хуулийн төслийн

тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна. /50 хувь/

**288.** Төрийн үйл ажиллагаанд иргэд бүхий л хэлбэрээр оролцдог байх бололцоог эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийх

**Биелэлт:** Хууль зүйн сайдын 2012 оны А/37 дугаар тушаалаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.

Хууль зүйн яамнаас эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төслийн талаар зүүн, баруун, төвийн бүсийн 14 аймгийн хууль сахиулах байгууллагуудын нийт 600 гаруй ажилтнуудад зориулсан сургалт, хэлэлцүүлгийг Орхон, Хэнтий, Ховд аймагт зохион байгуулахад Захиргааны ерөнхий хуулийн төслийг танилцуулж тэдний саналыг авах, түүнчлэн Аймаг, нийслэлийн хууль зүйн хэлтсийн дарга нар болон хуулийн хэлтсийн мэргэжилтнүүдэд 2 удаа сургалт семинар, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах зорилгоор 10 төрийн бус байгууллага, бие даасан судлаачдын төлөөлөл оролцсон 18 хүнд 2 өдрийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах замаар тэдний санал, зөвлөмжийг авах, мөн түүнчлэн Иргэний танхимд хуулийн төслийн талаархи мэдээлэл хийх зэргээр ажилласан байна.

Захиргааны ерөнхий хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, дагаж гарах хуулийн төслийг Засгийн газарт хүргүүлээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн болно. /50 хувь/

**289.** Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болох

**Биелэлт:** Хуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, болон төслийг боловсруулж байна. НҮБХХ-ийн "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" төслийн хүрээнд Хуулийн тухай хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй зөвлөх баг ажиллаж байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал", "Хуулийн үр дагаварын үнэлгээ хийх аргачлал", "Хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тооцох аргачлал", "Хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал" гэж задлан, илүү дэлгэрэнгүй зохицуулалт бүхий бие даасан аргачлалуудыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталдаг байхаар хуулийн төсөлд тусгаад байна. Хуулийн төслийн 2015 оны 1 дүгээр сард УИХ-д өргөн барьсан. /50 хувь/

**290.** Төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болох

**Биелэлт:** Төрийн албыг иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэн зохион байгуулах зорилтын хүрээнд Ерөнхий сайдын 2013 оны 38 дугаар захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны 67 дугаар тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулсан бөгөөд "Иргэн төвтэй" төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын баримт бичгийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн тухай, Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тухай хуулийн төслийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна. /50 хувь/

**291.** Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх

**Биелэлт:** Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг УИХ-аар батлуулж, хуулийн хэрэгжилтийг хангах, шаардлагатай дүрэм, журмын төсөл боловсруулах үүрэг

бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж, холбогдох журмуудыг боловсруулж дуусаад байна. Засгийн газрын “Агентлаг байгуулах тухай” 2014 оны 7 тогтоол, Хууль зүйн Сайдын 2014 оны А/08-р тушалаар Тахарын ерөнхий газрыг байгуулан ажиллаж байна. /100 хувь/

**292.** Хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хуульчдын ажил, мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгуурын гол үзүүлэлт болгох

**Биелэлт:** Хуульчийн эрх зүйн байдлын тухай болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хууль зүйн сайдын 2013 оны А/86 дугаар тушаалаар хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хуульчдын ажлын гол шалгуур үзүүлэлт болгов. /100 хувь/

**293.** Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхитай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох

**Биелэлт:** Зөрчлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслийг дагаж гарах 200 орчим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Зөрчлийн тухай хуулийн төсөл, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга буюу Гэмт хэргийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн боловч Засгийн газар буцаан татсан. Эдгээр хуулийн төслүүдэд холбогдох нэмэлт өөрчлөлтийг хийж дахин УИХ-д өргөн барихаар ажиллаж байна. /50 хувь/

**294.** Иргэний үндсэн эрхийн хяналтыг Үндсэн хуулийн цэцэд олгож иргэний үндсэн эрхийн баталгааг сайжруулах

**295.** Хууль зүйн мэргэжлийн болон иргэний боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжлийн хуульч бэлтгэх тогтолцоог шинэ шатанд гаргах. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Иргэний боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Биелэлт:** Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/208 дугаар тушаалаар иргэний боловсролын 10-12 дугаар ангийн сургалтын хөтөлбөр батлагдсан.

Иргэний боловсрол хичээлийн 6 дугаар ангийн сурах бичгийг 16962, 7 дугаар ангийн сурах бичгийг 8632, 8 дугаар ангийн сурах бичгийг 22395, 9 дүгээр ангийн сурах бичгийг 20625 ширхэг хэвлүүлэн түгээлээ. 2014 онд 10, 11 дүгээр ангийн Иргэний боловсролын сурах бичиг хэвлэгдэнэ.

Хуульч мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж байгаа болно.

Хууль зүйн дипломын бус боловсрол олгох ажлын хүрээнд 2013 онд Хууль сахиулахын их сургууль 1056 мэргэжлийн албан хаагчийг батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Ахлагчийн сургуульд бэлтгэн, мэргэжлийн үнэмлэх, сертификат олгосон. /50 хувь/

**296.** Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллагыг байгуулж чадавхижуулах

**Биелэлт:** Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүрээнд Хуульчдын анхдугаар их хурал 2013 оны 9 дүгээр сард хуралдаж, Монголын хуульчдын холбоог байгуулан, дүрмийг баталсан.

Мэргэжлийн хуульчдын давтан сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг Хуульчдын холбоонд шилжүүлсэн тул мэргэжлийн хуульчдын давтан сургалтын тогтолцоо бүрдүүлэх ажлыг тус холбоо зохион байгуулахаар болсон. /100 хувь/

**297.** Иргэдэд өдөр тутам үйлчилдэг нийтийн албан хаагчдыг иргэд өөрсдөө үнэлдэг тогтолцоонд оруулж, цалин хангамжийг ажлын бүтээмжтэй уялдуулан тооцож, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

**Биелэлт:** Төрийн албыг иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэн зохион байгуулах зорилтын хүрээнд Ерөнхий сайдын 2013 оны 38 дугаар захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2013 оны 67 дугаар тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулсан бөгөөд “Иргэн төвтэй” төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын баримт бичгийн төсөл, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн тухай, Төрийн байгууллага, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тухай хуулийн төслийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна. /50 хувь/

**298.** Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй болгох

**Биелэлт:** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн бүх шатны байгууллагын жинхэнэ албан хаагч “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг хуульд заасан хугацаанд багтаан бүрэн гаргаж өгч байна.

УИХ-д өргөн мэдүүлсэн Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд авлигын гэмт хэргийг “Авлигын эсрэг НҮБ-ын конвенци”-д нийцүүлэн томъёолж, бие даасан бүлэг болгон тусгасан. /90 хувь/

**299.** Удирдлагын академийг нийтийн албан хаагчдын үргэлжилсэн сургалтын байгууллага болгон өөрчлөх

**Биелэлт:** Засгийн газрын 2012 оны 44 дүгээр тогтоолоор Удирдлагын академийн дүрмийг шинэчлэн баталж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нийтийн албан хаагчдыг сургах, давтан сургах, нийтийн албаны хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах чиг үүрэгтэйгээр өөрчлөн зохион байгуулсан болно. /100 хувь/

**300.** Залуучуудын хөгжлийн асуудлаар үндэсний хэмжээнд бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Засгийн газрын Үндэсний хороог байгуулах

**Биелэлт:** Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Залуучуудын хөгжлийн Үндэсний хороо байгуулж, хорооны ажиллах журмыг баталсан.

Залуучуудын өнөөгийн нөхцөл байдал, тэдний өмнө тулгамдсан асуудлыг тодорхойлох, залуучуудын хөгжлийн асуудлаар үндэсний бодлого, “Монгол залуу хүн” хөтөлбөр боловсруулахад шаардлагатай санал, зөвлөмж гаргах зорилго бүхий бодлогын судалгааны ажлыг хийж гүйцэтгээд байна. Залуучуудын асуудлаарх бодлогын баримт бичигт “Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого, зорилт” үндэсний чуулганаас гарсан зөвлөмж, Залуучуудын асуудлаарх бодлогын судалгаа, Хүний хөгжлийн илтгэлийн хүрээнд хийгдсэн судалгаа, болоод бусад материал, холбогдох уулзалт хэлэлцүүлгүүдээс гарсан зөвлөмжид тулгуурлан олон улсын хэмжээнд залуучуудын хөгжлийн чиглэлээр баримталж буй бодлого хөтөлбөрийн



зорилго, зорилттой нийцүүлэн Монгол залуу хүн үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулаад байгаа бөгөөд 2015 оны 1-р улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. /70 хувь/

**301.** Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хууль батлуулж, иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн шинэ хувилбаруудыг бий болгох

**Биелэлт:** Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийж ирүүлсэн судалгааны ажилд дүн шинжилгээ хийж, хуулийн төслийн эхний хувилбар болон түүний үзэл баримтлалыг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. /30 хувь/

**302.** Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх

**Биелэлт:** Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Ерөнхий сайдын 2013 оны 196 дугаар захирамжаар Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх, иргэний нийгмийн байгууллагад шилжүүлэх ажил, үйлчилгээний жагсаалт, хэрэгжүүлэх арга зам, хугацаа, төсвийг зохицуулах санал бүхий төлөвлөгөө, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Эдийн засгийн хөгжлийн яамнаас бусад яам 1-37 ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа бөгөөд нийт 143 ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа дүнтэй байна.

“Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 250, 251 дүгээр тогтоолуудаар Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргах иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, тэдгээрийг зохион байгуулах чиг үүргийг хариуцлага хүлээх чадвар бүхий мэргэжлийн хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайдад зөвшөөрлөө.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 27 дугаар зүйлд Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох асуудлыг төрийн бус байгууллагад шилжүүлэхээр тусгасан.

Мөн Засгийн газраас 2014 оны 6 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлээд байгаа Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийг холбогдох төрийн бус байгууллагад нь шилжүүлэхээр тусгасан байна. /50 хувь/

**303.** Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжих

**Биелэлт:** Ханнс-Зайделийн сангаас хийсэн судалгааны материалуудыг судалж Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг баталсан ба хуулийн төсөл боловсруулалтын шатандаа байна. /30 хувь/

**304.** Судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулах

**Биелэлт:** Шинжлэх ухаан, технологийн салбарт олгогдож буй төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2012 оны байдлаар 0,19%, 2013 оны байдлаар 0,18%, 2014 оны байдлаар 0.17% байна. Энэ нь 2014 онд салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт нэмэгдээгүй, Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн жил бүр өсч байгаатай холбоотой.

“Шинжлэх ухааны байгууллагуудыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, нийгмийн бодлогын байнгын хорооны 2014 оны 7 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолоор Шинжлэх ухааны академи, түүний харъяа салбар академи, харъяа эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэнгүүдийн санхүүгийн бие даасан байдлыг хангаж, эрдэм шинжилгээний зардлын хэмжээ, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хангамжийг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын төсөл, хөтөлбөрт хамруулах талаар дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тухайн жилийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 5 хувьд хүргэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хуралд өргөн барьсан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн төсөлд тус салбарын санхүүжилтийг тогтвортой нэмэгдүүлэх, 2020 он гэхэд ДНБ-ний 2 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн.

Шинжлэх ухааны салбарын 8 эрдэм шинжилгээний байгууллагын 12 лабораторийн тоног төхөөрөмжийг 1.8 тэрбум төгрөгөөр худалдан авч нийлүүллээ.

Эрдэм шинжилгээний байгууллагын барилгын засварын ажилд 2013 онд 500.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн гүйцэтгэсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр Шинжлэх ухаан, технологийн салбарт 2009 оноос хойш хэрэгжиж байгаа судалгаа боловсруулалтын ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргах ажлыг зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдын хэрэгжүүлж байгаа 60 инновацийн төслийн явц, үр дүнтэй танилцан 33 төслийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх, 16 төслийн үр дүнг дуусгавар болгон хүлээн авахаар тогтсон.

Үр дүнгийн даалгавар нь төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа 61 төслийг 2013 онд үргэжлүүлэн санхүүжүүлэхээр тогтсон байна.

“Эрдэм шинжилгээ, Туршилт, Зохион бүтээх ажилд Патентийн мэдээллийг ашиглах нь” Үндэсний Сургалт ДӨӨБ, БШУЯ-тай хамтран зохион байгууллаа. “Оюуны өмчийн бүтээлийн үнэлгээ тогтоох, баталгаажуулах журам”, “Нууцын журам” болон “Маргаан шийдвэрлэх комиссийн ажиллах журам” боловсруулж, нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд оруулав. /50 хувь/

**305.** Салбарын мэргэшсэн хяналтын байгууллага бий болгох

**Биелэлт:** Хяналтыг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж анхны хэлэлцүүлэг хийсэн ч эгүүлэн татан авч, УИХ-ын гишүүдийн саналыг тусган Хяналтын тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах 83 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. /50 хувь/

**306.** Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг нээлттэй болгох

**Биелэлт:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон бусад албадуудтай мэдээллийг түргэн шуурхай дамжуулах, бичиг хэргийн зардлыг бууруулах үүднээс “Цахим шуудан ашиглах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

ШШГЕГ-ын даргын 2013 оны А/80 дугаар тушаалаар “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд иргэд, байгууллагаас амаар, бичгээр, утсаар болон цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шууд шийдвэрлэх боломжтой бол тэр даруй шийдвэрлэх, бусад тохиолдолд 14 хоногт багтаан холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж хариу өгч байна.

Хууль зүйн сайдын 2013 оны А/116 дугаар тушаалаар “Хууль зүйн цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг байгуулсан. Тус нэгжийн үйл ажиллагаа /тоног төхөөрөмж худалдан авах/-нд дэмжлэг үзүүлэхийг Дэлхийн банкны “Хууль зүйн үйлчилгээг сайжруулах төсөл”-өөс хүсээд байна. Хууль зүйн цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх ажлын хүрээнд бодлогын зөвлөл болон тусгайлсан нэгж байгуулан асуудлыг боловсруулан тодорхой санал шүүмж, шийдлийг төслийн нэгжийн гишүүдтэй хамтран хэлэлцэж байна.

ШШГЕГ, НШГА, Цагдан хорих 461 дүгээр анги нь “Нэг цэгийн үйлчилгээ болон Угтах үйлчилгээ”-г байгуулж, иргэдэд хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөөг өгч ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас, иргэд байгууллагад дараах лавлагаа, тодорхойлолтыг гарган өгч үйлчиллээ. Үүнд:

- ШШГЕГ-ын Төрөлжсөн архиваас нийт 224архивын лавлагаа;
- Ялтны суллагдсан талаарх 508 тодорхойлолт;
- Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөртэй эсэх лавлагааг улсын хэмжээнд 79437 удаа гарган өгсөн. Үүнээс иргэдэд шууд хэлбэрээр буюу хэвлэмэл цаасаар 32242, Арилжааны банкуудад цахим шуудангаар 41341, Орон нутаг дахь шийдвэр гүйцэтгэх албадад цахим шуудангаар 5202 лавлагаа өгөв. **/50 хувь/**

**307.** Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулахтай уялдуулан прокурор, өмгөөлөл, мөрдөх албаны зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх

**Биелэлт:** Мөрдөх албаны тухай хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төслүүдийг боловсруулсан бөгөөд эхний хувилбарыг сайжруулах, нэмэлт боловсруулалт хийж УИХ-д дахин өргөн барихаар ажиллаж байна. **/50 хувь/**

**308.** Шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн бүтцийг бий болгож, хүний эрхийн баталгааг дээшлүүлэх

**Биелэлт:** Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгч байхаар тусгаж байна.

Хүний эрхэнд халдах, эрхийг хязгаарлах албадлагын бүх арга хэмжээг зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр хэрэглэхээр хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр ажиллаж байна. **/30 хувь/**

**309.** Шүүн таслах ажиллагааг захиргааны үйл ажиллагаанаас тусгаарлаж, шүүхийн захиргааг мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх

**310.** Шүүх, шүүгчийн хамгаалалт, шүүгдэгчийг албадан авчрах, гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, хорихоос оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх зэрэг чиг үүрэг бүхий тусгай албыг бий болгож, эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах

**Биелэлт:** Тахарын албаны тухай хуулийг УИХ-аар батлуулсан бөгөөд 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хууль зүйн сайдын тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж уг хуульд заасны дагуу холбогдох дүрэм, журмыг боловсруулж байна.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай УИХ-ын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр өөрчлөлт оруулж, Тахарын албыг байгуулав.

Ял шийтгэл эдлүүлэх, нийгэмшүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан хуулийн үзэл баримтлалын төслийн эхний хувилбарыг боловсруулсан бөгөөд хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж байна.

**/90 хувь/**

**311.** Прокурорын байгууллагын хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлэх

**Биелэлт:** Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлэх асуудлыг тусгаж байна. Шүүхийн зөвшөөрөлтэй болон шүүхийн зөвшөөрөлгүй хийгдэх ажиллагааны талаар бие даасан бүлэг боловсруулж байна. Хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр ажиллаж байна. **/30 хувь/**

**312.** Захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, хилийн алба, татвар, бусад мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх

**Биелэлт:** ЦЕГ-ын гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх нэгдсэн сангийн программыг шинэчилсэн бөгөөд хууль сахиулах байгууллагын нэгдсэн сүлжээг байгуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Хууль сахиулах болон хяналтын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн менежмент нэвтрүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн сайдын 2013 оны А/248 дугаар тушаалаар эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулан баталсан. **/50 хувь/**

**313.** Мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх алба болгон нэгтгэн зохион байгуулж, мөрдөх албаны дэргэд шүүхийн шинжилгээний бүтцийг бий болгох

**Биелэлт:** Мөрдөх албаны тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг холбогдох байгууллагуудын төлөөлөлтэйгээр Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулсан.

Мөрдөх албаны тухай хуулийн төслийг 6 бүлэг, 40 зүйлтэйгээр боловсруулан, үзэл баримтлал, төслийн танилцуулга, дагаж гарах хуулийн төслүүдийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн боловч буцаан татан авсан. **/30 хувь/**

**314.** Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах

**Биелэлт:** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2014 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. **/50 хувь/**

**315.** Цагдаагийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах

**Биелэлт:** Энэ ажлыг 2014 онд хэрэгжүүлнэ. Нийслэлийн Засаг даргын 2012 оны “Улаанбаатар хотын авто замын ачааллыг зохицуулах нэмэлт зарим арга хэмжээ авах тухай” А/724 дугаар захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр 22 автобусны буудал дээр хэв журмын нөхцөл байдлыг хянах, Саппорогийн тойрог, баруун болон зүүн дөрвөн замын уулзвар дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хянах, Энхтайваны өргөн чөлөөнд зорчих хэсгийн нэгдүгээр эгнээний байрлал, замын хөдөлгөөнийг бүхэлд нь хянах, тээврийн хэрэгслийн дугаарыг санах зориулалт бүхий хяналтын камеруудыг суурилууллаа.

Сумдын хэсгийн төлөөлөгчийн ажлын байрыг VPN холболтоор холбон “Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээ”-нд ажиллах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын эхний ээлжинд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагдаагийн хэлтсийг энэхүү сүлжээнд холбов. Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлгийн 24 дүгээр зүйлд заасны дагуу “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөр аюулгүй байдлын хувцас өмсөж хэрэглэх журам, хувцасны загвар”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны хөдөлмөрийн гэрээ, ажил дүгнэх үзүүлэлт, үнэмлэхний загвар”-ыг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 382, 383, 384 дүгээр тушаалаар тус тус батлан, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Нутаг дэвсгэрт ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтан, иргэний зөвлөлийн гишүүний тоо, тэдгээрт олгогдох цалин, хөдөлмөрийн хөлс, урамшуулал, олон нийтийн цагдаагийн хөдөлмөр хамгааллын хувцас, тусгай хэрэгслээр хангахад шаардагдах хөрөнгийн төсвийг тодотгох зорилгоор Аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч нарт албан бичиг хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангах ажлын явц байдлын талаарх мэдээллийг авч нэгтгэж байна.

**/40 хувь/**

**316.** Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил, орлогыг ил тод болгож, хэвлэлийн байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлж, иргэний хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах

**Биелэлт:** Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулаад байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой мэдээллийг [www.burtgel.mn](http://www.burtgel.mn) цахим хуудсаар дамжуулан нийтэд ил тод болгож, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг тогтмол хийж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэлийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу ажлын 3 хоногт багтаан хийж байна. **/30 хувь/**

**317.** Шүүхийн шинэтгэлийн багц хуулиудын хэрэгжилтийг хангах техник, зохион байгуулалтын арга хэмжээг цогцоор нь төлөвлөж шийдвэрлэх

**Биелэлт:** Тахарын албаны тухай хууль, Засгийн газрын 2014 оны Агентлаг байгуулах тухай 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 11 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Тахарын ерөнхий газрыг байгуулж, удирдлагыг томилсон. Хууль зүйн сайдын тушаалаар Тахарын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, албаны зохион байгуулалтын бүтэц, 1-9 дүгээр тойргийн Тахарын албаны зохион байгуулалтын бүтцийг тус тус баталсан. Тахарын ерөнхий газрын даргын 2014 оны 11 дүгээр тушаалаар 10 дугаар тойргийн Тахарын албаны албан тушаалын орон тоо, Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах газрын бүтэц, Гэрч хохирогчийг хамгаалах газрын бүтцийг батлаж, 2014 оны 48 дугаар тушаалаар 1-9 дүгээр тойргийн Тахарын албаны бүтэц, орон тоо, албан тушаалын зэрэглэлийг баталсан.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-аас 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан. “Цагдаагийн

байгууллагын хөгжлийн хөтөлбөр"-ийг Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан. “Улаанбаатар хотын цагдаагийн газар байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 115, “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолыг тус тус баталсан. /30 хувь/

**318.** Шүүхээс гадуур хүний эрхийг хязгаарлаж, эрүүгийн хэргийг байцаан шалгадаг тогтолцоог халж, шүүхийн хяналтын дор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох

**Биелэлт:** Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд шүүх нь хуульд заасан үндэслэл журмын дагуу мөрдөн шалгах ажиллагааны зөвшөөрөл олгох, албадлагын арга хэмжээ авах, өөрчлөх хүчингүй болгох, гэмт хэргийн нотлох баримтын хууль ёсны байдал, шүүгдэгчийн гэм буруугийн асуудлыг хянан шийдвэрлэх, гэмт хариуцлага хүлээлгэх эсэх тухай шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгаж байна. Хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр ажиллаж байна. /30 хувь/

**319.** Хээл хахууль, шан харамжийг ялгамжтай зохицуулж, хахууль өгсөн талыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хөнгөлөх асуудлыг хуульчлах

**Биелэлт:** Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд Авлигын гэмт хэргийг бие даасан бүлэг болгон тусгаж УИХ-д өргөн мэдүүлсэн. Уг бүлгийг “Авлигын эсрэг НҮБ-ын конвенци”-д нийцүүлж, хээл хахууль, шан харамжийг ялгамжтай зүйлчилж, хээл хахууль өгсөн, зуучилсан этгээдийг хэргээ илчилсэн тохиолдолд оногдуулах ялаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэхээр хуулийн төсөлд тусгав. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр ажиллаж байна. /50 хувь/

-- о О о --